



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Шударга ёс, хөгжил дэвшилд

СУДАЛГААНЫ
ТАЙЛАН
ЭМХЭТГЭЛ
2008-2011 он

I БОТЬ

ННА 72
ДАА 001.4
У-314

Хянасан:

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар
З.Баасанням
Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах
комиссар Ц.Шинэбаяр

Боловсруулсан:

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан,
комиссар Ц.Бадам

Цаасны хэмжээ: А4
Хэвлэсэн тоо: 300

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-22-714-2

ӨМНӨХ ҮГ



Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан судалгааны тайлангуудыг эмхэтгэн Та бүхэнд толилуулж байна.

Тус газар нь 2007 онд байгуулагдсан цагаасаа эхлэн авлигын шалтгаан нөхцөл, цар хүрээ, үр дагавар, хэлбэр болон эдгээртэй холбоотой олон тооны үзүүлэлтийг тооцоолох, хэмжих зорилготой судалгааны ажлыг жил бүр зохион байгуулж ирсэн. Эдгээр судалгааны ажлын зорилго нь авлигын нөхцөл байдлыг тодорхойлж, хэмжээний үндсэн дээр авлигатай тэмцэх бодлогыг боловсруулахад ашиглах, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох явдал юм.

Энэхүү эмхэтгэл нь тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны үр дүнгийн тайлангуудаас бүрдэж байгаа бөгөөд эдгээрийг гурван боть болгон эмхэтгэлээ. Тухайлбал 2008 оноос 2018 онд зохион байгуулсан Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, 2009, 2011, 2013 онуудад зохион байгуулсан Авлигын индексийн судалгаа, 2010, 2012, 2014 онуудад зохион байгуулсан Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, 2015, 2016, 2018 онд зохион байгуулсан Шударга байдлын үнэлгээ, 2010 оноос 2019 онд зохион байгуулсан Хүүхдийн шударга

байдлын судалгаа, 2018 онд зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа зэрэг судалгааны тайлангуудыг эмхэтгэлд багтаан нийтийн хүртээл болгож байна.

Бид судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулахдаа олон улсын аргачлал, арга зүй, туршлагыг судлан үзэж, мөн манай улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачидтай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл судалгаа шинжилгээний ажлыг Авлигатай тэмцэх газар дангаараа бус харин олон тооны байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор гүйцэтгэдэг юм.

Судалгааны ажлын үр дүнгийн тайлангууд нь өргөн хүрээтэй, чухал ач холбогдолтой олон тооны мэдээ, мэдээлэл агуулсан бөгөөд бодлого боловсруулагчид, төрийн байгууллагын албан хаагчид, олон улсын байгууллагын ажилтнуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөх, үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг хүргэх, эрдэмтэд, судлаачдад судалгаа, мэдээллийн эх сурвалж болгох зорилгоор эмхэтгэлийг боловсрууллаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улс дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний 2019 оны тайланд судалгааны чиглэлээр хийгдэж байгаа ул суурьтай, хэвшиж тогтсон үйл ажиллагааг сайшаахын зэрэгцээ судалгааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд өнгөрсөн хугацаанд бий болсон их хэмжээний судалгааны мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглах, судалгаагаар тогтоогдсон илэрхий дүгнэлт, нотолгоонд дүн шинжилгээ

хийж, стратегийн төлөвлөлт болон үнэлгээний үйл ажиллагаанд хамтатган ашиглахыг уриалсан байдаг. Энэхүү зөвлөмж нь бидний санаа бодолтой бүрэн дүүрэн нийцэж байгааг илэрхийлэх нь зүйтэй.

Тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны ажлыг анх удаагаа эмхэтгэн хүргэж байгаа юм. Иймд энэхүү эмхэтгэлийг та бүхэн өөрсдийн үйл ажиллагаандаа

ашиглахын зэрэгцээ бидэнд хандан санал, зөвлөмжөө ирүүлбэл хүлээн авч хамтран ажиллахад бэлэн байна.

Судалгааны ажлуудыг зохион байгуулахад хамтран ажиллаж үнэтэй санал, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны мэргэжлийн байгууллагууд, судалгаанд хамтран оролцож байсан бүх хүмүүст талархлаа илэрхийлье.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА

ГАРЧИГ

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2008 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	7-18
МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2009 ОНЫ ТООЦООНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	19-32
УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2009 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	33-46
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	47-64
УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	65-84
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	85-132
УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2011 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	133-154
МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2011 ОНЫ ТООЦООНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	155-255

МХЗ-9 ХҮНИЙ ЭРХ, АРДЧИЛСАН
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
2008 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХИ ТӨСӨӨЛӨЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Судалгааны үндэслэл

Азийн сангаас 2005 онд явуулсан Монгол дахь авилгалын талаарх судалгааны тайланд хамгийн түрүүнд захиргааны болоод улс төрийн түвшний авлигыг хязгаарлахад чиглэгдсэн арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай болохыг тэмдэглэж, улс төрийн хүрээн дэх авилгал нь улс орны эдийн засагт хамгийн их хохирол учруулах магадлалтай байна хэмээн онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн тайланд: “Ерөнхийдөө, Монгол Улсын хувьд гол нь захиргааны болоод улс төрийн төвшний аль алинд нь байгаа авилгач байдлыг хазаарлах талаар үр ашигтай арга хэмжээнүүдийг хамгийн түрүүнд явах шаардлагатай байна гэжээ”¹. 2007-2008 онуудад явагдсан авлигын түвшин тогтоох судалгаа нь сүүлийн хоёр жилийн шинж байдал нааштай байж, хамгийн чухал салбаруудад бага зэргийн ахиц гарч байгаа боловч судалгаанд хамрагсдын дийлэнхи олонхи нь улс төр, бизнесийнхэн авлигад дунд буюу ихээхэн хэмжээгээр автсан гэж мэдээлж байна. Иргэдийн олонхийн бодож байгаагаар улс төрчид болон бизнес эрхлэгчид авлигаар “дунд” буюу “их хэмжээгээр” халдварласан хэвээр” гэжээ². Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтийн 2005, 2008 оны судалгаанд оролцсон олонхи нь мөн УИХ, Засгийн газар, яам, агентлагад авлига их дэлгэрсэн хэмээн үзсэн билээ³.

Улсын Их Хурал 2008 оны 1 дүгээр сард “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг шинээр тодорхойлсон Мянганы хөгжлийн зорилтын тухай тогтоолыг баталсан юм. Уг тогтоолын хавсралтаар зорилго, зорилтуудын харгалзах шалгуур үзүүлэлтүүдийг мөн баталсан билээ. Авлигыг тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын нэг шалгуур үзүүлэлт нь “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл” юм. Уг шалгуур үзүүлэлт нь Монголын нийгмийн дээд түвшин дэх “grand” буюу “ том” хэмээн нэрлэгддэг авлигын түвшинг хэмжих зорилготой бөгөөд улс төрийн болон хууль хяналтын байгууллага дахь “том” авлигын талаархи шинжээчдийн төсөөллийг тогтоох, илтгэн харуулах учиртай.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “МХЗ-9 Хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх төсөл”-ийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс дээр дурдсан “Улс төр, хууль хяналтын байгууллагуудын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл” хэмээх шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийх арга зүйг боловсруулж, анхны судалгааг явуулан дүгнэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү шалгуур үзүүлэлтийг судлан дүгнэсэн тайлан нь Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг Монгол улсын хуульд заасны дагуу авлигын индексийг тодорхойлон мэдээлж байх чиг үүргээ хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилготой бөгөөд цаашид түүний арга зүйг улам боловсронгуй болгож хэрэгжүүлэх юм.

Арга зүйн хандлага

Монголын улс төр, хууль хяналтын байгууллагуудын хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэх орчин, авлигын цар хүрээ, авлигад ихээр өртсөн салбар, байгууллага,

1 “Монгол Улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээний тайлан” 2005. ОУХА, Азийн сан. УБ., 2 дахь тал.

2 Авлигын түвшин тогтоох судалгааны судалгаа . 2006-2008. <http://www.asiafoundation.org/publications/pdf/299>

3 АЗШҮ-ийн 2005, 2008 оны судалгааны дүнгээс. Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт. УБ., Бемби сан, 2006.

авлигын түгээмэл хэлбэр, эдийн засгийн хор уршиг зэрэг улс төрийн болон төрийн захиргааны удирдлагын шатан дахь авлигын талаархи шинжээчдийн төсөөллийг тоон утгаар болон үнэлгээний дундаж оноогоор илэрхийлсэн үзүүлэлтүүдээр дүгнэхээр үнэлгээний асуултуудыг боловсруулав. Чингэхдээ “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд хэвшүүлэх” 24 дүгээр зорилтыг тодорхойлсон Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын 11 дэх шалгуур үзүүлэлтийг баримталж, судалгаанд хамрагдах байгууллагыг Улсын Их Хурал, бүх шатны ИТХ, яам, агентлаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн хяналт, шүүх, прокурорын болон цагдаагийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байхаар тооцож хүрээг нь тогтоов.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад өртөж буй үйл ажиллагаа, нөхцөлдүүлж буй орчин, хүчин зүйлс, авлигын арга хэлбэрийн талаархи төсөөллийг боловсруулж санал асуулгын хүрээ, асуултын задаргааны бүдүүвчийг гаргаж, түүнд үндэслэсэн судалгааны маягыг 13 асуулт, 87 үзүүлэлттэйгээр боловсруулж үнэлгээний судалгааг сонгосон шинжээчдийн дунд нэргүй асуулгаар явуулав.

Шинжээчдийг сонгохдоо тэдгээр нь төрийн захиргаа, хууль хяналтын байгууллагад ажиллаж авлигатай тэмцэх үйл явцад оролцдог буюу тэр тухай мэдээлэл олох боломжтой байх, бизнесийнхний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг төрийн захиргаа, хууль хяналтын байгууллагын өмнө хамгаалан ажилладаг өмгөөлөл, эрх зүйн туслалцааны туршлага бүхий байх, хувийн хэвшлийн хүрээнд аж ахуй эрхлэн удирдаж, улс төр, төрийн захиргаа, хууль хяналтын байгууллагатай харилцан ажиллаж байгаа туршлага бүхий бизнес эрхлэгч байх шалгууруудыг үндэслэл болгов. Шинжээчдийн бүрэлдэхүүнийг тогтоохдоо АТГ –аас өгсөн зөвлөмжийг харгалзаж бизнес эрхлэгчдийг түлхүү оруулав.

Яам, агентлаг, төрийн төв байгууллагад ажиллаж байгаа, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцдог буюу түүний талаархи мэдлэг, мэдээлэл бүхий төрийн захиргааны болон тусгай албан хаагч-5, хувийн хэвшлийн хүрээнд бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжийн захирал, орлогч захирал-7, өмгөөлөл, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны туршлага бүхий-3, нийт 15 шинжээчийг сонгож авав. Ажиллаж буй байгууллагаар нь үзвэл: төрийн өмчийн- 35,7%, хувийн хэвшил- 42,9% , төрийн бус байгууллага- 14,3%, олон нийтийн байгууллага-7,1%; үүнээс төрийн албан хаагчдаас- төрийн захиргаа 57,1 , төрийн тусгай албаны-42,9 хувь болсон. Хүйсийн байдлыг харахад шинжээчдийн 80 хувь эрэгтэй, 20 хувь нь эмэгтэй байв.

Үнэлгээг ерөнхийдээ 5 баллын эрэмбээр гаргаж (Тухайлбал: 1-с огт үгүй / авилгал байхгүй/ -5-маш их дэлгэрсэн) нийт дундаж үзүүлэлтээр тооцсон болно.

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТОЙМ

“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үнэлгээ нь 4,09 баллтай гарч байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хүрээний авилгыг нэлээд их байдаг гэж шинжээчид үзжээ.

Шинжээчдээр үнэлгээ хийлгэхдээ юуны өмнө авлигын тухай тэдгээрийн ойлголтыг асуусан асуулт тавьсан юм. Энэ асуултаар шинжээчид авлигын талаархи өөр өөрийн ойлголтыг товч тодорхойлсон байдлыг үзвэл ихэвчлэн авлига авагч ийн талаас нь хандаж, төрийн байгууллагын албан хаагч албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгох, түүний төлөө шан харамж авах, ашиг орлого олох хууль бус ажиллагаа, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ бусдаас хууль бусаар төлбөр авах гэж тодорхойлсон байна. Гэтэл Авлигын эсрэг хуулийн 3, 4-р

зүйлд зааснаар авлигын ойлголтыг албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу тал олгогчоор зогсохгүй, ийм үйлдэлд өдөөн хатгаж шан харамж өгөх үйлдлийг ч мөн адил хамруулан заасан байдаг. Зарим шинжээч авлигын субъектэд төрийн албан хаагчаас гадна төрийн бус байгууллагын албан хаагчийг хамруулан тодорхойлжээ.

Дээрхи байдлаас “том” авлигыг өдөөгч этгээдийн үйл ажиллагааг таслан зогсоох, саармагжуулах, урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх асуудал анхаарлын гадна орхигдож болзошгүй гэсэн дүгнэлт хийж, цаашид “том” авлигын үнэлгээ хийхэд анхаарах шаардлагатай гэж үзэв.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн заалтуудтай дотоодын хууль тогтоомжийг уялдуулах, ялангуяа авлигын субъектэд гадаадын төрийн болон олон улсын байгууллагын, түүнчлэн дотоодын төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн албан тушаалтныг хамруулан хуульчлах шаардлага байгаа нь харагдав.


Шинжээчдийн үнэлгээг асуулт нэг бүрээр хүснэгтээр гаргаж энэхүү тайланд хавсаргав. /Хавсралт 1/

Үнэлгээний дүнгээс тоймлон үзэхэд манай оронд авлигын дэлгэрсэн байдлыг үнэлсэн шинжээчдийн үнэлгээний дундажийг тооцоход 4.2 оноо буюу **их хэмжээтэй дэлгэрсэн** гэсэн дүн гарч байна.

Авлига манай оронд дэлгэрсэн шалтгааныг нийгэм, эдийн засгийн хөгжил сул, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүй сайн төлөвшөөгүй, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, “тунгалаг” байдал хангалтгүй, хүнд суртал, чирэгдэл их, улс төрчид асуудлыг явцуу ашиг сонирхлын үүднээс шийддэг, төрийн институциудын чадавхи сул, төрийн албаны ёс зүй, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул, ядуурал, хууль хэрэгжихгүй байх явдал гэж дүгнэжээ.


Том авлигад өртөмтгий удирдлагын түвшин, салбар, байгууллагыг тодорхойлсон шинжээчдийн үнэлгээгээр яам, агентлаг, төрийн захиргааны байгууллага- 4,29 оноо, улс төрийн намууд-4,36 оноо, шүүх-4,20 оноо, прокурорын байгууллага-4,15 оноо, цагдаагийн байгууллага -4,29 оноо, нутгийн захиргааны байгууллага- 4,14 оноо, УИХ -3,71 оноо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага-3,73 оноо, бүх шатны ИТХ- 3,77 оноо тус тус авчээ.

Авлига аль хүрээнд илүү дэлгэрсэн вэ? /5 баллын шкалын дундаж үзүүлэлт:1-огт үгүй -5-маш их дэлгэрсэн/



Улс төр хууль хяналтын байгууллагын хүрээний дундаж оноо нь 4,7 байгаа нь энэ хүрээнд авилга их тархсан гэсэн үнэлгээ болж байна.

Авлигыг дараах хүчин зүйл хэр зэрэг нөхцөлдүүлж байна гэж Та үнэлэх вэ? /5 баллын шкалын дундаж үзүүлэлт:1-огт үгүй -5-маш их дэлгэрсэн/



Авилгыг нөхцөлдүүлж буй хүчин зүйлсийн үнэлгээгээр намын томилгоо, намын санхүүжилтын механизм, сонгуулийн санхүүжилтийн механизм, сонгуулийн одоогийн тогтолцоо нь дунджаар 4,60 оноогоор үнэлэгдэж бусад хүчин зүйлсээс дээгүүр дүнтэй байгаа нь дээрх хүрээнд өөрчлөлт шинэчлэлт хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Улс төрийн хүрээнд өөрт давуу тал, ашигтай байдлыг бий болгох, хууль, бусад шийдвэр гаргуулах зорилгоор мөнгө хөрөнгө өгөх, ашиг орлогоо хуваахаар амлах, аялал, жуулчлалын зардал даах, сонгуулийн болон бусад арга хэмжээг санхүүжүүлэх, бэлэг сэлт өгөх зэрэг авилгын хэлбэр их байна (3,87 оноо).

Улс төрчид өөрийн сонирхлын болон бусдын захиалгаар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд дарамт, шахалт үзүүлэх, шан харамж нэхэх, бусдын хооронд зуучлах замаар үйл ажиллагаанд нь нөлөөлөх үзэгдэл их байна (3,62 оноо) гэж дүгнэжээ.

Улс төрчид төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртээх, тусгай зөвшөөрөл авах, сунгуулах, шүүх, хууль хяналтын байгууллагын ажиллагаанд нөлөөлөх, ажил албан тушаалд томилох үйл ажиллагаанд илүүтэй оролцож байгааг судалгааны дүн харуулж байна. Ялангуяа ажил, албан тушаалд томилох ажиллагаанд улс төрчид нөлөөлөх явдал маш их байна гэж шинжээчид үзэж 4,79 оноо өгчээ.

Төрийн захиргааны байгууллагад хүнд суртал, олон шат дамжлага, давхардал байгаа, төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шийдвэр гаргах үйл ажиллагааны “тунгалаг” байдал дутмаг, албан тушаалтан үзэмжээрээ шийдвэр гаргах боломж зохих хэмжээнд хязгаарлагдаагүй, хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцохгүй орхидог, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай, төрийн албан хаагчдын ёс зүй, чадавхи муугаас авлигыг ихээр нөхцөлдүүлж байна гэж шинжээчид үнэлжээ (4,27 оноо).

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах болон тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа 4,80 оноогоор үнэлэгдсэн нь бусдаас илүү өнөдөр байгаа нь дээрхи үйл ажиллагааны ил тод байдлыг хангах шаардлагатайг илтгэн харуулж байна.

“Том” авлигын хэмжээг шинжээчдийн дүгнэснээр авч үзвэл төсөл, хөтөлбөрт хамрагдахад нийт үнийн дүнгийн 6-15 хувийг авлигад зарцуулж байна гэж шинжээчдийн 46.7 хувь, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялахад нийт дүнгийн 6-20 хувийг зарцуулж байна гэж шинжээчдийн 71.6 хувь, өмч хувьчлах шийдвэр гаргуулахад үнийн дүнгийн 20 –оос дээш хувийг зарцуулж байна гэж шинжээчдийн 20.0 хувь, зээл авахад үнийн дүнгийн 5-15 хувийг зарцуулж байна гэж шинжээчдийн 46.6 хувь, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхэд үнийн дүнгийн 6-15 хувийг зарцуулж байна гэж шинжээчдийн 50.9 хувь, татвараас чөлөөлүүлэхэд үнийн дүнгийн 5-15 хувийг зарцуулж байна гэж шинжээчдийн 46.7 хувь нь тус тус дүгнэжээ.

Ажил, албан тушаалд ороход 1 саяас 10 сая төгрөг авлигад зарцуулж байна гэж шинжээчдийн 28.6 хувь нь, 10-20 сая төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 22.3 хувь нь, тусгай зөвшөөрөл авахад 1-10 сая төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 26.7 хувь нь, 10-20 сая төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 40.0 хувь нь, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгуулахад 500.0 мянгаас 10 сая төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 38.5 хувь нь, 10-20 сая, түүнээс дээш гэж шинжээчдийн 15.4 хувь нь, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгуулахад 500.0 мянгаас 10 сая төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 42.8 хувь нь, 10-20 сая, түүнээс дээш төгрөг зарцуулж байна гэж шинжээчдийн 21.4 хувь нь, ашиг сонирхолдоо нийцүүлсэн хууль, шийдвэр гаргуулахад 500.0 мянгаас 5 сая төгрөг

зарцуулдаг гэж шинжээчдийн 21.4 хувь нь, 10-20 сая, түүнээс дээш төгрөг зарцуулдаг гэж шинжээчдийн 21.4 хувь нь тус тус үнэлжээ.

Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж шинжээчдийн 60.0 хувь, сонгуулийн компани ажлын санхүүжилт, улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж шинжээчдийн 66.7 хувь, төрийн захиргааны байгууллагад шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох, төрийн байгууллагын менежмент, ил тод байдлыг сайжруулах шаардлагатай гэж шинжээчдийн 53.3 хувь, төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн давхардал, чирэгдлийг арилгах, АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай гэж шинжээчдийн 40.0 хувь, авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны шийтгэлийг чангатгах шаардлагатай гэж шинжээчдийн 50.0 хувь, шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдын ёс зүй, ажлын доголдлыг тооцож, хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай гэж шинжээчдийн 66.7 хувь нь, улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх шаардлагатай гэж шинжээчдийн 80.0 хувь нь тус тус үзжээ. Түүнчлэн “шударга ёсны сорил”-д төрийн албан хаагчдыг оруулж шалгадаг гадаад орны туршлагыг авч хэрэглэх, төрийн байгууллагын ил тод “тунгалаг” байдлыг сайжруулж, иргэдээс тавих хяналтыг хүчтэй болгох, төрийн албан тушаалтныг хянахдаа кодлох аргыг хэрэглэж хэн, хэзээ шалгасныг дээд албан тушаалтанмэдэж нөлөөлөх боломжгүй болгох, төсвийн байгууллагад хөндлөнгийн хяналтын байцаагчийг, түүний дотор гадаадын харьяат байцаагчийг ажиллуулах, шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг ил тод мэдээлдэг болгох, хувийн мөрдлөг хийх тухай хууль гаргах шаардлагатай гэж үзжээ.

АВЛИГЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл” шалгуур үзүүлэлтийг дүгнэсэн шинжээчдийн үнэлгээний дүнд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна:

1. УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн өнөөгийн тогтолцоог өөрчилж, сонгуулийн пропорционал буюу холимог тогтолцоонд шилжиж, сонгуулийн тойргийн явцуу ашиг сонирхлыг улс нийгмийн ашиг сонирхлоос дээгүүр тавих явдлаас сэргийлэх, сонгогчдын саналыг худалдан авах аливаа оролдлогыг хаах, сонгогдсон гишүүн бусдаас хараат байдалд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиудыг шинэчлэх,
2. Улс төрийн намын санхүүжилтын зарчмыг шударга ёсны шаардлагад нийцүүлэн өөрчлөх, үүнтэй холбогдуулан намын санхүүжилтэд төрөөс дэмжлэг, шалгуурыг тодорхой болгож, намаас сонгуульд нэр дэвшүүлэхдээ нэр дэвшигчээс хандив шаардаж байгаа одоогийн практикийг халах, намын дотоод ардчиллыг сайжруулах, үйл ажиллагааг шинэчлэх чиглэлээр Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн баталж мөрдүүлэх,
3. Захиргааны процессийн тухай хуулийг боловсруулж, захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуулийг хэрэглэх шийдвэр гаргах журам, шаардлагыг хуульчилж, албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломжийг хязгаарлан төрийн захиргааны байгууллагын ил тод, “тунгалаг” байдлыг хангах, олон нийтийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтуудыг тусган мөрдүүлэх,
4. Төрийн байгууллагад авлигыг нөхцөлдүүлж буй чиг үүргийн давхардал, олон

- шат дамжлагыг цөөрүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалт бүтцийн бүдүүвчийг боловсронгуй болгох,
5. Улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх,
 6. Төрийн албан хаагчдын шударга ёсны байдалд тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар судлах, “Шударга ёсны сорил” явуулах туршилт хийж, зохих эрх зүйн үндсийг бий болгох талаар асуудлыг судалж шийдвэрлэх,
 7. Төрийн ажил, албан тушаалд томилох тогтолцоог боловсронгуй болгож, энэ үйл ажиллагааны журмыг хуульчилж, хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг хаасан эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжилтэд тавих хяналтыг чангатгах,
 8. Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, уг ажиллагааны ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ авах,
 9. Хууль хяналтын байгууллагын ажилтны цалин, нийгмийн хангамжийг эрс сайжруулж, ажиллах нөхцлөөр бүрэн хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх,
 10. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн ёс зүй, үйл ажиллагааны доголдлыг тооцож хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх,
 11. Авлигын эсрэг Монгол улсын хуулийн хэрэгжилтийг дүгнэж, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийж, авлигын эсрэг үндэсний хууль тогтоомжийг авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх арга хэмжээ авах,
 12. Хуулийн хэрэгжилтэд тавих бүх талын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх зарчмыг хэрэгжүүлэх талаар бодит алхам хийх,
 13. Авлигачдад хүлээлгэх шийтгэлийг чангатгах чиглэлээр эрүүгийн болон захиргааны хариуцлагын хууль тогтоомжийг судалж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

ХАВСРАЛТ

ШИНЖЭЭЧДИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

2. Таны бодлоор авлига манай оронд хэр их дэлгэрсэн вэ?

1.Огт үгүй	
2.Бага зэрэг	6,7
3.Дунд	6,7
4. Их дэлгэрсэн	46,7
5. Маш их дэлгэрсэн	40,0

4. Авлига аль хүрээнд илүү дэлгэрсэн вэ?

1.	УИХ	3,71
2.	Яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага	4,29
3.	Бүх шатны ИТХ	3,77
4.	Нутгийн захиргааны байгууллага	4,14
5.	Шүүхийн байгууллага	4,20
6.	Прокурорын байгууллага	4,15
7.	Цагдаагийн байгууллага	4,29
8.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3,73
9.	Улс төрийн намууд	4,36
	Дундаж	4. 07

5. Авлигыг дараах хүчин зүйл хэр зэрэг нөхцөлдүүлж байна гэж Та үнэлэх вэ?

1	Сонгуулийн одоогийн тогтолцоо	4,14
2	Сонгуулийн санхүүжилтийн механизм	4,50
3	Намын санхүүжилтийн механизм	4,57
4	Намын томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4,71
5	УИХ-ийн хууль санаачлах, тогтоох үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,79
6	ИТХ-аас шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3,64
7	Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журам иж бүрэн хуульчлагдаагүй	4,00
8	Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	4,21
9	Шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3,64
10	Шүүгч, прокурор, мөрдөн байцаагчдын ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4,20
	Дундаж	4.13

6. Улс төрийн хүрээнд өөрт давуу тал, ашигтай байдлыг бий болгох хууль, бусад шийдвэр гаргуулах зорилготой дараах үйлдэл хэр түгээмэл байна гэж Та үнэлэх вэ?

1	Мөнгө хөрөнгө өгөх	4,07
2	Ашиг, орлогоо хуваахаар амлах	3,80
3	Аялал, жуулчлалын зардал даах	3,33
4	Сонгуулийн болон бусад арга хэмжээг санхүүжүүлэх	4,40
5	Бэлэг сэлт өгөх	3,73
	Дундаж	3.87

7. Улс төрч өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцох нөлөөлөх дараах хэлбэр хэр тархсан байна гэж Та үнэлэх вэ?

1	Дарамт шахалт үзүүлэх	3,64
2	Шан харамж нэхэх	3,43
3	Бусдын хооронд зуучлах	3,79
	Дундаж	3,62

8. Ингэхдээ улс төрчид ямар байгууллагын үйл ажиллагаанд илүү нөлөөлж байна гэж Та үнэлэх вэ?

1	Төрийн үйлчилгээ давуу байдлаар хүртэх	4,00
2	Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4,57
3	Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3,47
4	Төрийн захиргааны байгуулаллага, албан тушаалтантай холбоо тогтоох	4,00
5	Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3,67
6	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4,00
7	Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3,79
8	Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлөх	4,00
9	Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4,79
	Дундаж	4,03

9. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ямар доголдол нь авлигыг илүүтэй нөхцөлдүүлж байна вэ?

1	Хүнд суртал	4,47
2	Олон шат дамжлага, давхардал	4,33
3	Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй	3,73
4	Шийдвэр гаргах ажиллагааны тунгалаг байдал дутмаг	4,67
5	Албан тушаалтны үзэмжээр асуудал шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй	4,86

6	Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй	4,53
7	Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4,40
8	Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлэн захирагчдын хяналт сул	4,00
9	Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн халамж хангалтгүй	3,47
10	Төрийн албан хаагчийн ёс зүй, чадавхи дутагдалтай	4,27
	Дундаж	4.27

10. Төрийн захиргааны байгууллагын ямар үйл ажиллагаанд авлига илүү байна гэж Та үнэлэх вэ?

1	Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4,27
2	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4,80
3	Өмч хувьчлал	3,87
4	Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа	4,80
5	Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4,13
6	Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3,80
7	Ажил, албан тушаалд томилох	4,53
	Дундаж	4.31

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН
ИНДЕКСИЙН 2009 ОНЫ
ТООЦООНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**



МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2009 ОНЫ ТООЦООНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

1. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсын Авлигын индекс нь авлига хэмээх гэмт явдлын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц бөгөөд уг үзэгдлийн орон зайн болон цаг хугацааны өөрчлөлтийг илтгэн харуулна.

Өөрөөр хэлбэл, авлигын индекс нь:

- Авлигын цар хүрээ буюу авлигын хамрах хүрээ, эдийн засгийн болон нийгмийн үр дагавар
- Авлигын хэлбэр буюу авлига хэмээх үзэгдэл илрэн гарч буй нөхцөл байдал
- Авлигын шалтгаан буюу авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлс зэрэг үзүүлэлтүүдээр авлига цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг болон төрийн захиргааны байгууллагуудын хувьд ямар ялгаатай байгааг харуулах юм.

Монгол Улсын Авлигын индексийн онцлог юу вэ?

Монгол Улсын Авлигын индекс (цаашид авлигын индекс) нь Транспэрэнси интернэшнл олон улсын байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (CPI) болон бусад олон улсын байгууллагаас гаргадаг авлигын хэмжих үзүүлэлтүүдтэй харьцуулахад дараахь онцлогтой.

- ✓ Авлигыг нэгдсэн тоон үзүүлэлтээр, үндэсний түвшинд хэмжин гаргаж буй анхны тохиолдол
- ✓ Дан ганц төсөөллийн үзүүлэлтэд тулгуурлаагүй, авлигын талаарх төсөөлөл болон бодит тоо мэдээлэл дээр үндэслэн тооцогдсон
- ✓ Авлига хэмээх үзэгдлийг цар хүрээ, хэлбэр, шалтгаан гэсэн гурван талаас нь авч үзсэн зэрэг болно.

2. АВЛИГЫН ИНДЕКС ТООЦОХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Авлигын индексийг дараахь үндэслэлээр тооцож байгаа болно:

- Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйл “Авлигатай тэмцэх газрын чиг үүрэг, бүрэн эрх”, 18.1. “Авлигатай тэмцэх газар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ”: 18.1.3. “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индекс гарган олон нийтэд мэдээлэх”
- Монгол Улсын Их хурлын 2008 оны 13 дугаар тогтоол: Мянганы хөгжлийн 9 дэх зорилго: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, 24 дүгээр зорилт: Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх, 65 дахь шалгуур үзүүлэлт: Авлигын индекс

Авлигын индексийг дараахь зорилгоор тооцон гаргасан болно:

- ❖ Авлига хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлох;
- ❖ Авлигатай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх;
- ❖ Авлигын цар хүрээ, хэлбэрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон, цаашдын бодлого хөтөлбөрийг боловсруулах;
- ❖ Салбарын яам, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах

байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр өгөөж, авлигад өртөх эрсдлийг тодорхойлж харьцуулан үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийх;


- ❖ Төрийн, олон улсын, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагууд, судлаачид, олон нийтийг өргөн хүрээтэй мэдээллээр хангах.

3. АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦСОН АРГАЗҮЙ

Авлигын индексийн тоон үзүүлэлт нь авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн арифметикийн дундаж байна. Авлигын индекс нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үзнэ.

Авлигын цар хүрээний үзүүлэлтүүдэд дараахь үзүүлэлтийг авч үзсэн. Үүнд:

1. Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт буюу авлига түгээмэл гэж үзсэн олон нийт, шинжээчдийн эзлэх хувийн жин;
2. Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт буюу авлигын бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлд эзлэх хувь;
3. Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ буюу тодорхой төрлийн хэлцлийн үнийн дүн дэх авлига, хээл хахуулийн эзлэх хувь;
4. Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад төлсөн хээл хахуулийн өрхийн орлогод эзлэх хувь.



Авлигын хэлбэрийн үзүүлэлтүүдэд дараахь үзүүлэлтүүдийг авч үзсэн. Үүнд:

1. Давхар объектойд авлигын гэмт хэргийн эзлэх хувь;
2. Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь;
3. Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь;
4. Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт;
5. Шунахайн сэдэлттэй авлигын гэмт хэргийн эзлэх хувь;

4. АВЛИГЫН ИНДЕКСИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮНИЙГ ТООЦСОН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр буюу аймаг, нийслэл, тэдгээрийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн нэгж, орон нутаг дахь салбарын авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг харуулах тоон үзүүлэлт юм.

Авлигын индексийг тооцох чиглэлээр дараахь судалгааг явуулж, холбогдох тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.


- “Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгаа”-г нийт 6001 иргэн, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчийг хамруулан явуулсан.
- “Авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа”-г салбар бүрийг

- төлөөлсөн нийт 350 шинжээчийг хамруулан явуулсан.
- Төрийн байгууллагын авлигын эрсдлийн өөрийн үнэлгээний судалгаа буюу авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлангийн судалгааг нийт төрийн захиргааны төв байгууллагуудыг хамруулан явуулж үр дүнг нэгтгэн гаргасан.
- Баримтын судалгааг сүүлийн 2 жилийн буюу 2008-2009 оны авлигын гэмт хэрэг болон бусад тоо мэдээллийг хамруулан хийсэн.

5. АВЛИГЫН ИНДЕКСИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН

Дээр дурдсан судалгааны үр дүн, тоо мэдээлэлд үндэслэн батлагдсан аргачлалын дагуу түүнд дурдсан үзүүлэлтүүдээр авлигын индексийг үндэсний түвшинд тооцоход 0.64 гарсан. Цаашид авлигын индексийг хоёр жил дутам тооцож түүний өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тооцож үнэлэлт дүгнэлт өгөхөд индексийн ач холбогдол оршиж байгаа юм. Авлигын индексийн бүрдүүлэгч авлигын авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт 0.74, авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.54 гарч байна (Зураг 1).

Зураг 1. Авлигын индекс, түүнийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийн утга



Авлигын цар хүрээний үзүүлэлтүүд тус бүрээр нь авч үзвэл, авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 0.75 гарч байна (Хүснэгт 1). Өөрөөр хэлбэл, олон нийт, шинжээчдийн дунджаар тэдний 75.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж үзжээ.

Хүснэгт 1. Авлигын цар хүрээний үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Утга
Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт	0.75
Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт	0.03
Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ	0.10
Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ	0.15
Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт	0.74

Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 0.03 гарч байгаа нь улсын нэгдсэн төсвийн жилийн зарлагын 2.7 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас учирч байна.

Түүнчлэн, шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ 0.10 гарч байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалт буюу тендерт оролцох, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх зэрэг хэлцлүүдийн үнийн дүнгийн дунджаар 10.4 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө авлига, хээл хахууль байдлаар зарцуулагддаг гэж шинжээчид үзсэн байна. Үүний дотор төрийн байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдахын тулд дунджаар үнийн дүнгийн 10.1 хувийг, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалт буюу тендерт ялахын тулд гэрээний үнийн дүнгийн 10.45 хувийг, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхийн тулд тэдгээрийн дүнгийн 9.38 хувийг, татвараас чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэхийн тулд төлөх ёстой татварын дүнгийн дунджаар 11.5 хувийг авлига, хээл хахуульд зориулан зарцуулагддаг байна.

Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 13.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан бөгөөд тэд өрхийн жилийн төсвийнхөө дунджаар 14.6 хувьтай тэнцэх буюу 240.8 мянган төгрөгийн хээл хахуулийг төрийн албан хаагчдад өгчээ.

Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.54 гарч байгаа бөгөөд тэдгээрийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийн хувьд давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.31, хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.30, зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь 0.42, авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт 0.37, авлигын гэмт хэргийн шунахай сэдэлтийн үзүүлэлт 0.91 гарчээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Авлигын цар хүрээний үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Утга
Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.31
Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.30
Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.42
Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт	0.37
Авлигын гэмт хэргийн шунахай сэдэлтийн үзүүлэлт	0.91
Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт	0.54

6. АВЛИГЫН ИНДЕКСИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН, САЛБАРААР

Авлигын индексийг салбараар тооцохдоо “Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгаа”-ны “Төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаа”-ны үр дүн болон “Шинжээчдийн төсөөллийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн тооцсон. Өөрөөр хэлбэл, тухайн салбарт ажиллаж буй төрийн албан хаагчид, салбарын талаар мэдлэг, мэдээлэлтэй, олон жил ажилласан төрийн албан хаагчид, тус салбартай хамтран ажилладаг, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй олон улсын байгууллагын ажилтнууд, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдээс бүрдсэн шинжээчдийн үнэлгээгээр авлигын индексийн тооцсон.

Салбарын авлигын индекс-ийг үндсэндээ салбарын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ гэж энгийн байдлаар ойлгож болно. Салбарын авлигын индексийг тооцохдоо төрийн албан хаагчид, шинжээчдийн үнэлгээ төсөөлөлд үндэслэн тооцсон бөгөөд дараахь 14 төрлийн үзүүлэлтээр тооцсон. Үүнд:

1.	Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь;
2.	Тухайн салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус байна гэж үнэлсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь;
3.	Тухайн салбарын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь;
4.	Салбарын удирдах албан тушаалтнуудын дунд ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь;
5.	Салбарын бүтэц тогтолцоо сайн засаглалын үндсэн шалгууруудад огт нийцдэггүй гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь (Сайн засаглалын үндсэн шалгуурууд гэдэгт ил тод байдал, хариуцлага тооцдог механизм, шударга байдлын шалгууруудыг авч үзсэн болно);
6.	Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь ажилтан, албан хаагчдад байнга нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
7.	Байгууллагын удирдлагын шийдвэр нь ажилтан, албан хаагчдад байнга нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
8.	Байгууллагын үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
9.	Удирдлагаас өгч буй шагнал урамшуулал нь бодитой бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
10.	Салбарын албан хаагчид нь хүнд суртал байнга гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
11.	Салбарын албан хаагчид нь байнга хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
12.	Салбарын албан хаагчид нь байнга ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь;
13.	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн төрийн албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчид, дээд албан тушаалтнууд, найз нөхөд, танил хүмүүс, харилцагч байгууллагынхан, хамт ажиллагчид, улс төрийн нам бүлгийн гишүүд, бизнес эрхлэгчид, ах дүү хамаатан саднуудын зүгээс хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь;
14.	Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн төрийн албан хаагчид хээл хахууль өгөх гэсэн оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь.

Эдгээр үзүүлэлтийг тооцож гаргасны дараа тэдгээрийн дунджийг 100-гаас хасч 100-д хувааж тухайн салбарын авлигын индексийг тооцсон (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Авлигын индекс, салбараар

ДД	Салбарын ангилал /Үнэлгээ	Авлигын индекс
1	Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын	0.71
2	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын	0.69
3	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын	0.65
4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын	0.64
5	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын	0.64
6	Шадар сайдын эрхлэх асуудлын	0.63
7	Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын	0.63
8	Сангийн сайдын эрхлэх асуудлын	0.63
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын	0.63
10	Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын	0.61
11	Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын	0.61
12	Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын	0.47

7. АВЛИГЫН ИНДЕКСИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Авлигын индексийг аймаг, нийслэлээр тооцохдоо Авлигын талаарх талаарх олон нийтийн төсөөллийн судалгааны Иргэд, Төрийн албан хаагч, Бизнес эрхлэгчдийн судалгааны үр дүн болон Шинжээчдийн төсөөллийн судалгааны үр дүнд үндэслэн тооцсон. Аймаг, нийслэлээр авлигын индексийг тооцохдоо тухайн аймаг, нийслэл дэх нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг бүх түвшинд нь авч үзсэн болно.

Тухайн аймаг, нийслэлийн авлигын индекс-ийг үндсэндээ тухайн аймаг, нийслэл дэх нутгийн захиргааны байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ гэж энгийн байдлаар ойлгож болно. Аймаг, нийслэлийн авлигын индексийг тооцохдоо дараахь 12 төрлийн үзүүлэлтээр тооцсон. Үүнд:

1.	Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн олон нийт, шинжээчдийн эзлэх хувь
2.	Тухайн салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус байна гэж үнэлсэн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын төрийн албан хаагчид болон шинжээчдийн эзлэх хувь
3.	Тухайн аймаг, нийслэлийн удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь
4.	Тухайн аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтнуудын дунд ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь
5.	Нутгийн захиргааны байгууллагын бүтэц тогтолцоо сайн засаглалын үндсэн шалгууруудад огт нийцдэггүй гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь (Сайн засаглалын үндсэн шалгуурууд гэдэгт ил тод байдал, хариуцлага тооцдог механизм, шударга байдлын шалгууруудыг авч үзсэн болно)
6.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид улс төрийн нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
7.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид байнга ах дүү, танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
8.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид байнга хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
9.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид байнга хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
10.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид байнга ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
11.	Тухайн аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд, албан хаагчид байнга иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь
12.	Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн иргэдийн эзлэх хувь

Авлигын индексийг аймаг, нийслэлээр тооцож үзэхэд 0.47-0.71 хооронд гарч байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Авлигын индекс, аймаг нийслэлээр

ДД	Аймаг, нийслэл	Авлигын индекс	ДД	Аймаг, нийслэл	Авлигын индекс
1	Төв	0.71	12	Говь-Алтай	0.59
2	Говьсүмбэр	0.67	13	Сүхбаатар	0.58
3	Дундговь	0.66	14	Баянхонгор	0.58
4	Дорноговь	0.66	15	Хэнтий	0.56
5	Булган	0.66	16	Хөвсгөл	0.55
6	Завхан	0.64	17	Өмнөговь	0.55
7	Сэлэнгэ	0.64	18	Баян-Өлгий	0.54

8	Улаанбаатар	0.60	19	Увс	0.54
9	Өвөрхангай	0.60	20	Орхон	0.49
10	Дархан-Уул	0.60	21	Ховд	0.49
11	Дорнод	0.59	22	Архангай	0.47

8. АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНААС ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Төр засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд залуу хүмүүс илүү шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд авлига Монгол Улсад ихээхэн түгээмэл гэж үзэж байгаа залуучуудын эзлэх хувь харьцангуй өндөр байгаагаас залуучууд авлигатай тэмцэх, түүнийг үл тэвчих хүсэл эрмэлзэл илүү өндөр байна гэж дүгнэж байна. *Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шинэ залуу үе оюутан, сурагчдаас эхлэн хийх нь илүү чухал үр дүнтэй байх юм.*

Судалгаанд оролцогчид Монгол Улсад авлига хэр түгээмэл үзэгдэл гэж та үзэж байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 79.4 хувь нь түгээмэл гэж үзсэн бол, иргэд, бизнес эрхлэгчдээс танай аймаг, нийслэлд авлига хэр түгээмэл гэж үзэж байна гэсэн асуултыг тавихад дунджаар 51.6 хувь нь, төрийн албан хаагчдаас таны ажиллаж буй салбарт авлига хэр түгээмэл гэж үзэж байна вэ гэсэн асуултыг тавихад дунджаар 35.7 хувь нь түгээмэл гэж үзжээ. *Энэхүү зөрүүг иргэд, бизнес эрхлэгчид дээд түвшинд тухайлбал, төрийн захиргааны төв байгууллагад болон улс төр, хууль хяналтын хүрээнд авлига ихээхэн тархсан гэж үзэж байгаа болон төрийн албан хаагчид улс төрийн хүрээнд авлига түгээмэл байна гэж үзэж байгаатай холбон тайлбарлаж болох юм.* Үүнийг батлах өөр нэг жишээ нь Монгол Улсын тодорхой түвшнийхний дундах авлигын тархцын талаар асуухад шүүхийг судалгаанд оролцогчдын 66.8 хувь нь ихээхэн авлигад автсан гэж үзсэн бол, улс төрийн намуудыг 58.4 хувь нь, Улсын Их Хурлыг 55.0 хувь нь, төрийн албан хаагчдыг 49.8 хувь нь авлигад ихээхэн автсан гэж үзэж байгаа явдал юм. *Түүнчлэн удирдлагын түвшин доошлох тусам тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь нэмэгдэх хандлага байдаг байна.*

Улс төрийн нөлөөнд автаж асуудалд хандах, хүнд суртал гаргах, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, ажилдаа хариуцлагагүй хандах, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх, албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх зэрэг нөхцөл байдал тухайн байгууллагад ямар нэг байдлаар байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувийн жинг хос хосоор нь салбараар авч үзэхэд хүнд суртал гаргадаг болон ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг нь хоорондоо (хамаарлын хүч нь 0.91), хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг болон ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг нь хоорондоо (хамаарлын хүч нь 0.91), иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах болон албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх хоорондоо (хамаарлын хүч нь 0.92), хүнд суртал гаргадаг болон хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг нь хоорондоо (хамаарлын хүч нь 0.89) хүчтэй хамааралтай болох нь харагдаж байна. *Тэгэхээр хүнд суртал гаргах нь хээл хахууль оршин байхын үндэс, албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх нь иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандахын үндэс болдог байна.*

Судалгааны үр дүнгээс харахад төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх санаачлагыг голчлон иргэд, олон нийтийн зүгээс эхэлж гаргадаг байна. *Иргэд олон нийт төрийн үйлчилгээний талаархи мэдлэг, мэдээлэл муутай байдаг, тухайн асуудлыг дүрэм журмынх нь дагуу шийдвэрлүүлэх шат дарааллыг төдийлөн*

сайн мэддэггүйгээс хээл хахууль өгч асуудлаа шийдвэрлүүлдэг байна. Төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл буюу дүрэм журам, тавигдах шаардлага, асуудлыг шийдвэрлэх дараалал зэрэг мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар нээлттэй танилцуулах нь хүнд суртал, хээл хахуулиас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болох юм.

Тухайн салбарын авлигын тархцын түвшинд хариуцлагагүй байдал, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх байдал, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдал, хүнд суртал гаргах байдал, албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх байдал, салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус байдал, удирдлагаас өгсөн шагнал урамшуулал, томилгоо нь бодитой бус байх зэрэг үзүүлэлтүүд шууд хүчтэй нөлөөтэй болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Эндээс тухайн салбар дахь авлигын түвшин өндөр байгаа нь аливаа салбарын үйл ажиллагаа нь улс төрийн намын нөлөөнөөс ихээхэн хамааралтай, салбарын томилгоог улс төрийн намын нөлөөгөөр мэдлэг чадвар дутмаг албан хаагчдыг томилдог, тэр хүмүүс нь ажилдаа хариуцлагагүй хандаж, хүнд суртал гарган, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх хандлагатай, тэр хэмжээгээр салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашиггүй болж, шагнал урамшуулал, томилгоо нь бодитой бус байдаг нь авлигын түвшин өсөх шалтгаан болж байна гэж дүгнэхээр байна.

Авлигын талаарх бизнес эрхлэгчдийн төсөөллийн 2009 оны судалгааны дүнгээс төр, бизнес хоёрын зохисгүй холбоо хамаарал буюу бизнес нь төрийн албан хаагчид, улс төрчдийг дэмждэг, тэр хэмжээгээр эргээд ашиг хонжоо олдог тухай хэд хэдэн дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадтай хамтарсан аж ахуйн нэгжүүдийн хувьд төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагад хандив, дэмжлэг үзүүлэх хандлага илүү байдаг байна. Энэ хэмжээгээр хэмжээгээр хээл хахууль, авлигын асуудал цаана нь нуугдаж байх магадлалтай.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 3.9 хувь нь улс төрийн намд тусламж дэмжлэг үзүүлсэн гэж хариулсан нь сонирхол татахуйц үр дүн юм. Улс төрийн нам, улс төрчдийг төрийн өмчийн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр тусалж дэмждэг, үүгээрээ эргээд тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хэвээр үлдэх сонирхол байдаг нь эндээс харагдаж байна. Тэгэхээр төрийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцийг оновчтой байдлаар, дээрх нөхцөл байдлаас ангид байх нөхцлийг хангаж бүрдүүлэх нь зүйтэй юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгжүүдийн гуравны нэг нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан бол голлон экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн дөрөвний нэг нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд Монгол Улсад үйл ажиллагаа явуулахдаа төрийн албан хаагчид, улс төрчдөд хээл хахууль өгөх нь илүү түгээмэл байгаад дүгнэлт хийж, анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй. Түүнчлэн уул уурхай, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх хандлага илүү байдаг байна.

9. АВЛИГЫН ТАЛААРХ ШИНЖЭЭЧДИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНААС ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Авлигын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулах Авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2009 оны судалгаанд салбарыг үнэлэх шинжээчдээр тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг дахь салбар нэгжүүдийн төлөөллөөс гадна тухайн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаачид зэрэг олон төлөөллийг оролцуулсан нь салбар дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан, салбарын удирдлагын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх чухал ач холбогдолтой иэхээхэн хэмжээний мэдээллийг цуглуулсан чухал судалгаа боллоо.

Тухайн салбарын удирдах дээд байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөөтэй байсан хэдий ч шинжээчид тухайн салбарт тухайн салбарт энэ төрлийн төлөвлөгөө байддаггүй гэж үнэлсэн байгаа нь стратеги төлөвлөгөөгөө сурталчилдаггүй, энэхүү төлөвлөгөө нь тунхаглалын шинж чанартай, нэр төдий, түүнчлэн доод шатны байгууллагууддаа хүрдэггүй гэж дүгнэж болох юм. Салбарын авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгааныг шинжээчид төлөвлөгөө нь нэр төдий, цаасан дээр байдаг, түүнийг ажил хэрэг болгох хүсэл эрмэлзэл удирдлагуудад дутдаг, төлөвлөгөөний зорилго чиглэлийг сайтар сурталчилж үр дүнг танилцуулдаггүй, үр дүнг нь үнэлэх шалгуур байдаггүй, хариуцах эзэн тодорхойгүй, хөрөнгө мөнгө төсөвлөдөггүй, албан хаагчдаас санал авдаггүй, бодит боломжоос давсан зүйлсийг төлөвлөдөг, удирдлагын зүгээс дэмжлэг муутай байдаг, стратеги төлөвлөгөө нь нэгждээ хүрдэггүй, хэрэгжүүлэх арга зам нь буруу байдгаас нь уг төлөвлөгөө нь үр дүнд хүрдэггүй гэж үзжээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар үнэлж буй салбарын удирдах албан тушаалтнуудын дотор ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзэж байгаа бөгөөд түүнчлэн ашиг сонирхлоо зөрчлөө мэдүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Салбарын болон байгууллагын ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэмд авлига, хээл хахуультай холбоотой заалт оруулах, бэлэг дурсгал, давхар ажил эрхлэлт, харилцагч байгууллага, хувь хүмүүстэй хувийн харилцаа тогтоох зэрэг асуудлуудыг зохицуулах, төрийн байгууллагуудаас аж ахуйн нэгж бусад талуудтай байгуулж буй гэрээнд авлигатай холбоотой зүйл заалт оруулах зэрэг асуудлууд төрийн байгууллагууд нь хангалтгүй байгааг судалгааны мэдээлэл нотлон харууллаа. Энэ бүхэн нь авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг зааж өгч байна гэж үзэж байна.

10. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

АТГ байгуулагдсанаас хойш Авлигын эсрэг хуульд заасны дагуу холбогдох этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулж ажиллаж ирснээр хуульд заасан этгээдүүд хөрөнгө, орлогоо хуулийн хугацаанд бүрэн гаргаж хэвшсэн нь авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олсон томоохон амжилт юм. Цаашид хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааны хамрах хүрээ, хөрөнгө орлогын мэдүүлэгийн үнэн зөв байдалд тавих хяналт, шалгалт болон түүнд хийх дүн шинжилгээний ажилд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт яам, агентлаг, салбар нэгжийн

түвшинд харилцан адилгүй, түүнчлэн хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд бодитой, үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

11. АУДИТЫН ТАЙЛАНД ҮНДЭСЛЭН ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, авлига үүсэх дараахь нөхцөлүүд байгааг анхааралдаа авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналт шалгалт хангалтгүй, зарим сангууд удирдах болон хяналтын зөвлөлөгүй байсан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх зүйн зохицуулалт тодорхой бус байгаа нь төлбөр, хураамж болон сангийн хөрөнгөөр зохион байгуулсан арга хэмжээний орлогыг санд төвлөрүүлэхгүй байх, авлига барагдуулах ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, зориулалт бусаар зарцуулахад хүргэж байна.
2. Төрийн байгууллагуудын уялдаа, холбоо хангалтгүй, аливаа үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд тулгуурлан хийдэггүй нь бодит гүйцэтгэлээс давсан санхүүжилт хийгдэж, нөгөө талаар зарцуулагдаагүй үлдэгдлийг бүртгэх, тайлагнах, төсөвт эргэн төвлөрүүлэх зохицуулалт хангалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, ашиглах нөхцлийг бүрдүүлж байгааг ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, Гэр бүл, хүүхдийг дэмжин төсвөөс олгож буй хөрөнгийн зарцуулалт, үйлчилгээний зохион байгуулалтад хийсэн аудитын дүн харуулж байна.
3. Засгийн газрын агентлаг, төвүүдийн төлөвлөлт бодитой бус, түүнд тавих хяналт сул байгаагаас орлогыг бага төлөвлөж өндөр хувиар давуулж биелүүлсэн болох, зардлыг их төлөвлөж хэмнэсэн болж харагдаж, давуулж биелүүлсэн орлого, хэмнэгдсэн зардлыг байгууллагыг бхжүүлэх, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, машин техник худалдан авах зэрэгт зарцуулж байгаа нь үүнтэй зэрэгцээд байгууллагын дарга, албан тушаалтнууд хяналтгүйгээр зарцуулах нөхцлийг бүрдүүлж байна. Яамдын зарим зардлыг агентлаг, төв санхүүжүүлдэг дутагдал байсаар байна.
4. Эрүүл мэндийн даатгалын сан болон бусад сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хэрхэн байршуулах хууль эрхзүйн акт байхгүй, газрын дарга, нягтлан бодогч нарын мэдлийн асуудал болсон нь чөлөөт үлдэгдлийг хуульд заасан зориулалтаас өөр зүйлд зарцуулахад хүргэж байна.
5. Тендер зарлах хугацааг оройтуулснаас зарим худалдан авах ажиллагаа зарлагдаж амжихгүй, он дамжин сунжрах, тендер шалгаруулах журмыг өөрчлөн зарлах зэрэг тохиолдол гарч байгаа нь худалдан авах ажиллагаанд авлига үүсэх нөхцөл болж байна.
6. Тендерийн урилга, шалгаруулалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх тухай хуулийн заалт хангалтгүй хэрэгжиж байгаа нь тендерийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, тэгш өрсөлдөх зарчмаар явагдах боломжийг хааж байна.
7. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах аргыг буруу сонгож, шууд гэрээ байгуулсан зөрчил төрийн байгууллагуудад нийтлэг байна.
8. Гэрээ байгуулсан байдал, түүний хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд

хяналт тавих, дүгнэлт хийх ажил хангалтгүй байгаагаас гэрээний хэрэгжилт жигд бус, гэрээний нөхцөл, эрх үүрэг хэт ерөнхий тусгагдснаас үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож чадахгүйд хүрч байна.

9. Тендерт оролцож байгаа аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн сан бий болгож, өмнө нь үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийн жагсаалт гарган дараагийн тендерт оролцох эрхийг хасах, хариуцлага тооцох ажил хангалтгүй байгаа нь гэрээний үүргээ биелүүлдэггүй, авлига хээл хахуулийн асуудалд холбогдож байсан аж ахуйн нэгж тендерт дахин оролцох боломжийг олгож байна.

Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитаар 1908.1 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн нь 2008 оны улсын нэгдсэн төсвийн зарлагын 77.5 хувийг эзэлж байна. Энэхүү үзүүлэлт нь төсөвт байгууллагууд болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн бүртгэл, хяналт шалгалтын үйл ажиллагаа ихээхэн хангалтгүй байгааг харуулж байна. Санхүүгийн бүртгэл, хяналт шалгалтын үйл ажиллагаа хангалтгүй байх нь төсвийн хөрөнгийг хяналтгүй, зориулалтын бусаар зарцуулах, ашиглах нөхцлийг бүрдүүлж байна.

12. АВЛИГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ДАГАВАР

Авлигын индексийг тооцохтой холбоотойгоор цуглуулсан тоо мэдээлэлд үндэслэн авлигын эдийн засгийн үр дагаврыг нэгтгэн дүгнэхэд дараахь байдалтай байна.

1. Бүртгэгдсэн албан тушаалын гэмт хэргүүдийн дүнгээр авлигын гэмт хэргийн улмаас 66.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.7 хувьтай тэнцэж байна. Энэ хэмжээний хөрөнгөөр хөдөөгийн суманд 320 хүүхдийн суудалтай 95 дунд сургуулийг барьж байгуулах боломжтой байлаа. Энэ бол зөвхөн бүртгэгдэж тогтоогдсон хэсэг нь л юм.
2. Монгол Улсын нийт 677.8 мянган өрхийн 13.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад ямар нэг байдлаар хээл хахууль өгсөн, нэг өрх дунджаар 240.8 мянган төгрөгийг хээл хахуульд өгсөн гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан өрхийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн хэмжээг тооцож үзэхэд 21.7 тэрбум төгрөг болж байна. Энэ хэмжээний мөнгөөр Монгол улсын 4921 дундаж амьдралтай өрх бүтэн жилийн өрхийн хэрэгцээгээ хангах байлаа.
3. Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн 10.11 хувь нь авлига, хээл хахуульд зарцуулагддаг байна. Энэ дүнгээр ядуурлыг бууруулах, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, агаарын бохирдлыг бууруулах гэх зэрэг төсөл, хөтөлбөрийн төсөв танагдан, очих ёстой эзэндээ хүрдэг байна.
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад нийт гэрээний үнийн дүнгийн 10.45 хувь нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагддаг гэж шинжээчид дүгнэжээ. Тухайлбал, 58.5 км хатуу хучилттай замыг 1100.0 сая төгрөгөөр барьж байгуулах байсан гэж үзвэл 115.0 сая төгрөг нь авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулагдаж, энэ хэмжээгээр замыг барьж байгуулахад шаардлагатай материалын зардал танагдаж, замын ажлын чанарт нөлөөлдөг байна. Үндэсний аудитын газраас гаргасан 2008 онд нийт 613.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий тендер зарлагдсан гэсэн мэдээлэлд үндэслэн тооцож үзэхэд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

- бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хөрөнгөнөөс 64.1 тэрбум төгрөгийг авлига, хээл хахуультай холбоотойгоор зарцуулсан гэж үзэж болох юм.
5. Шинжээчдийн үзэж байгаагаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд татварт төлөх ёстой үнийн дүнгийн дунджаар 11.5 хувийг авлига, хээл хахууль хэлбэрээр зарцуулдаг байна. Хичнээн төгрөгийн татварын орлого буюу улсын төсөвт төвлөрөх ёстой хөрөнгө ийм байдлаар албан тушаалтны халаасыг түнтийлгэснийг тооцох боломжгүй юм.

13. СУДАЛГААНЫ ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ

- Хэрэв та бүхэн судалгааны талаарх илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
- “Авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан” Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, Улаанбаатар хот, 2010 он.
 - Авлигатай тэмцэх газрын вэб хуудас: <http://www.iaac.mn/index.php?cid=106>

Авлигын индекс тооцох аргачлалтай танилцахыг хүсвэл

- Авлигатай тэмцэх газрын вэб хуудас: http://www.iaac.mn/pdf/ssh/avligiin_indexiig_tootsoh_argachlal.pdf
- Үндэсний статистикийн хорооны вэб хуудас: <http://www.statis.mn/methodology/Avilgaliin%20index%20tootsoh.pdf> зэрэг эх үүсвэр дэлгэрэнгүй байдлаар авч үзэж болно.

Авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнг дараахь эх үүсвэрээс авч үзэж болно.

- “Шударга ёс” –Мэдээлэл, онол, арга зүйн улирал тутмын цуврал. 2010 он №1 (2) 65-73 дахь тал.
- “Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2009”, Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар хот, 2010 он.
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын мэдээллийн сангийн вэб хуудас: <http://www.devinfo.mn/>

Судалгааны үр дүн, аргачлал арга зүйн талаар асуух тодруулах болон санал солилцохыг хүсвэл дараахь хаягаар хандана уу?

Шуудангийн хаяг: Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба, 5-р хороолол Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот 14250

Харилцах утас: (976)-70112565, (976)-70113565

Электрон шуудан: gbbatzorig@iaac.mn, davaasuren@iaac.mn

**УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
2009 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



“УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХИ ТӨСӨӨЛӨЛ 2009” СУДАЛГААНЫ ДҮН

1. Үндэслэл, судалгааны зорилго

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газар тооцож мэдээлэхээр үүрэг болсон. Тус чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төслийн багтай хамтран 2 дахь жилдээ тус судалгааг явуулж байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа /цаашид судалгаа гээ/ Монголын нийгмийн дээд түвшин дэх “том” (grand) хэмээн нэрлэгддэг авлигыг хэмжих зорилготой.

2. Судалгааны аргачлал

Судалгаанд 26 шинжээч оролцлоо. Шинжээчдийн талаарх болон тэдний өгсөн мэдээллийн нууцыг чандлан хадгалж, судалгаагаар цуглуулсан мэдээллийг зөвхөн нэгдсэн дүн, дүгнэлт гаргахад ашигласан.

Шинжээчдийг ажлын туршлага, улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигатай холбоотой чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийх чадвар, хууль хяналтын байгууллагын болон улс төрийн үйл ажиллагаанд оролцдог байдал, мэргэшлийн үр чадвар зэргийг харгалзан сонгосон.

Шинжээчдийн 30.7 хувь нь яам, агентлагийн албан тушаалтан, 23.0 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, 19.2 хувь нь УИХ-ын гишүүн, төрийн өндөр албан тушаалтан, 19.2 хувь нь улс төр, хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаач, 11.5 хувь нь олон улсын болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагын ажилтан байлаа. Судалгаанд оролцсон шинжээчид нь насны хувьд 35-64 насны, 77.0 хувь эрэгтэй, 23.0 хувь нь эмэгтэй байв.

Үнэлгээг 5 онооны эрэмбээр гаргаж (Тухайлбал: 1- огт үгүй /авлига байхгүй/, 5-маш их /авлига маш их дэлгэрсэн/) дундаж үзүүлэлтээр тооцсон болно.

АТГ-ын Судалгаа шинжилгээний алба, Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төслийн багтай хамтран санал асуулгын хуудсыг “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл 2008” судалгааны санал асуулгын хуудсанд тулгуурлан сайжруулан боловсруулсан.

Шинжээчдээр үнэлгээ хийлгэхдээ үнэлж буй үзэгдлээ нэгэн утгаар ойлгож дүгнэх боломж олгох үүднээс “Авлига гэж албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил” гэсэн Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн тодорхойлолтыг тусгайлан тайлбарлаж өгсөн. Түүнчлэн *Улс төрийн хүрээ гэдэгт* бүх шатны сонгуулийн үр дүнд байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцаа, *Хууль хяналтын байгууллагын хүрээг* шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг тус тус хамруулсан. Хууль хяналтын байгууллагын хүрээг дэлгэрүүлэн асуулгыг нарийвчлан авах гэсэн зөвлөгөө өгснийг дараагийн судалгаанд харгалзан үзэж арга зүйг улам боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа (МХЗ-1)- ны мэдээлэл нь 162 хувьсагчтай, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын

талаархи төсөөллийн судалгаа (МХЗ-2)-ны мэдээлэл нь 128 хувьсагчтай байсан.


Мэдээллийг SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) програм ашиглан боловсруулсан. Мэдээллийн санг бэлтгэсний дараа мэдээллийн баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж тайлан бэлтгэхэд ашигласан.

3. Ерөнхий үнэлгээ

Тус судалгаагаар авлига үүсэх эрсдэл, авлигач зан үйл гаргаж буй зарим хүмүүсийн үйл ажиллагааны улмаас нийгэмд гарч байгаа өөрчлөлтийн талаар өгсөн шинжээчдийн үнэлгээ болохыг онцлон тэмдэглэе.

“Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үнэлгээ нь 3,95 буюу 2008 онтой харьцуулахад 2009 онд 0.14 үнэлгээгээр буурчээ. Өөрөөр хэлбэл улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын түвшин бага зэрэг буурсан гэж шинжээчид үнэлжээ.

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ



Улс төрийн хүрээн дэх авлига их түгээмэл буюу 4.54, хууль хяналтын байгууллагад авлига түгээмэл буюу 3.92 хэмээн шинжээчид үзжээ.


4. “Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл” судалгааны дүн

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх гэмт явдлын хамгийн түгээмэл төрөл нь авлига юм. Улс төрийн хүрээн дэх авлига нь “дээдэс нь суудлаа олохгүй бол доодос нь гүйдлээ олохгүй”, “Өөрөө шударга, авлигаас ангид байж бусдыг шударга бай гэж шаардана” гэдэгчлэн улс оронд хууль ёс хэрэгжих, шударга ёс тогтооход маш том саад, бул хар чулуу болдог.

Улс төрийн хүрээнд авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр УИХ – 4.46, төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг – 4.38, бүх шатны ИТХ

3.62, нутгийн захиргааны байгууллага буюу Засаг даргын тамгын газар – 4.23, улс төрийн намууд 3.92 тус тус авчээ (зураг 3) 2009 оны дундаж үнэлгээ 4.12 байна.

Зураг 2 Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ



Зураг 2-аас харахад УИХ-ын авлигад өртөмтгий байдлын үнэлгээ харьцангуй их өссөн бол, яам, агентлаг, Засаг даргын тамгын газруудын үнэлгээ бага зэрэг өссөн нь ажиглагдаж байна.

Хүснэгт 2. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгож шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн үнэлгээ

	2008	2009
Мөнгө, хөрөнгө өгөх	4.07	4.7
Бэлэг сэлт өгөх	3.73	4.7
Албан тушаалд томилох		4.4
Баяр, ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах		4.3
Олсон ашиг орлогоо хуваахаар амлах	3.80	4.2
Өндөр цалинтай сул ажилд оруулах		4.1
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох		4.0
Аялал жуулчлалын зардал даах	3.33	3.9
Гадаад арга хэмжээний зардал даах		3.8
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан шагнах		3.8
Сургалтын зардал даах		3.8
Эмчилгээ сувилгааны зардал даах		3.6
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах		3.6
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатай хожигдох		3.5
Гадаад банкинд данс нээж мөнгө өгөх		2.9
Өрийг нь төлөх		2.8
Хувьцаа өгөх		2.7
Гадаад харилцааг дэмжих		

Хүснэгт 3. Улс төрч өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх тархалтын үнэлгээ

	2008	2009
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах		4.4
Ажлаас нь хална, арга хэмжээ авна гэж дарамж шахалт үзүүлэх	3.64	4.0
Бусдын хооронд зуучлах нэрийн дор мөнгө нэхэх		3.9
Шан харамж нэхэх	3.43	3.9
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох		3.7
Хууль бус шаардлага тавих		3.6
Өөрийн хүнээ томилж ажлыг нь удирдах, нөлөөлөх, даалгавар бүхий шалгалт оруулах		
Ах дүүсийнх нь хувийн өмчтэй холбоотой зөрчлөөр дарамтлах		
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулалттай дайруулах		

Хүснэгт 4. Улс төрчид төрийн байгууллагын дор дурдсан үйл ажиллагаануудад нөлөөлөх давтамжийн үнэлгээ

	2008	2009
Ажил, албан тушаалд томилох үйл ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.6
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад нөлөөлөх	4.57	4.5
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэхэд нөлөөлөх	4.00	4.3
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.1
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.0
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.9
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлөх	4.00	3.9
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэхэд нөлөөлөх	3.47	3.6

Ажил, албан тушаалд томилох үйл ажиллагаанд улс төрчид нөлөөлөх явдал маш их байсаар байгаа ч 2008 онтой харьцуулбал 0.19 функтээр буурсан байна. Энэ улс төр төрөөс албыг зааглаж өгсөн Төрийн албаны хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байж болох юм.

Хүснэгт 5. Монгол дахь улс төр, бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцаа

	Үнэлгээ
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.7
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.7
Гадны улс төрийн бүлэглэл монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.1
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.1

Гадны бизнесийн бүлэглэл монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	3.2
Гадны бизнесийн бүлэглэл монголын улс төрийн нам бүлэглэлтэй нэгдсэн	2.8
Гадны улс төрийн бүлэглэл монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	2.8
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг гартаа оруулсан	2.4
Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл гартаа оруулсан	2.4
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.2
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.2
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.2
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.7

Хүснэгт 6. Монгол Улс дахь бүлэглэлүүд хэр хүчтэй байдаг үнэлгээ

	Үнэлгээ
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.4
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл /намуудын нэгдэл/	4.4
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.3
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл	4.0
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.9
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.8
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.8

Хүснэгт 5, 6-аас харахад Монголд хувийн тэр дундаа бизнесийн явцуу эрх ашгийг ард түмний эрх ашгаас илүүд тавьсан улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн нэгдэл илүү хүчирхэгжиж улмаар өөрсдийн үйл ажиллагаанд хууль хяналтын байгууллагыг татан оруулж байгаа талаар шинжээчид үнэлжээ. Тэд үйл ажиллагаандаа гэмт этгээдүүдийг татан оролцуулах нь Монголын эрүүгийн нөхцөл байдлыг огцом хүндрүүлж болзошгүй. Улс төр, бизнесийн бүлэглэлүүд нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг өөрсдийн явцуу эрх ашигт үйлчлүүлэх хандлага ажиглагдаж байгааг зарим шинжээчид цохон тэмдэглэсэн.

Хүснэгт 7. Улс төрчдийн хүрээн дэх авлигын хэлбэр

	Үнэлгээ
Сонгогчдын санал худалдан авах	4.7
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал олгох	4.5
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.5
Намд хандив өгөх	4.4
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах	4.4
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.3
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах	4.2

Төрийн өмчийг шамшигдуулах	4.0
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.0
Мөнгө угаах	4.0
Хувийн байгууллага, санд хандив өгөх	3.8
Хууль бусаар дампууруулах	3.6
гадаадынхны нөлөөнд автах	
Өр, зээлийг хүчингүй болгох	

Сонгогчдын санал худалдан авах нь улс төрийн хүрээнд дэлгэрсэн авлигын хамгийн түгээмэл хэлбэр байгаа нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх болсныг баталж байна. Түүнчлэн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлуудын авлигад нөлөөлөх нөлөө маш хүчтэй байгаа нь Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусдад хууль бусаар давуу байдал олгох үйлдлийг гэмт хэрэгт тооцох тухай НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцийн заалтыг Эрүүгийн хуульд оруулах шаардлага байгааг мөн илэрхийлж байна.

Хүснэгт 8. Улс төрийн хүрээний авлигын чиглэгдэх үйл ажиллагаа

	Үнэлгээ
Уул уурхайн салбар	4.7
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.5
Намд эрх мэдлээ тогтоох	4.5
Хэвлэл мэдээлэл	4.4
Бизнес эрх мэдлээ тогтоох	4.3
Орон сууц, барилга байгууламж барих	4.1
Гадаадын хөрөнгө оруулалт	3.8
Өмч хувьчлал	3.7
Газар тариалан	3.6
Гадаад экспортын үйл ажиллагаа	3.4
төсвөөс их хөрөнгө хуваарилахад	

Хүснэгт 8-аас харахад уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэгт улс төрийн хүрээний авлига чиглэгдэж байгааг төр засаг анхааралдаа авахыг харуулж байна. Түүнчлэн дөрөвдэх засаглал шударга үнэний дуу хоолой болсон хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд улс төрийн авлига ихээр чиглэх болсон нь захиалгагүй сэтгүүлзүйн үнэт зүйлд нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэнд хээл хахууль өгөх, авах дараах арга хэрхэн дэлгэрсэн талаар өгсөн үнэлгээ. Үүнд:

	Үнэлгээ
Сонгуулийн болон бусад үйл ажиллагааны санхүүжилт өгөх	4.6
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.2
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.1
Зуучлагчаар дамжуулах	4.1
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.9

Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.6
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.5
Шууд өөрт нь өгөх	3.5
Мөрийтэй тоглох санаатай алдах	3.4
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.4
Мөнгө зээлдүүлээд мартаж	3.0
шагнал, ажлын хөлс байдлаар өгөх	


Хүснэгт 10. Улс төрийн хүрээнийхний дундах хээл хахуулийн хэмжээ /үйл ажиллагааны үнийн дүнгийн хувиар/

	Хувь
Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	12.45%
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	16.5%
Өмч хувьчлах шийдвэр гаргуулах	15.78%
Зээл авах	11.5%
Өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх	11.08%
Татвараас чөлөөлүүлэх	15.5%

Хүснэгт 11. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрийн тархац

	Үнэлгээ
Орон сууц худалдан авдаг	4.8
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.8
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.6
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.6
Машин худалдан авдаг	4.5
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.4
Өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах	4.3
Дотоодын банкинд хадгалдаг	4.0
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.4
Гадаадын банкинд хадгалдаг	3.4
Дараачийн сонгуульд зарцуулах	3.3
Хувьцаа худалдан авдаг	3.0
Ломбард, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо	

Зураг 3. Улс төрийн хүрээн дэхь авлига үүсгэхэд нөлөөлж буй хүчин зүйлс



Судалгаанаас харахад (зураг 3) УИХ, Иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь ашиг сонирхлын зөрчил, улс төрийн намын томилгоо нь авлигад нөлөөлөх нөлөө урд жилийнхээс нэмэгдсэн байдалтай байна. Түүнчлэн төр данхайж бүх зүйл рүү орж байгаа болон ил тод бус байдал улс төрийн хүрээний авлига ихсэхэд нөлөөлж байна гэж дүгнэжээ. Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлийн ашиг сонирхлын зөрчил, сонгуулийн болон намын санхүүжилт, сонгуулийн тогтолцооны авлигад нөлөөлөх нөлөө маш хүчтэй хэвээр байна.

“Өнөөгийн улс төрийн болон сонгуулийн тогтолцооноос үүдэн ямар ч улс төрийн нам авлигад автана” гэсэнтэй шинжээчдийн 76.2 хувь санал нийлж байна. Эндээс харахад өнөөгийн улс төрийн болон сонгуулийн тогтолцоо хэвээр байгаа тохиолдолд ямар ч нам, улс төрийн хүчин сонгуульд ялж төрийн эрх барихад авлигад автах эрсдэл өндөр байх нь тодорхой харагдаж байна. Сонгуулийн тогтолцоог өөрчлөхгүйгээр улс төрийн хүрээн дэхь авлигатай тэмцэхэд хүндрэлтэй нь гэсэн 2008 оны судалгааны дүгнэлтийг¹ давхар баталж байна.

Шинжээчид улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Сонгуулийн тогтолцоо, сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх, улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, улс төр - бизнесийн хэлхээ холбоог таслах
2. Хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага хүлээлгэдэг болох, Авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатгах
3. Шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох
4. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, АТГ-ын нэр хүндийг өргөж, үйл ажиллагааг нь дэмжих, түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хараат бус байдал, санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх
5. Төрийн болон засгийн оролцоог багасган, улсын төсвийн зарлагыг ДНБ- ны 25 хувиас хэтрэхгүй байлгах,

1 “Улс төр хууль, хяналтын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа 2008” тайлан

6. Төрийн албыг цэвэршүүлэх, намын харъяаллаар албан тушаалд томилдогийг таслан зогсоох, төрийн албан тушаалтны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах хариуцлага тооцдог механизмыг бий болгох, авлига болон өмч хөрөнгөтэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон хэнийг ч төрийн албанд томилохгүй байх. Намууд хүнээ зөв олж сонгох.
 7. Бүх шатанд хууль хэрэгжүүлдэг болох, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, хариуцлагын механизмыг сайжруулах,
 8. Төрийн албаны зөвлөлийг улс төрөөс ангид хүчтэй байгууллага болох нь зүйтэй гэж тус тус үзжээ.
- Авлигатай үр дүнтэй тэмцэхийн тулд улс төрчдийн хүсэл эрмэлзлэлийг бий болгохын тулд УИХ-ын гишүүдийг лобби бүлэг байгуулахыг уриалж байна.


5. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн

Хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигад өртөмтгий байгууллагыг тодорхойлсон шинжээчдийн үнэлгээгээр Шүүхийн байгууллага – 3.49 прокурорын байгууллага – 3.12 цагдаагийн байгууллага – 3.50 шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага – 3.21 байна. /зураг 4/. 2009 оны судалгаанд үнэлгээг илүү нарийвчилсан байдлаар гаргасан нь Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад өртөмтгий байдал өөрчлөгдөхөд /зураг 5./ нөлөөлсөн байж болно.

Зураг 4. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигад өртөмтгий байдал



Зураг 5. Хууль хяналтын байгууллага дахь авлигын тархалт



Хүснэгт 12. Хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь авлига үүсэх эрсдэлийн үнэлгээ

	Үнэлгээ
Эрүүгийн хэрэг үүсгэх	3.9
Прокурор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64
Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн үйл явц	3.64
Ял шийтгэлийн хэмжээг бууруулах	3.6
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58
Шүүхийн шийдвэр хурдан гүйцэтгэх	3.56
Байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ авах, өөрчлөх, /цагдан хорих, баривчлах, барьцаа авах гэх мэт/	3.45
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	3.4
Торгууль ноогдуулах	3.36
Прокурор яллах дүгнэлт үйлдэх	3.33
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27
Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл явц	3.27
Хорих ангид ялтан хуваарилах	3.25
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах	3.22
Албан дуудлага худалдаанд оруулах	3.22
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.18
Ялтныг урамшуулах /шагналын хоног/	3.11
Захиргааны хэргийн шүүхийн үйл явц	3.0

Хүснэгт 13. Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахад түгээмэл хэрэглэдэг үйлдэл

	Үнэлгээ
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08
Бэлэг сэлт өгөх	4.08
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	3.7
Албан тушаалд томилох	3.6
Олсон ашиг орлогоо хуваахаар амлах	3.3
Өрийг нь төлөх	3.33
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.11
Төрийн одон медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдэг шагнах	3.14
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.0
Аялал жуулчлалын зардал даах	2.91
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатай хожигдох	2.89
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63
Сургалтын зардал даах	2.63
Гадаад арга хэмжээний зардал даах	2.5
Өндөр цалинтай сул ажилд оруулах	2.5
Хувьцаа өгөх	2.0
Гадаад банкинд данс нээх өгөх /мөнгө өгөх/	1.67
Гадаадын сургуульд улсын зардлаар явуулах	

Эндээс харахад хууль хяналтын байгууллагын ажилтнуудыг мөнгө, хөрөнгө болон бэлэг сэлт өгөх, албан тушаалд томилох, шагнал урамшуулал олгох авлигын хэлбэр илүү түгээмэл байна.

Хүснэгт 14. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтан өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцох хэлбэр

	Үнэлгээ
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.0
Олон удаа шалгуулах, шалгах	3.73
Дарамт шахалт үзүүлэх	3.64
Хууль бус шаардлага тавих	3.67
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.42
Шан харамж нэхэх	3.0
Хуулийн хийдэгдлийг ашигладаг	

Хүснэгт 15. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтанд хээл хахуулийг өгч авалцдаг хэлбэр

	Үнэлгээ
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.8
Зуучлагчаар дамжуулах	3.6
Мөнгө зээлдүүлээд мартаг	3.44
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	3.33
Ойр дотны хүнээр дамжуулах	3.0
Эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдан авах	3.0
Эд зүйлийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.0
Шууд өөрт нь өгөх	2.9
Мөрийтэй тоглож санаатай алдах	2.78
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29

Хээл хахуулийн хэмжээг ажилд орох, албан тушаал дэвшихэд 7.8 сая, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход 15.1 сая, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад 19.5 сая, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болгоход 8.5 сая, эрүүгийн хэрэг үүсгүүлэхэд 4.1 сая төгрөгийн хахууль дундажаар төлдөг гэж шинжээчид үнэлжээ.

Хүснэгт 16. Авлигаар бий болсон мөнгө, хөрөнгийг зарцуулдаг хэлбэр

Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.0
Машин худалдан авдаг	5.0
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5
Өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах	4.75
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зарцуулдаг	3.33
Орон сууц худалдан авдаг	3.33
Дотоодын банкинд хадгалдаг	3.25
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	3.0
Гадаадын банкинд хадгалдаг	2.64
Хувьцаа худалдан авдаг	2.83

Хүснэгт 17. Хууль хяналтын байгууллага дахь авлига бий болоход нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах байдлаар үнэлжээ:

	2008	2009
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхолын зөрчил		3.64
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал		3.42
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, үр өгөөжгүй, хяналтгүй байдал		3.67
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4.00
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.20	3.73
Боловсон хүчний сонголт хангалтгүй		
Эрх зүйн боловсрол мэдлэг		

Хүснэгт 18. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд авлигыг нөхцөлдүүлд буй дутагдал, доголдолын үнэлгээ

	2008	2009
Хүнд суртал	4.47	4.8
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.5
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.4
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.4
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.2
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.6
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.2
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналт сул	4.00	4.2
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	4.47	4.0
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.1
Сэтгэлгээний хоцрогдол		

Шинжээчид дараах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл хууль хяналтын байгууллагын хүрээн дэхь авлигаас урьдчилан сэргийлнэ гэж дүгнэжээ. Үүнд:

- Хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулан ур чадварт үндэслэсэн томилгоо хийх, хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах шударга, ил тод механизм бий болгох;
- Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, ажлын алдаа доголдыг хянан шалгаж, хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;
- АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангаруулах;
- Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын цалин хөлс нэмэх, нийгмийн болон хууль зүйн баталгааг сайжруулах;
- Хууль хяналтын байгууллагуудыг нэг анги, хамаатан садан, нэг нутаг зэргээр үүссэн хамаарлыг аль болох таслан зогсоох;
- Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх гэж тус тус дүгнэжээ.

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН




ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. Судалгааны зорилго, товч үр дүн

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн дунд зан үйлийн зөв төлөвшил, ёс суртахуун ямар байгааг судлах, цаашид шударга бус явдлын өмнө нугарахгүй зогсож чадах хүмүүсийг төвлөшүүлэхийн тулд өнөөдрийн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх ажлыг чиглүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршиж байгаа юм.

Хүүхдийн шударга байдлын 2010 оны судалгаанд аймаг, нийслэлийн нийт 820 хүүхэд хамрагдсан юм. Хүүхдүүдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ 2.74 гарсан бөгөөд 2008 оны үнэлгээнээс даруй 3.9 пунктээр доогуур гарсан байна (Зураг 1).

Зураг 1: Хүүхдийн шударга байдлын судалгааны үр дүн, (2008, 2010 он)

**2. Хүүхдийн шударга байдал-2010 судалгааны арга зүй, түүвэрлэлт**

Судалгааг 2008 онд БНСУ-ын Транспэрэнси интернэшнл байгууллагаас боловсруулан Энэтхэг, БНСУ, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан судалгааны асуулга, тооцоолох арга зүйг ашиглан явуулсан. Уг асуулга нь хүүхдүүдийн шударга байдал, ёс суртахуун, авлига болон гэмт хэргийг үл тэвчих байдал, аливаа асуудалд хандах хандлага, хууль, дүрэм, журам сахин биелүүлэх явдлыг хүүхдүүдээс маш энгийн, тэдэнд ойлгомжтой байдлаар асууж тодруулах боломж олгосноороо онцлог юм (Асуулгыг Хавсралтаас үзнэ үү).

Хүснэгт 1: Хүүхдийн шударга байдлын үзүүлэлтүүдийг илэрхийлэх асуултуудын дугаар

	Ёс зүй / Ёс суртахуун	Зөв төлөвшил	Хууль ягштал сахих	Авлигыг /үл/ тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг Хүснэгт 1-д байгаа асуулт – үзүүлэлтээр гаргаж ирсэн. Асуултуудаар илэрхийлсэн үзэл санаатай хүүхдүүдийн үзэл бодол нийлж байгаа эсэхийг “Санал бүрэн нийлж байна” гэдгээс эхлэн “Санал огт нийлэхгүй байна” хүртэл үнэлүүлсэн юм. Шударга байдлын үзүүлэлт нь 1-10 гэсэн утгаар

илэрхийлэх ба 10 руу ойртох тусам маш сайн, 1 рүү ойртох тусам маш муу гэсэн утгыг илэрхийлнэ. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох мэдээллийн эх үүсвэр нь “Хүүхдийн шударга байдал 2010” судалгааны үр дүн байв.

Хүүхдийн шударга байдлын судалгааны түүвэрлэлтийг хоёр түвшинд хийсэн. Түүвэрлэлтийн эхний шатанд сургуулийн ахлах ангийн хүүхдүүд буюу 7 дугаар ангиас дээш ба насны ангиллаар 12 дээш насны хүүхдүүдийг гаргаж ирсэн. Улсын хэмжээнд 2010-2011 оны хичээлийн жилд нийт 522,066 хүүхдүүд ерөнхий боловсролын сургуульд сурж байгаагийн 248,100 хүүхэд 7 буюу түүнээс дээш ангид суралцаж байна. Улмаар орон нутагт суралцаж буй хүүхдүүдийн тоогоор аймгуудыг 4 бүлэгт хуваасан. Нэгдүгээр бүлэг 5000 хүртэл ахлах ангийн хүүхэдтэй, хоёрдугаар бүлэг 5000-7000 ахлах ангийн хүүхэдтэй, гуравдугаар бүлэг 7000-10000 ахлах ангийн хүүхэдтэй, дөрөвдүгээр бүлэг 10000 ба түүнээс дээш ахлах ангийн хүүхэдтэй гэсэн бүлэгт хуваасан юм. Дээрх байдлаар ахлах ангид суралцаж буй хүүхдийн тоогоор аймгуудыг бүлэглэсний дараа бүлэг тус бүрээс нэг аймгийг санамсаргүй байдлаар сонгосон бөгөөд “Хүүхдийн шударга байдал 2010 судалгаа”-нд Өмнөговь, Дорнод, Дархан-Уул, Өвөрхангай аймгуудыг хамруулсан болно (Хүснэгт 2).

Хүснэгт 2: Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд хамрагдсан аймгийн сонголт

д/д	Аймаг	Суралцагчдын тоо	Бүлэг	Сонголт	Сонгогдсон аймаг
1	Говьсүмбэр	1401	1	0	
2	Дундговь	4108		0	
3	Сүхбаатар	4772		0	
4	Өмнөговь	4859		1	Өмнөговь
5	Дорноговь	5064	2	0	
6	Булган	5521		0	
7	Говь-Алтай	5637		0	
8	Хэнтий	6824		0	
9	Дорнод	6914		1	Дорнод
10	Төв	6967		0	
11	Завхан	8383	3	0	
12	Баянхонгор	8497		0	
13	Увс	9062		0	
14	Архангай	9256		0	
15	Сэлэнгэ	9468		0	
16	Дархан-Уул	9605		1	Дархан-Уул
17	Ховд	9745		0	
18	Орхон	10320	4	0	
19	Баян-Өлгий	10650		0	
20	Өвөрхангай	10997		1	Өвөрхангай
21	Хөвсгөл	12514		0	

Орон нутгаас судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт орон нутаг дахь ахлах ангид суралцагчдын тоонд пропорционалиар хуваарилсан (Хүснэгт 3).

Хүснэгт 3: Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд хамрагдсан нэгжийн тоо, аймгаар

ДД	Аймаг	Эх олонлогийн хэмжээ	Дүнд эзлэх хувь	Түүврийн хэмжээ
1	Өмнөговь	4859	15.0	37
2	Дорнод	6914	21.4	53
3	Дархан-Уул	9605	29.7	73
4	Өвөрхангай	10997	34.0	84
	Дүн	32375	100.0	246

Нийслэлийн түвшинд түүвэрлэлтийг хийхдээ мөн ахлах ангид суралцаж буй хүүхдийн тоог авч үзсэн. Нийслэлийн хэмжээнд 87,536 хүүхэд ахлах ангид суралцаж байгаагаас Багахангай дүүрэгт 251 хүүхэд суралцаж байхад Баянзүрх дүүрэгт 18 мянга гаруй хүүхэд суралцаж байна. Иймд нийслэлийн хэмжээнд ахлах ангид 2010-2011 хичээлийн жилд элсэн орсон ахлах ангийн хүүхдүүдийн тоогоор 3 бүлэгт хуваан авч үзсэн (Хүснэгт 4). Нэгдүгээр бүлэгт 3000 хүртэл хүүхэд ахлах ангид суралцаж байгаа, хоёрдугаар бүлэгт 10000 хүртэл хүүхэд ахлах ангид суралцаж байгаа, гуравдугаар бүлэгт 20000 хүртэл хүүхэд ахлах ангид суралцаж байгаа гэж хуваасан болно.

Хүснэгт 4: Нийслэлээс Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд хамрагдсан дүүргийн сонголт

	Дүүрэг	Суралцагчдын тоо	Бүлэг	Сонголт	Сонгогдсон дүүрэг
1	Багахангай дүүрэг	251	1	0	
2	Налайх дүүрэг	2373		1	Налайх дүүрэг
3	Багануур дүүрэг	2848		0	
4	Хан-Уул дүүрэг	7535	2	1	Хан-Уул дүүрэг
5	Чингэлтэй дүүрэг	9806		0	
6	Баянгол дүүрэг	14989	3	0	
7	Сүхбаатар дүүрэг	15425		1	Сүхбаатар дүүрэг
8	Сонгинохайрхан дүүрэг	15505		0	
9	Баянзүрх дүүрэг	18804		0	
	Дүн	87536			

Нийслэлээс судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт нийслэлийн ахлах ангид суралцагчдын тоонд пропорционалиар хуваарилсан (Хүснэгт 5).

Хүснэгт 5: Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд хамрагдсан нэгжийн тоо, дүүргээр

	Сонгогдсон дүүрэг	Эх олонлогийн хэмжээ	Дүнд эзлэх хувь	Түүврийн хэмжээ
1	Налайх дүүрэг	2373	9.4	52
2	Хан-Уул дүүрэг	7535	29.7	165
3	Сүхбаатар дүүрэг	15425	60.9	337
		25333	100.0	554

3. Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны ажлыг АТГ-ын Судалгаа шинжилгээний алба зохион байгуулж явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажлыг 2010 оны 12 дугаар сарын 15-аас 25-ны хооронд хийсэн юм. Судалгааны үр дүнг дахин нягтлах үүднээс нийслэлийн Налайх дүүргийн ахлах ангийн сурагчдаас судалгааг дахин авсан.


Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CSPro 4.0 (Census and Survey Program) программ дээр боловсруулсан. Мэдээллийг оруулж дууссаны дараа CSPro 4.0 программын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) программ руу хөрвүүлсэн. SPSS 16.0 программыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайлан бэлтгэхэд ашигласан.

4. Хүүхдийн шударга байдлын судалгааны үр дүн

4.1 Судалгаанд оролцогчдын бүтэц


Хүүхдийн шударга байдлын судалгаанд оролцогчдыг байршлаар нь авч үзвэл 69.8 хувь нь нийслэлийн, 30.2 хувь нь аймгийн ахлах ангид сурагчид байлаа (Зураг 2).

Зураг 2: Хүүхдийн шударга байдлын судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, байршлаар, дүнд эзлэх хувиар



Хүүхдийн шударга байдлын судалгаанд оролцогчдын бүтцийг хүйсээр авч үзвэл 38.8 хувийг эрэгтэй сурагчид, 48.9 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна. Харин сурагчдын 12.3 хувь нь энэ асуултад хариулаагүй байна (Зураг 3).


Зураг 3: Судалгаанд оролцогчдын бүтэц, хүйсээр



Судалгаанд оролцсон хүүхдүүдийг насны бүтцээр авч үзвэл 11 настай сурагчид 0.1 хувийг, 12 настай сурагчид 2.0 хувийг, 13 настай сурагчид 8.5 хувийг, 14 настай сурагчид 20.4 хувийг, 15 настай сурагчид 25.2 хувийг, 16 настай сурагчид 19.4 хувийг, 17 настай сурагчид 16.6 хувийг, 18 настай сурагчид 1.2 хувийг тус тус хүүхдүүд эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын бүтцийг сурч байгаа ангиар авч үзвэл 1.0 хувь нь 7 дугаар ангид, 10.0 хувь нь 8 дугаар ангид, 33.8 хувь нь 9 дүгээр ангид, 17.2 хувь нь 10 дугаар ангид, 25.7 хувь нь 11 дүгээр ангид тус тус суралцаж байгаа сурагчид байсан бол судалгаанд оролцогчдын 12.3 хувь нь ангиа хариулаагүй байна (Зураг 4).


Зураг 4: Судалгаанд оролцсон хүүхдүүдийн бүтэц, анги бүлгээр



4.2 Хүүхдийн шударга байдлын түвшний үнэлгээ


Хүүхдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ 2.74 гарсан бол үүнийг байршлаар нь авч үзвэл нийслэлийн хүүхдүүдийн шударга байдлын түвшний үнэлгээ 2.84 гарсан нь аймгийн хүүхдүүдийнхээс 0.34 пунктээр илүү байжээ (Зураг 5).

Зураг 5: Хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ, байршлаар




Хүүхдийн шударга байдлын үнэлгээг 2008 оныхтой харьцуулбал нийслэлд оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ даруй 2.4 дахин, орон нутагт оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 2.7 дахин тус тус буурсан байна.

Зураг 6: Хүүхдүүдийн шударга байдлын 2008, 2010 оны үнэлгээ, байршлаар




Хүүхдүүдийн шударга байдлыг хүйсээр үзвэл эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 2.91 гарсан нь эмэгтэй хүүхдийнхээс 0.30 пунктээр илүү байна (Зураг 8). Уг үзүүлэлтийг 2008 оны дүнтэй харьцуулбал эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 2.2 дахин, эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 2.6 дахин буурсан байна. Өмнөх судалгааны дүнгээр эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ эрэгтэй хүүхдийнхээс өндөр байсан бол энэ удаагийн судалгаагаар байдал өөрчлөгдсөн байна.

Зураг 7: Хүүхдүүдийн шударга байдлын 2008, 2010 оны үнэлгээ, хүйсээр




Хүүхдийн шударга байдлын үнэлгээг хүүхдийн насны ангиллаар авч үзвэл, 18 насныхны шударга байдлын үнэлгээ (3.07) бусад насныхнаас өндөр гарчээ (Зураг 8).

Зураг 8: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, насны ангилалаар



Хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл 10 дугаар ангийн сурагчдын шударга байдлын үнэлгээ (2.82) харьцангуй өндөр гарсан байна (Зураг 9).

Зураг 9: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, суралцаж буй ангиар



Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үзүүлэлтүүдийн үнэлгээг Хүснэгт 6-д харуулав. “Шалгалтандаа “шипи” хэрэглэсэн хүн нь миний сайн найз байсан ч энэ тухай багш, эцэг эх, дотны хүмүүстээ мэдэгдэх эсэх” (5.17), “Миний сайн найз шалгалтандаа шалгалтандаа шипи хэрэглэх нь буруу зүйл биш эсэх” (4.21) гэсэн дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ харьцангуй сайн гарсан бол “ангийн даргын сонгуульд ялахын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш эсэх” (1.61), “багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга эсэх” (1.57) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ харьцангуй доогуур гарсан байна.

Хүснэгт 6. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

Д/д			Дэд үзүүлэлт	Үнэлгээ
1	Ёс суртахуун	Танин мэдэхүй	Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш	2.85
2	Ёс суртахуун	Нөлөөлөл	Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл	2.19
3	Ёс суртахуун	Зан үйлийн	Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ	2.83
			Бүлгийн дундаж	2.62
1	Зөв төлөвшил	Танин мэдэхүй	Ангийн даргын сонгуульд ажилд ялахын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш	1.61
2	Зөв төлөвшил	Нөлөөлөл	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга	1.57
3	Зөв төлөвшил	Зан үйлийн	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь мэдэгдэнэ	2.44
			Бүлгийн дундаж	1.87
1	Хууль ягштал сахиу	Танин мэдэхүй	Миний сайн найз шалгалтандаа "шипи" хэрэглэх нь буруу зүйл биш	4.23

2	Хууль ягштал сахих	Нөлөөлөл	Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно	2.96
3	Хууль ягштал сахих	Зан үйлийн	Цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм сахихыг хичээхгүй	2.40
			Бүлгийн дундаж	3.20
1	Авлигыг үл тэвчих	Танин мэдэхүй	Томчуудын хууль бус үйл ажиллагаа нь миний амьдралд сайнаар нөлөөлж байвал энэ нь буруу зүйл биш	2.20
2	Авлигыг үл тэвчих	Нөлөөлөл	Шалгалтандаа "шипи" хэрэглэсэн хүн нь миний сайн найз байсан ч энэ тухай би багш /эцэг, эх/ дотны хүндээ мэдэгдэнэ	5.17
3	Авлигыг үл тэвчих	Зан үйлийн	Миний гэр бүлийн гишүүд төрийн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш	2.40
			Бүлгийн дундаж	3.25

Дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг дараагийн бүлгүүдэд тайлбарлав.

4.3 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ


Хүүхдийн шударга байдлын 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээг ёс суртахууны талаархи ойлголт, ёс зүй, суртахуунд нөлөөлөх нөлөөлөл, одоо тус дэд үзүүлэлт ямар түвшинд байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Ёс суртахууны талаархи танин мэдэхүйг нь - Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
- Ёс суртахуунд нөлөөлөх нөлөөллийг - Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл.
- Ёс суртахууны зан үйл нь - Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинонд орохыг хичээнэ.


Хүүхдүүдийн өнөөдрийн ёс суртахууны төлөв байдал, ёс зүйн байдлын хэм хэмжээ, стандарт ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 2.62 байна.

Нийслэлийн хүүхдүүд (2.75) орон нутагт оршин суудаг хүүхдүүдээс (2.31) ёс зүйн, ёс суртахуун 0.44 пунктээр, эрэгтэй хүүхдүүд (2.67) эмэгтэй хүүхдүүдээс (2.51) 0.16 пунктээр тус тус өндөртэй байна (Зураг 10, 11).

Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ, байршлаар




Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ, хүйсээр




Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ 12 наснаас (1.92) бага багаар дээшилсээр 14 насанд (2.74) болж улмаар 17 насанд 2.56 хүртэл доошилсон байна. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ 18 насныхны хувьд 3.08 болж дээшилсэн байна.

Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлт, насны ангилалаар



Хүүхдүүдийн ёс зүйн хэм хэмжээ ямар өнгө төрхтэй байгааг харуулж буй тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн сурч буй ангиар авч үзвэл дараахь байдалтай байна. Үүнд: Хамгийн доогуур үнэлгээ 7 ба 8 ангид (2.50, 2.48), хамгийн дээд үнэлгээ 10 ангид (2.78) байж байгаад 11 дүгээр ангид доошилж 2.54 болжээ.

Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ, суралцаж буй ангиар



4.4 Хүүхдийн зөв төлөвшил


Хүүхдийн шударга байдлын 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн зөв төлөвшлийн үнэлгээг хүүхдүүдийн зөв бурууг ялгах байдал, нөлөөлөх нөлөөлөл, хэрхэн илэрч байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Зөв төлөвшлийг танин мэдэхүй нь - Ангийн даргын сонгуульт ажилд ялахын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
- Зөв төлөвшилд нөлөөлөх нөлөөллийг - Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга.
- Зөв төлөвшлийн илэрч буй зан үйл нь - Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь мэдэгдэнэ.

Хүүхдүүдийн зөв бурууг ялгаж салган ойлгох чадвар ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 1.87 байна. Энэ нь хүүхдүүдийн ёс суртахуун, буруу зөв сайн мууг ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүүхдүүдийн дагаж мөрдөх чадвар, авлигыг үл тэвчих гэсэн дэд үзүүлэлтүүд дотор хамгийн доод үнэлгээ бөгөөд хүүхдүүд өнөөдөр сайн муу, буруу зөвийг ялгах чадвар муу байгааг харуулж байна.


Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (1.93) орон нутагт оршин сууж буй хүүхдүүдээс 0.18 пунктээр илүүтэйгээр зөв бурууг ялган ойлгох чадвартай байна (Зураг 14).

Зураг 14. Хүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ, байршлаар




Харин эрэгтэй хүүхдүүд (2.01) охидоос (1.75) 0.26 пунктээр илүүтэйгээр зөв бурууг ялгах салгадаг байна (Зураг 15).

Зураг 15. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ, хүйсээр




Одоогийн хүүхдүүдийн зөв буруу, сайн мууг ялгаж салгаж ойлгох чадварыг хүүхдүүдийн насны хувьд авч үзвэл хамгийн дээд үнэлгээ 12 насныхан 2.27 байгаад доошилсоор 14 настай 1.60 болж, 15 насанд 1.97 байснаа дахин доошилж 16 насанд 1.76 болсон байна. Харин хүүхдүүд нас ахиад сайн сууг ялгаж салгаж ойлгох чадвар сайжирч 2.15 болжээ (18 нас) (Зураг 16).

Зураг 16. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ, насны ангилалаар



Харин суралцаж буй ангиар нь авч үзвэл 8 болон 9 дүгээр ангид (1.80) байснаа 10 ангид 1.91 болоод, харин 11 ангид 1.86 болж бага зэрэг доошилсон байна (Зураг 17).

Зураг 17. Хүүхдийн төв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ, суралцаж буй ангиар



4.5 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдал


Хүүхдийн шударга байдлын 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэхэд өөрсдийгөө хэрхэн хянах чадвартайг харуулж буй дэд үзүүлэлтийг хэрхэн илэрч байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Хууль ягштал сахих явдлыг танин мэдэхүй нь - Миний сайн найз шалгалтандаа "шипипи" хэрэглэх нь буруу зүйл биш.
- Хууль ягштал сахих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно.
- Хууль ягштал сахих явдал илэрч буй зан үйл нь - Цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм сахихыг хичээхгүй.

Өсвөр насныхны ихэвчлэн зан байдал төлөвшөөгүй байдаг ба олон нийтээр хүлээн зөвшөөрөн дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журмыг хүндэтгэн дагах явдлыг төлөвшүүлэх нь чухал асуудал юм. Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгааны үр дүнгээр энэхүү хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүүхдүүд дагаж мөрдөх, өөрсдийгөө хянах чадварыг илтгэх тус дэд үзүүлэлтийн бүлгийн дундаж үнэлгээ 3.20 байна. Ямартаа ч хүүхдүүдийн сайн мууг ялгах чадвараас 1.33 пунктээр өндөр байна.


Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (3.38) орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдээс (2.78) 0.6 пунктээр өөрсдийгөө хянах чадвар өндр байна.

Зураг 18. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ, байршлаар




Харин эрэгтэй хүүхдүүд (3.49) охидоос (3.06) 0.43 пунктээр илүү хууль, дүрэм, журам сахих чадвартай байна (Зураг 19).

Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ, хүйсээр




Хүүхдүүдийн насны хувьд тус дэд үзүүлэлтийг аваад үзвэл хамгийн доод үнэлгээ 12 настай (2.55), хамгийн дээд үнэлгээ 18 насанд буюу 3.92 тус тус байна. Ер нь хүүхэд бага настай байхдаа өөрийгөө хянах чадвар сул байгаад 18 нас хүрэхэд өөрийгөө хянах чадвар дээшилдэг байна.

Зураг 20. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ, насны ангилалаар



Тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл дараахь байдалтай байна. Үүнд: 8 ангиас (2.87) дээшилж 10 ангид (3.40) болоод 11 ангид 3.11 болж 0.29 пунктээр буурсан байна.

Зураг 21. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ, суралцаж буй ангиар




4.6 Авлигыг (үл) тэвчих байдал

Хүүхдийн шударга байдлын 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих чадварыг хэмжих дэд үзүүлэлтийг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Авлигыг үл тэвчих явдлыг танин мэдэхүй нь - Томчуудын хууль бус үйл ажиллагаа нь миний амьдралд сайнаар нөлөөлж байвал энэ нь буруу зүйл биш.
- Авлигыг үл тэвчих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Шалгалтандаа "шипиг" хэрэглэсэн хүн нь миний сайн найз байсан ч энэ тухай би багш /эцэг, эх/ дотны хүндээ мэдэгдэнэ.
- Авлигыг үл тэвчих явдлын илэрч буй зан үйл нь - Миний гэр бүлийн гишүүд төрийн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.


Хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих явдлыг илэрхийлэх дэд үзүүлэлийн бүлгийн дундаж үнэлгээ 3.25 гарсан нь бусад бүх дэд үзүүлэлтүүдээс хамгийн өндөр үнэлгээ юм. Нийслэлд оршин суудаг хүүхдүүд (3.30) орон нутаг оршин суудаг хүүхдүүдээс (3.16) илүүтэйгээр авлигыг үл тэвчих явдал 0.14 өндөр байна.

Зураг 22. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ, байршлаар




Хүүхдүүдийн аливаа гэмт хэрэг шудага бус явдлыг үл тэвчих явдалд эрэгтэй хүүхдүүд (3.32) охидоос (3.16) 0.16 пунктээр өндөр чадвартай байна (Зураг 23).

Зураг 23. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ, хүйсээр




Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих чадварыг насны хувьд авч үзвэл 12 наснаас (3.02) бага багаар 15 нас хүртэл (3.27) дээшилж байгаад 16 насанд 3.23 болж буурчээ. 17 насанд өсөж 3.32 болсноо 18 насанд 3.14 болж буурсан байна (Зураг 24).

Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ, насны ангилалаар



Тус дэд үзүүлэлтийг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл анги ахих тутам хүүхдүүд аливаа гэмт хэргийг үл тэвчих чадвар дээшилж байна (Зураг 25).

Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ, суралцаж буй ангиар



5. Дүгнэлт


Тус судалгааг анхлан санаачлагч нар Транспаранси-Кореа байгууллагынхан “Ирээдүйд бид авлигатай амжилттай тэмцэхийн тулд өнөөдөр урьдчилан сэргийлэх хэрэгтэй, шударга ёсны хүмүүжил бол ёс зүйн маш нарийн эмзэг асуудал” гэж эхлүүлсэн юм. Хүүхдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ 2.74 гарсан нь 2008 онтой харьцуулахад 3.9 пунктээр буураад байгаа нь хүүхдүүтэй зөв ёс суртахуун төлөвшүүлэх чиглэлээр ажиллахгүй байгаа нь харагдаж байна. Бүх дэд үзүүлэлтийн үнэлгээ орон нутагт оршин сууж буй хүүхдүүдийн ёс суртахууны байдал, зөв бурууг ойлгох явдал, хууль, дүрэм журам сахин биелүүлэх чадвар, авлигыг үл тэвчих зэрэгт нийслэлд оршин сууж буй хүүхдүүдээс, түүнчлэн охид хөвгүүдээс тус тус доогуур гарлаа.

Өнөөгийн хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээ, ёс суртахууны талаархи ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, стандарт, сайн муу буруу зөвийг ялгаж салгаж ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрөн сахиж биелүүлэх хууль дүрэм журмыг сахин биелүүлэх хүүхдүүдийн чадвар, авлигыг үл тэвчих зэрэг дэд үзүүлэлтээс хүүхдүүд сайн муу, буруу зөвийг ялгах чадвар хамгийн доогуур үнэлгээтэй байна. Авлигын гэмт хэргийг үл тэвчих дэд үзүүлэлтийн үнэлгээ бусад дэд үзүүлэлтийн үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр байлаа.

Зөвлөмж

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад авлигын хор хөнөөлийг ойлгуулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр гарын авлага болон заах хичээлийн агуулга, хөтөлбөрийг бэлтгэж хичээл зааж байх, хүүхэд багачуудад шударга ёсны үзлийг төлөвшүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх, ингэхдээ сурган хүмүүжүүлэх ухааны эрдэмтэн, багш нартай хичээлийн агуулгыг боловсруулан хүүхэд, залуучуудад ойлгомжтой хэлбэрээр танин мэдүүлэх ажлыг тогтмол хийх.

**УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



“УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХИ ТӨСӨӨЛӨЛ 2010” судалгааны тайлан

1. Судалгааны арга зүй

1.1. Судалгааны үндэслэл, зорилго

Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагын дээд хэмжээний уулзалтаас гаргасан Мянганы тунхаглалыг баталсан бусад улс орны нэгэн адил улс орныхоо хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг тусгасан Мянганы хөгжлийн үндэсний зорилго, зорилтуудыг тодорхойлсон. УИХ-аас 2005 онд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-уудыг батлахдаа үндсэн найман зорилгоос гадна хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг нэмж баталсан.

Энэхүү зорилгын хүрээнд “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дэх зорилтыг тавьсан бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газар (АТГ)-т даалгасан.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн багийн боловсруулсан арга зүйн дагуу АТГ-аас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн судалгааг гуравдахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргаад байна.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа нь улс төрийн блон хууль хяналтын байгууллагын хүрээндэх авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг шинжээчдийн үнэлгээгээр тодорхойлж, энэ хүрээнд дэх авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг өгөх ач холбогдолтой судалгаа юм.

12. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээндэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь дараахь агуулгыг илэрхийлэх тоон үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын цар хүрээ, тархалт;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигад өртөх эрсдэл бүхий түвшин, салбар, байгууллага;
- Энэ хүрээнд дэх авлигын шалтгаан, нөхцөл;
- Энэ хүрээнд дэх авлигын төрөл, хэлбэр, хэмжээ.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа”-ны дүнд үндэслэн тооцсон. Судалгааны асуулгад дээрх үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг авах асуултуудын зэрэгцээ асуудлыг тайлбарлах нэмэлт асуултуудыг мөн оруулж өгсөн.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа, бүрдүүлэгч дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг 5 онооны хэмжээсээр гаргаж (тухайлбал: 1- огт үгүй, 5-маш их), дэд үзүүлэлтүүдийн энгийн арифметикийн дунджаар тооцсон болно.

Энэ удаагийн судалгаагаар Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг: улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт; хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт гэсэн байдлаар тус тусад нь тооцсон.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 7 бүлэг, 42 дэд үзүүлэлтээр, Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 6 бүлэг, 30 дэд үзүүлэлтээр тооцсон.

Энэхүү улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь зөвхөн судалгаанд хамрагдсан шинжээчдийн төсөөлөл, үнэлгээ, дүгнэлт гэдгийг энд дурьдах хэрэгтэй.

1.3. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ

Судалгаанд *Улс төрийн хүрээ* гэдэгт бүх шатны сонгуулийн үр дүнд байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн бол *Хууль хяналтын байгууллагын хүрээ* гэдэгт шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн.


Судалгаанд оролцох шинжээчдийг сонгохдоо улс төрийн болон хууль хяналтын байгууллагад ажилласан туршлага, тухайн хүрээний талаарх мэдээ мэдээлэлтэй ажиллаж буй эсэх, тэдгээрт тулгуурласан судалгаа дүн шинжилгээний ажил хийдэг, түүнчлэн өмнөх судалгаанд оролцож байсан эсэх зэрэг шалгуурыг харгалзан үзэж сонгосон. Энэ удаагийн судалгаанд улс төрийн хүрээг үнэлэх 13, хууль хяналтын байгууллагын хүрээг үнэлэх 13, нийт 26 шинжээч оролцсон.

2. Судалгааны үр дүн

2.1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн ерөнхий үр дүн

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2010 онд 4.07 болж, 2009 оныхоос 0.12 пунктээр өссөн байна (Зураг 1). Өөрөөр хэлбэл, шинжээчдийн үзэж байгаагаар улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын түвшин өмнөх оноос нэмэгдсэн байна.

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчийн төсөөллийн үзүүлэлт



Үүний дотор улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 4.13, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 3.98 байна.

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ ийнхүү нэмэгдэхэд дараахь хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

1. Шинжээчдийн үзэж байгаагаар яам, агентлагын авлигад өртөх эрсдэл (2009 оныхоос 0.11 пунктээр нэмэгдсэн), прокурорын байгууллага (0.69), шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага (0.09)-ын авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн.
2. Шинжээчдийн үзэж байгаагаар хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй болон хяналтгүй байдал (0.33), албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмын дутагдалтай байдал (0.27), шийдвэр гаргах ажиллагааны дүрэм журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал (0.23), хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (0.11) зэрэг авлигыг үүсгэгч хүчин зүйлсийн нөлөөлөл нэмэгдсэн байна.


2.2. “Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл” судалгааны дүн

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2010 оны байдлаар улс төрийн хүрээн дэх тархцын үнэлгээ 4.50 буюу “ихээхэн түгээмэл” гарсан нь 2009 оныхоос 0.04 пунктээр буурсан байна.

Улс төрийн хүрээн дэх авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр УИХ – 4.00, төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг – 4.40, бүх шатны ИТХ – 3.25, нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар – 3.83, улс төрийн намууд 4.00 тус тус үнэлэгдсэн байна. Улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын 2010 оны дундаж үнэлгээ 3.87 байна. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ 2009 оныхоос төрийн захиргааны төв


байгууллага буюу яам, агентлагийн хувьд 0.11 пунктээр, улс төрийн намуудын хувьд 0.08 пунктээр тус тус нэмэгдсэн бол 0.37-0.44 пунктээр буурчээ (Зураг 2).

Зураг 2. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ



Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өндөр байгаа төрийн захиргааны байгууллага дахь албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийг албан тушаалын түвшингээр нь авч үзвэл төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчдын буюу яам, агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагуудын түвшинд 4.50 гэсэн үнэлгээгээр тэргүүлж байгаа бол түүний дараа төрийн захиргааны байгууллагын удирдлагын буюу сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд 4.09 гэсэн үнэлгээгээр удаалж байна (Зураг 3).

Зураг 3. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



Улс төрийн хүрээн дэх авлигад сонгуулийн санхүүжилтийн механизм (үнэлгээ 4.42), нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо (4.42), намын санхүүжилтийн механизм (4.25) зэрэг хүчин зүйлс голлон хүчтэй нөлөөлж байна.

Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсээс 2010 онд сонгуулийн санхүүжилтийн механизмын үнэлгээ 2009 оныхоос 0.22 пунктээр өссөн бол бусад үзүүлэлтүүд 0.15-0.47 пунктээр буурсан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14	4.10	3.83	-0.27
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	0.22
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	-0.15
Улс төрийн томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.71	4.80	4.42	-0.38
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэнд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	4.30	3.83	-0.47
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	-0.40

Улс төрийн хүрээн дэх авлигын гол шалтгаан болсон сонгуулийн болон намын санхүүжилтийн механизм, түүнийг дагасан улс төрийн томилгоо нь энэ хүрээний үндсэн оролцогч болох улс төрийн намууд авлигад автагдах үндсэн хүчин зүйл болж байна. Өнөөгийн улс төрийн болон сонгуулийн тогтолцооноос хамааран ямар ч улс төрийн нам авлигад автана гэдэгтэй судалгаанд оролцсон дөрвөн шинжээч тутмын гурав нь санал нийлжээ.

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа албан тушаалд томилох (давтамжийн үнэлгээ 4.67), бэлэг бэлт өгөх (4.45), мөнгө /хөрөнгө/ өгөх (4.42), төрийн одон медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах (4.36), олсон ашиг, орлогоо хуваахаар амлах (4.36) зэрэг арга замуудыг харьцангуй их давтамжтайгаар хийдэг байна (Хүснэгт 2). Хүснэгт 2-т дурдсан арга замуудыг хэрэглэж буй давтамжийн дундаж үнэлгээ 2009 онд 3.81 байсан бол 2010 онд 3.99 болж 0.18 пунктээр нэмэгдсэн байна. Үүний дотор гадаадын банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/ (2010 онд өмнөх оныхоос 0.73 пунктээр нэмэгдсэн), өрийг нь төлөх (+0.65), хувьцаа өгөх (+0.63), төрийн одон медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах (+0.56) зэрэг үйлдлүүд илүү идэвхжсэн байна.

Хүснэгт 2. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Албан тушаалд томилох	-	4.40	4.67	0.27
Бэлэг сэлт өгөх	3.73	4.70	4.45	-0.25
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.07	4.70	4.42	-0.28
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	-	3.80	4.36	0.56
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.80	4.20	4.36	0.16
Гадаад арга хэмжээний зардал даах	-	3.80	4.33	0.53
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	-	4.30	4.11	-0.19
Аялал, жуулчлалын зардал даах	3.33	3.90	4.09	0.19

Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	-	4.00	4.00	0.00
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	-	4.10	3.89	-0.21
Сургалтын зардал даах	-	3.80	3.83	0.03
Эмчилгээ, сувилгааны зардал даах	-	3.60	3.82	0.22
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	-	2.90	3.63	0.73
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	-	3.50	3.56	0.06
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	-	3.60	3.56	-0.04
Өрийг нь төлөх	-	2.80	3.45	0.65
Хувьцаа өгөх өгөх	-	2.70	3.33	0.63
Дундаж үнэлгээ	-	3.81	3.99	0.18

Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөхдөө голчлоналбан тушаалтны зөрчлийг нь илрүүлж, түүгээр нь дарамтлах (тархцын үнэлгээ 4.09), дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэтээр/ (3.83) зэрэг үйлдлийг голчлон хэрэглэдэг байна. Гэхдээ төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх доорх үйлдлүүдийн тархцын дундаж үнэлгээ 3.71 байгаа нь 2009 оныхоос 0.21 пунктээр буурчээ (Хүснэгт 3).

Хүснэгт 2 болон Хүснэгт 3-д гарсан судалгааны үр дүн улс төрийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс шууд нөлөөлөх байдал харьцангуй буурч, шууд бус аргуудыг хэрэглэх явдал нэмэгдсэн болохыг харуулж байна.

Хүснэгт 3. Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	-	4.40	4.09	-0.31
Дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэт/	3.64	4.00	3.83	-0.17
Бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх	-	3.90	3.70	-0.20
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	-	3.70	3.67	-0.03
Хууль бус шаардлага тавих	-	3.60	3.67	0.07
Шан харамж нэхэх	3.43	3.90	3.27	-0.63
Дундаж үнэлгээ		3.92	3.71	-0.21

Сүүлийн гурван жилийн хугацаанд (2008-2009 оны хооронд) улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд голчлон ажил албан тушаалд томилох, тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад голчлон нөлөөлж байжээ. Улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх давтамж 2010 онд 2009 онтой харьцуулахад татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх (0.96 пунктээр нэмэгдсэн), шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх (0.30), хууль эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлөх (0.28) чиглэлээр илүү идэвхжсэн байна. Сонгогдсон үйл ажиллагаануудад нөлөөлөх давтамжийн дундаж үнэлгээ 2008 онд 4.04 байсан бол 2009 онд 4.11, 2010 онд 4.34 болж нэмэгдсэн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Улс төрчдийн төрийн байгууллагын зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.60	4.64	0.04
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3.47	3.60	4.56	0.96
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4.57	4.50	4.45	-0.05
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх	4.00	4.30	4.36	0.06
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.00	4.27	0.27
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.90	4.20	0.30
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд	4.00	3.90	4.18	0.28
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.10	4.09	-0.01
Дундаж үнэлгээ	4.04	4.11	4.34	0.23

Шинжээчдийн үзэж байгаагаар улс төрийн авлига бизнест эрх мэдлээ тогтоох (үнэлгээ 4.45), уул уурхайн салбар болон намд эрх мэдлээ тогтоох (тус бүр 4.42)-д түлхүү чиглэгддэг байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	0.18
Уул уурхайн салбар	4.67	4.42	-0.25
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	-0.13
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	-0.11
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	-0.33
Өмч хувьчлал	3.73	4.10	0.37
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	0.10
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	-0.16
Газар тариалан	3.60	3.00	-0.60
Дундаж үнэлгээ	4.18	4.07	-0.10

Улс төрийн хүрээнд бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах (тархцын үнэлгээ 4.64), ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох (4.58), сонгогчдын саналыг худалдан авах болон улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах (4.50) зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	0.31
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	0.04

Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	-0.19
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах	4.42	4.50	0.08
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхолоор зарцуулах	4.15	4.36	0.21
Намд хандив авах	4.42	4.25	-0.17
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	0.17
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших	4.00	4.00	0.00
Мөнгө угаах	4.00	3.80	-0.20
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	-0.11
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	0.00
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	-1.21
Дундаж үнэлгээ	4.19	4.10	-0.09

Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авахдаа үйл ажиллагааны зардал болгож өгөх (тархцын үнэлгээ 4.27), хувьцаа эд хөрөнгө өмчлүүлэх (4.22), зуучлагчаар дамжуулах (4.09), ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох (4.08) зэрэг аргууд илүү өргөн тархсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад үйл ажиллагааны зардал болгон өгөх (тархцын үнэлгээ 2009 оныхоос 0.91 пунктээр нэмэгдсэн), мөнгө зээлдүүлээд мартагч (+0.56) зэрэг аргуудын тархац илүү нэмэгдсэн байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцын

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	0.91
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	0.14
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	-0.01
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	-0.12
Шууд өөрт нь өгөх	3.45	3.80	0.35
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	-0.14
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	0.31
Мөнгө зээлдүүлээд мартагч	3.00	3.56	0.56
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	-0.01
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	-0.05
Дундаж үнэлгээ	3.66	3.85	0.19


Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө ихэвчлэн хүүхдийн сургалтын төлбөрт (тархцын үнэлгээ 4.82), өдөр дутмынхаа хэрэгцээнд (4.64), машин, орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах (4.45)-д зарцуулдаг байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад дараагийн сонгуульд зарцуулах (тархцын үнэлгээ 2009 оныхоос 0.75 пунктээр нэмэгдсэн), хувьцаа худалдан авах (+0.67), гадаадын банкинд хадгалах (0.56) зэрэг хэлбэрүүдийн тархац илүү нэмэгдсэн байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хэлбэрүүд / хариулт	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	0.22
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	0.31
Машин худалдан авдаг	4.45	4.45	0.00
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	-0.37
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	-0.37
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	-0.33
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	-0.20
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	0.56
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	0.75
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	-0.33
Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	0.67
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	0.04
Дундаж үнэлгээ	4.09	4.17	0.08

Шинжээчдийн үзэж байгаагаар бизнес эрхлэгчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхдээ дунджаар татвар ногдох дүнгийн 11.39 хувийг, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхдээ нэхэмжлэлийн дүнгийн 11.0 хувийг, зээл авахдаа зээлийн дүнгийн 10.0 хувийг, өмч хувьчлах шийдвэр гаргуулахдаа хувьчлах хөрөнгийн үнийн дүнгийн 15.83 хувийг, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялахын тулд тендерийн дүнгийн 13.41 хувийг, төсөл, хөтөлбөрт хамрагдахдаа төсөл хөтөлбөрийн төсвийн 12.91 хувийг авлигатай холбоотойгоор зарцуулдаг байна (Зураг 4). Судалгааны дүнгээс харахад 2009 онтой харьцуулахад 2010 онд бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн нийт үнийн дүнд эзлэх хувь татвараас чөлөөлүүлэх, өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх, зээл авах, төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах, төсөл хөтөлбөрт хамрагдах зэрэг хэлцлүүд дээр 0.08-3.09 хувиар буурсан байна.

Зураг 4. Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн нийт үнийн дүнд эзлэх хувь



Ажил, албан тушаалд ороход дунджаар 13.4 сая төгрөгийг, тусгай зөвшөөрөл авахад дунджаар 16.2 сая төгрөгийг, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад дунджаар 21.0 сая төгрөгийг тус тус авлигад зарцуулдаг гэж шинжээчид үзжээ.

Шинжээчид төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох (авлигын тархцын үнэлгээ 4.83), төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (4.75) зэрэг үйл ажиллагаанд авлига их тархсан гэж үзэж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Төрийн байгууллагын зарим үйл ажиллагаан дахь авлигын тархцын

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4.80	4.69	4.83	0.14
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	4.80	4.54	4.75	0.21
Ажил, албан тушаалд томилох	4.53	4.46	4.50	0.04
Өмч хувьчлал	3.87	3.82	4.50	0.68
Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4.27	4.38	4.42	0.04
Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4.13	4.08	4.25	0.17
Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3.80	4.00	4.20	0.20
Дундаж үнэлгээ	4.31	4.28	4.49	0.21

Судалгаанд оролцсон шинжээчид бүгд 100.0 хувь улс төрийн авлига илүү далд шинжтэй болсон гэдэгтэй санал нийлж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар улс төрчидийн зүгээс бизнесийг бүлэглэл, гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулах явдал 2010 онд илүү эрчимжсэн байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Монгол улс дахь улс төр болон бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ

Үзүүлэлт	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.23	3.50	1.27
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.69	4.50	-0.19
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.67	4.67	0.00
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэл /мафи/-ийг гартаа оруулсан	2.40	2.78	0.38
Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл /мафи/ гартаа оруулсан	2.80	3.40	0.60
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	3.18	3.73	0.55
Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.11	3.91	-0.20
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	2.78	3.60	0.82
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.22	1.40	0.18
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.20	3.00	1.80
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.67	5.00	0.33
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.08	4.50	0.42

Монгол улсад хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон, нам тойрсон, бизнесийн, нам дамжсан, нэг нутаг тойрсон хүрээлэл шинжээчдийн үзэж байгаагаар 2009 онтой харьцуулахад илүү эрчимжсэн байна. Харин найз нөхдийн хүрээллийн үйл ажиллагааны хүч бага зэрэг буурсан байна. Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл хүч султай байгаа хэдий ч эрчимжих хандлагатай болж байгаа нь нааштай үр дүн болж байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Монгол улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Бүлэглэлүүд / үнэлгээ	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.77	4.00	0.23
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.31	4.75	0.44
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.42	4.58	0.17
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл / намуудын нэгдэл/	4.38	4.42	0.03
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл	4.00	4.08	0.08
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.92	3.75	-0.17
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.82	2.27	0.45

Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагад авлига оршин байхад олон шат дамжлага (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.75), хуулийн хэрэгжилтэд тавих хяналт (4.75), хүнд суртал (4.67) зэрэг хүчин зүйл илүү хүчтэй нөлөөлдөг байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	0.21
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт	4.40	4.15	4.75	0.60
Хүнд суртал	4.47	4.75	4.67	-0.08
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	0.20
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	0.20
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	0.41
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	-0.29
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	0.25
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	0.10
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	0.17
Дундаж үнэлгээ	4.27	4.33	4.51	0.18

Авлигыг бууруулахад ямар арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай талаарх асуултад шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий

болгох гэсэн санаа 34.5 хувийн, УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх гэсэн санаа 24.1 хувийн, Улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл, зоригийг нэмэгдүүлэх; Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх; Хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага оноодог болох гэсэн санаанууд тус бүр 13.8 хувийн санал авсан нь голлох санаанууд болж байна.


Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараахь арга замуудыг илэрхийлсэн. Үүнд:

- Улс төрийн дээд хүрээнд авлига авсан этгээдийг зоригтой илрүүлж шийтгэх
- Бизнесийн ашиг сонирхлоороо эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон бүлэглүүдийг илрүүлэн, шийтгэх
- Авлига авсан этгээдүүдийг доороос биш дээрээс нь шийтгэж төрийн алба хаах эрхийг хязгаарлах
- АТГ-ыг жинхэнэ утгаар нь ажиллуулах, ёс зүйтэй хүмүүсээр бүрдүүлэх
- АТГ-ыг жинхэнэ утгаар нь улс төрөөс хараат бус болгох (захын прокурор авлига биш гэж гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож байна)
- Төрийн байгууллагын хүнд суртал, олон шат дамжлагыг бууруулах
- Төрийн байгууллагуудад хяналт тавих
- Хууль хяналтын байгууллагын хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах улс төр, эдийн засаг, эрх зүйн баталгаа бий болгох
- Авлига бол манай ардын ёс заншил мэт болсон. Иймээс улс төр, нийгмийн удирдлагын болон хяналтын цоо шинэ систем бий болгох
- Ухамсартай эх оронч иргэн төлөвшүүлэх бодлого, сургалтыг бүх шатны сургуулиудад үндсэн хичээл болгон хэвшүүлэх
- Олон нийтийн хандлагыг (авлигыг үл тэвчих уур амьсгалыг) бий болгох, соён гэгээрүүлэх
- Нийгмийн сэтгэл зүйг авлигатай тэмцэх чин хүсэл эрмэлзэлтэй болгох
- Шийдвэр гаргах үйл явц, төрийн байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх
- Энэ ажлыг системийн ерөнхий онол синергетикийн зарчимд тулгуурлан хийх ёстой.
- Авлига гарах боломжгүй нөхцлүүдийг өргөн хүрээтэй, цогц байдлаар бий болгох (Нийгэм эдийн засаг, улс төр бүхий л хүрээнд)
- Мэдээлэл сайн өгч байх, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх
- Хэвлэл мэдээллийг жинхэнэ утгаар нь зохион байгуулах (Улс төрч бүр хувийн сонин телевизтэй байж болохгүй)

2.3. Хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүн

Шинжээчдийн үнэлгээгээр шүүхийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.46 болж, 2009 оныхоос 0.03 пунктээр, цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.48 болж, 0.02 пунктээр буурсан байна. Харин прокурорын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.75 болж, 2009 оныхоос 0.63 пунктээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагынх 3.30 болж, 0.09 пунктээр тус тус нэмэгдсэн байна (Зураг 5).

Зураг 5. Хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, салбараар



Шүүх байгууллагын хувьд хяналтын (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.75) болон давж заалдах шат (3.67)-нд авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байгаа бол прокурорын байгууллагын хувьд аймаг, нийслэлийн прокурорын (3.92) болон сум (сум дундын), дүүргийн прокурорын (3.75) байгууллагад авлигад өртөх эрсдэл өндөр байна. Харин цагдаагийн байгууллагын хувьд замын цагдаа (3.83), мөрдөн байцаагч (3.75) нарын түвшинд авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байгаа бол шүүхийн шийдвэр байгууллагын хувьд аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд (3.70) авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Хууль хяналтын байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар

Түвшин	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Анхан шатны шүүх	3.64	3.58	-0.06
Хяналтын шатны шүүх	3.45	3.75	0.30
Давж заалдах шатны шүүх	3.44	3.67	0.23
Дээд шүүх	3.44	2.85	-0.59
Шүүхийн байгууллагын дундаж үнэлгээ	3.49	3.46	-0.03
Сум /сум дундын/, дүүргийн прокурор	3.18	3.75	0.57
Аймаг, нийслэлийн прокурор	3.27	3.92	0.65
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	0.67
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	3.12	3.75	0.63
Мөрдөн байцаагч	3.82	3.75	-0.07
Хэрэг бүртгэгч	3.55	3.50	-0.05
Эрүүгийн цагдаа	3.82	3.50	-0.32
Хэв журмын цагдаа	2.91	3.45	0.54
Замын цагдаа	3.82	3.83	0.01
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	-0.27

Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	3.50	3.48	-0.03
Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	0.25
Хорих ял эдлүүлэх алба	3.36	3.20	-0.16
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	0.18
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	3.21	3.30	0.09

Шинжээчдийн үзэж байгаагаар хууль хяналтын байгууллагад холбогдох үйл ажиллагаануудаас прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 4.40), хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах (4.13), прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах (4.09), эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, ялын хэмжээг бууруулах, өр барагдуулах (4.00) зэрэг үйл ажиллагаанд авлигад өртөх харьцангуй өндөр эрсдэлтэй байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа / эрсдлийн үнэлгээ	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Эрүүгийн хэрэг үүсгэх үйл ажиллагаа	3.90	3.92	0.02
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	0.17
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	0.27
Тодорхой хугацаагаар эрх хасах	-	3.83	-
Торгууль ногдуулах	3.36	3.75	0.39
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	0.42
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах	3.22	4.09	0.87
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	0.76
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	0.37
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	0.40
Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	0.26
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх	-	3.78	-
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	0.61
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	0.38
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	3.40	3.50	0.10
Хорих ял эдлүүлэх	-	3.30	-
Өр барагдуулах	-	4.00	-
Хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах	-	4.13	-
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	0.42
Ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/	3.11	3.63	0.52
Албадан дуудлага худалдаанд оруулах	3.22	3.13	-0.10
Шүүхийн шийдвэрийг хурдан гүйцэтгэх	3.56	3.71	0.15

Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал; хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцлийн хангалтгүй байдал; хууль хяналтын байгууллагын

албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмийн дутагдалтай байдал зэрэг хүчин зүйлсийн Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөллийн үнэлгээ харьцангуй өндөр байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ 4.00 байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ

Хүчин зүйлс / нөлөөлөл	2008	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	0.11
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	0.22
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	0.33
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4.00	4.00	0.00
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.20	3.73	4.00	0.27
Дундаж үнэлгээ	3.92	3.69	3.88	0.19

Албан тушаалтны зөрчлийг илрүүлж, түүгээр нь дарамтлах байдал хууль хяналтын байгууллагынхны дунд нийтлэг болсон (тархцын үнэлгээ 4.22) арга хэлбэр болж байна. Хууль бусаар байгууллагын дотоод үйл ажиллагаанд нь оролцох хэлбэрийн тархцын үнэлгээ 2009 онд 3.42 байсан бол 2010 онд 3.83 болж 0.41 пунктээр нэмэгдсэн нь хамгийн их нэмэгдсэн хэлбэрийн нэг болж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтан өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Оролцох нөлөөлөх хэлбэр / тархац	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	0.22
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	0.18
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.42	3.83	0.41
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	-0.06
Шан харамж нэхэх	3.00	3.13	0.13
Дундаж үнэлгээ	3.55	3.72	0.18

Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа бэлэг сэлт өгөх (давтамжийн үнэлгээ 4.09), мөнгө, хөрөнгө өгөх (4.08), олсон ашиг орлогоо хуваахаар амлах (4.00) зэрэг аргуудыг голчлон хэрэглэдэг байна. Шинжээчдийн үзэж байгаагаар 2010 онд нийтлэг болсон арга замуудад өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох (4.22),

улс төрийн хамгаалалтад авах (4.14) арга замууд орж байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахад хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	1.33
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83	4.14	1.31
Бэлэг сэлт өгөх	4.08	4.09	0.01
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	0.00
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	0.70
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.11	3.83	0.72
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	1.25
Өрийг нь төлөх	3.33	3.75	0.42
Албан тушаалд томилох	3.60	3.73	0.13
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.14	3.71	0.57
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	2.50	3.40	0.90
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	0.47
Сургалтын зардал даах	2.63	3.25	0.62
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	0.25
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	0.54
Хувьцаа өгөх	2.00	3.00	1.00
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	3.70	3.00	-0.70
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	1.67	2.50	0.83
Дундаж үнэлгээ	2.99	3.57	0.57

Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 12.0 сая төгрөгийн, хэрэг бүртгэх мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 13.5 сая төгрөгийн, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад дунджаар 12.6 сая төгрөгийн, эрүүгийн хэрэг үүсгэхэд дунджаар 12.6 төгрөгийн хээл хахууль өгдөг өгдөг гэж шинжээчид үзжээ.

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд хээл хахууль өгөхдөө өмгөөлөгчөөр дамжуулах (3.82), зуучлагчаар дамжуулах (3.73) хэлбэрийг илүү түлхүү хэрэглэдэг байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгч, авдаг хэлбэрүүдийн үнэлгээ

	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	0.02
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	0.13
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	0.85
Мөнгө зээлдүүлээд мартгах	3.44	3.57	0.13
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	0.00
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.00	3.22	0.22

Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	0.17
Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	0.27
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	0.14
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	0.51
Дундаж үнэлгээ	3.11	3.36	0.24

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд авлигаар бий болгосон хөрөнгөө голчлон өдөр дутмын хэрэгцээнд болон зугаа цэнгэлд зарцуулах (үнэлгээ 4.78) буюу машин, орон сууц худалдан авах (4.56)-д зарцуулдаг байна (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрүүдийн үнэлгээ

Хэлбэрүүд	2009	2010	Өсөлт, бууралт (2010-2009)
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	0.03
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	-0.22
Машин худалдан авдаг	5.00	4.56	-0.44
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	1.23
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	1.17
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	-0.75
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	3.00	3.67	0.67
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	-0.25
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	0.36
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	0.17
Дундаж үнэлгээ	3.81	4.01	0.20

Шинжээчид хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад нэн тэргүүнд албан хаагчдын ёс зүй, ажлын доголдол, дутагдлыг илрүүлж, хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх (4.67), ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх (4.64), ур чадварт томилгоо хийх (4.62), хууль хяналтын байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх (4.58) зэрэг хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн ач холбогдлын түвшин

Арга хэмжээ / ач холбогдлын түвшин	Ач холбогдлын түвшний үнэлгээ
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын ёс зүй, ажлын доголдлыг тооцож хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	4.67
Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх	4.64
Ур чадварт үндэслэн томилгоо хийх	4.62
Хууль хяналтын байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх	4.58
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх	4.55
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын хууль зүйн балгааг сайжруулах	4.50
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох	4.42

АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	4.38
Авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагын арга хэмжээг чангатгах	4.36
Хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах	4.33
Иргэний нийгмийг өргөн хүрээнд оролцуулах	4.09
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг сэлгэн ажиллуулах	4.00

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараахь арга замуудыг илэрхийлсэн. Үүнд:

- Авлигатай тэмцэх байгууллагын хүрээг тодорхой болгох
- Авлигатай тэмцэхэд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
- Иргэний нийгмийг өргөн хүрээнд оролцуулах
- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй явуулах, үр өгөөжийг дээшлүүлэх
- Албан хаагчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх цогц бодлого боловсруулах
- Ур чадварт суурилсан томилгоог хийх
- Хууль хяналтын байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх
- Орлогын мэдүүлгийг өөрчлөн хяналтыг чангатгах
- Төрийн үйлчилгээг ил тод болгох
- Төрийн албаны хүнд суртлыг арилгах
- Төрийн байгууллагын шат дамжлагыг багасгах
- Төрийн албан тушаалтан, ялангуяа төрийн өндөр албан тушаалтныг авлигын хэрэгт шалгахгүй байгаа зөрчлийг арилгах
- Шүүх, прокурорын болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд зөрчилдөж байгаа хуулиудад нэн яаралтай нэмэлт өөрчлөлтүүдийг хийх.
- Мэргэжлийн ёс зүй болон мэдлэгийн өндөр чадвартай хуульчдыг шударгаар сонгон шалгаруулж томилж байх, төрийн албаны бүтэц болон эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох.
- Хүний нөөцийн шинэчлэл хийх, албан тушаал "зардаг" авдаг тогтолцоог өөрчлөх
- Шүүх эрх мэдлийн хүрээнд иж бүрэн шинэтгэл хийх
- Төрийн зарим эрх мэдлийг хувийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх
- Улс төрийн болон төрийн зүтгэлтний томоохон хахуулийн гэмт хэргийг сайтар мөрдөж шүүн таслан нийтэд ил болгох
- УИХ-ын сонгуулийг төгөлдөршүүлэх, бизнесменүүдийг төрийн бүх байгууллагад орохыг зогсоох, хутган үймүүлэгч, хор найруулагч улс төрчидтэй тэмцэх, ах дүү хамаатан найзын сүлжээг төрийн албанд таслан зогсоох
- Төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагааны ил тод байдал, шударга ёсны зарчим, ажлын байрны сонгон шалгаруулалт, төрийн албан хаагчдын нийгэм эдийн засгийн баталгааг сайжруулах
- Хууль хяналтын байгууллагыг улс төрийн нөлөөллөөс ангид болгох, хуулийн хориг хаалтыг бий болгох,
- Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын албан хаагчдыг хооронд нь зарим хэсгийг сэлгэн ажиллуулах,
- Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг дээшлүүлэх,

- Боловсон хүчний томилгоог ил тод явуулах, өрсөлдөөний журмаар шийдвэрлэх.

3. Дүгнэлт

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн гуравдахь удаагийн судалгааг явуулж үр дүнг нэгтгэн гаргаж та бүхэнд танилцуулж байна. Энэхүү судалгааг гурван жил дараалан явуулснаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдлын өөрчлөлт, хөдөлгөөнийг тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаа юм.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд улс төрийн бүх шатны байгууллага, сонгуулийн үр дүнд байгуулагддаг бүх шатны байгууллага, хэвлэл, мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг; Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд хууль хяналтын байгууллагын бүх салбар, түвшний төрийн байгууллага, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг сонгож оролцуулсан нь тооны хувьд цөөн шинжээч оролцсон хэдий ч өргөн хүрээтэй мэдлэг, мэдээлэл бүхий шинжээчдийг оролцуулан нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч чадсан гэж дүгнэж байна.

Судалгаагаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдал, цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлохын зэрэгцээ энэ хүрээнд аль түвшинд нь авлигын эрсдэл өндөр байгаа, улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлига аль салбар, үйл ажиллагаа голлон чиглэгдэж байгаа, авлигыг үүсгэж байгаа шалтгаан нөхцлүүд, авлига, хээл хахуулийг ямар хэлбэрээр хэрэгжүүлж байгаа, авлигаар бий болгосон хөрөнгөө юунд, хэрхэн зарцуул байгаа, хэдий хэр хэмжээний хөрөнгө авлигатай холбоотойгоор эргэлдэж байгаа зэрэг өргөн хүрээтэй мэдээллийг эндээс олж авах боломжтой.

Судалгааны үр дүн гагцхүү судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлэлт, төсөөлөл бөгөөд тэдгээрт ямар нэг нэмэлт дүгнэлт, тайлбар оруулахгүйгээр шууд танилцуулж байна.

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА
БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2010
ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2010 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

1.1 Судалгааны зорилго, ач холбогдол

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” нь Авлигатай тэмцэх газар (цаашид АТГ гэх)-ын үндсэн чиг үүргийн нэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасны дагуу төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг олон нийтэд хүргэхдээ шударга, хуулийн хүрээнд, ил тод, нээлттэй, тэгш байдлыг хангаж ажиллах ёстой. Шударга байдлын түвшинг үнэлж дүгнэн, үр дүнг нь үйл ажиллагаандаа ашиглах нь төрийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй нэг хэлбэр болно.

Төрийн үйл ажиллагаанд ямар ч нөхцөлд заавал удирдлага болгох нэг үндсэн зарчим бол Үндсэн хуульд тунхагласан шударга ёсны зарчим юм. Хэдийгээр шударга ёс нь өргөн утгаараа ёс суртахуун, улс төр, эрх зүйн шинжтэй асуудал боловч арга зүйн хүрээнд буюу төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хувьд суурь ухагдахуун нь Үндсэн хуулийн дээрх зарчим байх ёстой. Иймээс төрийн байгууллагын шударга байдлын тухай ойлголтыг юуны өмнө Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд авч үзлээ.

АТГ төрийн албаны ард түмэнд шударгаар үйлчлэх зарчим хэрхэн хангагдаж байгаад төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгааны үр дүнд тулгуурлан үнэлгээ өгөх, цаашид төрийн үйлчилгээг хүргэж буй төрийн байгууллагуудын шударга байдал, түүний дотор ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоог дээшлүүлэх ач холбогдолтой юм.

1.2 Судалгааны тайлангийн бүтэц, агуулга

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны тайлан нь дараахь 4 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- Бүлэг 1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны ерөнхий тойм
- Бүлэг 2. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны арга зүй, зохион байгуулалт
- Бүлэг 3. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны үр дүн
- Бүлэг 4. Судалгааны үр дүнд хийсэн дүгнэлтүүд, санал, зөвлөмж.

Тайлангийн 1-р бүлэгт судалгааны зорилго, ач холбогдол, тайлангийн бүтэц, агуулга болон судалгааны товч үр дүн, Бүлэг 2-т судалгааны арга зүй, зохион байгуулалт,

Бүлэг 3-т төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны дүн, төрийн үйлчилгээний төрлөөр, Бүлэг 4-т судалгааны үр дүнд хийсэн дүгнэлтүүд, санал, зөвлөмжийг багтаасан болно.

1.3 Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны товч үр дүн

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааг сонгогдсон төрийн үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлсэн 2503 иргэнийг хамруулсан “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаа”-ны үр дүнд үндэслэн тооцлоо. **Төрийн үйлчилгээний сонгогдсон салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (1-5 хүртэлх үнэлгээгээр) 2.77 буюу дунджаас бага зэрэг дээгүүр гарчээ** (Хүснэгт 1). Төрийн үйлчилгээний сонгогдсон салбаруудын төрийн байгууллагын шударга байдлын түвшин 2.70–2.99 хооронд үнэлэгджээ. Шударга байдлын түвшний үнэлгээгээр Татварын байгууллага (2.99), Нийгмийн даатгалын байгууллага (2.91), Гаалийн байгууллага (2.89) тэргүүлж байгаа бол Газрын алба (2.70), Цагдаагийн байгууллага (2.70), Эрүүл мэндийн байгууллага (2.70) харьцангуй доогуур үнэлгээтэй гарсан байна (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Салбар	Шударга байдлын үнэлгээ	Хувийн жин	Жигнэсэн үнэлгээ
Эрүүл мэндийн байгууллага	2.70	0.549	1.483
Боловсролын байгууллага	2.88	0.035	0.100
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2.84	0.084	0.238
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	0.173	0.502
Газрын алба	2.70	0.020	0.054
Татварын байгууллага	2.99	0.038	0.115
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	0.050	0.135
Гаалийн байгууллага	2.89	0.001	0.002
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	0.043	0.119
Цагдаагийн байгууллага	2.70	0.009	0.024
Төрийн байгууллагуудын дундаж			2.77

БҮЛЭГ II.


ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны арга зүй

АТГ-ын Судалгаа шинжилгээний албанаас төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны аргачлалын төслийг Дэлхийн банкны Засаглалыг дэмжих төслийн дэмжлэгтэйгээр үндэсний зөвлөх, гавьяат хуульч Б.Чимид, доктор Ж.Төртогтох нар хамтран боловсруулсан. Аргачлалын төслийг боловсруулах явцад БНСУ-ын Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны аргачлал, үнэлэх явцтай танилцан өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулсан. Аргачлалын төслийг Үндэсний статистикийн хорооны аргачлал судалгааны байнгын зөвлөлд хүргүүлэн санал авч, АТГ-ын даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлуулсан.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ нь дараахь үзүүлэлт, дэд үзүүлэлтүүдээс бүрддэг (Зураг 1.).

Зураг 1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний үзүүлэлт, дэд үзүүлэлт



Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх мэдээллийн эх үүсвэр нь “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаа”-ны үр дүн байсан. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэхдээ юуны өмнө төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээр тухайн төрийн байгууллагаас иргэдэд төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд дээр дурдсан дэд үзүүлэлт тус бүр хир ач холбогдолтой болох, тухайн байгууллагаас үйлчилгээ авахад дээрх дэд үзүүлэлтүүд ямар түвшинд байсныг үнэлүүлсэн. Үүний дараа дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээ (Т1-7 болон А1-6)- г тухайн дэд үзүүлэлтийн ач холбогдлын түвшний хувийн жингээр үржүүлэн үзүүлэлт тус бүрийн үнэлгээ (Т болон А)-г ; дэд үзүүлэлт (Т болон А) тус бүрийн үнэлгээг тухайн үзүүлэлтийн ач холбогдлын түвшний хувийн жингээр үржүүлэн төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (I)-г тооцсон.

Энэхүү аргачлал нь дараахи онцлог давуу талуудтай:

- Үйлчлүүлэгчдийн тухайн төрийн үйлчилгээнээс хүсч буй үр дүн буюу хүлээлтийг үйлчилгээний гүйцэтгэл буюу үйлчлүүлэгчдийн үнэлгээтэй харьцуулан төрийн байгууллагын шударга байдлыг сайжруулах чиглэлээр цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой.
- Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ нь үйлчлүүлэгчдийн төрийн байгууллагын шударга байдлын талаарх үнэлгээний цаг, хугацаа орон зайн өөрчлөлтийг харуулах үзүүлэлт болохын хувьд цаашид уг судалгааг хоёр жил тутам явуулж, цаг хугацааны хувьд болон салбаруудын хооронд

харьцуулсан дүгнэлт хийж, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийх боломжтой.

Энэ аргачлалын дагуу Төрийн ямар ч байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх боломжтой. Аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn вэб хуудаснаас үзнэ үү.

2.2 Төрийн үйлчилгээ авсан иргэдийн судалгааны түүвэрлэлт

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн судалгааны түүвэрлэлтийг гурван түвшинд хийсэн. **Түүвэрлэлтийн эхний шатанд** төрийн үйлчилгээний төрөл буюу салбарыг тодорхойлсон. Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангахын тулд төрөөс үзүүлж буй дараахь төрлийн төрийн үйлчилгээг хамруулав. Нөгөө талаар эдгээр төрийн үйлчилгээ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрт төлөөлөлтэй байх, үйлчилгээ нь шууд иргэдэд хүрдэг байх гэсэн шалгуурыг давхар авч үзлээ.

Үүнд:

1. Төрийн өмнөөс эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид эрүүл мэндийн байгууллага гэх),
2. Төрийн өмнөөс боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид боловсролын байгууллага гэх),
3. Төрийн өмнөөс хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага гэх),
4. Төрийн өмнөөс нийгмийн даатгалын харилцаатай холбоотой үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид нийгмийн даатгалын байгууллага гэх),
5. Төрийн өмнөөс газрын харилцаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид газрын алба гэх),
6. Төрийн өмнөөс татварын харилцаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид татварын алба гэх),
7. Төрийн өмнөөс улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид улсын бүртгэлийн байгууллага гэх),
8. Төрийн өмнөөс гаалийн хилээр бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид гаалийн байгууллага гэх),
9. Төрийн захиргааны хяналт шалгалтын үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид мэргэжлийн хяналтын байгууллага гэх),
10. Төрийн өмнөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйлчилгээг үзүүлж буй төрийн захиргааны байгууллага (цаашид цагдаагийн байгууллага гэх).

Түүнчлэн 2009 онд явуулсан Авлигын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулах Олон нийтийн төсөөллийн судалгаанаас олон нийтийн төсөөллөөр авлигад ихээхэн автсан гэж тооцогдож буй төрийн байгууллагуудыг төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2010 оны судалгаанд мөн нэмж хамруулсан.

Судалгааны түүвэрлэлтийг хийхийн тулд дээр дурдсан салбаруудаар 2009 онд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог аймаг, нийслэл болон байгууллагын түвшин тус бүрээр нь гаргуулан авсан. Энэ дашрамд төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх статистик мэдээлэл салбар, байгууллага бүр дээр харилцан адилгүй, хангалтгүй байгааг дурдах нь зүйтэй. **Монгол Улсын ДНБ-ий хагасыг зарцуулдаг,**

нийт ажиллагчдын 15 орчим хувь нь ажиллаж байгаа төрийн байгууллагын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь зөвхөн төсвийн зарцуулалт, ажиллагчдын **тоогоор хязгаарлагдаж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.**

Салбар тус бүрийн төрийн захиргааны төв байгууллагаас 2009 онд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог гаргуулан авахад 2009 онд дээрх 10 салбарын төрийн байгууллагуудаар давхардсан тоогоор 25.3 сая үйлчлүүлэгч үйлчлүүлжээ.

Хүснэгт 2. Сонгосон төрийн үйлчилгээний байгууллагуудаар 2009 онд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо, давхардсан тоогоор¹

ДД	Салбар	Үйлчлүүлэгчдийн тоо, мянга	Дүнд эзлэх хувь
1	Эрүүл мэндийн байгууллага	13 881.7	54.9
2	Боловсролын байгууллага	882.4	3.5
3	Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2 125.5	8.4
4	Нийгмийн даатгалын байгууллага	4 366.8	17.3
5	Газрын алба	504.9	2.0
6	Татварын байгууллага	969.1	3.8
7	Улсын бүртгэлийн байгууллага	1 255.4	5.0
8	Гаалийн байгууллага	13.8	0.1
9	Мэргэжлийн хяналтын байгууллага	1 078.6	4.3
10	Цагдаагийн байгууллага	223.2	0.9
	Дүн	25 301.4	100.0

Түүвэрлэлтийн хоёрдахь шатанд салбар доторх байгууллагыг сонгосон. Ингэхдээ салбарын байгууллагуудыг түвшингээр нь ангилан гаргасан. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагын хувьд төрийн захиргааны төв байгууллага буюу Эрүүл мэндийн яам, агентлаг буюу Эрүүл мэндийн газар, тэдгээрийн салбар нэгж буюу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, сумын эмнэлэг, өрхийн эмнэлэг, клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгүүд гэх мэт. Байгууллагын түүвэрлэлтийг нийслэлийн болон аймгийн гэсэн хоёр түвшинд хийсэн.

Аймгийн түвшинд байгууллагын түүвэрлэлтийг хийхдээ түүвэрлэлтийн эхний шатанд сонгогдсон салбаруудаар болон аймгаар 2009 онд үйлчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдийн тоог гаргаж, үйлчлүүлэгчдийн тоогоор нь таван бүлэгт хуваасан. Нэгдүгээр бүлэг 450 мянга хүртэл тооны үйлчлүүлэгч; хоёрдугаар бүлэг 450-550 мянган үйлчлүүлэгч; гуравдугаар бүлэг 550-600 мянган үйлчлүүлэгч; 600-650 мянган үйлчлүүлэгч; тавдугаар бүлэг 650 мянга ба түүнээс дээш тооны үйлчлүүлэгч үйлчлүүлсэн гэсэн таван бүлэгт хуваасан. Дээрх байдлаар төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоогоор аймгуудыг бүлэглэсний дараа бүлэг тус бүрээс нэг аймгийг санамсаргүй байдлаар сонгосон бөгөөд “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаа”-нд Хөвсгөл, Булган, Дорноговь, Ховд, Төв зэрэг аймгуудыг хамруулсан болно (Хүснэгт 3).

¹ Салбарын удирдах дээд байгууллагаас нэгтгэн гаргаж АТГ-т ирүүлсэн мэдээлэл

Хүснэгт 3. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд хамрагдсан аймгийн сонголт

Аймаг	Үйлчлүүлэгчдийн тоо	Бүлэг	Сонголт	Сонгогдсон аймгийн нэр
Булган	411 857	1	1	Булган
Дундговь	346 819	1	0	
Говьсүмбэр	150 481	1	0	
Говь-Алтай	544 989	2	0	Дорноговь
Дорноговь	512 436	2	1	
Өмнөговь	493 559	2	0	
Сүхбаатар	463 719	2	0	
Архангай	555 365	3	0	Төв
Дорнод	578 853	3	0	
Төв	558 610	3	1	
Хэнтий	551 838	3	0	
Баянхонгор	604 485	4	0	
Завхан	610 670	4	0	Хөвсгөл
Өвөрхангай	614 808	4	0	
Увс	630 616	4	0	
Ховд	600 617	4	1	
Баян-Өлгий	677 949	5	0	
Сэлэнгэ	668 667	5	0	
Хөвсгөл	929 106	5	1	Хөвсгөл
Дархан-Уул	1 035 082	5	0	
Орхон	898 591	5	0	

Салбаруудын сонгосон аймаг дахь хэлтэс, газар, албадыг нэлэнхүй байдлаар, аймгийн төвийн бусад нэгжүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосон. Тухайлбал, Ховд аймгийн эрүүл мэндийн байгууллагын хувьд Ховд аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэгийг шууд, аймгийн төвийн өрхийн эмнэлэгүүдээс түүвэрлэх байдлаар сонгож судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт үйлчлүүлэгчдийн тоонд пропорционалиар хуваарилсан (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд оролцох нэгжийн тоо, аймгаар

ДД	Сонгогдсон аймгийн нэр	Эх олонлогийн хэмжээ	Дүнд эзлэх хувь	Түүврийн хэмжээ
4	Булган	411 857	13.7	167
7	Дорноговь	512 436	17.1	208
14	Төв	558 610	18.6	227
10	Ховд	586 312	19.6	250
17	Хөвсгөл	929 106	31.0	377
	Дүн	2 998 321	100.0	1229

Нийслэлийн түвшинд түүвэрлэлтийг хийхдээ салбарын байгууллагуудыг түвшингээр нь ангилан, түвшин тус бүрийн байгууллагын тоо гурваас доош байх тохиолдолд тухайн түвшний байгууллагуудыг нэлэнхүй байдлаар, бусад тохиолдолд санамсаргүй түүврийн аргаар байгууллагуудыг сонгов. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагуудын хувьд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар, Улсын клиникийн

төв эмнэлэг, Клиникийн нэгдсэн II эмнэлэг, Клиникийн нэгдсэн III эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг байгууллагыг нэлэнхүй байдлаар, бусад төвүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эмнэлэгүүдийг санамсаргүй түүврийг аргаар сонгосон. Судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт үйлчлүүлэгчдийн тоонд пропорционалиар хуваарилсан.

Түүвэрлэлтийн гуравдахь шатанд сонгогдсон төрийн байгууллагын үйлчлүүлэгчдээс судалгаанд хамрагдах нэгж буюу үйлчлүүлэгчийг сонгон судалгааг явуулав. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд буюу 2010 оны 6 дугаар сарын 22-ноос 25-ны өдрүүдэд сонгогдсон төрийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчид түүвэрлэлтийн гурав дахь шатны нэгж болсон. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд 2500 нэгж буюу үйлчлүүлэгчдийг хамруулахаар төлөвлөсөн.

2.3 Судалгааны зохион байгуулалт

Судалгааны ажлыг Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас удирдан зохион байгуулж явуулсан бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулах ярилцлага авагч нарын сургалтыг 2010 оны 6 дугаар сарын 21-ний өдөр явуулж, ярилцлага авагч нарыг сургаж бэлтгэн тэднээр дамжуулан ярилцлагаар мэдээллийг 2010 оны 6 дугаар сарын 22-ноос 25-ны хооронд цуглуулсан.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дараахи дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн.

- АТГ-ын США-ны зүгээс судалгааны түүвэрлэлт, хуваарийг гаргасан.
- Судалгааны ярилцлага авагч нарыг сонгон авч, тэдэнд зориулсан сургалтыг зохион байгуулсан.
- Ярилцлага авагч нарт судалгааны асуулга, заавар, судалгаанд хамрагдах нэгжийн жагсаалтыг хүлээлгэн өгсөн.
- Ярилцлага авагч нар сонгогдсон нэгж дээр очиж судалгааны нэгжтэй ярилцах байдлаар судалгааны асуулгыг бөглүүлж авсан.
- Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Хөвсгөл, Ховд, Булган, Дорноговь, Төв аймаг болон нийслэлд хянаж, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажилласан.
- США-наас цуглуулсан мэдээллийг асуулгын дагуу бөглөсөн эсэхэд хяналт тавьж, компьютерт шивж оруулахаар операторуудад хүлээлгэн өгсөн.

Судалгааны мэдээлэл цуглуулах ярилцлага авагч нарт зориулсан зааврыг боловсруулж, тэдэнд зориулсан сургалтан дээр тайлбарлаж танилцуулан ажилласан. Энэхүү зааварт судалгааны зорилго, ач холбогдол, судалгааны ажлын зохион байгуулалт, ярилцлага хийх, асуулгыг бөглөх зөвлөмж, судалгааны мэдээллийг цуглуулахад анхаарах асуудал, судалгааны асуулт тус бүрийг хэрхэн ойлгох тайлбар зэргийг оруулж өгсөн.

2.4 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Ярилцлагаар судалгаанд оролцогчоос үнэн зөв мэдээллийг авахын тулд судалгааны мэдээлэл цуглуулах үе шатанд дараахи зарчмыг баримталсан. Үүнд:

- а) Судалгааны асуулгад судалгааны нэгжийн нэр, хаягийг тусгаагүй.
- б) Ярилцлага өгөгчийг бусдын нөлөөнд автахгүй тайван хариулт өгөх боломжийг

- бүрдүүлсэн нөхцөлд ярилцлагыг явуулсан.
- в) Төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын дэргэд ярилцлага хийгээгүй.
 - г) Ярилцлага өгөгчид асуулгын мөн чанарыг сайтар тайлбарлаж ойлгуулсны дараа ярилцлагаа эхлүүлж явуулсан.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд нийслэл хотод 20, орон нутагт 13, нийт 33 ярилцлага авагч ажиллав.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CPro 4.0 (Census and Survey Program) программ дээр боловсруулсан. Энэхүү мэдээлэл оруулах загвар нь асуулга дээрх мэдээллийн алдааг оруулах үед хянах, операторын зүгээс алдаатай мэдээлэл оруулах эрсдлийг бууруулах боломжийг олгож өгч байгаа юм.

Мэдээллийг оруулж дууссаны дараа CPro 4.0 программын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) программ руу хөрвүүлсэн. Мэдээллийн баазыг бэлтгэсний дараа мэдээллийн баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж мэдээллийг шалгаж холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн. SPSS 16.0 программыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайлан бэлтгэхэд ашигласан.

БҮЛЭГ III. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН


3.1 Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн бүтэц

Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд сонгогдсон төрийн үйлчилгээний арван салбараар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдээс санамсаргүй байдлаар түүвэрлэн судалгаа авсан нь судалгааны мэдээлэлд үндэслэн төрийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн ерөнхий хандлагыг тодорхойлох боломжийг олгож байгаа юм.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд оролцогчдын зонхилох хэсэг нь өөрийгөө болон өрхөө төлөөлөн төрийн байгууллагад хандсан байна. Тухайлбал,

53.8 хувь нь буюу 1347 нь өөрийгөө төлөөлж, 38.4 хувь буюу 962 нь өрх болон өрхийн гишүүдээ төлөөлж төрийн байгууллагад хандсан бол 7.8 хувь буюу 194 нь аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлж төрийн үйлчилгээ авахаар төрийн байгууллагад хандсан байна. Судалгаанд оролцогчдын бүтцийг хүйсээр авч үзвэл тэдний 45.7 хувийг эрэгтэйчүүд, 54.3 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна (Зураг 2.).


Зураг 2. Судалгаанд оролцогчдын бүтэц, хүйсээр




Судалгаанд оролцогчдын насны бүтцээс харахад төрийн байгууллагаар бүхий л насны хүмүүс үйлчлүүлдэг байна. Тухайлбал, нийт үйлчлүүлэгчдийн 39.0 хувь нь 30 хүртэлх насны, 27.8 хувь нь 31-40 насны, 20.5 хувь нь 41-50 насны, 9.2 хувь нь 51-60 хүртэлх насны, 3.5 хувь нь 61 болон түүнээс дээш насны хүмүүс байжээ (Зураг 3.).

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаагаар үйлчлүүлэгчдийн өрхийн амьжиргааны түвшинг бусад дундаж орлоготой өрхүүдтэй харьцуулахад ямар түвшинд байгаа болохыг судалгаанд оролцогчдоор өөрсдөөр нь үнэлүүлсэн. Энэхүү үнэлэмжээр судалгаанд оролцогчдын 57.1 хувь нь дундаж түвшинд, 17.0 хувь нь дунджаас доогуур түвшинд, 10.3 хувь нь доод түвшинд гэж үнэлсэн бол зөвхөн 2.0 хувь нь дээд түвшинд байна гэж үнэлжээ. Төрийн байгууллагаар ихэвчлэн (нийт үйлчлүүлэгчдийн 84.4 хувь нь) дундаж болон түүнээс доогуур түвшний амьжиргаатай өрхийг төлөөлсөн иргэд үйлчлүүлдэг байна (Зураг 4).

Зураг 3. Судалгаанд оролцогчдын бүтэц, насны бүлгээр



Зураг 4. Судалгаанд оролцогчдын амьжиргааны түвшний үнэлгээ, судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар



Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн бүтцийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд 44.1 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош, 16.7 хувь нь техник мэргэжлийн анхан болон тусгай мэргэжлийн дунд шатны, 34.4 хувийг дипломын болон бакалаврын дээд, 4.8 хувийг магистр болон түүнээс дээш боловсролтой иргэд эзэлж байна (Хүснэгт 5.).

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн бүтцийг ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд үйлчилгээ авсан иргэдийн 22.5 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 20.9 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагчид, 16.3

хувийг төрийн албан хаагчид, 11.8 хувийг оюутан/сурагчид, 9.9 хувийг ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа) иргэд, 7.6 хувийг гэртээ байдаг иргэд, 6.0 хувийг тэтгэвэрийн өндөр настнууд, 5.0 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэд эзэлж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 5. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, бүтэц, дүнд эзлэх хувь, боловсролын түвшингээр

Боловсролын түвшин	Тоо	Дүнд эзлэх хувь
Боловсролгүй	28	1.1
Бага боловсролтой	55	2.2
Бүрэн бус дунд	325	13.0
Бүрэн дунд	696	27.8
Техник мэргэжлийн анхан шатны	121	4.8
Тусгай мэргэжлийн дунд	298	11.9
Дипломын болон бакалаврын дээд	860	34.4
Магистр болон түүнээс дээш	120	4.8
Дүн	2503	100.0

Хүснэгт 6. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, бүтэц, дүнд эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал	Тоо	Дүнд эзлэх хувь
Төрийн албан хаагч	407	16.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагч	522	20.9
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэн	126	5.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	564	22.5
Оюутан / сурагч	295	11.8
Ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа)	248	9.9
Гэртээ байдаг	191	7.6
Тэтгэвэрт	150	6.0
Дүн	2503	100.0

3.2 Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн төлөв байдал


Иргэд, үйлчлүүлэгчдээр төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлүүлэхдээ юуны өмнө тэдний тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлж буй давтамж, төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд тохиолддог хүндрэл бэрхшээл, нийт төрийн байгууллага шударга ажилладаг эсэх талаарх ерөнхий үнэлгээг тодруулсан. Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хамгийн сүүлд хэзээ хандсаныг судалгаанд оролцогчдоос асуухад анх удаа хандаж байгаа иргэд 20.7 хувийг, нэг долоо хоногийн өмнө хандсан иргэд 14.4 хувийг, хоёр долоо хоногийн өмнө хандсан иргэд 9.4 хувийг, нэг сарын өмнө хандсан иргэд 21.3 хувийг, гурван сарын өмнө хандсан иргэд 14.6 хувийг, хагас жилийн өмнө хандсан иргэд 10.9 хувийг, жил ба түүнээс дээш хугацааны өмнө хандсан иргэд 8.7 хувийг эзэлж байна. Нийт үйлчлүүлэгчид дунджаар 37 хоногийн дараа буюу нэг сар, нэг долоо хоногийн дараа тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр дахин ирсэн байна.

Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хандсан давтамжийг үзвэл 1-2 удаа хандаж байгаа иргэд 47.8 хувийг, 3-6 удаа хандаж байгаа иргэд 29.4 хувийг, 7-8 удаа хандаж байгаа иргэд 8.8 хувийг, 9 ба түүнээс дээш удаа хандаж байгаа иргэд 13.9

хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогчид дунджаар сүүлийн 12 сарын хугацаанд тухайн төрийн байгууллагад 4.2 удаа хандсан байна.

Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн 10 хүн тутмын 9-д нь хүндрэл бэрхшээл тохиолддог байна. Судалгаанд оролцогчдын 10.1 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж хариулсан бол үлдсэн 89.9 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддог гэжээ. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог бэрхшээлээр төрийн албан хаагчид хүнд суртал ихтэй гэж 25.1 хувь нь, бүрдүүлэх бичиг баримт хэт олон гэж 19.7 хувь нь, төрийн үйлчилгээний шат дамжлага олон гэж 15.9 хувь нь, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу гэж 12.3 хувь нь, хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус гэж 11.7 хувь нь, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар тааруу гэж 4.8 хувь нь, 0.4 хувь нь бусад хүндрэл бэрхшээлүүд тохиолддог гэж үзсэн байна (Зураг 5.).

Зураг 5. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог хүндрэл бэрхшээлүүд, судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар



Нийт төрийн байгууллага, албан хаагчид шударга ажилладаг эсэх дээр судалгаанд оролцогчдын 6.0 хувь нь санал огт нийлэхгүй байна, 17.4 хувь нь санал бага зэрэг нийлж байна, 34.4 хувь нь санал дунд зэрэг нийлж байна, 20.0 хувь нь санал нийлж байна, 23.2 хувь нь санал бүрэн нийлж байна гэж хариулсан байна. Энэхүү үнэлгээнд үндэслэн нийт төрийн байгууллагын шударга байдлын түвшнийг нэгтгэн тооцоход 3.37 гарсан байна.

3.3 Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг хариуцлагатай байдлын болон ил тод байдлын үзүүлэлт, тэдгээрийг бүрдүүлэгч 13 дэд үзүүлэлтээр үнэлсэн. Төрийн байгууллага, албан хаагчид төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд эдгээр дэд үзүүлэлтүүд хэр чухал ач холбогдолтой болохыг судалгаанд оролцогчдоор ач холбогдолгүйгээс маш их ач холбогдолтой хүртэлх (1-5) таван шкалаар үнэлүүлсэн. Иргэд үйлчлүүлэгчид төрийн байгууллага, албан хаагчид төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.36), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.31), албан хаагчдын


ёс зүйтэй байдал (4.29), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.26) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 6.).

Сонгон авсан 13 дэд үзүүлэлтийн дунджаар ач холбогдлын түвшний үнэлгээ 4.13 буюу “ач холбогдолтой” байгаа нь төрийн байгууллага, албан хаагчид үйл ажиллагаагаа шударгаар явуулахад ач холбогдолтой гэж үзэж буй үзүүлэлтүүдийг үнэлгээ, судалгаанд сонгон авч чадсан болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, иргэд үйлчлүүлэгчдийн төрийн байгууллагын үйл ажиллагаанаас хүлээж буй үзүүлэлтүүдийг төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх загварт оруулсан байна гэж үзэж байна. Төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд шударгаар хүргэхийн тулд тухайн үйлчилгээний ямар үзүүлэлтүүдэд нь иргэд, үйлчлүүлэгчид илүү ач холбогдол өгч байна вэ гэдэг дээр анхаарлаа хандуулж ажиллах нь зүйтэй.

Үзүүлэлтийн түвшинд хариуцлагатай байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.21, ил тод байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.05 гэсэн дүнтэй байна.

Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага шударгаар ажиллахад хариуцлагатай байх нь ил тод байхаас илүү ач холбогдолтой гэж иргэд үзэж байна.


Зураг 6. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдэд судалгаанд оролцогчдын өгсөн ач холбогдлын үнэлгээ



Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 13 дэд үзүүлэлтийн ач холбогдлын түвшинг үйлчлүүлэгчдээр үнэлүүлсний дараа дэд үзүүлэлт тус бүр тухайн байгууллагаар үйлчлүүлэхэд хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд байсан гэдэг дээр санал нийлж буй эсэхийг (1-5) таван шкалаар үнэлүүлсэн.

Нийт төрийн байгууллагын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.77 буюу дундаас бага зэрэг дээгүүр түвшинд гарсан байна. Үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлт 2.95, ил тод байдлын үзүүлэлт 2.58 гэж үнэлэгдсэн байна (Зураг 7.). Төрийн байгууллагын шударга байдлын ерөнхий үнэлгээ иргэдийн хүлээлтээс 1.36 пунктээр, үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлтийн үнэлгээ 1.26 пунктээр, ил тод байдлын үзүүлэлтийн үнэлгээ 1.47 пунктээр доогуур байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаа бөгөөд ялангуяа төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал дээр ихээхэн зөрүүтэй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

Зураг 7. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон үнэлгээ



Дэд үзүүлэлтийн түвшинд хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.04), албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.99), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (2.95), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл (дүрэм, журам, стандарт)-ийн энгийн, ойлгомжтой байдал (2.93), албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (2.92) зэрэг дэд үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан бол төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.34), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (2.45), төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог эсэх (2.58) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ харьцангуй доогуур гарсан байна (Зураг 8.).

Зураг 8. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ



Дэд үзүүлэлтийн түвшинд бүх үзүүлэлт дээр иргэдийн хүлээлтээс бодит байдлын үнэлгээ доогуур байгаа бөгөөд энэ хэмжээгээр төрийн байгууллагууд иргэдэд хүссэн хэмжээнд үйлчилж чадахгүй байгааг илтгэн харуулж байгаа юм. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.55), үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.54), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.53), төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.53) тал дээр ихээхэн учир дутагдалтай байгааг иргэд үйлчлүүлэгчид өөрсдийн үнэлгээгээр харууллаа (Зураг 9.).

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаагаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг бүрдүүлэгч 13 дэд үзүүлэлт тус бүрийг үнэлүүлэн, ерөнхий төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлүүлсний зэрэгцээ “энэ удаа танд үйлчилгээ үзүүлсэн төрийн байгууллага, албан хаагч шударга ажилласан гэдэгтэй санал нийлж байна уу?” гэж шууд үнэлүүлсэн. Шууд үнэлгээгээр төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.98 гарсан нь Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлалын дагуу тооцсон үнэлгээнээс 0.21 пунктээр дээгүүр гарсан байна.

Дээрх зөрүү татварын байгууллага (зөрүү 0.33), нийгмийн даатгалын байгууллага (зөрүү 0.26), улсын бүртгэлийн байгууллага (зөрүү 0.25) дээр их гарсан бол цагдаагийн байгууллагын хувьд зөрүүгүй байна (Хүснэгт 7).

Зураг 9. Төрийн байгууллагын үйл ажиллагааны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын болон бодит байдлын үнэлгээний зөрүү



Хүснэгт 7. Төрийн байгууллагын шударга байдалд өгсөн шууд үнэлгээ болон төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, тэдгээрийн зөрүү, салбараар

Салбар	Шууд үнэлгээ	ТБШБТ-ний үнэлгээ	Зөрүү
Эрүүл мэндийн байгууллага	2.87	2.70	0.17
Боловсролын байгууллага	3.08	2.88	0.20
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2.94	2.84	0.10
Нийгмийн даатгалын байгууллага	3.17	2.91	0.26
Газрын алба	2.80	2.70	0.10
Татварын байгууллага	3.33	2.99	0.33
Улсын бүртгэлийн байгууллага	2.98	2.73	0.25
Гаалийн байгууллага	3.06	2.89	0.17
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.89	2.80	0.09
Цагдаагийн байгууллага	2.70	2.70	0.00
Төрийн байгууллагуудын дундаж	2.98	2.77	0.21

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээнд хамрагдсан төрийн үйлчилгээний салбар тус бүрээр төрийн байгууллагын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг авч үзье.

3.4 Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Эрүүл мэндийн байгууллагаар 2009 онд давхардсан тоогоор 13.9 сая үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.70 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.07 пунктээр доогуур гарсан байна. Эрүүл мэндийн байгууллагын хувьд байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (зөрүү -0.14); төсөв санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.11); үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.10); хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.09); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.09); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.09) зэрэг дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.09-0.14 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 8.). Эрүүл мэндийн байгууллагын хувьд харин иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох тал дээр бусад төрийн байгууллагуудаас дээгүүр үнэлэгдсэн (0.05) байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Эрүүл мэндийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	2.94	3.04	-0.09
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.78	2.87	-0.09
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	2.93	2.99	-0.06
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.86	2.92	-0.06
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.00	2.95	0.05
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.74	2.82	-0.08
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.87	2.93	-0.06
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.62	2.71	-0.09
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.76	2.77	-0.01
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.57	2.62	-0.05
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.48	2.58	-0.10

Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.23	2.34	-0.11
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.31	2.45	-0.14
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.70	2.77	-0.07

Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (үнэлгээ 3.00), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (2.94), албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.93) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.23), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.31) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 8).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар эрүүл мэндийн байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.42), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.34), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.34), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.26) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 10.).

Эрүүл мэндийн байгууллага, албан хаагчид үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийнхээ талаарх мэдээллийг хүртээмжтэй байлгах (зөрүү -1.70), төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.65), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.64), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.64) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 10.).

3.5 Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ


Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.88 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.11 пунктээр дээгүүр гарсан байна. Боловсролын байгууллагын хувьд төсөв санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (зөрүү 0.20); үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.18); үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.17); байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (0.16) зэрэг дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.16-0.20 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 9.).

Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.08), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.08), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (3.07), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (3.07) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй

байдал (2.54), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.63), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.69) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 9).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар боловсролын байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.25), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.21) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 11.). Багш сурган хүмүүжүүлэгч нар нь мэдлэг чадвартай байж, суралцагчдыг ялгаварлалгүй тэгш, соёлтой боловсон хандах нь боловсролын байгууллагын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Зураг 10. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



Боловсролын байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.43), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-1.28), албан хаагчид нь мэдлэг чадвартай байж, түргэн шуурхай

үйлчлэх (-1.26) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 11.).

3.6 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.83 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.07 пунктээр дээгүүр гарсан байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын хувьд төсөв санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (зөрүү 0.19); үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.14); үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.13); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.13); иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (0.11) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.11-0.19 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 10.).


Хүснэгт 9. Боловсролын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Боловсролын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.08	3.04	0.04
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.98	2.87	0.12
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.07	2.99	0.08
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.01	2.92	0.09
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.99	2.95	0.04
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.99	2.82	0.16
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.07	2.93	0.14
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.81	2.71	0.11
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.77	2.77	0.00
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.69	2.62	0.07
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.76	2.58	0.17

Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.54	2.34	0.20
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.63	2.45	0.18
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.88	2.77	0.11

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага, тэдгээрийн албан хаагчид олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж ажиллаж буй байдал (-0.05), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.02), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.01) зэрэг үзүүлэлтийн хувьд төрийн байгууллагуудын дунджаас доогуур байна.

Зураг 11. Боловсролын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.17), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.00), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (2.97), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (2.93) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.48), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.64), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.71) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 10).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага шударгаар ажиллахад төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.28), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.26), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.24), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.22) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 12.).


Хүснэгт 10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.17	3.04	0.13
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.91	2.87	0.04
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.00	2.99	0.01
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.97	2.92	0.05
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.93	2.95	-0.02
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.92	2.82	0.10
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.92	2.93	-0.01
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.74	2.71	0.03
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.72	2.77	-0.05
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.73	2.62	0.11
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.71	2.58	0.13

Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.48	2.34	0.14
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.64	2.45	0.19
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.83	2.77	0.07

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.54), төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (-1.42), төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.40), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1,39), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.37) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 12.).

Зураг 12. Хөдөлмөр халамжийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.7 Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.91 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.14 пунктээр дээгүүр гарсан байна. Нийгмийн даатгалын байгууллагын хувьд үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (зөрүү 0.24); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (0.23); үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.21); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.18) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.18-0.24 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 11.). Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.10) гэсэн үзүүлэлтийн хувьд төрийн байгууллагуудын дунджаас доогуур байна.

Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.22), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.12), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.10), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.04) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.50), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.69), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.70) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 11).


Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар нийгмийн даатгалын байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.30), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.29), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.23) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 13.).

Нийгмийн даатгалын байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.44), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.42), байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.37), төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.34) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 13.).

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Нийгмийн даатгалын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.22	3.04	0.18
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.10	2.87	0.23
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.12	2.99	0.13
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.04	2.92	0.12
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.85	2.95	-0.10
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.92	2.82	0.10
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.09	2.93	0.16
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.87	2.71	0.16
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.87	2.77	0.10
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.70	2.62	0.08
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.79	2.58	0.21
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.50	2.34	0.16
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.69	2.45	0.24
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.91	2.77	0.14

Зураг 13. Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.8 Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээ

Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээ 2.70 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.07 пунктээр доогуур гарсан байна. Газрын албаны хувьд хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (зөрүү -0.24), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.22), албан хаагчдын ёс зүйтэй байдал (-0.11), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.08) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.08-0.24 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад голчлон нөлөөлсөн байна (Хүснэгт 12.).


Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.34), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.44), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.58) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Газрын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Газрын алба	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	2.80	3.04	-0.24
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.80	2.87	-0.07
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	2.88	2.99	-0.11
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.89	2.92	-0.03
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.73	2.95	-0.22
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.81	2.82	-0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.86	2.93	-0.07
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.63	2.71	-0.08
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.72	2.77	-0.05
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.64	2.62	0.02
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.58	2.58	-0.01
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.34	2.34	0.00
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.44	2.45	-0.01
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.70	2.77	-0.07

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар газрын алба шударгаар ажиллахад албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.30), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.26), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.21), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (4.20) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 14.).

Зураг 14. Газрын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



Газрын албаны хувьд төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (зөрүү -1.60) төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.59), байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.58), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.55) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 14.).

3.9 Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээ

Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээ 2.99 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.22 пунктээр дээгүүр гарсан байна. Татварын албаны хувьд төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (зөрүү 0.31); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.29); албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.29); үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.26); албан хаагчдын ёс зүйтэй байдал (0.24); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.24) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.24-0.30 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 13.).

Хүснэгт 13. Татварын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү


Үзүүлэлт	Татварын алба	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.33	3.04	0.29
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.06	2.87	0.19
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.23	2.99	0.24
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.22	2.92	0.29
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.10	2.95	0.15
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.00	2.82	0.17
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.25	2.93	0.31
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.95	2.71	0.24
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.96	2.77	0.19
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.75	2.62	0.13
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.78	2.58	0.19
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.52	2.34	0.18
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.71	2.45	0.26
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.99	2.77	0.22

Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.33), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (3.25), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.23), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.22), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.10) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.52), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.71), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.75) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 13).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар татварын алба шударгаар ажиллахад албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.30), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.29), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.23) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 15.).

Татварын албаны хувьд төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.50), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.44), байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.37), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-1.35) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 15.).

Зураг 15. Татварын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.10 Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.73 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.04 пунктээр доогуур гарсан байна. Улсын бүртгэлийн байгууллагын хувьд төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.20), иргэдийг чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.19), албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (-0.14); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.07) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.07- 0.20 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 14.).

Хүснэгт 14. Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Улсын бүртгэлийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.03	3.04	-0.01
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.80	2.87	-0.07
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	2.96	2.99	-0.03
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.78	2.92	-0.14
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.75	2.95	-0.19
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.83	2.82	0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.88	2.93	-0.05
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.80	2.71	0.09
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.57	2.77	-0.20
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.60	2.62	-0.02
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.54	2.58	-0.04
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.43	2.34	0.09
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.46	2.45	0.01
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.73	2.77	-0.04


Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.43), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.46), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.54) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байна (Хүснэгт 14).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар улсын бүртгэлийн байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.31), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.22), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.20), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.20) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 16.).

Улсын бүртгэлийн байгууллагын хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (зөрүү -1.53), албан хаагчид нь мэдлэг чадвартай байж, түргэн

шуурхай үйлчлэх (-1.52), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.52), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр

Зураг 16. Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.11 Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.87 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.10 пунктээр дээгүүр гарсан байна. Гаалийн байгууллагын хувьд албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (зөрүү 0.44); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.39); албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.36); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.26); албан хаагчдын ёс зүйтэй байдал (0.24) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.24-0.44 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 15.). Түүнчлэн иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.33), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.18), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.18) зэрэг үзүүлэлтүүд дээр нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарсан байна.

Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (үнэлгээ 3.31), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.30), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.28), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.23) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.21), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.41), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.46) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 15).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар гаалийн байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.42), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.39), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.34), байгууллагын удирдлага хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй байдал (4.25), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (4.25), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.25) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 17.).


Хүснэгт 15. Гаалийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Гаалийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.30	3.04	0.26
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.31	2.87	0.44
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.23	2.99	0.24
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.28	2.92	0.36
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.62	2.95	-0.33
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.90	2.82	0.08
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.03	2.93	0.10
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.10	2.71	0.39
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.76	2.77	-0.01
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.69	2.62	0.07
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.41	2.58	-0.18
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.21	2.34	-0.13

Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.46	2.45	0.01
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.87	2.77	0.10

Гаалийн байгууллагын хувьд байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (зөрүү -1.70), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох (-1.63), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.41), төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж ажиллах (-1.31) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 17.).

Зураг 17. Гаалийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.12 Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.79 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.03 пунктээр дээгүүр гарсан байна. Мэргэжлийн хяналтын байгууллагын хувьд байгууллагын удирдлага хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (зөрүү 0.20); байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (0.15); төрийн байгууллага, албан хаагчийн үйл

ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (0.10); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.08) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.08-0.20 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 16.). Нөгөө талаар байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.10), байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.10), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.08) зэрэг үзүүлэлтүүд дээр нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарсан байна.

Хүснэгт 16. Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү


Үзүүлэлт	Мэргэжлийн хяналтын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.07	3.04	0.03
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.81	2.87	-0.05
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.05	2.99	0.06
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.98	2.92	0.06
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.99	2.95	0.04
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.02	2.82	0.20
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.84	2.93	-0.10
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.79	2.71	0.08
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.67	2.77	-0.10
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.53	2.62	-0.08
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.54	2.58	-0.04
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.49	2.34	0.15
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.55	2.45	0.10
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.79	2.77	0.03

Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ

3.07), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.05), байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (3.02) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.49), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.53), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.54) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 16).

Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар мэргэжлийн хяналтын байгууллага шударгаар ажиллахад байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.36), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.28), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.27), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.24), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (4.23) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 18.).

Зураг 18. Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



Мэргэжлийн хяналтын байгууллагын хувьд байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр

тогтмол ажил зохиож ажиллах (зөрүү -1.69), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.57), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (-1.55), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.49), албан хаагчид нь мэдлэг чадвартай байж түргэн шуурхай үйлчлэх (-1.47) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 18.).

3.13 Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.70 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.07 пунктээр доогуур гарсан байна. Цагдаагийн байгууллагын хувьд хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.19); иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.17); байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.16); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.12), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.12) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.12-0.19 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 17.).

Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.22), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.44), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.49), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.59) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 17).


Иргэд үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар цагдаагийн байгууллага шударгаар ажиллахад байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.14), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.08), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.07), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.04), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (4.01) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 19.).

Цагдаагийн байгууллагын хувьд байгууллагын үйл ажиллагааны төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.51), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (-1.51), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.49), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.44), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (-1.42), албан хаагчид нь мэдлэг чадвартай байж түргэн шуурхай үйлчлэх (-1.33) зэрэг асуудал дээр иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 19.).

Хүснэгт 17. Цагдаагийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Цагдаагийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	2.85	3.04	-0.19
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.75	2.87	-0.12
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	2.92	2.99	-0.07
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.89	2.92	-0.03
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.88	2.95	-0.07
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.81	2.82	-0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.77	2.93	-0.16
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.66	2.71	-0.05
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.75	2.77	-0.02
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.44	2.62	-0.17
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.59	2.58	0.01
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.22	2.34	-0.12
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал	2.49	2.45	0.04
Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	2.70	2.77	-0.07

Зураг 19. Цагдаагийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



БҮЛЭГ IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС ХИЙСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1 Судалгааны үр дүнгээс хийсэн дүгнэлт

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаагаар цуглуулагдсан мэдээлэл болон Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээнд үндэслэн дараахь дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Төрийн байгууллага иргэд, үйлчлүүлэгчдийн өмнө хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулахад салбарын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх статистик мэдээлэл, тухайлбал, үйлчлүүлэгчдийн тооны талаарх мэдээлэл хангалтгүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх статистик мэдээлэл салбар, байгууллага бүр дээр харилцан адилгүй, хангалтгүй байна. Монгол Улсын ДНБ-ий хагасыг зарцуулдаг, нийт ажиллагчдын 15 орчим хувь нь ажиллаж байгаа төрийн байгууллагын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь зөвхөн төсвийн зарцуулалт, ажиллагчдын тоогоор хязгаарлагдаж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.
- Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй арван хүн дутмын ес нь ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчид хүнд суртал ихтэй, төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримт, шат дамжлага хэт олон, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу, хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус зэрэг хүндрэл бэрхшээлүүд иргэд үйлчлүүлэгчдэд голчлон тохиолддог байна. Салбар бүрээр энэ нөхцөл байдлыг арилгах, төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд юунд анхаарлаа хандуулан ажиллах шаардлагатайг энэ судалгааны үр дүн зааж өгөх болно.
- Сонгосон төрийн үйлчилгээний салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.77 буюу дунджаас бага зэрэг дээгүүр гарсан хэдий ч иргэдийн хүлээлтээс 1.36 пунктээр доогуур гарсан байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлт тус бүрээр иргэдийн хүлээлтээс хол зөрүүтэй байгаа үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулж, тэдгээрийг сайжруулах замаар иргэдийн хүсэн хүлээсэн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд чиглэн ажиллах шаардлагатай байна.
- Иргэд, үйлчлүүлэгчид төрийн байгууллагаас төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд албан хаагчдын мэдлэг ур чадвар, түргэн шуурхай байдал, соёлтой боловсон үйлчлэх, ёс зүйтэй байх, хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй тэгш хандаж үйлчлэх нь илүү чухал ач холбогдолтой гэж үзсэн байна.
- Үзүүлэлтийн түвшинд хариуцлагатай байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.21, ил тод байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.05 гэсэн дүнтэй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага шударгаар ажиллахад хариуцлагатай байх нь ил тод байхаас илүү ач холбогдолтой гэж иргэд үзэж байна.
- Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаа бөгөөд ялангуяа төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал дээр ихээхэн зөрүүтэй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.55),

үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийнхээ талаарх мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.54), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (- 1.53), төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.53) тал дээр ихээхэн учир дутагдалтай байгааг иргэд, үйлчлүүлэгчид өөрсдийн үнэлгээгээр харууллаа.

- Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчид “нийт төрийн байгууллага шударга ажилладаг уу” гэсэн асуултад 3.37, “энэ удаа танд үйлчилсэн төрийн байгууллага албан хаагч шударга ажилласан уу” гэсэн асуултад 2.98 гэсэн үнэлгээ өгсөн бол Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2.77 гарсан байна. Энэ нь шударга байдлыг иргэд янз бүрээр ойлгодог бөгөөд үзүүлэлт тус бүрээр нь ялган авч үзэхэд илүү нарийн үнэлгээг өгдөг болохыг дээрх үр дүн харуулж байна.
- Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгааны үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээний 10 салбарын шударга байдлын түвшинг тодорхойлсон бөгөөд энэхүү тооцооны үр дүнгээс дараахь дүгнэлтүүдийг хийх боломжтой. Үүнд:
 - Салбарын төрийн байгууллагын зүгээс иргэдэд төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдийг тодорхойлох.
 - Шударга байдлын үнэлгээ харьцангуй өндөр болон доогуур гарсан үзүүлэлтийг тодорхойлж, анхаарах чиглэлийг тогтоох.
 - Төрийн бусад үйлчилгээний салбартай харьцуулахад ямар түвшинд байгааг тодорхойлж, энэ чиглэлээр сайн үнэлгээтэй байгаа салбарын нөхцөл байдлыг судлан үзэж, туршлагыг нэвтрүүлэх.
 - Иргэд үйлчлүүлэгчдийн хүлээлт буюу ач холбогдлын үнэлгээнээс харьцангуй их зөрүүтэй байгаа үзүүлэлтийг тогтоож, энэ чиглэлд анхаарлаа хандуулан ажиллаж, зөрүүг арилгах.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2010 оны судалгаагаар цуглуулагдсан мэдээлэл болон Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээнд үндэслэн дараахь санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг бүрдүүлэгч үзүүлэлт, дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлыг нийт төрийн байгууллага, иргэд үйлчлүүлэгчдэд сурталчлан таниулах. Тухайлбал, “Шударга байна гэдэг бол ил тод нээлттэй байна гэсэн үг”, “Ил тод, нээлттэй байна гэдэг бол иргэдийн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах явдал юм” гэх мэт.
2. Төрийн үйлчилгээний салбар тус бүрээр шударга байдлын түвшинг дээшлүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч ажиллах. Үүнд:
 - 2.1 Салбарын төрийн байгууллагын зүгээс иргэдэд төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулан ажиллах.
 - 2.2 Иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээлт буюу ач холбогдлын үнэлгээнээс харьцангуй их зөрүүтэй байгаа үзүүлэлтэд анхаарлаа хандуулан ажиллаж, зөрүүг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах.
 - 2.3 Төрийн бусад үйлчилгээний салбартай харьцуулахад ямар түвшинд байгааг тодорхойлж, энэ чиглэлээр сайн үнэлгээтэй байгаа салбарын нөхцөл байдлыг судлан үзэж, туршлагыг нэвтрүүлэх.
3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг тодорхойлох зорилгоор төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн, тухайлбал үйлчлүүлэгчдийн тооны талаарх статистик мэдээллийн тогтолцоог төрийн үйлчилгээний байгууллагуудад нэвтрүүлэх.

Хавсралт.

Төрийн байгууллагын шударга байдлын
үнэлгээний үзүүлэлтүүд, салбараар

Салбар	Шударга байдлын түвшний үнэлгээ	Дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын дундаж үнэлгээ	Үйлчлүүлэгчдийн хүлээлт болон бодит байдлын үнэлгээ хоёрын зөрүү	Төрийн байгууллагын дундажтай харьцуулсан зөрүү	Ач холбогдол өндөртэй дэд үзүүлэлтүүд
Эрүүл мэндийн байгууллага	2.70	4.13	- 1.43	- 0.07	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.42), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.34), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.34), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.26)
Боловсролын байгууллага	2.88	4.02	- 1.14	+ 0.11	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.25), 2. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), 3. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.21), 4. Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (4.13)
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2.84	4.12	- 1.28	+ 0.07	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.28), 2. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.26), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.24), 4. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.22)
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	4.12	- 1.21	+ 0.14	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.30), 2. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.29), 3. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.23)
Газрын алба	2.70	4.11	- 1.41	-0.07	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.30), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.26), 3. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.21), 4. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (4.20)

Татварын байгууллага	2.99	4.19	- 1.20	+0.22	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.30), 2. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.29), 3. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.24), 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.23)
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	4.08	- 1.35	- 0.04	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.31), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.22), 3. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.20), 4. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.20)
Гаалийн байгууллага	2.89	4.12	- 1.23	+ 0.10	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.42), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.39), 3. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.34), 4. Байгууллагын удирдлага хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй байдал (4.25), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (4.25), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.25)
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	4.16	- 1.36	+ 0.03	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.36), 2. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.28), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.27), 4. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.24)
Цагдаагийн байгууллага	2.70	3.97	- 1.27	- 0.07	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.14), 2. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.08), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.07), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.04), 4. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (4.01)
Төрийн байгууллагуудын дундаж	2.77	4.13	- 1.36		<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.36), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.31), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.29), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.26)

Үргэлжлэл

Салбар	Үнэлгээ харьцангуй өндөр гарсан дэд үзүүлэлтүүд	Үнэлгээ харьцангуй доогуур гарсан дэд үзүүлэлтүүд	Үйлчлүүлэгчдийн хүлээлтээс үнэлгээ харьцангуй их зөрүүтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Эрүүл мэндийн байгууллага	<ol style="list-style-type: none"> Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (3.00), Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (2.94), Албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.93), Албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (2.86) 	<ol style="list-style-type: none"> Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.23), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.31) Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог эсэх (2.48) Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.57) 	<ol style="list-style-type: none"> Байгууллага, албан хаагчид үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийнхээ талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (зөрүү -1.70), Төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.65), Төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.64), Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.64)
Боловсролын байгууллага	<ol style="list-style-type: none"> Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.08), Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.08), Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (3.07), Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (3.07) 	<ol style="list-style-type: none"> Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.54), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.63), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.69), Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог эсэх (2.76) 	<ol style="list-style-type: none"> Байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.43), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-1.28), Албан хаагчид нь мэдлэг чадвартай байж, түргэн шуурхай үйлчлэх (-1.26), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байлгах (-1.23)
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	<ol style="list-style-type: none"> Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.17), Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.00), Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (2.97), Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (2.93) 	<ol style="list-style-type: none"> Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.48), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.64), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.71) 	<ol style="list-style-type: none"> Байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -1.54), Төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (-1.42), Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.40), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.39)
Нийгмийн даатгалын байгууллага	<ol style="list-style-type: none"> Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.22), Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.12), Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.10), Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.04) 	<ol style="list-style-type: none"> Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.50), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.69), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.70) 	<ol style="list-style-type: none"> Төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.44), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.42), Байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.37), Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.34)

Салбар	Үнэлгээ харьцангуй өндөр гарсан дэд үзүүлэлтүүд	Үнэлгээ харьцангуй доогуур гарсан дэд үзүүлэлтүүд	Үйлчлүүлэгчдийн хүлээлтээс үнэлгээ харьцангуй их зөрүүтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Газрын алба	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.34), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.44), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.58), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (2.63) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.34), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.44), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.58), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (2.63) 	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (зөрүү -1.60) 2. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.59), 3. Байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.58), 4. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.55)
Татварын байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.33), 2. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (3.25), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.23), 4. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.22) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.52), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.71), 3. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.75) 4. Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.78) 	<ol style="list-style-type: none"> 1. Төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.50), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (-1.44), 3. Байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.37), 4. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-1.35)
Улсын бүртгэлийн байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.03), 2. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.96), 3. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (2.88), 4. Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (2.83) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.43), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.46), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.54), 4. Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (2.57) 	<ol style="list-style-type: none"> 1. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (зөрүү -1.53), 2. Албан хаагчид нь мэдлэг чадвартай байж, түргэн шуурхай үйлчлэх (-1.52), 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.52), 4. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (-1.50)

Салбар	Үнэлгээ харьцангуй өндөр гарсан дэд үзүүлэлтүүд	Үнэлгээ харьцангуй доогуур гарсан дэд үзүүлэлтүүд	Үйлчлүүлэгчдийн хүлээлтээс үнэлгээ харьцангуй их зөрүүтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Гаалийн байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (үнэлгээ 3.31), 2. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.30), 3. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.28), 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.23) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.21), 2. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.41) 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.46) 4. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (2.62) 	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (зөрүү -1.70), 2. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох (-1.63), 3. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.41), 4. Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж ажиллах (-1.31)
Мэргэжлийн хяналтын байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.07), 2. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.05), 3. Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (3.02), 4. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (2.99) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.49), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.53), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.54) 4. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.55) 	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (зөрүү -1.69), 2. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.57), 3. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (-1.55), 4. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.49)
Цагдаагийн байгууллага	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.92), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (2.89), 3. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (2.88), 4. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (2.85) 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.22), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.44), 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (2.49), 4. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (2.59) 	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг нээлттэй байлгах (зөрүү -1.51), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (-1.51), 2. Байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.49), 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.44), 4. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (-1.42)

Салбар	Үнэлгээ харьцангуй өндөр гарсан дэд үзүүлэлтүүд	Үнэлгээ харьцангуй доогуур гарсан дэд үзүүлэлтүүд	Үйлчлүүлэгчдийн хүлээлтээс үнэлгээ харьцангуй их зөрүүтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Төрийн байгууллагуудын дундаж	<ol style="list-style-type: none"> Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.04), Албан хаагчдын ёс зүйтэй байдал (2.99), Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (2.95), Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл (дүрэм, журам, стандарт)-ийн энгийн, ойлгомжтой байдал (2.93) 	<ol style="list-style-type: none"> Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.34), Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (2.45), Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог эсэх (2.58) Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (2.62) 	<ol style="list-style-type: none"> Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.55), Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийнхээ талаарх мэдээллийг хүртээмжтэй байлгах (-1.54), Төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.53), Төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.53)

Үргэлжлэл

Салбар	Төрийн байгууллагын дунджаас дээгүүр үнэлгээтэй гарсан дэд үзүүлэлтүүд	Төрийн байгууллагын дунджаас доогуур үнэлгээтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Эрүүл мэндийн байгууллага	<ol style="list-style-type: none"> Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (0.05) 	<ol style="list-style-type: none"> Байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (зөрүү -0.14); Төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.11); Үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.10); Хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.09); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.09); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.09)
Боловсролын байгууллага	<ol style="list-style-type: none"> Төсөв санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (зөрүү 0.20); Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.18); Үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.17); Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (0.16) 	
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	<ol style="list-style-type: none"> Төсөв санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (зөрүү 0.19); Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.14); Үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.13); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.13); Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (0.11) 	<ol style="list-style-type: none"> Байгууллага, албан хаагчид олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж ажиллаж буй байдал (-0.05), Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.02), Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.01)
Нийгмийн даатгалын байгууллага	<ol style="list-style-type: none"> Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (зөрүү 0.24); Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (0.23); Үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.21); Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.18) 	<ol style="list-style-type: none"> Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.10)

Салбар	Төрийн байгууллагын дунджаас дээгүүр үнэлгээтэй гарсан дэд үзүүлэлтүүд	Төрийн байгууллагын дунджаас доогуур үнэлгээтэй гарсан дэд үзүүлэлтүүд
Газрын алба	1. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (зөрүү 0.02)	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (зөрүү -0.24), 2. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.22), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (-0.11), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.08)
Татварын байгууллага	1. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (зөрүү 0.31); 2. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.29); Албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.29); 3. Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.26); 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (0.24); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.24)	
Улсын бүртгэлийн байгууллага	1. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.09), Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (0.09) 2. Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (0.01), Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (0.01)	1. Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.20), 2. Иргэдийг чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.19), 3. Албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (-0.14); 4. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.07)
Гаалийн байгууллага	1. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (зөрүү 0.44); 2. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.39); 3. Албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.36); 4. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.26)	1. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.33), 2. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.18), 3. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.18)
Мэргэжлийн хяналтын байгууллага	1. Байгууллагын удирдлага хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (зөрүү 0.20); 2. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (0.15); 3. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (0.10); 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.08)	1. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.10), Байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.10), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.08), 3. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.05), 4. Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.04)
Цагдаагийн байгууллага	1. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаархи мэдээллийн хүртээмжтэй байдал (0.04) 2. Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (0.01)	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.19); 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.17); 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаархи (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.16); 4. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.12), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (-0.12)

**УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
2011 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2011 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны үндэслэл, зорилго

Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагын дээд хэмжээний уулзалтаас гаргасан Мянганы тунхаглалыг баталсан бусад улс орны нэгэн адил улс орныхоо хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг тусгасан Мянганы хөгжлийн үндэсний зорилго, зорилтуудыг тодорхойлсон. УИХ-аас 2005 онд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-уудыг батлахдаа үндсэн найман зорилгоос гадна хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг нэмж баталсан.

Энэхүү зорилгын хүрээнд “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дэх зорилтыг тавьсан бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуурын нэгээр “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газар (АТГ)-т даалгасан.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн багтай хамтран боловсруулсан арга зүйн дагуу АТГ-аас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн судалгааг гурав дахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргаад байна.

Тус судалгаа нь улс төрийн болон хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг шинжээчдийн үнэлгээгээр тодорхойлж, энэ хүрээнд дэх авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг өгөхөд чиглэгдсэн юм.

1.2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь дараахь агуулгыг илэрхийлэх тоон үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын цар хүрээ, тархалт;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигад өртөх эрсдэл бүхий түвшин, салбар, байгууллага;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын шалтгаан, нөхцөл;
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын төрөл, хэлбэр, хэмжээ.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа”-ны дүнд үндэслэн тооцсон. Судалгааны асуулгад дээрх үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг авах, түүнчлэн, асуудлыг тайлбарлах нэмэлт асуултуудыг оруулсан.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын төсөөллийн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа, бүрдүүлэгч дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг 5

онооны хэмжээсээр гаргаж (тухайлбал: 1- огт үгүй, 5-маш их), дэд үзүүлэлтүүдийн энгийн арифметикийн дунджаар тооцсон болно.

Энэ удаагийн судалгаагаар Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг: улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт; хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт гэсэн байдлаар тус тусад нь тооцсон.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 7 бүлэг, 42 дэд үзүүлэлтээр, Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 6 бүлэг, 30 дэд үзүүлэлтээр тооцсон.

Энэхүү улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь зөвхөн судалгаанд хамрагдсан шинжээчдийн төсөөлөл, үнэлгээ, дүгнэлт гэдгийг энд дурьдах хэрэгтэй.

1.3. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ

Судалгаанд *Улс төрийн хүрээ* гэдэгт бүх шатны сонгуулийн үр дүнд байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн бол *Хууль хяналтын байгууллагын хүрээ (шүүх эрх мэдлийн ба хууль сахиулах байгууллага)* гэдэгт шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн.


Судалгаанд оролцох шинжээчдийг сонгохдоо улс төрийн болон хууль хяналтын байгууллагад ажилласан туршлага, тухайн хүрээний талаарх мэдээ мэдээлэлтэй ажиллаж буй эсэх, тэдгээрт тулгуурласан судалгаа дүн шинжилгээний ажил хийдэг, түүнчлэн өмнөх судалгаануудад оролцож байсан эсэх зэрэг шалгуурыг харгалзан үзсэн. Энэ удаагийн судалгаанууд улс төрийн хүрээг үнэлэх 13, хууль хяналтын байгууллагын хүрээг үнэлэх 13, нийт 26 шинжээч оролцсон.

2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийн ерөнхий үр дүн

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2011 онд 4.07 болж, 2010 оны түвшинд байсан байна (Зураг 1). Өөрөөр хэлбэл, шинжээчдийн үзэж байгаагаар улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын түвшин өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна.

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчийн төсөөллийн үзүүлэлт



Үүний дотор улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 4.14 болж, 2010 оныхоос 0.01 пунктээр нэмэгдсэн бол хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт 3.95 болж 0.03 пунктээр буурчээ.

2.2. “Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл” судалгааны дүн

Судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлгээгээр 2011 оны байдлаар улс төрийн хүрээн дэх авлигын тархцын үнэлгээ 4.58 буюу “ихээхэн түгээмэл” гарсан нь 2010 оныхоос 0.08 пунктээр өссөн байна.


Улс төрийн хүрээн дэх авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр хууль тогтоох дээд байгууллага буюу УИХ – 3.75, төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг – 4.00, бүх шатны ИТХ – 3.55, нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар – 4.08, улс төрийн намууд 4.27 гэсэн тус тус үнэлэгдсэн байна. Улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын 2011 оны дундаж үнэлгээ 3.82 байна. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ 2010 оныхоос нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар, ИТХ болон улс төрийн намуудын хувьд 0.24-0.30 пунктээр нэмэгдсэн бол УИХ болон төрийн захиргааны байгууллага яам, агентлагийн хувьд 0.25-0.40 пунктээр буурчээ (Хүснэгт 2). Орон нутаг дахь нутгийн захиргааны байгууллага буюу Засаг даргын тамгын газар, Засаг дарга нарын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах болсныг энэхүү өөрчлөлт харуулж байна.

Хүснэгт 1. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ

	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
УИХ	3.71	4.46	4.00	3.75	-0.25
Ерөнхийлөгчийн тамгын газар	-	2.91	3.75	3.27	-0.48
Төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг	4.38	4.29	4.40	4.00	-0.40
Бүх шатны ИТХ	3.77	3.62	3.25	3.55	+0.30
Нутгийн захиргааны байгууллага буюу бүх шатны Засаг даргын тамгын газар	4.14	4.23	3.83	4.08	+0.24
Улс төрийн намууд	4.36	3.92	4.00	4.27	+0.27

Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өндөр байгаа төрийн захиргааны байгууллага дахь албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийг албан тушаалын түвшингээр нь авч үзвэл төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчдын буюу яам, агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагуудын түвшинд 4.23 гэсэн үнэлгээгээр тэргүүлж байгаа бол түүний дараа төрийн захиргааны байгууллагын удирдлагын буюу сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд 4.08 гэсэн үнэлгээгээр удаалж байна (Зураг 2).

Зураг 2. Төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



Улс төрийн хүрээн дэх авлигад бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил (үнэлгээ 4.69), сонгуулийн санхүүжилтийн механизм (4.50), нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо (4.46), намын санхүүжилтийн механизм (4.38) зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14	4.10	3.83	3.45	-0.38
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	4.50	0.08
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	4.38	0.13
Улс төрийн томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.71	4.80	4.42	4.46	0.04
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэнд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	4.30	3.83	4.33	0.50
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	4.00	0.50

Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн дотроос 2011 онд сонгуулийн тогтолцооны үнэлгээ 2010 оныхоос 0.38 пунктээр буурсан нь УИХ-ын сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, улс төрчид, олон нийтийн зүгээс сонгууль зохион байгуулах үйл явцтай холбоотой нааштай өөрчлөлтүүд орсон гэсэн

хүлээлт байгааг харуулж байна. Гэвч уг хуулиар улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм асуудалтай хэвээр үлдсэн гэж шинжээчид үзжээ.

Улс төрийн хүрэн дэх авлигын гол шалтгаан болсон сонгуулийн болон намын санхүүжилтийн механизм, түүнийг дагасан улс төрийн томилгоо нь энэ хүрээний үндсэн оролцогч болох улс төрийн намууд авлигад автах үндсэн хүчин зүйл болж байна. Өнөөгийн улс төрийн болон сонгуулийн тогтолцооноос хамааран ямар ч улс төрийн нам авлигад автана гэдэгтэй судалгаанд оролцсон таван шинжээч тутмын гурав нь санал нийлжээ.

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа албан тушаалд томилох (давтамжийн үнэлгээ 4.38), төрийн одон медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах (4.25), мөнгө / хөрөнгө/ өгөх (4.15) зэрэг арга замуудыг харьцангуй олон давтамжтайгаар ашигладаг байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3-т дурдсан улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа хэрэглэж буй үйлдлүүдийн давтамжийн дундаж үнэлгээ 2010 онд 3.99 байсан бол 2011 онд 3.85 болж 0.14 пунктээр буурчээ.

Хүснэгт 3. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалд томилох	-	4.40	4.67	4.38	-0.28
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	-	3.80	4.36	4.25	-0.11
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.07	4.70	4.42	4.15	-0.26
Гадаад арга хэмжээний зардал даах	-	3.80	4.33	4.08	-0.25
Аялал, жуулчлалын зардал даах	3.33	3.90	4.09	4.08	-0.01
Бэлэг сэлт өгөх	3.73	4.70	4.45	4.00	-0.45
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.80	4.20	4.36	4.00	-0.36
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	-	4.00	4.00	4.00	0.00
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	-	4.10	3.89	3.92	0.03
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	-	4.30	4.11	3.83	-0.28
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	-	3.50	3.56	3.80	0.24
Сургалтын зардал даах	-	3.80	3.83	3.77	-0.06
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	-	3.60	3.56	3.73	0.17
Эмчилгээ, сувилгааны зардал даах	-	3.60	3.82	3.60	-0.22
Хувьцаа өгөх өгөх	-	2.70	3.33	3.36	0.03
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	-	2.90	3.63	3.33	-0.29
Өрийг нь төлөх	-	2.80	3.45	3.22	-0.23
Дундаж үнэлгээ		3.81	3.99	3.85	-0.14

Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөхдөө голчлон албан тушаалтны зөрчлийг нь илрүүлж, түүгээр нь дарамтлах (тархцын үнэлгээ 4.00), дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэтээр/ (4.00) зэрэг үйлдлийг голчлон хэрэглэдэг байна. Гэхдээ төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд

оролцож нөлөөлөх доорх үйлдлүүдийн тархцын дундаж үнэлгээ 3.85 байгаа нь 2010 оныхоос 0.14 пунктээр буурчээ (Хүснэгт 4).

Хүснэгт 3 болон Хүснэгт 4-д гарсан судалгааны үр дүн улс төрийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс шууд нөлөөлөх байдал харьцангуй буурч, шууд бус аргуудыг хэрэглэх явдал нэмэгдсэн болохыг харуулж байна.

Хүснэгт 4. Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	-	4.40	4.09	4.00	-0.09
Дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэт/	3.64	4.00	3.83	4.00	0.17
Хууль бус шаардлага тавих	-	3.60	3.67	3.92	0.25
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	-	3.70	3.67	3.91	0.24
Бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх	-	3.90	3.70	3.75	0.05
Шан харамж нэхэх	3.43	3.90	3.27	3.50	0.23
Дундаж үнэлгээ	-	3.92	3.71	3.85	0.14

Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд (2008-2011 оны хооронд) улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд голчлон ажил албан тушаалд томилох, тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад голчлон нөлөөлж байжээ. Улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх давтамж 2011 онд 2010 онтой харьцуулахад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх (0.41 пунктээр нэмэгдсэн), шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх (0.30), хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх (0.23) чиглэлээр илүү идэвхжсэн байна. Сонгогдсон үйл ажиллагаануудад нөлөөлөх давтамжийн дундаж үнэлгээ 2009 онд 4.11 байсан бол 2010 онд 4.34, 2011 онд 4.43 болж нэмэгдсэн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Улс төрчдийн төрийн байгууллагын зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.60	4.64	4.67	0.03
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4.57	4.50	4.45	4.58	0.13
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.00	4.27	4.50	0.23
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.90	4.20	4.50	0.30
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.10	4.09	4.50	0.41
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд	4.00	3.90	4.18	4.33	0.15
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3.47	3.60	4.56	4.18	-0.37
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх	4.00	4.30	4.36	4.15	-0.21
Дундаж үнэлгээ	4.04	4.11	4.34	4.43	0.08

Шинжээчдийн үзэж байгаагаар улс төрийн авлига уул уурхайн салбар болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл (тус бүр 4.54 гэсэн үнэлгээтэй), намд эрх мэдлээ тогтоох (4.33)-д түлхүү чиглэгддэг байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Уул уурхайн салбар	4.67	4.42	4.54	0.12
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	4.54	0.27
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	4.33	-0.09
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	4.30	0.13
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	4.23	0.31
Өмч хувьчлал	3.73	4.10	4.20	0.10
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	4.17	0.25
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	3.92	-0.53
Газар тариалан	3.60	3.00	3.25	0.25
Дундаж үнэлгээ	4.18	4.07	4.16	0.09

Улс төрийн хүрээнд мөнгө угаах (тархцын үнэлгээ 4.67), намд хандив авах (4.62), улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах (4.38) зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Мөнгө угаах	4.00	3.80	4.67	0.87
Намд хандив авах	4.42	4.25	4.62	0.37
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах	4.42	4.50	4.38	-0.12
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	4.33	-0.30
Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	4.31	-0.19
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	4.23	-0.35
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	4.15	0.90
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших	4.00	4.00	4.08	0.08
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхолоор зарцуулах	4.15	4.36	4.08	-0.29
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	3.91	-0.26
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	3.78	0.22
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	3.73	0.09
Дундаж үнэлгээ	4.19	4.10	4.19	0.09

Өмнөх жилүүдэд бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байсан бол 2012 онд УИХ-ын болон орон нутгийн сонгууль болохтой холбоотойгоор дээрх байдлаар олсон орлогоо сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулахаар хувиргах, сонгуулийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бий болгоход анхаарлаа хандуулах болсон байна.

Иймд нэр дэвших болон сонгуулийн санхүүжилтэд зарцуулж буй хөрөнгийн үүслийг нарийн шалгах шаардлагатай байна.

Улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авахдаа зуучлагчаар дамжуулах (4.00), ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох (3.90) зэрэг аргууд илүү өргөн тархсан байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах болон зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах зэрэг аргуудын тархац 0.25-0.32 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	4.00	-0.09
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	3.90	-0.18
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	3.90	0.15
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	3.80	0.25
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	3.78	0.32
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	3.75	0.00
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	3.50	-0.77
Мөнгө зээлдүүлээд мартаx	3.00	3.56	3.40	-0.16
Шууд өөрт нь өгөх	3.45	3.80	3.33	-0.47
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	3.18	-1.04
Дундаж үнэлгээ	3.66	3.85	3.65	-0.20

Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө ихэвчлэн орон сууц худалдан авах (тархцын үнэлгээ 4.82), хүүхдийнхээ сургалтын төлбөрт болон машин, үл хөдлөх хөрөнгө худалдан авах (4.80)-д зарцуулдаг байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах (тархцын үнэлгээ 2010 оныхоос 0.51 пунктээр нэмэгдсэн), орон сууц худалдан авах (0.36 пунктээр) машин, үл хөдлөх хөрөнгө худалдан авах (тус бүр 0.35 пунктээр) зэрэг хэлбэрүүдийн тархац илүү нэмэгдсэн байна (Хүснэгт 9).

Энэхүү үнэлгээ нь АТГ-ын зүгээс албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгт хийх хяналт шалгалтыг ажлыг юунд хандуулах ёстойг харуулж байна гэж үзэж байна.

Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хэлбэрүүд / хариулт	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	4.82	0.36
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	4.80	-0.02
Машин худалдан авдаг	4.45	4.45	4.80	0.35
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	4.80	0.35
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	4.78	0.51
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	4.45	0.25
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	4.40	-0.24
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	3.60	-0.40
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	3.25	-0.19

Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	3.22	-0.44
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	3.00	-1.00
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	3.00	-0.67
Дундаж үнэлгээ	4.09	4.17	4.08	-0.10

Шинжээчдийн үзэж байгаагаар бизнес эрхлэгчид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхдээ дунджаар татвар ногдох дүнгийн 15.3 хувийг, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхдээ нэхэмжлэлийн дүнгийн 14.6 хувийг, зээл авахдаа зээлийн дүнгийн 11.0 хувийг, өмч хувьчлах шийдвэр гаргуулахдаа хувьчлах хөрөнгийн үнийн дүнгийн 16.9 хувийг, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялахын тулд тендерийн дүнгийн 12.5 хувийг, төсөл, хөтөлбөрт хамрагдахдаа төсөл хөтөлбөрийн төсвийн 12.0 хувийг авлигатай холбоотойгоор зарцуулдаг байна (Хүснэгт 10). Судалгааны дүнгээс харахад 2010 онтой харьцуулахад 2011 онд бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн нийт үнийн дүнд эзлэх хувь татвараас чөлөөлүүлэх, өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх, зээл авах, өмч хувьчлах шийдвэр гаргуулах зэрэг хэлцлүүд дээр 1.0-3.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь

Ажил үйлчилгээ / Үнийн дүнгийн хувь	2009	2010	2011
Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	12.45	12.91	12.00
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах	16.50	13.41	12.50
Өмч хувьчлах шийдвэр гаргуулах	15.78	15.83	16.94
Зээл авах	11.50	10.00	11.00
Өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх	11.08	11.00	14.64
Татвараас чөлөөлүүлэх	15.50	11.39	15.28

Ажил, албан тушаалд ороход дунджаар 16.1 сая төгрөгийг, тусгай зөвшөөрөл авахад дунджаар 15.5 сая төгрөгийг, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад дунджаар 22.1 сая төгрөгийг тус тус авлигад зарцуулдаг гэж шинжээчид үзжээ. Авлигын өртөг 2010 оныхоос нэмэгдсэн байна.

Шинжээчид төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (авлигын тархцын үнэлгээ 4.54), төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох (4.46) зэрэг үйл ажиллагаанд авлига их тархсан гэж үзэж байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Төрийн байгууллагын зарим үйл ажиллагаан дахь авлигын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	4.80	4.54	4.75	4.54	-0.21
Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4.80	4.69	4.83	4.46	-0.37
Ажил, албан тушаалд томилох	4.53	4.46	4.50	4.31	-0.19
Өмч хувьчлал	3.87	3.82	4.50	4.00	-0.50
Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4.13	4.08	4.25	3.85	-0.40

Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3.80	4.00	4.20	3.85	-0.35
Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4.27	4.38	4.42	3.67	-0.75
Дундаж үнэлгээ	4.31	4.28	4.49	4.10	-0.40

Өмнөх судалгаагаар шинжээчид бүгд 100.0 хувь улс төрийн авлига илүү далд шинжтэй болсон гэдэгтэй санал нийлж байсан бол энэ үзүүлэлт 84.6 хувь болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, зарим талаар улс төрийн авлига ил цагаандаа гарах болсон байна гэдгийг энэ үр дүн харуулж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар бизнесийн бүлэглэлийн зүгээс улс төрчдийг эрхшээлдээ оруулах явдал 2011 онд илүү эрчимжсэн байна (Хүснэгт 12). Энэ нь сонгуулийн хугацаа ойртож, улс төрчид рүү чиглэсэн бизнесийн бүлэглэлийнхний лобби болон бусад нөлөөллийн үр ажиллагаа эрчимжиж байгаатай холбоотой.

Хүснэгт 12. Монгол Улс дахь улс төр болон бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ

Үзүүлэлт	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.23	3.50	2.83	-0.67
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.69	4.50	4.69	0.19
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.67	4.67	4.33	-0.33
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэл /мафи/-ийг гартаа оруулсан	2.40	2.78	2.11	-0.67
Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл /мафи/ гартаа оруулсан	2.80	3.40	2.83	-0.57
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/- ыг гартаа оруулсан	3.18	3.73	3.00	-0.73
Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.11	3.91	2.64	-1.27
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/- тай нэгдсэн	2.78	3.60	2.00	-1.60
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.22	1.40	1.55	0.15
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.20	3.00	3.20	0.20
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.67	5.00	4.23	-0.77
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.08	4.50	4.54	0.04

Монгол Улсад хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон болон найз нөхдийн хүрээлэл шинжээчдийн үзэж байгаагаар 2010 онтой харьцуулахад илүү эрчимжсэн байна. Харин нам тойрсон хүрээллийн үйл ажиллагааны хүч бага буурсан байна. Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл хүч султай хэвээр байна (Хүснэгт 13). Эдгээр бүлэглэлүүдээс хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан бизнесийн хүрээлэл хамгийн хүчтэй болох нь харагдаж байна.

Хүснэгт 13. Монгол Улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Бүлэглэлүүд / үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2010-2009)
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.77	4.00	3.69	-0.31
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.31	4.75	4.08	-0.67
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.42	4.58	4.31	-0.27
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл /намуудын нэгдэл/	4.38	4.42	4.08	-0.34
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл	4.00	4.08	4.31	0.23
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.92	3.75	3.77	0.02
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.82	2.27	2.08	-0.19
Дундаж үнэлгээ	3.80	3.98	3.76	-0.22

Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн байгууллагад авлига оршин байхад хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.54), хуулийн хэрэгжилтэд тавих хяналт (4.46), олон шат дамжлага, давхардал (4.31) зэрэг хүчин зүйл илүү хүчтэй нөлөөлдөг байна (Хүснэгт 12). Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн хэрэгжилт, хариуцлага тооцох механизм сул байгаа нь авлига үүсэх гол хүчин зүйл солж байна.

Хүснэгт 14. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	4.54	0.21
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.15	4.75	4.46	-0.29
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	4.31	-0.44
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	4.23	-0.35
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	4.23	-0.10
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	4.15	-0.18
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	4.08	-0.51
Хүнд суртал	4.47	4.75	4.67	4.00	-0.67
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	4.00	-0.58
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	4.00	-0.17
Дундаж үнэлгээ	4.27	4.33	4.51	4.20	-0.31

Авлигыг бууруулахад ямар арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай талаарх асуултад намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх гэсэн санаа 18.4 хувийн, шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох гэсэн санаа 15.8 хувийн, улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл, зоригийг нэмэгдүүлэх гэсэн санаа 13.8 хувийн санал авсан нь голлох санаанууд болж байна.

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад дээр дурдсан арга хэмжээнүүдээс гадна дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Санал болгож буй арга хэмжээнүүд	Тэдгээрийг хэрэгжүүлэх арга замууд
<ul style="list-style-type: none"> Авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгох, нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх 	<ul style="list-style-type: none"> Ёс зүйт орчинг төрийн бүх салбарт адил тэгш нэвтрүүлэх Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимтэй явуулах, авлигын томоохон тодорхой хэргүүдийг шүүхээр шийдүүлэн авлига эрсдэлтэй зүйл гэдгийг улс төрчдөд ойлгуулах
<ul style="list-style-type: none"> Төрийн болон олон нийтийн өмчийн тухай хууль гаргах Иргэний болон эрүүгийн хууль дахь төрийн өмчтэй холбогдох хэсгийг дэлгэрэнгүй болгох Төрийн өмчийн прокурор бий болгох 	<ul style="list-style-type: none"> Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, үүний тулд иргэдэд татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх Төрийн байгууллагын бараа, үйлчилгээнд зарцуулсан НӨАТ-ыг 100 хувь буцааж өгдөг байх. Энэ нь тендер дагасан хахуулийг устгана. Сүүлийн 5-н жилд татварын хуульд орсон өөрчлөлтүүдийг батлуулахад оролцсон УИХ-ын гишүүд, түүнтэй холбоотой бизнесийн үйл ажиллагааг судлан үзэх хэрэгтэй байна. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг газар дээр нь шууд шалгаж, хөрөнгийн эх үүсвэрийг нь баталгаажуулах шаардлагатай.
<ul style="list-style-type: none"> Хамгийн түрүүнд цагдааг авлигагүй болгох, Хонконгийн туршлагыг хэрэгжүүлэх Сайд дарга нарын тансаг хэрэгцээнд хуулиар хязгаарлалт хийх Дарга нарын тоог цөөлж иргэдэд үйлчилдэг хэсгийг өргөжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Хэвлэлээр гарсан шүүмжлэлийн мөрөөр шалгадаг арга хэмжээ авдаг хуулийн тогтолцоо бий болгох Алдаа гаргасан, иргэдийг гомдоосон албан тушаалтныг төрийн албанд дахин ажиллуулахгүй байх Хөрөнгө орлогын мэдүүлгийг сайн шалгах аас гадна нийтэд ил тод болгох
<ul style="list-style-type: none"> Шүүх хараат бус байх нөхцөлийг бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Хууль хяналтын байгууллагынхныг улс төр, бизнесийнхнээс хараат байдлаас салгах бүхий л арга хэмжээг авах
<ul style="list-style-type: none"> Улсын төсвийг шударга зохиож авлига нуугдах боломжийг хаах Аливаа шийдвэр болон төрийн мөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод явуулах, олон нийтийн хяналтыг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Улсын төсөвийг батлахдаа УИХ-ын гишүүдийн саналаар биш алс хэтийн төлөвлөлтийг үндэслэн санхүүжүүлэх объектийн дараалалыг ҮАБЗ-өөр тогтоосон байх, Аливаа тендерийг явуулахдаа хамгийн бага үнээр биш харин дэлхийн жишигт хийцсэн хамгийн сайн бүтээгдэхүүнээр бодитоор үнэлэх Мэдээллийн нээлттэй байдлыг дэмжих Төрийн албан хаагчдын цалинг нэмж шударга ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

<ul style="list-style-type: none"> · Хэрэг хийсэн хээл хахууль авсан л бол шийтгэж байх · Төрийн албаны боловсон хүчний бодлогыг шат дараалан гүйцэтгэдэг журам тогтоох · Улс төрчдийн хувьд ёс зүйг эрхэмлэдэг жишиг тогтоох · Мэдлэг чадвар, туршлага, шударга байдлыг томилгооны гол шалгуур болгох · Уламжлалт зан заншил, ёс суртахууны хүмүүжил соён гэгээрүүлэх ажлыг сайн хийж хууль зөрчихөөс нь өмнө ёс суртахууны зөрчил гаргасан, нэр нь холбогдсон албан тушаалтанд ёс зүйн хариуцлага тооцож албан тушаалаас нь өөрчилдөг байх · Авлигад өртгөмтгий албан тушаалд ёс зүйтэй шударга 45-аас дээш насны хүмүүсийг томилох 	<ul style="list-style-type: none"> · Төрийн албаны томилгооноос эхлэх шаардлагатай. Дүрэм журмын дагуу явагдаж буй эсэхэд Төрийн албаны зөвлөлөөс дүгнэлт гаргадаг болох. · Боловсон хүчнийг томилохдоо шат алгасаж улс төрийн томилгоо хийдэгийг болих. · Ёс суртахууны зөрчил гаргасан, нэр холбогдсон албан тушаалтныг ажлаас нь өөрчилдөг болох
<ul style="list-style-type: none"> · Лоббиг зохицуулах тухай хууль гаргах 	<ul style="list-style-type: none"> · Лобби бүлгийг ил тод мэдээлж зарлах · Хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргах, хянах · Сонгуулийн авлигыг тусгайлан авч үзэж бууруулах · Улс төрчид сонгогчдын саналыг татаж буй арга нь авлига үүсгэж байгааг зогсоох
<ul style="list-style-type: none"> · Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (2011 оны 6 сард батлагдсан) хуулийн хэрэгжилт сайжруулах, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг бий болгох, төлбөрт хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн үйл ажиллагааг хуульчлах 	<ul style="list-style-type: none"> · Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бизнесийн бүлэглэлүүдийн хараат байдлаас гаргаж, паблик хувьцаат компанийн хэлбэрт оруулах
<ul style="list-style-type: none"> · Бизнесийн бүлэглэлүүд төрийн бодлогод, боловсон хүчний томилгоонд нөлөөлдөг тогтолцоог устгах 	<ul style="list-style-type: none"> · Томоохон бизнестэй, бизнесийн ашиг сонирхол бүхий этгээдийг төрийн захиргааны албанд томилогүй, УИХ-ын сонгуульд оролцуулахгүй байх механизмыг бий болгох

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн хяналт үнэлгээний тогтолцооны хүрээнд Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааг 2008 оноос хойш 4 дэх удаагаа явуулж байгаа бөгөөд энэ удаагийн судалгаанд оролцсон шинжээчдийн судалгааны талаарх санал бодлыг нь тодруулах асуултыг оруулсан. Судалгааны талаар шинжээчид дараахь байдлаар санал бодлоо илэрхийлж байсан.

- Бидний зүгээс өгсөн саналууд хаана, хэрхэн яаж тусгалаа олдог, хэрхэн ажил болж буйг эргэж мэдээлдэг байх хэрэгтэй. Энэ нь дараагийн судалгаанд оролцох, саналаа өгөхөд илүү үр дүнтэй байх болно.

2.3. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүн

Шинжээчдийн үнэлгээгээр шүүхийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.62 болж, 2010 оныхоос 0.16 пунктээр, цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.53 болж, 0.05 пунктээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагынх 3.50 болж, 0.20 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Харин прокурорын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.40 болж, 2010 оныхоос 0.35 пунктээр буурсан байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15: Хууль хяналтын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, салбараар

Хууль хяналтын байгууллагууд	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Шүүхийн байгууллага	4.20	3.49	3.46	3.62	0.16
Прокурорын байгууллага	4.15	3.12	3.75	3.40	-0.35
Цагдаагийн байгууллага	4.29	3.50	3.48	3.53	0.05
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.73	3.21	3.30	3.50	0.20

Шүүх байгууллагын хувьд хяналтын шатанд авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.67) байгаа бол прокурорын байгууллагын хувьд аймаг, нийслэлийн прокурорын болон сум (сум дундын), дүүргийн прокурорын (тус бүр 3.55) байгууллагад авлигад өртөх эрсдэл өндөр байна. Харин цагдаагийн байгууллагын хувьд замын цагдаа (3.91), хэрэг бүртгэгч (3.89), мөрдөн байцаагч (3.73) нарын түвшинд авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байгаа бол шүүхийн шийдвэр байгууллагын хувьд аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд (3.80) авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Хууль хяналтын байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар

Түвшин	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Анхан шатны шүүх	3.64	3.58	3.64	0.05
Хяналтын шатны шүүх	3.45	3.75	3.67	-0.08
Давж заалдах шатны шүүх	3.44	3.67	3.64	-0.03
Дээд шүүх	3.44	2.85	3.56	0.71
Шүүхийн байгууллагын дундаж үнэлгээ	3.49	3.46	3.62	0.16
Сум /сум дундын/, дүүргийн прокурор	3.18	3.75	3.55	-0.20
Аймаг, нийслэлийн прокурор	3.27	3.92	3.55	-0.37
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	3.10	-0.48
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	3.12	3.75	3.40	-0.35
Мөрдөн байцаагч	3.82	3.75	3.73	-0.02
Хэрэг бүртгэгч	3.55	3.50	3.89	0.39
Эрүүгийн цагдаа	3.82	3.50	3.70	0.20
Хэв журмын цагдаа	2.91	3.45	3.30	-0.15
Замын цагдаа	3.82	3.83	3.91	0.08
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	-0.19
Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	3.50	3.48	3.53	0.05
Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	3.80	0.10

Хорих ял эдлүүлэх алба	3.36	3.20	3.70	0.50
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	0.00
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	3.21	3.30	3.50	0.20

Шинжээчдийн үзэж байгаагаар хууль хяналтын байгууллагад холбогдох үйл ажиллагаануудаас ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/ (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 4.44), өр барагдуулах (4.20), эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх болон ялын хэмжээг бууруулах (4.11), эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах (4.10) зэрэг үйл ажиллагаанд авлигад өртөх харьцангуй өндөр байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа / эрсдлийн үнэлгээ	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/	3.11	3.63	4.44	0.82
Өр барагдуулах	-	4.00	4.20	0.20
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх	-	3.78	4.11	0.33
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	4.11	0.11
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	4.10	0.10
Хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах	-	4.13	4.00	-0.13
Шүүхийн шийдвэрийг хурдан гүйцэтгэх	3.56	3.71	4.00	0.29
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	3.91	-0.49
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	3.90	0.23
Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	3.89	-0.01
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	3.89	0.01
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	3.80	0.35
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах	3.22	4.09	3.78	-0.31
Эрүүгийн хэрэг үүсгэх үйл ажиллагаа	3.90	3.92	3.67	-0.26
Албадан дуудлага худалдаанд оруулах	3.22	3.13	3.67	0.54
Торгууль ногдуулах	3.36	3.75	3.63	-0.13
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	3.40	3.50	3.55	0.05
Хорих ял эдлүүлэх	-	3.30	3.50	0.20
Тодорхой хугацаагаар эрх хасах	-	3.83	3.44	-0.39
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	3.44	0.07
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	3.44	-0.26
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	3.22	-0.22
Дундаж үнэлгээ	3.38	3.75	3.80	0.05

Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.40), хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмийн дутагдалтай байдал (4.33), хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөлийн хангалтгүй байдал (4.27) зэрэг хүчин зүйлсийн хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсгэх нөлөөллийн үнэлгээ харьцангуй өндөр байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн үнэлгээ

Хүчин зүйлс / нөлөөлөл	2008	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	3.92	0.17
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	4.00	0.36
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	4.40	0.40
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4.00	4.00	4.27	0.27
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.2	3.73	4.00	4.33	0.33
Дундаж үнэлгээ	3.92	3.69	3.88	4.18	0.31

Албан тушаалтны зөрчлийг илрүүлж, түүгээр нь дарамтлах байдал хууль хяналтын байгууллагынхны дунд нийтлэг болсон (тархцын үнэлгээ 4.33) арга хэлбэр болж байна. Хууль хяналтын байгууллагын албан тушаалд дарамт шахалт үзүүлэх байдлын үнэлгээ 2010 онд 3.58 байсан бол 2011 онд 3.82 болж 0.23 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтан өөрийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Оролцох нөлөөлөх хэлбэр / тархац	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	4.33	0.11
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	3.82	0.23
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	3.70	-0.15
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.42	3.83	3.70	-0.13
Шан харамж нэхэх	3.00	3.13	3.38	0.25
Дундаж үнэлгээ	3.55	3.72	3.79	0.06

Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа мөнгө, хөрөнгө өгөх (давтамжийн үнэлгээ 4.44), улс төрийн хамгаалалтад авах (4.29), төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах болон хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох (4.00) зэрэг аргуудыг голчлон хэрэглэдэг байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хууль хяналтын байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахад хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	4.44	0.37
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83	4.14	4.29	0.14
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.14	3.71	4.00	0.29
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	4.00	0.75
Бэлэг сэлт өгөх	4.08	4.09	3.90	-0.19
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	3.88	-0.35
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	3.86	-0.14
Албан тушаалд томилох	3.60	3.73	3.80	0.07
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	1.67	2.50	3.67	1.17
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	3.70	3.00	3.50	0.50
Өрийг нь төлөх	3.33	3.75	3.44	-0.31
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.11	3.83	3.38	-0.46
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	2.50	3.40	3.33	-0.07
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	3.17	-0.58
Хувьцаа өгөх	2.00	3.00	3.00	0.00
Сургалтын зардал даах	2.63	3.25	2.86	-0.39
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	2.71	-0.45
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	2.57	-0.80
Дундаж үнэлгээ	2.99	3.57	3.54	-0.03

Шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 13.6 сая төгрөгийн, хэрэг бүртгэх мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 9.2 сая төгрөгийн, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад дунджаар 11.8 сая төгрөгийн, эрүүгийн хэрэг үүсгэхэд дунджаар 6.4 сая төгрөгийн хээл хахууль өгдөг өгдөг гэж шинжээчид үзжээ.

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд хээл хахууль өгөхдөө зуучлагчаар дамжуулах (4.20), өмгөөлөгчөөр дамжуулах (4.11) хэлбэрийг илүү түлхүү хэрэглэдэг байна (Хүснэгт 21). Доорх бүх хэлбэрийн давтамж, тархац 2010 онтой харьцуулахад нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 21. Хууль хяналтын байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгч, авдаг хэлбэрүүдийн үнэлгээ

Хэлбэрүүд	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	4.20	0.47
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	4.11	0.29
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	3.88	0.55
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	3.86	0.69
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	3.75	0.12
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.00	3.22	3.67	0.45

Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	3.64	0.47
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	3.63	0.49
Мөнгө зээлдүүлээд мартаж	3.44	3.57	3.63	0.06
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	2.86	0.06
Дундаж үнэлгээ	3.11	3.36	3.72	0.36

Хууль хяналтын байгууллагын албан тушаалтнууд авлигаар бий болгосон хөрөнгөө голчлон өдөр дутмын хэрэгцээндээ болон хүүхдийн сургалтын төлбөртөө зориулах (үнэлгээ 5.00) буюу машин, орон сууц худалдан авах (4.78)- д зарцуулдаг байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрүүдийн үнэлгээ

Хэлбэрүүд	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	5.00	0.22
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	5.00	0.50
Машин худалдан авдаг	5.00	4.56	4.78	0.22
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	4.78	0.22
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	4.75	0.50
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	4.50	-0.28
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	3.00	3.67	4.43	0.76
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	4.00	1.00
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	3.86	0.86
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	3.80	0.80
Дундаж үнэлгээ	3.81	4.01	4.49	0.48

Шинжээчид хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад нэн тэргүүнд АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах (4.83), хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах (4.82), албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах шударга ил тод механизм бий болгох (4.73) зэрэг хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хууль хяналтын байгууллага дахь авлигыг бууруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн ач холбогдлын түвшин

Арга хэмжээ / ач холбогдлын түвшин	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	4.38	4.83	0.45
Хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах	4.33	4.82	0.48
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох	4.42	4.73	0.31
Хууль хяналтын байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх	4.58	4.67	0.08
Авлигачдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагын арга хэмжээг чангатгах	4.36	4.67	0.30
Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх	4.64	4.58	-0.05
Ур чадварт үндэслэн томилгоо хийх	4.62	4.55	-0.07
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын ёс зүй, ажлын доголдлыг тооцож хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	4.67	4.45	-0.21

Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын хууль зүйн баталгааг сайжруулах	4.50	4.45	-0.05
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх	4.55	4.42	-0.13
Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг сэлгэн ажиллуулах	4.00	4.36	0.36
Иргэний нийгмийг өргөн хүрээнд оролцуулах	4.09	4.08	-0.01
Дундаж үнэлгээ	4.43	4.55	0.12

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараахь арга замуудыг илэрхийлсэн. Үүнд:

- Хээл хахууль авсан хүнд ногдуулах шийтгэлийг чангатгаж, өгсөн этгээдийг өөрөө хэргээ илчлэн ирсэн тохиолдолд хариуцлагаас чөлөөлж байх. Ингэснээр авлигын гэмт хэргийн илрүүлэлт сайжирч, хээл хахууль авах нь багасна гэж үзэж байна.
- АТГ-ын хараат бус, бие даасан байдлыг баталгаажуулах.
- Хуулийг боловсронгуй болгож, хуулийн хэрэгжилтийг сайжруулах.
- Ил тод байдлыг нэмэгдүүлэх. Уг ажлыг хууль тогтоох дээд байгууллага УИХ-аас өөрөөс нь эхлэх.
- Ажиглалтын аргыг хэрэгжүүлж, үндэслэлгүй баяжсан төрийн албан хаагчдын хөрөнгийг хураах.
- Урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд үр дүнтэй зохион байгуулах.
- Төрийн албаны томилгоог боловсронгуй болгох.
- Алба тушаалтнуудын үүрэг хариуцлагын тогтолцоо механизмыг сайжруулах хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим дээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд шинэтгэл хийх.
- Нийгмийн бүх давхарга дахь олон нийтийн авлигын талаарх ойлголт, ухамсрыг дээшлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх.
- Хууль хяналтын байгууллагын удирдах ажилтны томилгоог улс төрөөс ангид болгож яамдын төрийн нарийн бичгийн дарга нар томилдог болох.
- Хууль хяналтын байгууллагын албан хаагчдыг ил тодоор ур чадвар туршлага мэдлэг суурилсан сонгон шалгаруулалтаар томилох төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх. Албан тушаал зардаг явдлыг зогсоох, улсын мөнгөөр бизнес хийх зорилготой хүмүүст зориуд бололцоо олгож, томилгоо хийдэг явдлыг таслан зогсоох.
- Ашиг сонирхолын зөрчлийг мэдээлэх журамд яаралтай шилжүүлэх.
- Авлигын хэргийг шалгах шийдвэрлэх эрх бүхий дагнасан мэргэшсэн бүтэц бүрэлдэхүүнийг бий болгох. Авлигын хэргийг мөрдөн шалгах илрүүлэн эрх бүхий байгууллагын уялдаа харилцан хамтран ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Хуулийн ажилтны үйлдсэн авлигын хэргийг УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж байгаа тул гүйцэтгэх ажилтны эрх олгох. Тэднийг энэ чиглэлийн сургалтанд хамруулах.
- Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлтийг нотлох ажиллагаанд ашиглах аргачлалыг боловсруулж, үр нөлөөг дээшлүүлэх.
- Зөвшөөрлийн аливаа системд хяналт тавих.

Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд оролцсон шинжээчдийн хувьд судалгааны үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний үр дүнг олон нийтэд мэдээлж байх шаардлагатай гэж үзэж байна.

3. ДҮГНЭЛТ

Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн дөрөв дэх удаагийн судалгааг явуулж, үр дүнг нэгтгэн гаргаж, та бүхэнд танилцуулж байна. Энэхүү судалгааг дөрвөн жил дараалан явуулснаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдлын өөрчлөлт, хөдөлгөөнийг тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаа юм.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд улс төрийн бүх шатны байгууллага, сонгуулийн үр дүнд байгуулагддаг бүх шатны байгууллага, хэвлэл, мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл

13 шинжээчийг; Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд хууль хяналтын байгууллагын бүх салбар, түвшний төрийн байгууллага, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг сонгож оролцуулсан нь тооны хувьд цөөн шинжээч оролцсон хэдий ч өргөн хүрээтэй мэдлэг, мэдээлэл бүхий шинжээчдийг оролцуулан нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч чадсан гэж дүгнэж байна.

Судалгаагаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын нөхцөл байдал, цаг хугацааны өөрчлөлтийг тодорхойлохын зэрэгцээ энэ хүрээнд аль түвшинд нь авлигын эрсдэл өндөр байгаа, улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлига аль салбар, үйл ажиллагаа голлон чиглэгдэж байгаа, авлигыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөлүүд, авлига, хээл хахуулийг ямар хэлбэрээр хэрэгжүүлж байгаа, авлигаар бий болгосон хөрөнгөө юунд, хэрхэн зарцуулж байгаа, хэдий хэр хэмжээний хөрөнгө авлигатай холбоотойгоор эргэлдэж байгаа зэрэг өргөн хүрээтэй мэдээллийг эндээс олж авах боломжтой.

Судалгааны үр дүн гагцхүү судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлэлт, төсөөлөл бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн дараахь дүгнэлт, зөвлөмжийг өгч байна.

- Шинжээчдийн үзэж байгаагаар 2011 онд улс төрийн хүрээн дэх авлигын үзүүлэлт өмнөх оноос нэмэгдсэн бол хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үзүүлэлт бага зэрэг буурчээ. Энэ хүрээн дэх авлигын үзүүлэлт төдийлөн өөрчлөгдөхгүй байна.
- Өнгөрсөн онд 2010 онтой харьцуулахад бүх шатны ИТХ, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаан дахь авлигын эрсдэл нэмэгджээ. Энэ нь орон нутаг дахь нутгийн захиргааны байгууллага буюу Засаг даргын тамгын газар, Засаг дарга нарын үл ажиллагаанд чиглүүлсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай болсныг харуулж байна.
- Төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчид буюу газар, хэлтсийн дарга нар авлигад өртөх эрсдэл илүү байгааг анхаарч үзэх нь зүйтэй.
- Энэ хүрээн дэх авлигыг бууруулахад чухал шаардлагатай эрх зүйн зохицуулалт болох ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь чухал алхам болсон. Энэхүү зохицуулалт нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигыг үүсгэх нэг шалтгаан болж буй бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлыг хязгаарлах чухал алхам байх болно. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй.
- УИХ-ын сонгуулийн тухай хууль батлагдснаар сонгуулийн болон улс төрийн авлигыг таслан зогсооход чухал алхам болсон хэдий ч улс төрийн хүрээн дэх авлигын үндсэн шалтгаан болсон улс төрийн намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн зохицуулалт хангалтгүй хэвээр байна.
- Улс төрийн намын болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн

зохицуулалтын дараа авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ бол зэрэгцээ лобби үйл ажиллагаа ил тод болгох, зохицуулах асуудал болж байна.

- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын үйлдлийг ямар арга замаар хэрэгжүүлдэг, хэрхэн төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлдөг, төрийн байгууллагын ямар үйл ажиллагаа, салбар руу авлига чиглэгдэж, хэрхэн хээл хахуулийг өгч, авдаг авлигаар олсон хөрөнгийг юунд зарцуулдаг болох зэрэг авлигын хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх, таслан зогсоох, хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийхэд анхааралдаа авах шаардлагатай мэдээллийг энэхүү судалгаа өгч байна. Иймд АТГ-ын холбогдох хэлтэс, албад судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өөрсдийн үйл ажиллагаандаа авч ашиглах нь зүйтэй.
- Иргэний болон эрүүгийн хууль дахь төрийн болон олон нийтийн өмчтэй холбогдох заалтуудыг тодорхой болгох, нарийвчлан авч үзэх, төрийн ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн тохиолдолд төрийг төлөөлөх үүргийн хэрэгжилтийг дээшлүүэх шаардлагатай байна.
- АТГ-аас санаачлан бусад хууль хяналтын байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх, шийдвэрт ашиглах аргачлалыг боловсруулан, мөрдөж турших, үр нөлөөг сайруулах нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэхэд чухал үр нөлөөтэй байх болно.
- Эцэст нь судалгааны үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан бусад төрийн байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт өгдөг байх шаардлагатай байна.

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН
ИНДЕКСИЙН 2011 ОНЫ ТООЦООНЫ
ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**



**МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2011 ОНЫ
ТООЦООНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН****ӨМНӨХ ҮГ**

Авлигын асуудал нь аливаа улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд бий болдог цогц үзэгдэл юм. Авлига нь ардчиллын үнэт зүйлсийг гажуудуулах, эдийн засгийн хөгжлийг удаашруулах, засгийн газрын тогтворгүй байдлыг бий болгох зэрэг шууд болон шууд бус олон нөлөөтэй байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд олон улс орон, олон улсын байгууллагууд сайн засаглал, засаглалын шинэтгэл, түүний дотор авлигатай тэмцэх асуудалд анхаарлаа хандуулж болжээ.

Монгол улсын хувьд ч мөн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж, УИХ-аас Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг 2002 онд, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг 2005 онд соёрхон баталж, Авлигын эсрэг хуулийг 2006 онд батлан хэрэгжүүлж бие даасан, хараат бус Авлигатай тэмцэх газрыг байгуулсан билээ. Түүнчлэн Монгол Улс “Мянганы тунхаглал” дахь Мянганы хөгжлийн найман зорилго дээр нэмж “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” гэсэн 9 дэх зорилго, түүний дотор “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” зорилтыг тавин хэрэгжүүлж байгаа билээ.

Аливаа бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэн цаашдын зорилтыг тодорхойлоход бодитой мэдээлэл, судалгаа чухал ач холбогдолтой. Түүнчлэн аливаа гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь судалгаа шинжилгээний ажил юм. Ийм ч учраас Авлигын эсрэг хууль болон Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтийг батлах тухай УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолд Авлигын индексийг тооцон олон нийтэд мэдээлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрсэн түвшинг үнэлэхээр заасны дагуу тус газраас энэ удаагийн судалгааны үр дүнгийн тайланг бэлтгэн гаргаад байна.

Авлигыг хэмжих, судалгааны үр дүнг Монгол Улсын авлигын эсрэг бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд ашиглах төдийгүй, НҮБ-ын Мянганы тунхаглалын дагуу Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын хэрэгжилтийг НҮБ-д тайлагнах, Авилгалын эсрэг конвенцийн 61 дүгээр зүйлд заасан авлигын талаарх тоо баримт, судалгаа мэдээлэл, тэдгээрийн арга зүй, туршлагын талаарх мэдээллийг бусад орнуудтай хуваалцах үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглах юм.

Авлигын индекс тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулах явцад өргөн хүрээтэй, чухал ач холбогдолтой олон тооны мэдээлэл цугларсан бөгөөд бодлого боловсруулагчид, төрийн байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтнууд, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн ажилтнууд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөх, үнэлж дүгнэхэд нь шаардлагатай мэдээллийг хүргэх, эрдэмтэн судлаачид, оюутан залуус, төрийн бус байгууллагуудын ажилтнууд энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ ажил хийхдээ мэдээллийн эх үүсвэр болгон ашиглуулах зорилгоор товхимолд эдгээр мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар оруулсан болно. Энэхүү товхимлыг уншиж танилцаж буй Та бүхэн судалгааны ажилд ач холбогдол өгч, өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.

Түүнчлэн авлигын индекс тооцох, судалгаа явуулах бүхий л үе шатанд бидэнтэй хамтран ажиллаж үнэтэй санал өгч, дэмжлэг туслалцаа үзүүлж байсан эрдэмтэн судлаачид, төрийн албан хаагчид, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтнууд, судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулахад оролцсон ярилцлага авагч нар болон бусад ажилтнууд, судалгааны ажилд оролцон үнэтэй мэдээлэл өгсөн судалгаанд оролцогчид, бүх байгууллага, хүмүүст талархлаа илэрхийлэн, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Авлигатай тэмцэж, шударга ёсыг тогтоон, хөгжил дэвшилд хүргэнэ!

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР** **Н.ГАНБОЛД**

ХУРААНГУЙ

Авлигатай тэмцэх газраас авлигын индексийг 2009 онд анх тооцож байсан бол хоёр жилийн дараа буюу 2011 онд хоёр дахь удаагаа тооцож байна. Ингэснээр цаг хугацааны хувьд уг үзэгдэл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаа нь энэ удаагийн судалгааны нэг онцлог болж байна.

Монгол Улсын Авлигын индекс тооцох аргачлалыг Авлигатай тэмцэх газрын болон Үндэсний Статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76/(06/69) хамтарсан тушаалаар баталсан юм.

Аргачлалд тусгагдсаны дагуу авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр буюу аймаг, нийслэл, тэдгээрийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн нэгж, орон нутаг дахь салбар дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц юм. Тиймээс авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр буюу аймаг, нийслэл, тэдгээрийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн нэгж, орон нутаг дахь салбарын авлигын цар хүрээг тодорхойлох тоон үзүүлэлтийг хамруулж авч үзлээ.

Авлигын индексийн тоон үзүүлэлт нь авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн дундаж бөгөөд индекс нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үзнэ. Тухайлбал, авлигын хэлбэрийн үзүүлэлтийн утга нэмэгдэж байвал авлигын хүнд хэлбэрүүд үгүй болж байна гэж үзнэ.

Монгол Улсын Авлигын индекс 2011 онд 0.63 гарсан нь 2009 оныхоос 0.01 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл, хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад авлигын нөхцөл байдал муудсан болохыг харуулж байна. Авлигын индексийг бүрдүүлэгч үзүүлэлтээс авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.02 пунктээр буурсан нь авлигын индекс ийнхүү буурахад нөлөөлжээ.

Энэхүү тайлангийн 1 дүгээр бүлэгт Монгол Улсын авлигын индекс, түүний салбар, аймаг нийслэлийн түвшинд, 2 дугаар бүлэгт Авлигын төлөв байдал, цар хүрээний асуудал, 3 дугаар бүлэгт Авлигын илрэн гарч буй хэлбэр, 4 дүгээр бүлэгт Авлигын үүсгэж буй шалтгаан нөхцөл, 5 дугаар бүлэгт Авлигын индекс тооцох аргазүй, олон нийтийн төсөөллийн судалгааны мэдээллийн эх үүсвэрийн тайлбар, судалгаанд оролцогчдын ерөнхий үзүүлэлтийг хамруулан авч үзлээ.

БҮЛЭГ I. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС, САЛБАР, АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ТҮВШИНД

Монгол Улсын Авлигын индекс нь авлига хэмээх сөрөг үзэгдлийн цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтийн нийлбэр цогц бөгөөд уг үзэгдлийн орон зайн (салбар болон аймаг, нийслэлийн түвшинд) болон цаг хугацааны өөрчлөлт (хоёр жил тутамд)-ийг илтгэн харуулдаг.


Авлигатай тэмцэх газраас авлигын индексийг 2009 онд анх тооцож байсан бол хоёр жилийн дараа буюу 2011 онд хоёр дахь удаагаа тооцож байна. Ингэснээр цаг хугацааны хувьд уг үзэгдэл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаа нь энэ удаагийн судалгааны нэг онцлог болж байна.

Тайлангийн энэ бүлэгт үндэсний түвшин дэх авлигын индекс, түүнийг бүрдүүлэгч үзүүлэлт, тэдгээрт гарсан цаг хугацааны өөрчлөлт (дэд бүлэг: I.1), салбар буюу төрийн захиргааны төв байгууллагын болон аймаг, нийслэлийн буюу нутгийн захиргааны, нутгийн өөрөө удирдах байгууллагын авлигын индексийн харьцуулалт, өөрчлөлтийг (дэд бүлэг: I.2, I.3) авч үзсэн болно.

1.1 Монгол улсын авлигын индекс, түүнд гарсан өөрчлөлт

Монгол Улсын Авлигын индекс 2011 онд 0.63 гарсан нь 2009 оныхоос 0.01 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл, хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад авлигын нөхцөл байдал муудсан болохыг харуулж байна. Авлигын индексийг бүрдүүлэгч үзүүлэлтээс авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.02 пунктээр буурсан нь авлигын индекс ийнхүү буурахад нөлөөлжээ. Энэ нь авлига хэмээх үзэгдэл илүү ноцтой байдлаар илрэн гарах болсныг харуулж байна.

Зураг 1. Монгол Улсын авлигын индекс, түүний бүрдүүлэгч үзүүлэлт



Авлигын цар хүрээний үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл, авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 0.79 гарч байна (Хүснэгт 1). Өөрөөр хэлбэл, 2011 онд олон нийт, шинжээчдийн 79.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж үзсэн нь 2009 оныхоос 4.0 пунктээр нэмэгджээ. Үүний дотор Монгол Улсад авлига түгээмэл үзэгдэл болсон гэж 2009 онд иргэдийн 79.4 хувь нь үзэж байсан бол 2011 онд энэ үзүүлэлт 81.4 хувь болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Авлигын цар хүрээний үзүүлэлт

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт	0.75	0.79	0.04
Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт	0.03	0.02	-0.01
Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ	0.10	0.11	0.01
Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ	0.15	0.13	-0.02
Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт	0.74	0.74	0.00

Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 0.02 гарч байгаа нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.1 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас учирсан байна.

Түүнчлэн, шинжээчдийн төсөөллөөр авлигын хувь хэмжээ 0.11 гарсан нь 2009 оныхоос 0.01 пунктээр нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалт буюу тендерт оролцох, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх зэрэг хэлцлүүдийн үнийн дүнгийн дунджаар 11.1 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө авлига, хээл хахууль байдлаар зарцуулагддаг гэж шинжээчид үзсэн байна.

Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 20.0 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан бөгөөд тэд өрхийн жилийн төсвийнхөө дунджаар 12.6 хувьтай тэнцэх буюу 321.3 мянган төгрөгийн хээл хахуулийг төрийн албан хаагчдад өгчээ. Төрийн албан хаагчдад төлсөн хээл хахуулийн өрхийн төсөвт эзлэх хувийн жин буурсан хэдий ч хээл хахууль өгсөн өрхүүдийн эзлэх хувь 6.7 пунктээр, төлсөн хээл хахуулийн дундаж хэмжээ 33.4 хувиар өссөн байна.

Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.52 гарсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.02 пунктээр буурсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Авлигын хэлбэрийн үзүүлэлт

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.31	0.19	-0.12
Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.30	0.51	0.21
Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь	0.42	0.58	0.16
Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт	0.37	0.40	0.03
Авлигын гэмт хэргийн шунахайн сэдэлтийн үзүүлэлт	0.91	0.69	-0.22
Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт	0.54	0.52	-0.02

Авлигын хэлбэрийн үзүүлэлт ийнхүү буурахад авлигын хэргийн давталт, зохион байгуулалттай байдлын болон ангиллын үзүүлэлт 0.03-0.21 пунктээр нэмэгдсэн нь нөлөөлжээ. Тухайлбал, 2009 онд хоёр болон түүнээс дээш давтан үйлдэлтэй авлигын гэмт хэрэг нийт гэмт хэргийн 30.0 хувийг эзэлж байсан бол 2011 онд 51.0 хувь болж 21.0 пунктээр нэмэгдсэн байна. Авлигын гэмт хэргийн давталт буюу үйлдлийн тоо нэмэгдэж байгаа нь төрийн байгууллагын дүрэм, журмын гажуудал, үйл ажиллагааны ил тод бус байдал нь эдгээр хэргийг дахин давтан үйлдэгдэхэд хүргэж байна. Мөн зохион байгуулалттай гэмт хэргийн эзлэх хувь 2009 онд 42.0 хувь байсан бол 2011 онд 58.0 хувь болж 16.0 пунктээр нэмэгдсэн нь авлигын гэмт

хэргийг илүү зохион байгуулалттайгаар үйлдэх болсныг харуулж байна.

Түүнчлэн авлигын хэргийн ангиллын үзүүлэлт 0.03 пунктээр нэмэгдсэн нь авлигын гэмт хэрэгт хүндэвтэр, хүнд хэргүүд зонхилох болж, илүү ноцтой, хор уршигтай болжээ.

1.2 Салбарын авлигын индекс, тэдгээрт гарсан өөрчлөлт

Авлигатай тэмцэх газраас авлигын индексийг үндэсний түвшинд тооцон гаргасны зэрэгцээ салбараар буюу сайд нарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаар тооцон гаргадаг. Энэ нь салбаруудын хооронд авлигад өртөх эрсдэлээр нь харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Салбарын авлигын индексийг тэдгээр дэх авлигыг үүсгэгч нөхцөлүүд болон бодит байдлын талаарх шинжээчид, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчдийн санаа бодлыг тусгасан тус бүр 14 төрлийн үзүүлэлтийг ашиглан тооцсон.

Эрдэс баялаг, эрчим хүчний (0.57), Эрүүл мэндийн (0.59) болон Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын (0.59) төрийн байгууллагууд авлигад өртөх илүү эрсдэлтэй гэж тодорхойлогдсон байна.

Хүснэгт 3. Авлигын индекс, салбараар

Салбар, эрхлэх асуудал	2009	2011	Өөрчлөлт
Сангийн сайдын	0.63	0.66	0.03
Гадаад харилцааны сайдын	0.63	0.64	0.01
Хууль зүй, дотоод хэргийн сайдын	0.61	0.60	-0.01
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын	0.65	0.64	-0.01
Батлан хамгаалахын сайдын	0.71	0.59	-0.12
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын	0.64	0.61	-0.03
Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын	0.64	0.60	-0.03
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын	0.69	0.67	-0.02
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын	0.63	0.67	0.04
Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын	0.47	0.57	0.09
Эрүүл мэндийн сайдын	0.61	0.59	-0.02
Шадар сайдын	0.63	0.59	-0.04

Мөн Батлан хамгаалахын сайд, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд зэрэг 8 салбарт авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн буюу авлигын индекс буурсан байна (Хүснэгт 3). Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын салбарын авлигын индекс 2009 оныхоос 0.09 пунктээр сайжирсан хэдий ч бусад салбартай харьцуулахад хамгийн доогуур үзүүлэлттэй хэвээр байна.

Салбаруудын авлигын индексийн өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг салбараар тус бүрээр авч үзье.

Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн захиргааны байгууллагууд:

Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн захиргааны байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад авлигад өртөх эрсдэл 0.03 пунктээр буурсан байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангаагүй, удирдлагын шийдвэр нээлттэй бус, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан

гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 0.3-23.1 пунктээр буурсан нь төрийн захиргааны байгууллагуудын авлигын эрсдэл багассанд нөлөөлсөн байна.

Хэдийгээр дээрх үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарч байгаач үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэсэн үзүүлэлт 05-21.7 пунктээр ихэссэнээр сангийн сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс өмнөх оныхтой харьцуулахад төдийлөн өөрчлөгдсөнгүй.

Хүснэгт 3. Сангийн сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	33.6	32.9	-0.7
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	17.7	10.3	-7.4
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	48.7	30.8	-17.9
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	46.2	23.1	-23.1
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	35.9	23.1	-12.8
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	21.1	23.1	2.0
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	28.6	12.0	-16.6
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	18.1	21.2	3.1
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.3	15.5	9.2
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.1	6.6	0.5
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.5	27.2	21.7
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	8.6	12.8	4.2
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	16.1	14.5	-1.6
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.2	5.9	-0.3
Авлигын индекс	0.63	0.66	0.03

Бусад салбаруудтай харьцуулахад Сангийн сайдын эрхлэх асуудлын байгууллагууд 0.66 пунктээр 2 дугаарт байгаа нь авлигад өртөх эрсдэл бага байгааг харуулж байна. Тухайлбал, албан хаагчид нь хүнд суртал гаргах явдал бага, хээл хахууль өгөх явдал бага гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.01 пунктээр өсөж авлигад өртөх эрсдэл ялимгүй

буурсан байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангадаггүй, удирдлагын шийдвэр нээлттэй бус, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 0.9-21.3 пунктээр буурсан нь Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын эрсдэл багассанд нөлөөлсөн байна.

Тус салбар нь авлигад өртөх эрсдэл багатай салбарын тоонд орж байгаа ч төсөв санхүүгийн асуудал нээлттэй бус байдал, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийддэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг зэрэг үзүүлэлтүүд өссөн нь үнэлгээнд сөргөөр нөлөөлжээ.

Хүснэгт 4. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	25.0	24.7	-0.3
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	19.7	8.3	-11.4
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	50.0	44.4	-5.6
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.0	44.4	-5.6
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	58.3	37.0	-21.3
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	29.9	31.0	1.1
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	20.0	17.5	-2.5
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	18.9	8.0	-10.9
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.1	23.3	17.2
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.9	6.7	2.8
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	18.9	18.9
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.1	6.7	0.6
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	8.2	7.3	-0.9
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	2.8	2.8
Авлигын индекс	0.63	0.64	0.01

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагыг бусад байгууллагатай харьцуулахад 0.64 пунктээр 3 дугаарт байгаа нь тус салбарын авлигад өртөх эрсдэл бага байна. Тухайлбал, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашиг ихтэй, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан нь бага гэж судалгаанд оролцогчид дүгнэжээ. Харин сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж шинжээчдийн 37.0 хувь, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус гэж төрийн албан хаагчдын 31.0 хувь нь үзэж байгаа нь хамгийн өндөр байна.

Хууль зүй, дотоодын хэргийн сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.01 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, удирдлагын шагнал урамшуулал бодит биш, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийддэг, бусад талуудаас хууль бус санал тавьдаг гэсэн үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 2011 оны байдлаар 3.2-40.1 пунктээр өссөн нь салбарын авлигад өртөх эрсдэлийг нэмсэн байна.

Хэдийгээр дээрх үзүүлэлтүүд сөрөг өөрчлөлтүүд гаргаж байгаа хэдий ч салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, сайн засаглалын шалгуур хангадаггүй, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, хээл хахууль өгөх оролдлого гардаг гэсэн үзүүлэлтүүд буурснаар эерэг нөлөө үзүүлж байна гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 5. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	41.9	45.3	3.4
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	34.7	26.8	-7.9
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	45.2	40.0	-5.2
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	14.3	40.0	25.7
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	31.0	24.4	-6.6
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	47.9	28.0	-19.9
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	26.3	13.6	-12.7
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	16.0	7.2	-8.8
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.0	16.5	11.5
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	10.7	4.7	-6.0
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.3	45.4	40.1
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	10.3	8.2	-2.1
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	19.2	22.4	3.2
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	12.1	8.7	-3.4
Авлигын индекс	0.61	0.60	-0.01

Бусад салбаруудтай харьцуулахад Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс 0.60 буюу сүүлээсээ 3 дугаарт байгаа нь авлигад өртөх эрсдэл өндөр юм. Тухайлбал, авлига түгээмэл гэж үзсэн шинжээчдийн хувь 45.3, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийддэг гэж үзсэн төрийн албан хаагчдын хувь 45.4 буюу өндөр байна. Харин судалгаанд оролцогчид албан хаагчид нь хүнд суртал гаргах явдал бага гэж үзжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.01 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл өмнөх судалгааныхаас нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шагнал урамшуулал бодит биш, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийддэг гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 2.5-20.8 пунктээр өссөн нь салбарын авлигад өртөх эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Тус салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, ах, дүү, танил талаараа асуудалд ханддаг зэрэг үзүүлэлтүүд нь өмнөх жилтэй харьцуулбал буурсан гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 6. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	40.2	36.0	-4.2
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	26.7	20.7	-6.0
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	56.4	60.0	3.6
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	30.8	33.3	2.5
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.6	28.9	3.3
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	10.7	31.5	20.8
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	9.0	7.6	-1.4
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	34.6	17.2	-17.4
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.5	22.5	16.0
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.4	0.0	-7.4
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.0	15.2	8.2
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	4.8	4.4	-0.4

Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.8	2.7	-3.1
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.5	0.0	-6.5
Авлигын индекс	0.65	0.64	-0.01

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын авлигын индекс 0.64 буюу 3 дугаар байгаа нь авлигад өртөх эрсдэл багатайг харуулж байна. Тухайлбал, тухайн салбарт ах дүү танил, талаараа асуудалд хандах, бусад талуудаас хууль бус санал тавьдаг гэсэн үзүүлэлт бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй бага гэж төрийн албан хаагчид дүгнэжээ. Судалгаанд оролцсон шинжээчид тус салбарын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн буюу 60.0 хувьд хүрсэн нь бусад салбаруудтай харьцуулахад өндөр байна.

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигад өртөх эрсдэл 2009 оныхоос нэмэгдсэн буюу авлигын индекс 0.12 пунктээр буурсан байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангадаггүй, удирдлагын шагнал урамшуулал бодит бус, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүдийг 2009 оныхтой харьцуулахад 4.8-32.5 пунктээр өссөн нь салбарын авлигад өртөх эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Хэдийгээр Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын салбарын авлигын индекс буурсан ч төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь нээлттэй бус зэрэг үзүүлэлт 2009 оныхтой харьцуулахад 1.8-9.8 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Шинжээчдийн дүгнэж буйгаар Батлан хамгаалахын салбар хамгийн улс төрөөс хамааралгүй салбар гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь нь 3.6 хувь байна.

Хүснэгт 7. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	11.8	20.7	8.9
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	17.5	37.5	20.0
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	38.9	71.4	32.5
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	16.7	28.6	11.9
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	27.8	33.3	5.5
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	36.4	26.6	-9.8

Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	14.5	12.7	-1.8
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	8.3	3.6	-4.7
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	37.9	37.9
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	10.5	10.5
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	42.3	42.3
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	4.8	4.8
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.7	15.1	7.4
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	4.5	11.8	7.3
Авлигын индекс	0.71	0.59	-0.12

Тус салбар 2009 онд авлигад (0.71) өртөх хамгийн эрсдэл багатай салбар байсан бөгөөд 2011 онд авлигын индекс нь 0.59 сүүлээсээ 6 дугаарт байна. Тухайлбал, Батлан хамгаалахын салбарын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг бусад салбартай харьцуулж үзэхэд хамгийн сул буюу шинжээчдийн эзлэх хувь нь 71.4 байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.03 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлт 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 0.1-27.2 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хэдийгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын салбарын авлигын индекс буурсан ч салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, бусад талаас хууль бус санал тавьж байсан, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 0.1-8.8 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	38.2	40.9	2.7
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	23.6	20.2	-3.4
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	50.0	41.2	-8.8

Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	33.3	44.4	11.1
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	31.5	35.2	3.7
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	25.5	25.5	0.0
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	14.9	13.3	-1.6
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	17.9	11.7	-6.2
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	4.1	23.0	18.9
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.6	4.4	-2.2
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.1	30.3	27.2
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.7	7.6	-0.1
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	12.4	10.9	-1.5
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.6	6.7	0.1
Авлигын индекс	0.64	0.61	-0.03

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индексийн үзүүлэлт 0.61 буюу 4 дүгээрт байгаа нь авлигад өртөх эрсдэлтэйг харуулж байна. Тухайлбал, шинжээчдийн 35.2 хувь нь сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж дүгнэсэн бол төрийн албан хаагчдын зөвхөн 4.4 хувь нь тус салбарын албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж дүгнэсэн нь бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм.

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.03 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 3.1-25.9 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хэдийгээр Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс буурсан ч салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлт 2009 оныхтой харьцуулахад 4.8-25.6 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 9. Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	48.1	38.5	-9.6
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	36.5	10.9	-25.6
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	46.2	56.3	10.1
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	30.8	43.8	13.0
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	48.7	33.3	-15.4
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.5	23.5	16.0
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.5	16.2	8.7
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	18.7	6.7	-12.0
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.8	30.5	24.7
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.7	2.9	-4.8
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.9	29.8	25.9
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	3.1	3.1
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	16.1	20.9	4.8
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	9.5	18.3	8.8
Авлигын индекс	0.64	0.60	-0.04

Зам тээвэр, барилга хот байгуулалтын салбарыг бусад салбартай харьцуулахад авлигын индекс нь 0.60 буюу сүүлээсээ 3 дугаарт байгаа нь авлигад өртөх эрсдэл их байгааг харуулж байна. Тухайлбал, удирдлагын шагнал урамшуулал бодит бус гэж төрийн албан хаагчид дүгнэсэн бол албан хаагчид нь хүнд суртал бараг гаргадаггүй гэж дүгнэсэн буюу төрийн албан хаагчдын эзлэх хувь 2.9 байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.02 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтийг дэлгэрэнгүй авч үзвэл, салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашиггүй, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, удирдлагын шийдвэр нээлттэй бус, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлт 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 0.9-16.4 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Тус салбарын авлигын индекс өмнөх оныхоос буурсан хэдий ч 2011 онд авлигад өртөх хамгийн эрсдэл багатай салбар байна.

Хэдийгээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс буурсан ч ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2.9-10.7 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 10. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	28.0	17.3	-10.7
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	21.0	23.9	2.9
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	53.3	62.5	9.2
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	26.7	18.8	-7.9
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	24.4	35.4	11.0
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	12.3	9.4	-2.9
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.5	16.9	11.4
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	23.7	13.7	-10.0
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.8	14.5	10.7
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	0.0	0.0
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	16.4	16.4
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	0.0	0.0
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	17.3	9.2	-8.1
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	0.9	0.9
Авлигын индекс	0.69	0.67	-0.02

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индекс нь 0.67 буюу 1 дүгээрт байгаа нь авлигад өртөх хамгийн эрсдэл багатай салбарын нэг болж байгаа хэдий ч шинжээчид авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хамгийн сул салбар гэж дүгнэжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.04 пунктээр өсөж авлигад өртөх эрсдэл буурсан байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 3.1-30.4 пунктээр буурсан нь эдгээр байгууллагын авлигын эрсдэл багассанд нөлөөлсөн байна.

Хэдийгээр тус салбар авлигад өртөх эрсдэл багатай салбар ч төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, бусад талуудаас хууль бус санал тавьж байсан, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүд 4.6-23.2 пунктээр ихэссэн нь сөрөг нөлөө үзүүлж байна гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 11. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	33.8	29.3	-4.5
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	23.6	20.5	-3.1
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	57.1	41.7	-15.4
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.0	8.3	-41.7
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	31.0	19.4	-11.6
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	14.3	26.0	11.7
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	10.9	5.1	-5.8
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	39.9	9.5	-30.4
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.6	26.8	23.2
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	4.1	8.7	4.6
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.1	15.9	10.8
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	13.3	4.3	-9.0
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	13.4	18.2	4.8
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	5.1	5.1
Авлигын индекс	0.63	0.67	0.04

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индекс нь (0.67) буюу 1 дүгээрт байгаа нь авлигад өртөх хамгийн эрсдэл багатай салбар нэг гэж судалгаанд оролцогчид дүгнэжээ. Мөн тус салбарын удирдлагын шийдвэр хамгийн нээлттэй буюу төрийн албан хаагчдын эзлэх хувь 5.1 байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.09 пунктээр нэмэгдэж авлигад өртөх эрсдэл буурсан байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, бусад талуудаас хууль бус санал тавьдаг гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 4.8-39.2 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл буурахад нөлөөлсөн байна.

Хэдийгээр тус салбарын авлигын индекс нэмэгдсэн ч авлигад өртөх хамгийн эрсдэл ихтэй салбар бөгөөд салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашиггүй, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангахгүй, хээл хахууль өгөх оролдлого гарч гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 3.0-33.3 пунктээр нэмэгдэж сөрөг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 12. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	65.0	50.8	-14.2
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	29.5	36.8	7.3
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	69.7	36.4	-33.3
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	36.4	72.7	36.3
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	30.3	33.3	3.0
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	40.6	16.5	-24.1
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	26.0	14.3	-11.7
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	59.6	20.4	-39.2
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	31.3	18.6	-12.7
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	27.5	6.9	-20.6
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	37.6	32.8	-4.8
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	34.3	11.2	-23.1

Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	23.5	17.3	-6.2
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	0.0	12.5	12.5
Авлигын индекс	0.47	0.57	0.10

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индекс нь (0.57) буюу сүүлээсээ 1 дүгээрт байгаа нь авлигад өртөх хамгийн эрсдэл өндөртэй салбар гэж судалгаанд оролцогчид дүгнэжээ. Бусад салбаруудтай харьцуулахад тухайн салбарт авлигын тархац өндөр, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангалтгүй, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж судалгаанд оролцогчид үзсэн юм.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын байгууллагууд:

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын байгууллагын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.02 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, бусад талуудаас хууль бус санал тавьдаг, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 0.6-20.8 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хэдийгээр Эрүүл мэндийн салбарын авлигын индекс буурсан ч салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, сайн засаглалын шалгуур хангахгүй байна, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 0.8-13.4 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 13. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	43.5	56.7	13.2
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	23.4	19.3	-4.1
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	53.7	52.9	-0.8
Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	44.4	47.1	2.7
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	29.6	25.5	-4.1
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	30.8	23.9	-6.9
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	22.0	18.0	-4.0

Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	23.9	10.5	-13.4
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.6	26.4	20.8
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	7.8	10.7	2.9
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	5.7	19.8	14.1
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	11.6	15.1	3.5
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	13.4	14.0	0.6
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	4.7	7.6	2.9
Авлигын индекс	0.61	0.59	-0.02

Эрүүл мэндийн салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индекс нь 0.59 буюу сүүлээсээ 2 дугаарт байгаа нь тус салбар авлигад өртөх эрсдэл маш их байгааг харуулж байна. Тухайлбал, авлигын тархац хамгийн өндөр буюу төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь 56.7 байна. Мөн тус салбарыг авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нь сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж судалгаанд оролцогчид дүгнэсэн байна.

Шадар сайд нарын эрхлэх асуудлын байгууллагууд:

Шадар сайдын эрхлэх асуудлын байгууллагуудын авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.04 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл нэмэгдсэн байна. Тус салбарын авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан, сайн засаглалын шалгуур хангахгүй, төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус, албан хаагчид нь хүнд суртал гаргадаг, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ах дүү танил талаараа асуудалд ханддаг, хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 2011 оны байдлаар 2.3-39.2 пунктээр өссөн нь тус салбарын авлигын эрсдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Хэдийгээр Шадар сайд нарын салбарын авлигын индекс буурсан ч салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, удирдлагын шийдвэр нээлттэй бус, үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай, бусдаас хууль бус санал тавьдаг гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 0.5-14.4 пунктээр буурч эерэг нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэж байна.

Хүснэгт 14. Шадар сайд нарын эрхлэх асуудлын авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Үзүүлэлт	2009	2011	Өөрчлөлт
Тухайн салбарт авлига түгээмэл гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	33.7	30.3	-3.4
Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үзсэн төрийн албан хаагчид, шинжээчдийн эзлэх хувь	33.2	22.4	-10.8
Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үнэлсэн шинжээчдийн эзлэх хувь	54.2	57.1	2.9

Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	31.3	35.7	4.4
Сайн засаглалын шалгуур хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	27.1	33.3	6.2
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	27.4	30.5	3.1
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	16.8	11.3	-5.5
Үйл ажиллагаа нь улс төрөөс хамааралтай байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	24.9	10.5	-14.4
Удирдлагын шагнал урамшуулал нь бодит бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	6.4	28.0	21.6
Албан хаагчид нь хүнд суртал гаргадаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	3.0	7.4	4.4
Албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	1.3	40.5	39.2
Ах дүү танил талаараа асуудалд ханддаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	8.2	12.1	3.9
Бусад талуудаас хууль бус санал тавьж байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	14.8	14.3	-0.5
Хээл хахууль өгөх оролдлого гарч байсан гэж хариулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	9.0	11.3	2.3
Авлигын индекс	0.63	0.59	-0.04

Шадар сайд нарын салбарыг бусад салбаруудтай харьцуулахад авлигын индекс нь 0.59 буюу сүүлээсээ 2 дугаарт байгаа нь тус салбар авлигад өртөх эрсдэл маш их байгааг харуулж байна. Тухайлбал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, удирдлагын шагнал урамшуулал бодит бус, албан хаагчид нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж судалгаанд оролцогчид дүгнэжээ.

1.3 Аймаг, нийслэлийн авлигын индекс, тэдгээрт гарсан өөрчлөлт

Авлигатай тэмцэх газраас авлигын индексийг үндэсний түвшинд тооцон гаргасны зэрэгцээ аймаг, нийслэлээр буюу аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудаар тооцон гаргадаг. Энэ нь аймаг, нийслэлийн хооронд авлигад өртөх эрсдэлээр нь харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Аймаг, нийслэлийн авлигын индексийг мөн тэдгээр дэх авлигыг үүсгэгч нөхцөл болон бодит байдлын талаарх шинжээчид, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчдийн санаа бодлыг тусгасан тус бүр 14 төрлийн үзүүлэлтийг ашиглан тооцсон.

Аймаг, нийслэлийн авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 9 аймагт өссөн, 3 аймагт өөрчлөгдөөгүй, 10 аймаг, нийслэлд буурсан байна (Хүснэгт 4). Баян-Өлгий (0.46), Ховд (0.49), Дархан-Уул (0.52), Өмнөговь (0.53), Хөвсгөл (0.53) аймгуудын авлигын индекс доогуур буюу харьцангуй авлигад өртөх эрсдэл өндөртэй аймгууд болж байна.

Хүснэгт 15. Авлигын индекс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2009	2011	Өөрчлөлт
Архангай	0.47	0.60	0.14
Баян-Өлгий	0.54	0.46	-0.09
Баянхонгор	0.58	0.58	0.01
Булган	0.66	0.66	0.00
Говь-Алтай	0.59	0.62	0.03
Дорноговь	0.66	0.64	-0.02
Дорнод	0.59	0.65	0.06
Дундговь	0.66	0.55	-0.11
Завхан	0.64	0.63	-0.02
Өвөрхангай	0.60	0.66	0.06
Өмнөговь	0.55	0.53	-0.01
Сүхбаатар	0.58	0.67	0.09
Сэлэнгэ	0.64	0.69	0.05
Төв	0.71	0.68	-0.03
Увс	0.54	0.54	0.00
Ховд	0.49	0.49	0.00
Хөвсгөл	0.55	0.53	-0.02
Хэнтий	0.56	0.68	0.13
Дархан-Уул	0.60	0.52	-0.08
Улаанбаатар	0.60	0.58	-0.02
Орхон	0.49	0.56	0.07
Говьсүмбэр	0.67	0.58	-0.09

Аймаг, нийслэлийн авлигын индексийн өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг аймаг тус бүрээр авч үзье.

Архангай аймаг

Архангай аймгийн авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 0.14 пунктээр өсөж авлигад өртөх эрсдэл буурсан байна. Архангай аймгийн авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, Архангай аймгийн нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх түвшинд нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах, хээл хахууль, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтүүд 2009 оныхтой харьцуулахад 19.86-31.6 пунктээр буурсан нь Архангай аймгийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын авлигын эрсдэл буурахад нөлөөлсөн байна. Хэдийгээр дээрхи зэрэг өөрчлөлтүүд гарч байгаа ч аймгийн удирдлагын түвшинд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байх гэсэн үзүүлэлт 33.33 пунктээр өссөн байна.

Хүснэгт 16. Архангай аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгч, шинжээчдийн эзлэх хувь	61.2	60.14	-1.06
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	53.46	33.6	-19.86

Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	66.67	100.0	33.3
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	71.43	50.0	-21.4
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	57.14	25.0	-32.1
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	35.71	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	48.4	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	33.33	33.3	0.0
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	66.67	45.8	-20.8
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	60.78	29.17	-31.6
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.94	33.33	-19.6
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	47.06	33.33	-13.7
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.94	22.92	-30.0
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	13.73	2.7	-11.0
Аймгийн авлигын индекс	0.47	0.60	0.13

Архангай аймгийн авлигын индекс 0.60 гарсан нь 11 дүгээрт байна. Үүнд аймгийн удирдлагын түвшинд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус, ашиг сонирхлын зөрчил их тархсан, нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байгаа зэрэг нь нөлөөлсөн байна.

Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын авлигын индексийн 2009 оны судалгаанд ашиглаагүй 2 үзүүлэлт 2011 оны судалгаанд ашигласан юм. Энэ нь төсөв, санхүүгийн үйл ажиллагааны болон удирдлагын шийдвэрийн нээлттэй байдал юм.

Баян-Өлгий аймаг

Баян-Өлгий аймгийн авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад -0.09 пунктээр буурч авлигад өртөх эрсдэл өссөн байна. Баян-Өлгий аймгийн авлигын индексийг тооцсон үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл, өнгөрсөн хугацаанд Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх түвшинд Баян-Өлгий аймгийн захиргааны байгууллагын удирдлага сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ажилдаа хариуцлагагүй хандах гэсэн үзүүлэлтүүд 4.17-33.3 пунктээр өссөн нь авлигын эрсдэлийг дагуулж байна. Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж судалгаанд оролцогчдын 21.2 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 12.1 пунктээр өссөн, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлт 19.7 пунктээр өссөн зэрэг нь тус аймагт авлигын эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Баян-Өлгий аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх, хүнд суртал гаргах,

иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах зэрэг үзүүлэлтүүд 1.52-12.48 пунктээр буурсан байна.

Баян-Өлгий аймгийг бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад авлигын эрсдэл хамгийн өндөр юм. Авлигын тархцын үзүүлэлт 64.98, аймгийн захиргааны удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэсэн үзүүлэлт 87.50, ашиг сонирхлын зөрчил их тархсан.

Хүснэгт 17. Баян-Өлгий аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгч, шинжээчдийн эзлэх хувь	52.46	64.98	12.52
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	49.40	36.93	-12.48
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	83.33	87.50	4.17
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	75.00	75.00	0.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	33.33	66.67	33.33
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	56.88	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	71.56	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	31.82	45.45	13.64
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	69.70	62.12	-7.58
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	30.30	50.00	19.70
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	51.52	48.48	-3.03
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	22.73	37.88	15.15
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	37.88	36.36	-1.52
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	9.09	21.21	12.12
Аймгийн авлигын индекс	0.54	0.46	-0.09

Баянхонгор аймаг

Баянхонгор аймгийн авлигын индекс 2009 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй 0.58 байна. Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 2011 онд 4.72-29.53 пунктээр буурч нааштай хандлага ажиглагдаж байгаач авлигын тархац, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил, сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгөх явдал өсөж байна

гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Баянхонгор аймгийг бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад авлигын тархац харьцангуй өндөр, аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашиггүй, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг, аймгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж судалгаанд оролцогчид үзсэн байна. Сүүлийн 12 сарын хугацаанд иргэдийн зүгээс төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж судалгаанд оролцсон иргэдийн 30.19 хувь нь үзсэн үзүүлэлт аймгуудын дунд хамгийн өндөр байна.

Хүснэгт 18. Баянхонгор аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	43.75	59.09	15.34
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	54.53	25.00	-29.53
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	58.33	62.50	4.17
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	37.50	50.00	12.50
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	41.67	33.33	-8.33
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	46.88	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	34.59	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.00	45.28	-4.72
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	65.00	47.17	-17.83
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	53.33	43.40	-9.94
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.67	43.40	6.73
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	25.00	28.30	3.30
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	26.67	33.96	7.30
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	16.67	30.19	13.52
Аймгийн авлигын индекс	0.58	0.58	0.01

Булган аймаг

Булган аймгийн авлигын индекс 2009 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй 0.66 байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил тал, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх зэрэг үзүүлэлтүүд 4.75-16.63 пунктээр буурсан боловч Булган аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэсэн үзүүлэлтүүд 21.90-26.54 пунктээр өссөн байна.

Булган аймгийн нутгийн захиргаа болон өөрөө нутгийн удирдах байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаа, аливаа гаргаж буй шийдвэр нь нээлттэй бус байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил тал, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, хүнд суртал гаргах, ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзэх төрийн албан хаагч, иргэдийн эзлэх хувь 21.21-28.93 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад авлигын индекс харьцангуй өндөр гарахад нөлөөлсөн байна.

Харин Булган аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байгаа үзүүлэлтүүд нь авлигын индекс өөрчлөгдөөгүйд нөлөөлсөн байна.

Хүснэгт 19. Булган аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	51.62	49.34	-2.29
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	26.25	48.15	21.90
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	66.67	71.43	4.76
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	20.00	42.86	22.86
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	40.00	38.10	-1.90
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	22.64	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	28.93	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	37.84	21.21	-16.63
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.95	33.33	-12.61
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	29.73	24.24	-5.49
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.14	27.27	-7.86
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	29.73	21.21	-8.52
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	18.92	45.45	26.54
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	10.81	6.06	-4.75
Аймгийн авлигын индекс	0.66	0.66	0.00

Говь-Алтай аймаг

Говь-Алтай аймгийн авлигын индекс 2009 онтой харьцуулахад 0.62 болж 0.03 пунктээр өссөн байна. Энэ нь аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил, авлигын тархац, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа асуудлыг

шийдвэрлэх, хүнд суртал гаргах зэрэг үзүүлэлтүүд 2.97-25.0 пунктээр буурсан нь Говь-Алтай аймгийн индекс өсөхөд нөлөөлсөн байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 2.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь 2009 онтой харьцуулахад 10.46 пунктээр буурсан байна.

Говь-Алтай аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэсэн төрийн албан хаагч, шинжээчдийн үзүүлэлт 2011 онд 32.07 хувь болсон нь 2009 онтой харьцуулахад 15.48 пунктээр, аймгийн удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэх шинжээчдийн үзүүлэлт 75.0 хувь байгаа нь 2009 онтой харьцуулахад 19.44 пунктээр тус тус өссөн нь тус аймгийн удирдлага, төрийн байгууллагаас авлигатай тэмцэх чиглэлээр илүү ихийг олон нийт хүсэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Говь-Алтай аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчлийн тархцын талаарх шинжээчдийн үзүүлэлт бусад аймагтай харьцуулахад харьцангуй бага буюу 25 хувь байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 2.70 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь бусад аймагтай харьцуулахад бага үзүүлэлт юм.

Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 40.54 хувь нь иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэсэн нь Говь-Алтай аймгийг бусад аймагтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Түүнчлэн төсөв санхүүгийн үйл ажиллагаа нээлттэй бус гэж Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үзүүлэлт 56.88 хувь байгаа нь бусад аймагтай харьцуулахад мөн харьцангуй өндөр байна.

Хүснэгт 20. Говь-Алтай аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	48.25	45.28	-2.97
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	16.59	32.07	15.48
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	55.56	75.00	19.44
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	25.00	-25.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	37.50	-12.50
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	56.88	56.88
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	39.09	39.09
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	34.21	29.73	-4.48
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	63.16	48.65	-14.51
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	31.58	29.73	-1.85

Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	55.26	40.54	-14.72
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.84	32.43	-4.41
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	34.21	40.54	6.33
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	13.16	2.70	-10.46
Аймгийн авлигын индекс	0.59	0.62	0.03

Дорноговь аймаг

Дорноговь аймгийн авлигын индекс 0.64 гарсан нь 2009 онтой харьцуулахад 0.02 пунктээр буурсан байна. Хэдийгээр авлигын индекс буурсан ч гэсэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн авлигын тархцын үзүүлэлт, аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус гэж үзэх төрийн албан хаагч, шинжээчдийн үзүүлэлт, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзэх шинжээчдийн үзүүлэлт 9.45-33.33 пунктээр 2009 онтой харьцуулахад буурсан байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 2.70 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь бусад аймагтай харьцуулахад доогуур үзүүлэлт юм.

Дорноговь аймгийн захиргааны байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тарсан, ах дүү, танил тал, хээл хахуулиар болон улс төрийн намын нөлөөнд автаж, хээл хахуулиар асуудлыг асуудлыг шийдвэрлэдэг, ажилдаа хариуцлагагүй, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэсэн үзүүлэлтүүд өнгөрсөн 2 жилийн хугацаанд 7.45-21.46 пунктээр буурсан нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дорноговь аймгийг бусад аймаг, нийслэлтэй харьцуулбал, аймгийн захиргааны байгууллагын удирдлага авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж судалгаанд оролцсон иргэд, шинжээчид үзсэн байна. Тус аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх түвшинд ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх явдал гэсэн үзүүлэлт бусад аймаг нийслэлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 70.69 хувьд хүрсэн байна. Эдгээр нь тус аймгийн авлигын индекс буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 21. Дорноговь аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	43.08	33.63	-9.45
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	47.50	34.68	-12.82
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	37.50	25.00	-12.50
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.00	37.50	12.50
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	16.67	-33.33

Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	47.47	47.47
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	29.00	29.00
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	32.31	53.45	21.14
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	49.23	70.69	21.46
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	32.31	39.66	7.35
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	44.62	44.83	0.21
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	27.69	36.21	8.51
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	18.46	36.21	17.75
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	4.62	2.70	-1.92
Аймгийн авлигын индекс	0.66	0.64	-0.02

Дорнод аймаг

Дорнод аймгийн авлигын индекс 0.65 болж 2009 онтой харьцуулбал 0.06 пунктээр авлигын эрсдэл буурчээ. Дорнод аймгийн авлигын эрсдэлд улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах гэсэн үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 15.98-28.69 пунктээр буурсан нь нөлөөлсөн байна. Тэгэхдээ аймгийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх явдал гүнзгийрч байна. Эдгээр үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 17.26-21.43 пунктээр өссөн байна.

Дорнод аймгийн авлигын индекс 0.65 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 7 дугаарт байна. Тус аймгийн авлигын индекс мөн түүн дэх авлигыг үүсгэгч нөхцөл болон бодит байдлын талаарх шинжээчид, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчдийн санаа бодлыг тусгасан тус бүр 14 төрлийн үзүүлэлтээр дундаж түвшинд байна.

Хүснэгт 22. Дорнод аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	28.32	35.83	7.51
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	21.89	28.00	6.11
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	47.62	50.00	2.38
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	28.57	50.00	21.43
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	28.57	45.83	17.26
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	38.71	38.71

Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	32.26	32.26
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.59	29.17	-21.42
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	57.65	41.67	-15.98
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	51.76	30.56	-21.21
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	64.71	38.89	-25.82
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.47	29.17	-7.30
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	56.47	27.78	-28.69
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	15.29	12.50	-2.79
Аймгийн авлигын индекс	0.59	0.65	0.06

Дундговь аймаг

Дундговь аймгийн авлигын индекс 0.55 байгаа нь 2009 онтой харьцуулахад 0.11 пунктээр буурсан байна. Дундговь аймгийн авлигын эрсдэл өсөхөд авлига үүсгэгч нөхцөлийн 9 үзүүлэлт өссөн нь нөлөөлсөн байна. Үүн дотор хамгийн ихээр аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэсэн үзүүлэлтүүд нөлөөлсөн байна. Эдгээр үзүүлэлтүүд 33.33-50.00 пунктээр өссөн байна. Үүнээс гадна аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтүүд ч өссөн нь авлигын индекс буурахад нөлөөлсөн байна.

Дундговь аймгийн авлигын индекс 0.55 байгаа нь бусад аймаг нийслэлтэй харьцуулахад 16 дугаарт байна. Тус аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил их тархсан зэрэг үзүүлэлтүүд 87.50 байгаа нь аймаг, нийслэл дунд хамгийн өндөр үзүүлэлт юм.

Хүснэгт 23. Дундговь аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	31.73	34.78	3.05
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	24.50	33.42	8.92
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	54.17	87.50	33.33
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	37.50	87.50	50.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	41.67	33.33	-8.33
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	56.35	56.35

Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	40.00	40.00
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	43.59	42.86	-0.73
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	48.72	60.00	11.28
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	23.08	38.24	15.16
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	33.33	48.57	15.24
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	30.77	37.14	6.37
Иргэд үйлчлүүлэг-чидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	25.64	25.71	0.07
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	10.26	5.71	-4.54
Аймгийн авлигын индекс	0.66	0.55	-0.11

Завхан аймаг

Завхан аймгийн авлигын индекс 0.63 гарсан нь 2009 онтой харьцуулбал 0.02 пунктээр буурсан байна.

Завхан аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэсэн үзүүлэлтүүд 16.67-20.83 пунктээр 2009 онтой харьцуулахад буурсан ч авлигын тархац, аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтүүд 5.61-15.54 пунктээр өссөн байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 21.05 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн зүгээс нь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь 2009 онтой харьцуулахад 8.55 пунктээр өссөн байна.

Завхан аймгийн авлигын индекс 0.63 гарсан нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 9 дүгээрт байна. Завхан аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэсэн үзүүлэлтүүд бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад дээгүүр буюу 16.83-20.83 хувь байгаа нь авлигын эрсдэлийг бууруулах боломж байгааг харуулж байна. Тэгэхдээ тус аймагт авлигын тархцын үзүүлэлт 60.71 байгаа нь харьцангуй өндөр юм. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 21.05 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлт 41.03 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Хүснэгт 24. Завхан аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	56.25	60.71	4.46
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	34.23	16.83	-17.40
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	66.67	50.00	-16.67

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.00	37.50	12.50
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	41.67	20.83	-20.83
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	48.34	48.34
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	48.34	48.34
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	22.92	38.46	15.54
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	39.58	38.46	-1.12
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.42	41.03	5.61
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	39.58	35.90	-3.69
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	27.08	30.77	3.69
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	27.08	33.33	6.25
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	12.50	21.05	8.55
Аймгийн авлигын индекс	0.64	0.63	-0.02

Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймгийн авлигын индекс 0.66 буюу 2009 онтой харьцуулахад 0.06 пунктээр өссөн байна. Өвөрхангай аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага бүхий л түвшинд улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх, ажилдаа хариуцлагагүй хандаж хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлтүүд өнгөрсөн хугацаанд 11.69-27.80 пунктээр буурсан байна.

Өнгөрсөн хугацаанд Өвөрхангай аймгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, авлигатай хийх тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус гэсэн үзүүлэлтүүд 13.90-25.00 пунктээр өссөн нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Өвөрхангай аймгийн авлигын индекс 0.66 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 5 дугаарт байна. Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, удирдлагын шийдвэр нээлттэй бус гэсэн үзүүлэлтүүд 27.54-29.90 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад харьцангуй доогуур байна. Гэтэл аймгийн захиргааны авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэсэн үзүүлэлт 49.33 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн өндөр байна.

Хүснэгт 25. Өвөрхангай аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	43.75	36.61	-7.14
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	35.44	49.33	13.90

Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	58.33	50.00	-8.33
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	12.50	37.50	25.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	29.17	20.83	-8.33
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	39.71	39.71
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	29.90	29.90
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	59.09	37.68	-21.41
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	72.73	44.93	-27.80
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	28.41	27.54	-0.87
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.27	40.58	-11.69
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	38.64	26.09	-12.55
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	44.32	23.19	-21.13
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	6.82	7.35	0.53
Аймгийн авлигын индекс	0.60	0.66	0.06

Өмнөговь аймаг

Өмнөговь аймгийн авлигын индекс 0.53 болж 2009 онтой харьцуулаад

0.01 пунктээр буурсан байна. Тус аймгийн авлигын индекс, авлигын эрсдэлийг бүрдүүлэгч нөхцөлийг авч үзвэл авлигын тархац, аймгийн захиргааны удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх явдал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байх гэсэн үзүүлэлтүүд 10.83-18.33 пунктээр 2009 онтой харьцуулахад буурсан ч аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хүнд суртал гаргах, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ашиг сонирхлын зөрчил их тархах явдал гэсэн үзүүлэлт 10.00-19.52 пунктээр өссөн нь авлигын индекс буурахад нөлөөлжээ.

Өмнөговь аймгийн авлигын индекс 0.53 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 18 дугаарт буюу сүүлээсээ 5 дугаарт байна. Үүнд улс төрийн нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх зэрэг үзүүлэлтүүд 43.59-66.67 нөлөөлсөн байна. Энэ нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад харьцангуй өндөр юм. Түүнчлэн аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлт 71.79 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байна.

Хүснэгт 26. Өмнөговь аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	59.55	46.53	-13.02
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	30.00	31.92	1.92
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	73.33	62.50	-10.83
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	40.00	50.00	10.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	60.00	41.67	-18.33
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	38.67	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	41.72	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	25.00	43.59	18.59
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	56.82	66.67	9.85
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.45	46.15	0.70
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.27	71.79	19.52
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.00	48.72	-1.28
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.36	35.90	-0.47
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	15.91	25.64	9.73
Аймгийн авлигын индекс	0.55	0.53	-0.01

Сүхбаатар аймаг

Сүхбаатар аймгийн авлигын индекс 0.67 байгаа нь 2009 онтой харьцуулахад 0.09 пунктээр өссөн байна. Аймгийн авлигын индекс, түүн дэх авлигыг бүрдүүлэгч нөхцөлөөс өнгөрсөн 2 жилийн хугацаанд Сүхбаатар аймгийн хувьд 9 үзүүлэлт 4.90-25.00 пунктээр буурсан байгаа нь авлигын индекс өсөхөд нөлөөлсөн байна. Харин Сүхбаатар аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлт 62.79 байгаа нь 2009 онтой харьцуулахад 1.92 пунктээр өссөн байна.

Сүхбаатар аймгийн авлигын индекс 0.67 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 4 дүгээрт байна. Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, авлигын тархац зэрэг үзүүлэлт 12.50-24.54 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулбал харьцангуй доогуур байна. Харин төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлтүүд 44.19-62.79 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

Хүснэгт 27. Сүхбаатар аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	38.32	24.54	-13.78
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	50.43	27.62	-22.81
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	41.67	25.00	-16.67
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.00	12.50	-12.50
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	37.50	12.50	-25.00
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	53.39	53.39
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	34.75	34.75
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	43.48	44.19	0.71
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	63.04	58.14	-4.90
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.65	39.53	-6.12
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	60.87	62.79	1.92
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	39.13	25.58	-13.55
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	54.35	30.23	-24.12
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	0.00	4.65	4.65
Аймгийн авлигын индекс	0.58	0.67	0.09

Сэлэнгэ аймаг

Сэлэнгэ аймгийн авлигын индекс 0.69 байгаа нь 2009 онтой харьцуулбал 0.05 пунктээр өссөн байна. Үүнд авлигын эрсдэлийг бүрдүүлэгч нөхцөлөөс 8 үзүүлэлт буурсантай холбоотой юм. Эдгээрээс аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх түвшинд ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэх, захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул байх зэрэг үзүүлэлт 12.70-15.42 пунктээр буурсан байна. Харин олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцсон иргэдийн 10.98 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь 2009 онтой харьцуулбал 3.28 пунктээр нэмэгдсэн байна.

Тус аймгийн авлигын индекс 0.69 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулбал хамгийн сайн үзүүлэлттэй байна. Харин ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлт 32.93 байгаа нь бусад аймаг, нийслэлийн дунд хамгийн доогуур үзүүлэлт байна.

Хүснэгт 28. Сэлэнгэ аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	51.65	41.25	-10.40
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	44.95	33.11	-11.85
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	57.14	44.44	-12.70
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	42.86	33.33	-9.52
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	21.43	29.63	8.20
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	33.33	33.33
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	36.07	36.07
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	28.57	24.39	-4.18
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	48.35	32.93	-15.42
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	28.57	30.49	1.92
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	34.07	30.49	-3.58
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	29.67	29.27	-0.40
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.16	23.17	-11.99
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	7.69	10.98	3.28
Аймгийн авлигын индекс	0.64	0.69	0.05

Төв аймаг

Төв аймгийн авлигын индекс 0.68 байгаа нь 2009 онтой харьцуулбал 0.03 пунктээр буурчээ. Үүнд нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, удирдлагын шийдвэр нээлттэй бус байх, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах зэрэг үзүүлэлтүүд 6.25-27.62 пунктээр өссөн нь нөлөөлсөн байна.

Хэдийгээр тус аймгийн авлигын индекс буурч авлигын эрсдэл өсөж байгаач аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэсэн үзүүлэлт 28.57 байгаа нь 2009 онтой харьцуулбал 18.10 пунктээр, авлигын тархцын үзүүлэлт 20.0 болсон нь 11.88 пунктээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд тус тус буурсан байна.

Төв аймгийн авлигын индекс 0.68 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад эхнээсээ гуравдугаарт байна. Авлигын тархацын үзүүлэлт бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад тус аймагт хамгийн бага буюу 20.0 байна. Түүнчлэн тус аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархацын үзүүлэлт 14.29 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад доогуур үзүүлэлт байна.

Харин удирдлагын шийдвэр нээлттэй бус гэсэн үзүүлэлт 56.76 байгаа нь бусад аймаг, нийслэлд дунд харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Хүснэгт 29. Төв аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	31.88	20.00	-11.88
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	28.57	28.67	0.10
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	46.67	28.57	-18.10
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	20.00	14.29	-5.71
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	20.00	47.62	27.62
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	40.14	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	56.76	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	18.75	25.00	6.25
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	39.58	40.00	0.42
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.42	30.00	-5.42
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	41.67	42.50	0.83
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	29.17	35.00	5.83
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	31.25	25.00	-6.25
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	6.25	12.50	6.25
Аймгийн авлигын индекс	0.71	0.68	-0.03

Увс аймаг

Увсаймгийн авлигын индекс 0.54 байгаань 2009 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, хүнд суртал гаргадаг гэсэн үзүүлэлтүүд 10.15-14.25 пунктээр буурсан ч улс төрийн намын нөлөөнд автаж асуудлыг шийдвэрлэдэг, аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус гэсэн үзүүлэлтүүд 3.64-8.65 пунктээр өссөн нь авлигын эрсдэл оршсоор байгааг харуулж байна.

Бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад тус аймгийн авлигын индекс 0.54 байгаа нь 17 дугаарт харьцангуй доогуур юм. Үүнд төсөв санхүүгийн үйл ажиллагаа, удирдлагын шийдвэр нээлттэй бус гэсэн үзүүлэлтүүд 62.67-65.56 буюу бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн өндөр байна.

Хүснэгт 30. Увс аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	48.71	50.18	1.47
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	31.67	35.31	3.64
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	37.50	-12.50
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.00	25.00	0.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	33.33	33.33	0.00
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	65.56	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	62.67	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	51.72	60.38	8.65
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	70.69	67.92	-2.77
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	68.97	54.72	-14.25
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	72.41	62.26	-10.15
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.21	33.96	-2.24
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	41.38	39.62	-1.76
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	25.86	13.21	-12.65
Аймгийн авлигын индекс	0.54	0.54	0.00

Ховд аймаг

Ховд аймгийн авлигын индекс 0.49 буюу 2009 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүх түвшинд ажилдаа хариуцлагагүй хандах, иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах, хүнд суртал гаргах зэрэг үзүүлэлтүүд 10.98-27.84 пунктээр буурсан ч аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан, сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, аймгийн захиргааны байгууллагын удирдлага авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэсэн үзүүлэлтүүд 14.29-32.14 пунктээр буурсан байна.

Ховд аймгийн индекс 0.49 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад доороосоо хоёрдугаарт байна. Үүнд тус аймаг дахь авлигын тархац, аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа үр ашигтай бус, аймгийн удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэх мэтчилэн авлигыг үүсгэгч 14 нөхцөл 8 нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байгаа нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 31. Ховд аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	69.05	69.26	0.22
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	44.21	40.45	-3.77
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	66.67	87.50	20.83
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	42.86	75.00	32.14
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	52.38	66.67	14.29
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	51.40	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	40.22	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.51	39.34	2.84
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	63.49	65.57	2.08
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	63.49	60.66	-2.84
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	65.08	54.10	-10.98
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.79	22.95	-27.84
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	44.44	29.51	-14.94
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	12.70	8.06	-4.63
Аймгийн авлигын индекс	0.49	0.49	0.00

Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймгийн авлигын индекс 0.53 гарсан нь 2009 онтой харьцуулахад 0.02 пунктээр буурсан байна. Үүнд аймгийн удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, аймгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй, ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэх, авлигын тархац нэмэгдсэн зэрэг үзүүлэлтүүд өнгөрсөн 2 жилийн хугацаанд 14.41-33.33 пунктээр өссөнтэй холбоотой байна.

Хэдийгээр Олон нийтийн судалгаанд оролцсон иргэд, тэдний гэр бүлээс сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэх иргэд 9.62 хувь болж 2009 онтой харьцуулахад 24.50 пунктээр, ажилдаа хариуцлагагүй хандах, улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах гэсэн үзүүлэлтүүд 15.75-16.49 пунктээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд тус тус буурсан ч дээрх авлигыг үүсгэгч нөхцөлийг анхаарах шаардлагатай байна.

Тус аймгийн авлигын индекс 0.53 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад сүүлээсээ гуравдугаарт байна. Хөвсгөл аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил их тархсан, сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй, ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлтүүдээр бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн муу үнэлгээг авсан байна.

Хүснэгт 32. Хөвсгөл аймгийн индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	41.93	56.34	14.41
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	42.28	41.94	-0.35
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	66.67	100.00	33.33
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	57.14	75.00	17.86
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	42.86	66.67	23.81
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	34.43	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	39.02	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	38.82	23.08	-15.75
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	51.76	70.00	18.24
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.88	50.00	4.12
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	42.35	42.31	-0.05
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	37.65	21.15	-16.49
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	37.65	23.08	-14.57
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	34.12	9.62	-24.50
Аймгийн авлигын индекс	0.55	0.53	-0.02

Хэнтий аймаг

Хэнтий аймгийн авлигын индекс 0.68 байгаа нь 2009 онтой харьцуулахад 0.13 пунктээр нэмэгдсэн байна. Үүнд авлигын тархац, аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг, ажилдаа хариуцлагагүй ханддаг, ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг зэрэг үзүүлэлтүүдээр 2009 онтой харьцуулахад 14.59-37.50 пунктээр буурсан нь нөлөөлжээ. Гэвч аймгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, иргэд, үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй ханддаг зэрэг үзүүлэлтүүд өнгөрсөн хугацаанд 9.97-28.89 пунктээр нэмэгдсэн нь авлигын эрсдэл оршсоор байгааг харуулж байна.

Тус аймгийн авлигын индекс 0.68 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад эхнээсээ хоёрдугаарт байна.

Хүснэгт 33. Хэнтий аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	53.02	22.08	-30.94
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	16.30	45.19	28.89
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	62.50	25.00	-37.50
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	50.00	0.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	50.00	29.17	-20.83
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	16.03	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	19.23	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	48.39	40.91	-7.48
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	53.23	38.64	-14.59
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	54.84	26.19	-28.65
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.16	50.00	4.84
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	45.16	27.27	-17.89
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.48	45.45	9.97
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	16.13	6.98	-9.15
Аймгийн авлигын индекс	0.56	0.68	0.13

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн авлигын индекс 0.52 байгаа нь 2009 онтой харьцуулбал 0.08 пунктээр буурсан байна. Үүнд аймгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их, авлигын тархац, аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэсэн үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 13.10-48.21 пунктээр буурсан нь нөлөөлжээ.

Тус аймгийн авлигын индекс 0.52 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад доороосоо хоёрдугаарт байна. Үүнд авлигын тархац их, аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил их тархсан, захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байх, төсөв санхүүгийн үйл ажиллагаа болон удирдлагын шийдвэр нээлттэй бус байгаа нь нөлөөлсөн байна. Түүнчлэн Олон нийтийн судалгаанд оролцсон иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс 26.26 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад өндөр байна.

Хүснэгт 34. Дархан-Уул аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	47.28	69.98	22.71
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	18.93	18.77	-0.15
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	61.90	75.00	13.10
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	14.29	62.50	48.21
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	42.86	54.17	11.31
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	60.00	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	50.00	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	40.82	35.16	-5.66
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	56.46	56.25	-0.21
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	43.54	46.03	2.49
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	55.10	49.22	-5.88
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	34.69	38.28	3.59
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	41.50	36.72	-4.78
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	25.17	26.56	1.39
Аймгийн авлигын индекс	0.60	0.52	-0.08

Орхон аймаг

Орхон аймгийн авлигын индекс 0.56 байгаа нь 2009 онтой харьцуулахад 0.07 пунктээр өссөн байна. Үүнд авлигын тархац, ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэх явдал, хүнд суртал гаргах, ажилдаа хариуцлагагүй хандах, иргэд үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй хандах зэрэг үзүүлэлтүүдийг 9.22-21.34 пунктээр бууруулж чадсан байна. Гэвч судалгаанд оролцсон шинжээчд аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж дүгнэн эзлэх хувь 62.50 болж 2009 онтой харьцуулахад 15.83 пунктээр өссөн байна.

Тус аймгийн авлигын индекс 0.56 байгаа нь бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 15 дугаарт байна. Үүнд авлигын тархац, хүнд суртал гаргах, иргэд үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй хандах, аймгийн удирдлагын шийдвэр нээлттэй бус байх зэрэг үзүүлэлтүүд бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн доогуур байна. Түүнчлэн аймгийн захиргааны байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх зэрэг үзүүлэлтүүд бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад хамгийн доогуур байна.

Хүснэгт 35. Орхон аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	72.53	63.31	-9.22
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	22.58	22.34	-0.24
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	46.67	62.50	15.83
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	20.00	12.50	-7.50
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	53.33	33.33	-20.00
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	66.88	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	56.60	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.74	36.72	-16.02
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	76.03	54.69	-21.34
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	64.38	60.94	-3.45
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	70.55	52.34	-18.20
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	49.32	35.94	-13.38
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	56.16	40.63	-15.54
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	23.29	17.97	-5.32
Аймгийн авлигын индекс	0.49	0.56	0.07

Говьсүмбэр аймаг

Говьсүмбэр аймгийн авлигын индекс 0.58 гарсан нь 2009 онтой харьцуулахад 0.09 пунктээр буурсан байна. Үүнд авлигын тархац, аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчил их тархсан, сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, иргэд үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй хандах зэрэг үзүүлэлтүүд 10.08-30.16 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тус аймгийн авлигын индекс 0.58 байгааг бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад 14 дүгээрт байна. Тухайн аймгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул, ашиг сонирхлын зөрчилд автсан, сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй, ажилдаа хариуцлагагүй ханддаг зэрэг үзүүлэлтүүдээр бусад аймаг, нийслэлтэй харьцуулахад дээгүүр байна.

Хүснэгт 36. Говьсүмбэр аймгийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	32.14	42.22	10.08
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	47.00	25.23	-21.77
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	47.62	77.78	30.16
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	28.57	55.56	26.98
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	23.81	48.15	24.34
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	44.09	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	44.09	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	27.27	28.57	1.30
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	36.36	38.10	1.73
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	31.82	47.62	15.80
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.00	47.62	-2.38
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	40.91	42.86	1.95
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	18.18	38.10	19.91
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	13.64	14.29	0.65
Аймгийн авлигын индекс	0.67	0.58	-0.09

Улаанбаатар хот

Нийслэлийн авлигын индекс 0.58 гарсан нь 2009 онтой харьцуулахад 0.02 пунктээр буурсан байна. Үүнд нийслэлийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, ашиг сонирхлын зөрчил их тархсан гэсэн үзүүлэлтүүд 2009 онтой харьцуулахад 5.00-22.74 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцсон иргэдийн үзэж байгаагаар сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэсэн иргэдийн хувь мөн хугацаанд 24.32 болсон байгаа нь 6.33 пунктээр нэмэгдсэн байна.

Нийслэлийн индекс 0.58 гарсан нь бусад аймагтай харьцуулахад 13 дугаарт байна. Үүнд нийслэлийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус, ажилдаа хариуцлагагүй хандах, хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, иргэд үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй хандах зэрэг үзүүлэлтүүд бусад аймагтай харьцуулахад доогуур байна. Түүнчлэн Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж 24.32 хувь нь үзсэн нь бусад аймагтай харьцуулахад өндөр үзүүлэлтийн нэг юм. Иймд цаашид авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр авлигыг үүсгэгч эдгээр нөхцөлийг анхаарах шаардлагатай байна.

Хүснэгт 37. Нийслэлийн авлигын индекс, авлига үүсгэгч нөхцөл

Авлигыг үүсгэгч нөхцөл	2009	2011	Өөрчлөлт
Авлига түгээмэл гэж үзсэн иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн эзлэх хувь	59.08	52.67	-6.41
Нутгийн захиргааны байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь үр ашигтай бус гэж үнэлсэн төрийн албан хаагч, шинжээчдийн эзлэх хувь	20.83	43.57	22.74
Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл сул гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	45.00	35.00	-10.00
Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ашиг сонирхлын зөрчил их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	25.00	30.00	5.00
Нутгийн захиргааны байгууллагын удирдлага нь сайн засаглалын шалгууруудыг огт хангахгүй байна гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувь	43.33	36.67	-6.67
Төсөв санхүүгийн үйл ажиллагаа нь нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	52.84	-
Удирдлагын шийдвэр нээлттэй бус байдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувь	-	47.63	-
Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	35.87	34.81	-1.06
Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	50.59	49.66	-0.93
Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	46.44	48.24	1.80
Хүнд суртал гаргадаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	52.88	50.79	-2.08
Ажилдаа хариуцлагагүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	38.65	40.84	2.19
Иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй ханддаг гэж үзсэн иргэдийн эзлэх хувь	43.23	42.10	-1.13
Сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан иргэдийн эзлэх хувь	18.00	24.32	6.33
Нийслэлийн авлигын индекс	0.60	0.58	-0.02

БҮЛЭГ II. АВЛИГЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЦАР ХҮРЭЭ

Авлигын индекс тооцох аргачлалд авлигын цар хүрээ гэдэгт авлигын тархалтын хэмжээ, давтамжийг авч үзнэ гэж заасан байдаг.

2.1. Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн судалгааны дүн

Авлигын талаарх шинжээчид, олон нийтийн төсөөллийн судалгааны бүлэг тус бүрээс буюу шинжээчид, иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдээс тухайн бүлэг тус бүрд зориулсан ялгаатай асуулгаар судалгааг авсан хэдий ч судалгаанд оролцогчдын талаарх ерөнхий үзүүлэлтүүд буюу судалгаанд оролцогчдын төр засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ, авлигын тархцын талаарх үнэлгээ, Монгол Улсын тодорхой түвшнийхний авлигын тархцын үнэлгээ, сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн байдал, өгөх болсон болон өгөөгүй шалтгаан, ирэх хоёр жилийн хугацаанд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаарх төсөөлөл зэрэг мэдээллийг нийтлэг байдлаар цуглуулсан болно.

Төр засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын 4.4

хувь нь ихээхэн үр ашигтай байна гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулбал -2.0 хувиар, 14.0 хувь нь зарим талаараа үр ашигтай байна гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулбал -3.8 хувиар, 23.4 хувь нь үр ашигтай ч биш, үр ашиггүй ч биш гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулбал -2.0 хувиар тус тус буурсан байна. Харин судалгаанд оролцогчдын 18.2 хувь нь зарим талаараа үр ашиггүй байна гэж дүгнэсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.8 хувиар, 21.8 хувь нь ихээхэн үр ашиггүй байна гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 1.0 хувиар тус тус нэмэгджээ.

“Монгол Улсад авлига хэр түгээмэл гэж Та үзэж байна вэ” гэсэн асуултад 2009 онд судалгаанд оролцогчдын 34.5 хувь нь ихээхэн түгээмэл гэж үзэж байсан бол 2011 онд 37.9 хувь болж нэмэгдсэн байна. Түүнчлэн 43.5 хувь нь манай улсад авлига түгээмэл гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад -1.9 хувиар, 11.3 хувь нь дунд зэрэг гэсэн нь -1.1 хувиар, 3.0 хувь нь бага зэрэг гэсэн -0.5 хувиар, 0.2 хувь нь огт байхгүй гэсэн нь -0.1 хувиар тус тус буурчээ.

Монгол улсын тодорхой түвшнийхний дундах авлигын тархцын талаар асуухад 2009 онд судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 66.8 хувь нь шүүхийг авлигад ихээхэн автсан гэж үзэж байсан бол 2011 онд 65.5 хувь болж бага хэмжээгээр, төрийн албан хаагчдыг авлигад ихээхэн автсан гэж үзсэн нь судалгаанд оролцогчдын эзлэх хувь 49.8-аас 46.9 хувь болон тус тус буурсан байна. Судалгаанд оролцогчдын 58.8 хувь нь Улс төрийн намуудыг, 58.5 хувь нь Улсын их хурлыг авлигад ихээхэн автсан гэж үзэж байгаа нь 2009 оныхтой харьцуулахад 0.4-3.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Дээрхи үзүүлэлтээс харахад судалгаанд оролцогчид хууль хяналт, улс төрийн хүрээнд авлига ихээхэн тархсан гэж дүгнэжээ. Харин судалгаанд оролцогчдын харьцангуй бага буюу 20.8-37.9 хувь нь төрийн бус байгууллагын ажилтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бизнес эрхлэгчдийг авлигад ихээхэн автсан гэж үзжээ.

Сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд оролцогчдын зүгээс төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн эсэхийг тодруулахад 15.4 хувь нь өгсөн гэх ба энэ нь 2009 оныхтой харьцуулахад 2.1 хувиар өссөн бол 82.1 хувь нь өгөөгүй, 2.5 хувь нь хариулаагүй буюу мэдэхгүй гэж хариулсан байна. Түүнчлэн 30 хүртэлх насны иргэдийн 14.7 хувь нь, 31-40 насныхны 17.4 хувь нь, 41-50 насныхны 17.2 хувь нь, 51-60 насныхны 14.4 хувь нь, 61-70 насныхны 12.1 хувь нь, 71 болон түүнээс дээш насныхны 6.7 хувь хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн байдлыг судалгаанд оролцогчдын боловсролын түвшингээр авч үзэхэд бүрэн дунд хүртэлх боловсролтой иргэдийн 18.0 хувь нь хээл хахууль өгсөн гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 6.0 хувиар, техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн боловсролтой иргэдийн 16.4 хувь нь буюу 2009 оныхтой харьцуулахад 1.0 хувиар, бакалавр болон магистр түүнээс дээш боловсролтой иргэдийн 15.3 хувь нь буюу 2009 оныхтой харьцуулахад 1.9 хувиар тус тус өссөн байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн хэмжээг тодруулахад хээл хахууль өгсөн гэж хариулсан судалгаанд оролцогчдын 12.9 хувь нь 35.0 мянган төгрөгийн, 28.2 хувь нь 35.1-115.0 мянган төгрөгийн, 24.0 хувь нь 115.1-575.0 мянган төгрөгийн, 9.2 хувь нь 575.1-1150.0 мянган төгрөгийн, 5.5 хувь нь 1200.0 мянган төгрөг болон түүнээс дээш төгрөгийн хээл хахуулийг төрийн албан хаагчдад өгсөн гэж хариулсан бол 20.3 хувь нь хариулахаас татгалзсан эсвэл мэдэхгүй гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдоос сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгөх болсон шалтгааныг тодруулахад иргэдийн 43.6 хувь нь тухайн тохиолдолд хээл хахуульгүйгээр асуудлаа шийдвэрлэх боломжгүй гэж урьдаас мэдэж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 4.3 хувиар нэмэгдсэн

байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 20.3 хувь нь албан тушаалтан авлига өгөхийг шаардаагүй боловч би хээл хахууль өгсөн нь найдвартай гэж үзсэн, 17.7 хувь нь албан тушаалтан надад санал болгосон, шаардсан, тийм байдалд оруулсан, 12.0 хувь нь хариулахад хүндрэлтэй байна,

6.4 хувь нь бусад шалтгаанаар хээл хахууль өгсөн гэж хариулжээ. Сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн 30 хүртэлх насны иргэдийн 41.4 хувь нь хээл хахууль өгөх болсон шалтгаанаа тухайн тохиолдолд хээл хахуульгүйгээр асуудлаа шийдвэрлүүлэх боломжгүй гэж урьдаас мэдэж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулбал 7.8 хувиар өсчээ. Мөн 31-40 насны хүмүүсийн 40.1 хувь нь, 41-50 насны хүмүүсийн 50.7 хувь нь, 51-60 насны хүмүүсийн 44.7 хувь нь, 61-70 насны хүмүүсийн 32.6 хувь нь, 71 болон түүнээс дээш насны хүмүүсийн 43.8 хувь нь дээрх байдлаар тайлбарлажээ.

Харин сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгөөгүй гэж хариулсан хүмүүсийн 71.5 хувь нь хээл хахууль өгөх шаардлага гараагүй, 11.1 хувь нь хүмүүс бүгд өгч байсан ч би зарчмын хувьд хээл хахууль өгдөггүй, 5.2 хувь нь хээл хахууль өгөхөд дургүй хүрч байсан, 4.1 хувь нь хариулахад хүндрэлтэй, 3.1 хувь нь бусад шалтгаанаар, 2.3 хувь нь хээл хахуулийн дүн нь маш их байсан, 2.1 хувь нь хээл хахууль өгөхөө мэдэхгүй, 0.5 хувь нь хариуцлага хүлээн гэдгээс айсан гэж тус тус тайлбарласан байна.

Дээрх үзүүлэлтийг 2009 оныхтой харьцуулбал хээл хахууль өгөх шаардлага гараагүй гэсэн хүмүүсийн эзлэх хувь 0.4 хувиар, хээл хахууль өгөхөд дургүй хүрч байсан гэж тайлбарласан судалгаанд оролцогчдын эзлэх хувь 0.2 хувиар, хүмүүс бүгд өгч байсан ч би зарчмын хувьд хээл хахууль өгдөггүй гэсэн хүмүүсийн эзлэх хувь 1.2 хувиар, бусад шалтгаанаар гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь 0.4 хувиар тус тус өсчээ. Харин хариуцлага хүлээнэ гэдгээс айсан, хээл хахууль хэрхэн өгөхийг мэдэхгүй байсан, хариулахад хүндрэлтэй гэсэн хүмүүсийн эзлэх хувь -0.4-1.2 хувь хүртэл буурчээ.

Судалгаанд оролцогчид “Хамгийн сүүлд тантай хэзээ хээл хахуультай холбоотой асуудал тулгарсан бэ?” гэсэн асуултад 2009 онд тэдний 61.7 хувь нь тийм асуудал тулгарч байгаагүй гэсэн бол 2011 онд энэ үзүүлэлт 50.4 хувь болж буурсан байна. Судалгаанд оролцогчдын 11.7 хувь нь нэг сараас хагас жилийн дотор, 10.3 хувь нь нэг жилийн өмнө, 10.0 хувь нь хагас жилээс нэг жилийн дотор, 5.0 хувь нь долоо хоногоос нэг сарын дотор, 2.7 хувь нь долоо хоногийн өмнө хээл хахуультай холбоотой асуудал тулгарч байсан гэж хариулсан бол 10.0 хувь нь хариулахад хүндрэлтэй гэж үзсэн байна.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшин өссөн гэж судалгаанд оролцогчдын 33.7 хувь нь үзсэн бол 21.8 хувь нь өөрчлөгдөөгүй, 5.7 хувь нь буурсан гэж дүгнэжээ. Харин судалгаанд оролцогчдын 38.8 хувь нь авлигын түвшингийн өөрчлөлтийн талаар ямар нэг төсөөлөл байхгүй буюу мэдэхгүй гэж хариулжээ.

Ирэх хоёр жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөх талаар судалгаанд оролцогчдын төсөөлөл хүлээлтийг тодруулахад 24.8 хувь нь өснө, 21.8 хувь нь өөрчлөгдөхгүй, 13.3 хувь нь буурна, 40.1 хувь мэдэхгүй байна гэж хариулсан байна.

2.2. Авлигад хамгийн өртсөн байгууллагуудын талаарх олон нийт, шинжээчдийн асуулгад хийсэн дүн шинжилгээ

Судалгаанд оролцогчид өөрийн үнэлж буй салбар, аймаг, нийслэл дахь хамгийн их авлигад өртсөн байгууллагуудыг нэрлэснийг бүлэг тус бүрээр авч үзье /Судлагаанд

оролцогсодын хамгийн их гэж нэрэлсэн дарааллаар бичсэн болно/.

Шинжээчдийн төсөөлж буйгаар салбар тус бүрээр авлигад хамгийн их автсан байгууллагуудыг авч үзэхэд:

- Шадар сайдын эрхлэх асуудлын байгууллагуудад хамгийн их авлигад өртсөн байгууллагыг /санал асуулгын нийт дүнгийн дарааллаар/ МХЕГ, аймаг, нийслэл, сумдын салбар, ОБЕГ, УБЕГ-ыг
- Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд аймаг, сумдын ЗДТГ, Тендерийн хороо, комисс, гишүүд, ГХБХБГ-ыг
- Гадаад харилцааны яамны харьяа Консулын газар, тус яамны ТЗУГ, Хүний нөөц, ДБУААГ, Гадаад худалдааны агентлаг, Гадаадын хөрөнгө оруулалтын газрууд;
- Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Цагдаагийн ерөнхий газар түүний харьяа байгууллагууд, Хилийн цэргийн ангиуд, шалган нэвтрүүлэх ангиуд;
- Байгаль орчин аялал жуулчлалын яамны аялал жуулчлал хариуцсан газар, Богдхан уулын ТХГ-ын захиргаа;
- Батлан хамгаалах яамны, ЗХЖШ, түүний хүний нөөцийн хэлтэс, арын албан, Цэргийн штаб-1, Техник хэрэгслийн засвар үйлчилгээний нэгж;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Боловсрол соёлын газрууд, Төрийн өмчит их дээд сургуулиуд;
- Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамны Авто тээврийн газар, ИНЕГ, ЗТБХБЯ, Оношлогоо, хяналт зохицуулалтын алба, Төмөр зам, Барилгын асуудал эрхэлсэн хяналтын алба, Төрийн өмчит үйлдвэрийн,
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хөдөлмөр халамж үйлчилгээний газрууд;
- Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Газар тариалангийн газар, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Био комбинат, Мал аж ахуй хариуцсан салбар,
- ЭБЭХЯ-ны Эрчим хүчний газар, Ашигт малтмалын газар;
- Эрүүл мэндийн яамны Төрийн өмчит эмнэлгүүд, ЭМШУИС-ийг тус тус авлигад хамгийн их өртсөн гэж шинжээчид үзсэн байна.

Авлигад хамгийн их автсан байгууллагуудыг шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгч, иргэд орон нутгийн түвшинд дараах байдлаар нэрлэжээ.

Архангай аймаг

Шинжээч - Архангай аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, МХГ;

Төрийн албан хаагч - Эмнэлэг, Шүүх, Цагдаа, ЕБС, МХГ, ХХҮХ, Хууль хяналтын байгууллага;

Бизнес эрхлэгч - МХГ, Цагдаа, шүүх, Газрын алба;

Иргэд - МХГ, Цагдаа, Эмнэлэг, Шүүх, Прокурор, ГХБХБГ-ын албадыг авлигад хамгийн их өртсөн гэжээ.

Баян-Өлгий аймаг

Шинжээч - Баян-Өлгий аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Эмнэлэг, Сургууль;

Иргэд - МХГ, Цагдаагийн газар, Эмнэлэг, Шүүх, Прокурор;

Бизнес эрхлэгч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, МХГ, Эрүүл мэндийн газар, Прокурор, ХХҮХ, ЕБС;

Төрийн албан хаагч -Эмнэлэг, Шүүх, Цагдаа, Хууль хяналтын байгууллага, Сургууль, ЗДТГ, Газрын алба, Боловсролын салбар зэргийг авлигад хамгийн их өртсөн гэж дүгнэж байна.

Баянхонгор аймаг

Шинжээч - МХГ, ГХБХБГ, Аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар;

Иргэд - Цагдаагийн газар, Эмнэлэг, Аймаг, сумын ЗДТГ, МХГ, Шүүх, ГХБХБГ, Прокурор, ЕБС, Татварын газар;

Бизнес эрхлэгч - Аймгийн ЗДТГ, Цагдаа, Шүүх, Эмнэлэг, МХГ;

Төрийн албан хаагч - Эрүүл мэндийн газар, Цагдаа, Шүүх, Газрын алба, МХГ, Боловсролын газар, Сургууль, ЗДТГ, Хууль хяналтын байгууллагынхан гэсэн газруудыг авлигад ихээхэн өртсөн гэж үзжээ.

Булган аймаг

Шинжээч - Булган аймгийн Эмнэлэг, ГХБХБГ, Аймгийн ЗДТГ, Цагдаа, ХХҮХ, Зам тээврийн газрууд;

Иргэд - Эмнэлэг, Шүүх, Цагдаа, Прокурор, ГХБХБГазрууд;

Төрийн албан хаагч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, ХХҮХ, Хууль хяналтын байгууллага, ЗДТГ, МХГ, Нийгмийн даатгал, Газрын алба, Прокурор, боловсрол, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар, Бизнесийнхэн авлигад хамгийн их автсан гэсэн байна.

Говь-Алтай аймаг

Шинжээч - Говь-Алтай аймгийн ГХБХБГ, ЗДТГ, Эмнэлэг, Шүүх, Цагдаа, Шүүх, ЕБС, Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГазар, Прокурор, Боловсрол соёлын газруудыг;

Бизнес эрхлэгч - Цагдаа, Шүүх, Эмнэлэг, Прокурор, Төрийн албан хаагчид, Их дээд сургуулиуд, Төр захиргааны байгууллага, Нам;

Төрийн албан хаагч - Эрүүл мэндийг газар, Шүүх, Цагдаа, Хууль хяналтын байгууллага, ЗДТГ, ЕБС, Газрын алба, Боловсролын газар, Хил гааль, Цэцэрлэгүүдэд авлига түгээмэл гэжээ.

Дорноговь аймаг

Шинжээч - Дорноговь аймгийн Эмнэлэг, Цагдаа, ГХБХБГ, Гааль, Шүүх, МХГ;

Иргэд - Шүүх, Гааль, Цагдаа, Эмнэлэг, МХГ, ЗДТГ, ГХБХБГазар, Прокурор, Төмөр замын байгууллагууд;

Бизнес эрхлэгч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, МХГ, Гааль, Банк;

Төрийн албан хаагч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, Гааль, ЗДТГ, Прокурорын байгууллагуудыг авлигад хамгийн их өртсөн гэж үзсэн байна.

Дорнод аймаг

Шинжээч - Дорнод аймгийн засаг дарга, Гааль, Боловсрол соёлын газар, МХГ;

Иргэд - Цагдаа, Шүүх, Эмнэлэг, Эрүүл мэндийн газар, ГХБХБГ, Боловсрол соёлын газар, Бүрэн дунд сургууль, Прокурор, Аймаг, сумдын ЗДТГ, Гааль, МХГ, Тагнуулын байгууллага;

Төрийн албан хаагч - Эрүүл мэндийн газар, ШШГЕГ, Шүүх, Цагдаа, Хууль хяналтын байгууллага, МХГ, Боловсрол, Гааль, Газрын алба, Иргэний бүртгэл, ЗДТГ, Хувийн хэвшлийнхнийг тус тус авлигад хамгийн их автсан гэжээ.

Дундговь аймаг

Шинжээч - Дундговь аймгийн ЗДТГ, Цагдаа, Аймгийн ИТХ, МХГ;

Төрийн албан хаагч - Эрүүл мэндийн газар, Шүүх, Цагдаа, Прокурор, Засаг дарга нар, МХГ, Газрын алба, ЗДТГ, Хууль хяналтын байгууллага, ИТХ;

Бизнес эрхлэгч - Цагдаа, Шүүх, Цэцэрлэг, ЗДТГ;

Иргэд - Цагдаа, Шүүх, Аймаг, сумдын ЗДТГ, МХГ, Прокурор, Эмнэлэг, Боловсрол соёлын газар, Бүрэн дунд сургуулийг тус тус дурджээ.

Завхан аймаг

Шинжээч - Завхан аймгийн ГХБХБГ, Эмнэлэг, МХГ, Боловсрол соёлын газар, Цагдаагийн газар;

Төрийн албан хаагч - Эрүүл мэнд байгууллага, Шүүх, Цагдаа, ЕБС, Хууль хяналтын байгууллага, МХГ, ЗДТГ, Газрын алба, Цэцэрлэг, ХХҮХ, Төрийн алба, Прокурор;

Бизнес эрхлэгч - Цагдаа, Шүүх, Прокурор, Эмнэлэг, Байгаль орчны газрууд, ГХБХБГ, ЕБС;

Иргэд - Шүүх, Эмнэлэг, Цагдаа, ЕБС, Аймаг, сумдын ЗДТГ, Боловсрол соёлын газар, Прокурорыг хамгийн их авлигад автсан гэжээ.

Өвөрхангай аймаг

Шинжээч - Өвөрхангай аймгийн МХГ, ГХБХБГ, Цагдаа, Аймаг сумдын ЗДТГ;

Төрийн албан хаагч -Эмнэлэг /Бүсийн оношлогоо эмчилгээний төв орсон/, Шүүх, Цагдаа, Прокурор, Цэцэрлэг, Сургууль, МХГ, ЗДТГ, Газрын алба, Боловсролын газар, Тендер шалгаруулдаг комисс;

Бизнес эрхлэгч - ЗДТГ, Газрын алба, хот байгуулалтын газар, Цагдаа, Эмнэлэг, Шүүх;

Иргэд - Цагдаа, Шүүх, Эмнэлэг, Аймаг, сумдын ЗДТГ, Цэцэрлэг, МХГ, Бүрэн дунд сургууль, ГХБХБГ, Прокурорын газрыг авлигад хамгийн автсан гэж үзсэн байна.

Өмнөговь аймаг

Шинжээч - Өмнөговь аймгийн ГХБХБН, Цагдаа, МХГ, Прокурор, Гаалийн газар;

Төрийн албан хаагч -Эрүүл мэнд, Шүүх, Цагдаа, МХГ, Газрын алба, Төрийн албан хаагч, Сургууль, Гааль, Боловсрол, Татвар, Прокурор, Оюу Толгой;

Бизнес эрхлэгч - Цагдаа, мөрдөн байцаагчид, Эмнэлэг, Шүүх, Гааль, Прокурор, МХГ;

Иргэд - Эрүүл мэндийн газар, Эмнэлэг, Цагдаа, Шүүх, Аймаг, сумдын ЗДТГ, МХГ, ГХБХБГ-ыг авлигад хамгийн их өртсөн гэж дурджээ.

Сүхбаатар аймаг

Шинжээч - Сүхбаатар ГХБХБГ, Цагдаа, МХГ, Эрүүл мэндийн газар, Шүүх;

Төрийн албан хаагч - Цагдаа, Шүүх, Газрын алба, Эмнэлэг, ЗДТГ, Прокурор, Цэцэрлэг, Сургууль, Хууль хяналтын байгууллага, Боловсрол, ХААЖДҮГ;

Бизнес эрхлэгч - МХГ, Шүүх, Газрын алба, хот байгуулалтын газар, Цагдаа, ЗДТГ;

Иргэд - Цагдаа, Эмнэлэг, Шүүх, МХГ, ГХБХБГазар, Аймаг, сумдын ЗДТГ, Бүрэн дунд сургууль, Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийг авлигад хамгийн их автсан гэсэн байна.

Сэлэнгэ аймаг

Шинжээч - Сэлэнгэ аймгийн МХГ, Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар, Шүүх, Татвар, Гааль, Цагдаа, Боловсрол соёлын газар;

Төрийн албан хаагч -Цагдаа, Шүүх, Гааль, МХГ, Газрын алба, Улсын бүртгэлийн газар, Хууль хяналт, Татвар, Сургууль, Аймаг, сумын захиргаа, Байгал орчны газар, Цэцэрлэг, Прокурор, Боловсрол;

Иргэд - Эмнэлэг, Прокурор, Аймаг, сумдын ЗДТГ, МХГ, ГХБХБГ, Татвар, Гаалийн газрыг авлигад ихээхэн автсан гэжээ.

Төв аймаг

Шинжээч - Төв аймгийн ГХБХБГ, Цагдаагийн газар;

Төрийн албан хаагч - Шүүх, Газар, Эмнэлэг, Прокурор, ЗДТГ, Хуулийн байгууллагууд, Төсөл тендер хариуцсан;

Бизнес эрхлэгч - ГХБХБГ, Цагдаа, Шүүх, Прокурор, ЗДТГ, Эмнэлэг, Сургууль;

Иргэд - Цагдаа, Шүүх, Аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ, Эмнэлэг, Бүрэн дунд сургууль, МХГ зэрэг байгууллагууд авлигад өртсөн гэж үзсэн байна.

Увс аймаг

Шинжээч - Увс аймгийн ЗДТГ, МХГ, Газрын алба, Цагдаа, Шүүх, Прокурор, Гааль, Барилгын салбар;

Төрийн албан хаагч - Шүүх, Цагдаа, Прокурор, Эмнэлэг, Хууль хяналтын байгууллага, ЗДТГ, МХГ, Газар, Хил гааль, Боловсрол, Байгаль орчны газар, Банк;

Бизнес эрхлэгч - Цагдаа, ЗДТГ, Эмнэлэг, Прокурор, Шүүх, МХГ, ЕБС, Банк;

Иргэд - Шүүх, Цагдаа, Прокурор, Аймаг сумдын ЗДТГ, Эмнэлэг, МХГ, ГХБХБГ, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газар, Бүрэн дунд, сургууль, Хилийн шалган нэвтрүүлэх анги, Татварын байгууллагыг хамгийн их авлигад өртсөн гэж үзжээ.

Ховд аймаг

Шинжээч - Ховд аймгийн ЗДТГ, Боловсрол соёлын газар, Цагдаа, Шүүх, Прокурор, Газрын алба, Бүрэн дунд сургууль;

Төрийн албан хаагч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, ЗДТГ, Хууль хяналтын байгууллага, МХГ, Тендерийн хороо, Татвар, Газрын алба, Боловсрол соёлын газар, Хил гааль, ХХҮХ;

Бизнес эрхлэгч - Цагдаа, МХГ, Шүүх, Эмнэлэг, Прокурор, ЗДТГ, Газрын алба, хот байгуулалтын газар, Гааль;

Иргэд - Эрүүл мэндийн газар болон эмнэлэг, Шүүх, Цагдаа, Аймаг, сумдын ЗДТГ, МХГ, Бүрэн дунд сургуулиуд, Татвар, Боловсрол соёлын газар, Гааль, Хилийн шалган нэвтрүүлэх анги, ГХБХБГ-уудыг хамгийн их авлигад өртсөн гэж тодорхойлжээ.

Хөвсгөл аймаг

Шинжээч - Хөвсгөл аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Эрүүл мэндийн газар, ХХҮХ, МХГ, Хөгжлийн бодлогын хэлтэс, Төрийн сан, Цагдаагийн газар;

Төрийн албан хаагч - Эмнэлэг, Шүүх, Цагдаа, ЗДТГ, Хууль хяналтын байгууллага, Газар, МХГ, Боловсрол, Сургууль;

Бизнес эрхлэгч - Цагдаа, Шүүх, ЗДТГ, Эмнэлэг, Прокурор, Эрүүл мэндийн газар;

Иргэд - Эмнэлгүүд, Шүүх, МХГ, Прокурор, Цагдаа, Аймаг, сумдын ЗДТГ, Бүрэн дунд сургууль, Цэцэрлэгийг авлигад хамгийн их өртсөн салбарууд гэж үзэж байна.

Хэнтий аймаг

Шинжээч - Хэнтий аймгийн Цагдаа, Газрын алба, Шүүх, МХГ;

Төрийн албан хаагч - Шүүх, Эмнэлэг, Цагдаа, Прокурор, ЗДТГ, Газрын алба, Сургууль, ХХҮХ;

Бизнес эрхлэгч - Цагдаа, Газрын алба, хот байгуулалтын газар, Прокурор;

Иргэд - Цагдаа, Шүүх, Прокурор, ГХБХБГ Газар, Эмнэлэг, МХГ, Аймаг, сумдын ЗДТГ-ыг авлигалд хамгийн их өртсөн салбар гэжээ.

Дархан-Уул аймаг

Шинжээч - Дархан-Уул аймаг, сумдын засаг дарга, ЗДТГ, Газрын алба, Эмнэлэг, Цагдаа, Шүүх, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газар;

Төрийн албан хаагч - Эмнэлэг, Шүүх, Цагдаа, Хууль хяналтын байгууллага, Газрын алба, ЗДТГ, Тавар;

Бизнес эрхлэгч - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, Төрийн байгууллага, Прокурор, ЕБС, Газрын алба, хот байгуулалтын газар, МХГ, Цэцэрлэг, ЗДТГ;

Иргэд - Шүүх, Цагдаа, Эмнэлэг, Сургууль, ГХБХБГ, МХГ, Аймаг, сумдын ЗДТГ, Цэцэрлэг, Прокурор, Улсын бүртгэлийн газар, Татвар, Хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд /үүнээс Төмөрлөгийн үйлдвэр/, Гааль, Эрчим хүчний газрыг хамгийн их авлигад өртсөн гэсэн байна.

Улаанбаатар

Шинжээч - Улаанбаатар хотын Хүн эмнэлгүүд, МХЕГ түүний харьяа газар, хэлтэс албад, Газрын алба, Авто тээврийн газар, Цагдаагийн байгууллага, НХХЯ, ХХҮГазар, Нийслэлийн ЗДТГ, УБЕГ түүний харьяа газрууд, ЭМЯ, Хотын захирагчийн алба, ЭБЭХЯ-ны харьяа газрууд, Татварын ерөнхий газар, татварын хэлтэс, АМГ, ШШҮТ, Төрийн өмчийн болон бусад их дээд сургуулиуд, Сангийн яам, Ойн газрууд;

Төрийн албан хаагч - Газрын алба, Шүүх, Эмнэлэг, Эрүүл мэндийн салбар, Хууль хяналтын байгууллага, Цагдаа, Төрийн байгууллагууд, Прокурор, Цэцэрлэг, МХГ, УИХ, Татвар, Яамдууд, ШШГА, Хэвлэл мэдээллийн байгууллага, Хувийн байгууллага, Уул уурхай, Нам, Иргэний бүртгэл, Сургууль, Лиценз олголт, Их сургууль, Засгийн газар, Дүүрэг, хороодын засаг дарга, ЗДТГ, Нийгмийн даатгал, Гааль, Боловсролын газар, Ашигт малтмалын газар, АТГ, Халамж, Барилга, Тендер шалгаруулалтын хороо;

Бизнес эрхлэгч - Эмнэлэг, Цагдаа, Газрын алба, МХГ, Прокурор, Татварын ерөнхий газар, татварын байцаагчид, Цэцэрлэг, Төрийн байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар, ЕБС, ШШГЕГ, Эрүүл мэндийн газар, Дүүрэг хороод, Гааль, УИХ, Төрийн албан хаагчид, Засгийн газар, Лиценз, зөвшөөрөл өгдөг газар, Боловсролын газар, Эмч нар, Яам, агентлагууд, Их дээд сургууль;

Иргэд - Эрүүл мэндийн салбар, үүнээс Эмнэлгүүд, Эрүүл мэндийн газар, Шүүх, Боловсролын байгууллага, үүнээс БСШУЯ, Бүрэн дунд сургууль, Их дээд сургууль, Цэцэрлэг, Цагдаагийн байгууллага, үүнээс Замын цагдаагийн газар, Мөрдөн байцаах, Газрын алба, МХЕГ, МХБайгууллагууд, Төрийн байгууллагууд, Нийслэл, дүүргийн ЗДТГ, Улсын их хурал, Гаалийн байгууллага, Татварын байгууллага, Улс төрийн намууд, Засгийн газар, Яамдууд, Прокурор, Баг, хороод, Хувийн хэвшил, бизнес эрхлэгчид, ХХҮГазар, Уул уурхайн салбарын байгууллага аж ахуйн нэгж, АМГ-ыг авлигад хамгийн их өртсөн гэжээ.

Орхон аймаг

Шинжээч - Орхон аймгийн Сургууль, Боловсрол соёлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Газрын алба;

Төрийн албан хаагч - Эмнэлэг, Шүүх, ГОК, Цагдаа, Хууль хяналтын байгууллага, Прокурор, Мэргэжлийн хяналтын газар, ЗДТГ, Газрын алба, Боловсрол, Сургууль;

Бизнес эрхлэгч - Эрдэнэт үйлдвэр, Газрын алба, МХГ, ЕБС, Цагдаа, Прокурор, ЗДТГ, Эмнэлэг, Цэцэрлэг;

Иргэд - Сургууль, Эмнэлэг, Цагдаа, Шүүх, Эрдэнэт үйлдвэр, ГХБХБГ, Аймаг, сумын ЗДТГ, МХГ, Цэцэрлэг, Прокурорын газрыг авлигад хамгийн их өртсөн гэж үзсэн байна.

Говьсүмбэр аймаг

Шинжээч - Говьсүмбэр Аймаг сумдын ИТХ, ЗДТГ, Сургууль, Цагдаа, Шүүх, Прокурор, Газрын алба, Онцгой байдлын газар, ШШГГазар, МХГ, Төмөр зам, Эрүүл мэндийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газар;

Төрийн албан хаагч - Шүүх, Цагдаа, Эрүүл мэндийн газар, эмнэлэг, Боловсрол, Прокурор, Хууль хяналтын байгууллага, Төмөр зам, МХГ, Газрын алба, Цэцэрлэг, Сургууль;

Бизнес эрхлэгч - УБЕГ, Цэцэрлэг, Цагдаа;

Иргэд - Цагдаа, Эмнэлэг, Төмөр зам, МХГ, ГХБХБГазар, Сургууль, Цэцэрлэг, Шүүхийг тус тус авлигад хамгийн их өртсөн гэжээ.

БҮЛЭГ III. АВЛИГЫН ИЛРЭН ГАРЧ БУЙ ХЭЛБЭР

3.1. Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэст бүртгэгдсэн гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ

Авлигын индекс тооцох аргачлалд авлигын хэлбэрийн үзүүлэлт гэдэгт авлигын гэмт хэргийн зохион байгуулалттай байдал, авлигын гэмт хэргийн объект, давталт, ангилал, шунахай сэдэлт зэргийг Авлигатай тэмцэх газар шалгагдсан хэргүүдийн баримтын судалгаанд үндэслэн тооцдог.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс нь 2007 оны 08 сарын 09 ны өдрийн УИХ-аас өөрчлөн найруулсан “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2007 оны 09 дүгээр сарын 07- ны өдрөөс эхлэн Эрүүгийн хуулийн 263.1. /Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264.1. /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 266.1. /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 270.1. /Хээл хахууль зуучлах/, 273.1. /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, Эрүүгийн хуулийн 263.2./Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264.2. /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265. /Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266.2./Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 268. /Хээл хахууль авах/, 269. /Хээл хахууль өгөх/, 270.2. /Хээл хахууль зуучлах/, 273.2. /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар болж иргэд, байгууллагаас харьяаллын гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг хүлээн авч шалгасан байна.

Авлигатай тэмцэх газар 2011 онд ирсэн нийт гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 443 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Нийт 443 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 54 гомдол, мэдээлэл буюу 12.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 214 гомдол, мэдээлэл буюу 48.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, 164 гомдол, мэдээлэл буюу 37.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 3 гомдол, мэдээлэл буюу 1.0 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж шийдвэрлэсэн бөгөөд ажиллагаанд 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 98.2 хувьтай байна.


2011 онд хуульд заасан харьяаллын 142 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан, 57 /эрүүгийн хэргээс тусгаарлаж үүсгэсэн 3/ хэрэгт Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар эрүүгийн хэрэг үүсгэж, 37 хэргийг харьяаллын дагуу хүлээн авчээ. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 17 материалд прокуророос

эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Мөн хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3 эрүүгийн хэрэг, мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн 8 эрүүгийн хэргийг сэргээж шалгажээ. Шүүх, прокурорын шатнаас нийт 8 эрүүгийн хэрэг буцсан байна.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт зааснаар нь ангилбал:

- Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 41 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 29.0 хувь
- Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 18 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 13.0 хувь
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 7 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 5.0 хувь
- Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 6 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 4.0 хувь
- Хээл хахууль авах 33 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 22.0 хувь
- Хээл хахууль өгөх 5 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 4.0 хувь
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 4 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан гэмт хэргийн 3 хувийг
- Бусад 28 гэмт хэрэг буюу нийт шалгасан гэмт хэргийн 20.0 хувийг эзэлж байна.

Зураг 2: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан гэмт хэрэг



Нийт шалгасан эрүүгийн 142 гэмт хэргийг шийдвэрлэлтээр нь авч үзвэл:


- Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн эрүүгийн 43 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан эрүүгийн гэмт хэргийн 30.0 хувь
- Хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн эрүүгийн 35 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан эрүүгийн гэмт хэргийн 25.0 хувь
- Харьяаллын дагуу шилжүүлсэн эрүүгийн 27 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан эрүүгийн гэмт хэргийн 19 хувь
- Түдгэлзүүлсэн эрүүгийн 3 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан эрүүгийн гэмт хэргийн 2 хувь
- Бусад хэрэгт нэгтгэн шалгасан эрүүгийн 7 гэмт хэрэг буюу нийт шалгагдсан эрүүгийн хэргийн 5.0 хувь

- Нийт бүртгэгдэн шалгагдсан эрүүгийн гэмт хэргийн 19 хувь буюу эрүүгийн 25 гэмт хэргийг одоо үргэлжлүүлэн шалгаж холбогдох ажиллагааг хийж байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн хэргийн 35 хувь нь ил, 65 хувь нь далд аргаар үйлдэгдсэн байна. Эдгээр хэрэгт нийт 142 хүн сэжигтэн яллагдагчаар татагдсан бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн 6 буюу 4 хувийг, төрийн захиргааны 24 буюу 17 хувийг, төрийн тусгай 9 буюу 6 хувийг, төрийн үйлчилгээний 45 буюу 32 хувийг, энгийн буюу аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан 57 буюу 40 хувийг, гадаадын иргэн 1 буюу 1 хувийг тус тус эзэлж байна.

Шалгасан эрүүгийн 142 гэмт хэрэгт нийт 313 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл:

Зураг 3: Сэжигтэн, яллагдагч (албан тушаалын ангилалаар)



- Төрийн улс төрийн албан хаагч 24 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 8.0 хувийг,
- Төрийн захиргааны албан хаагч 68 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 22.0 хувийг,
- Төрийн тусгай албан хаагч 25 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 8.0 хувийг,
- Төрийн үйлчилгээний албан хаагч 66 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 21.0 хувийг эзэлсэн байна.
- Харин аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 127 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 40 хувийг,
- Гадаадын иргэн 3 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдийн 1.0 хувийг тус тус эзэлжээ.

Мөрдөн шалгасан эрүүгийн гэмт хэргийн улмаас нийт 22.739.976.825 төгрөгийн хохирол учирсан байх бөгөөд 1.117.575.433 төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын явцад барагдуулж, 3.018.145.280 төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн ажилласан байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн хэргээс: 52 шүүгдэгчид холбогдох 21 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн ба үүнээс 40 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ял шийтгэж, 2 хэргийн 3 шүүгдэгчийг гэмт хэрэг

үйлдсэн гэм буруутайд тооцож 2009 оны “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар ялаас өршөөн хэлтрүүлсэн. 18 шүүгдэгчийг хорих ялаар, 10 шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг тэнсэж, 9 шүүгдэгчийг торгох ял тус тус оногдуулсан байна.

Хүснэгт 39. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт (2011 оны байдлаар)

Үзүүлэлт		Гүйцэтгэл	Хувь
Тайлант хугацаанд хүлээж авсан	Хэрэг бүртгэлтийн	2	100%
	Мөрдөн байцаалтын	140	
Үүнээс:	Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн	43	30%
	Хэрэгсэхгүй болгосон	35	25%
	Харъяаллын дагуу шилжүүлсэн	27	19%
	Түдгэлзсэн	3	2%
	Нэгтгэсэн	7	5%
Тайлант хугацааны үлдэгдэл		27	19%
Холбогдож шалгагдсан албан тушаалтан		313	100%
Төрийн албаны ангиллаар авч үзвэл	Улс төрийн	24	8%
	Төрийн захиргааны	68	22%
	Төрийн үйлчилгээний	66	21%
	Төрийн тусгай	25	8%
	Аж ахуйн нэгж байгууллагын	127	40%
	Гадаадын иргэн	3	1%
Нийт гэмт хэрэг		142	100%
Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт заасан үйлдлээр нь ангилвал	Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	41	29%
	Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх	18	13%
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах	7	5%
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх	6	4%
	Хээл хахууль авах	33	22%
	Хээл хахууль өгөх	5	4%
	Хээл хахуульд зуучлах		
Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	4	3%	
Бусад гэмт хэрэг		28	20%

3.2. Авлига, албан тушаалтын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл:

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс нь 2011 онд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс /цаашид хуулийн этгээд гэх/ гэмт хэргийн шинжтэй 443 /өнгөрсөн оны 27/ гомдол, мэдээлэл хүлээн авч, бүртгэн шалгасан байна.

Эдгээр гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь ангилвал бичгээр 179, утсаар 38, шуудангаар 92, интернетээр 7, биечлэн 86, факсаар 14 гомдол, мэдээлэл иржээ.

Дээрх хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн

байдлаар нь авч үзвэл:

- 54 гомдол, мэдээлэлд буюу нийт хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 12.0 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан
- 214 гомдол, мэдээлэл буюу хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 48.0 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан
- 164 гомдол, мэдээлэл буюу хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 37.0 хувийг шалгаж харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлсэн.
- 3 гомдол, мэдээллийг буюу хүлээн авч шалгасан гомдол мэдээллийн 1.0 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгасан
- 8 гомдол, мэдээллийг буюу хүлээн авсан гомдол мэдээллийн 2 хувийг одоо үргэлжлүүлэн шалгаж холбогдох ажиллагааг хийж байна.

Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэлд 1172 хүн холбогдон шалгагдсаныг төрийн албаны ангиллаар ангилан авч үзвэл:

- Төрийн улс төрийн албан хаагч 166 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 14 хувийг,
- Төрийн захиргааны албан хаагч 312 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 27 хувийг,
- Төрийн тусгай албан хаагч 233 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 20 хувийг,
- Төрийн үйлчилгээний албан хаагч 274 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 23 хувийг эзэлсэн байна.
- Харин аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 176 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 15 хувийг,
- Гадаадын иргэн 11 хүн буюу нийт шалгагдсан холбогдогчдын 1 хувийг тус тус эзэлжээ.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, салбараар авч үзвэл:

- Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 82 гомдол мэдээллийн
- 64 гомдол, мэдээлэл нь Засаг даргын үйл ажиллагаанд
- 18 гомдол, мэдээлэл нь Иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд
- Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 91 гомдол мэдээлэл байгаагийн
- 14 гомдол, мэдээлэл нь цагдаа, цагдаагийн байгууллагад
- 5 гомдол, мэдээлэл нь прокурор, прокурорын байгууллагад
- 10 гомдол, мэдээлэл нь шүүгч, шүүхийн байгууллагад
- 2 гомдол, мэдээлэл нь хил хамгаалах байгууллагад
- 9 гомдол, мэдээлэл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад
- 14 гомдол, мэдээлэл нь мэргэжлийн хяналтын байгууллагад
- 9 гомдол, мэдээлэл нь татварын байгууллагад
- 25 гомдол, мэдээлэл нь гаалийн улсын байцаагч, гаалийн байгууллагад
- 3 гомдол, мэдээлэл нь аудитын байгууллагад
- Боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний салбарт хамаарах 65 гомдол мэдээллийн
- 37 гомдол, мэдээлэл нь боловсролын байгууллагад
- 12 гомдол, мэдээлэл нь эрүүл мэндний байгууллагад
- 6 гомдол, мэдээлэл нь хөдөлмөр халамж үйлчилгээний байгууллагад
- 10 гомдол, мэдээлэл нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт
- Төрийн захиргааны төв байгууллага /яам/-д хамаарах 17 гомдол мэдээлэл

- Газар, ашигт малтмалын салбарт хамаарах 23 гомдол мэдээлэл
- Банк санхүүгийн байгууллагад хамаарах 11 гомдол мэдээлэл
- Төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах 24 гомдол мэдээлэл
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах /хувийн хэвшил/ 17 гомдол мэдээлэл
- УИХ-ын гишүүний үйл ажиллагаа, сайдад хамаарах 7 гомдол мэдээлэл
- Иргэний инсэхийн үйл ажиллагаанд хамаарах 5 гомдол мэдээлэл
- Авто тээврийн газрын үйл ажиллагаанд хамаарах 10 гомдол мэдээлэл
- Бусад байгууллага, албан тушаалтанд холбогдох гомдол, мэдээлэл 85 байна.

Гэмт хэргийн шинжгүй авлига, хүнд суртал, төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой гомдол, мэдээлэл:

Авлигатай тэмцэх газартиргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллүүдээс эрүүгийн хэрэг үүсэх үндэслэлгүй, төрийн албаны хүнд суртал, чирэгдэл, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай, ил тод байдал зэрэгтэй холбоотой асуудлыг тус газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс шалгаж шийдвэрлэдэг. Тус хэлтэс эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй, төрийн албаны хүнд сурталтай холбоотой нийт 375 гомдол, мэдээллийг 2010-2011 онд шалгасан байна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн 29 нь буюу 7.7 хувь нь үйл ажиллагаандаа мөрддөг тодорхой дүрэм, журам, тушаал зэргийг зөрчсөн нь тогтоогдож, 33 буюу 8.8 хувийг нь тухайн байгууллага тус бүрд нь шилжүүлсэн ба 313 нь буюу 83.5 хувь нь тус байгууллагын харьяалалд хамааралгүй мэдээлэл байна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг холбогдох байгууллага, салбараар авч үзвэл:

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 46 гомдол мэдээллийн

- 14 нь Засаг даргын үйл ажиллагаанд
- 32 нь Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд

Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 61 гомдол мэдээлэл байгаагийн

- 14 нь цагдаа, цагдаагийн байгууллагад
- 21 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад
- 7 нь шүүгч, шүүхийн байгууллагад
- 2 нь тагнуулын байгууллагад
- 5 нь мэргэжлийн хяналтын байгууллагад
- 6 нь татварын байгууллагад
- 6 нь гаалийн улсын байцаагч, гаалийн байгууллагад

Боловсрол, эрүүл мэнд болон төрийн үйлчилгээний салбарт хамаарах 142 гомдол мэдээллийн

- 26 нь боловсролын байгууллагад
- 17 нь эрүүл мэндийн байгууллагад
- 14 нь нийгмийн халамжийн байгууллагад
- 15 нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт
- 70 нь газрын албанд холбогдох гомдол, мэдээлэл байна.

Байгууллагын удирдлагуудтай холбоотой авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр:

- Хууль бусаар зөвшөөрөл олгож хээл, хахууль авах, эрх мэдлээ хэтрүүлэх,

- урвуулах
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчих
- Ажилд авахдаа хээл, хахууль авах
- Тендер сонгон шалгаруулах явцад эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулж хууль бус шаардлага, үүрэг даалгавар өгөх
- Тендер шалгаруулалтгүйгээр үйл ажиллагаа явуулах
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- Эрх мэдлээ ашиглан хуурамч шийдвэр гаргах
- Байгууллагын өмчийг бусдад хямд үнээр зарах, зах зээлийн үнээс өндөр үнээр эд зүйл авах
- Онцгой албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас зайлсхийх
- Бэлэн мөнгөнд тавих хяналт сул, санхүүгийн анхан шатны баримтыг цаг хугацаанд нь санаатайгаар бүрдүүлэхгүй байх
- Тогтоосон дүрэм, журмаа сахин биелүүлэхгүй хайнга хандах

Зөвшөөрөл олгох үйл явц дахь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Зөвшөөрөл олгохдоо хахууль, шан харамж авах
- Хууль бус зөвшөөрөл олгох
- Танил талдаа хууль бусаар зөвшөөрөл олгох
- Зохих зөвшөөрөлгүй эд зүйл борлуулах, худалдан авах
- Холбогдох хууль, дүрэм, норм стандартуудыг зөрчих

Бараа бүтээгдэхүүн худалдан авах сонгон шалгаруулах үйл явц дахь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Тендер шалгаруулалтгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг явуулах
- Нээлттэй тендер зарлалгүй бараа материал худалдан авах
- ТБОНӨХБАҮХАТХ-н холбогдох заалтыг зөрчих
- Тендерийг санаатайгаар будилаантуулах
- Тендерийг хууль бусаар явуулах
- Тендерийн үнийн саналыг урьдчилан боловсруулахдаа зохиомлоор өсгөн бодит бус үнэ тогтоох
- Засвар, үйлчилгээ хийлгэх явцад илүү зардал төлөвлөн завших
- Хуурамч бичиг баримт үйлдэх
- Хууль бус дүгнэлт, сонгон шалгаруулалт гаргах, хийх
- Танил талаасаа бараа бүтээгдэхүүн зах зээлийн үнээс өндөр үнээр авах
- Танил талдаа төрийн өмчийг зах зээлийн үнээс хямд үнээр зарах
- Бичиг баримт хуурамчаар үйлдэж эд зүйл хувьдаа завших

Албан хаагчдын үйл ажиллагааны явц дахь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Үндэслэлгүй нэмэлт төлбөр, хураамж нэхэж хахууль, шан харамж авах
- Хууль бус шаардлага тавьж бэлэн мөнгө авах
- Хууль бус үйлдэл хийхээр амлаж хээл хахууль авах
- Хууль бус үйл ажиллагааг нуун дарагдуулахаар хахууль авах
- Хясан боогдуулж шан харамж, хээл хахууль авах
- Хууль бусаар хандив авах
- Хуурамч бичиг баримт үйлдэн мөнгө ашиглах

- Эрх мэдлээ ашиглан хууль бус үйл ажиллагаа хийх
- Хурааж авсан эд зүйлийг зарж хувьдаа ашиглах
- Тусламжийн бараа бүтээгдэхүүнийг хувьдаа ашиглах
- Эрх мэдлээ хэтрүүлэн бусдад баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох
- Тендерт ялахад тусалж хахууль авах
- Хууль бусаар зөвшөөрөл олгох
- Хууль бус үйлдлийг нуун дарагдуулж хахууль, шан харамж авах
- Хөрөнгө мөнгийг зарцуулах, хэрэглэх журам зөрчих
- Татвар ноогдуулах, татвар ноогдуулах явцад хяналт тавих

Хууль, хяналтын байгууллага дахь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Үндэслэлгүйгээр иргэний болон эрүүгийн хэрэг, маргааныг хэрэгсэхгүй болгож хахууль авах
- Хахууль авч хэргийг цагаатгах
- Хуурамч нотлох баримт бүрдүүлж хэргийг хэрэгсэхгүй болгох
- Хуульд зааснаас гадуур өөрийн үзэмжээр татвар, хураамж тогтоох
- Хориглосон буюу хязгаарласан эд зүйлийг хахууль авч хил нэвтрүүлэх
- Татварыг бууруулж өгөхөөр амалж хахууль авах
- Татваргүй эд зүйл хилээр нэвтрүүлэх
- Хураагдсан эд зүйлийг ашиглах
- Хууль зөрчсөн этгээдээс хахууль авч өнгөрөөх
- Автомашины улсын дугаар олгохдоо хээл хахууль, шан харамж авах

Байгууллагын дотоод үйл ажиллагаан дахь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- Байгууллагын дотоод ажил шалгах явцад зөрчлийг нуун дарагдуулж хахууль авах
- Журам зөрчин байгууллагын хөрөнгийг хувьдаа завших
- Байгууллагын өрөнд хураагдсан бараа материалыг хэрхэн борлуулах талаар тодорхой мөрддөг журам үгүй, зохицуулсан зохицуулалт байдаггүй
- Асуудлыг танил тал харж шийдвэрлэдэг
- Эрх мэдлээ ашиглан хуурамч бичиг баримт үйлдэн мөнгө завших
- Эрх мэдлээ ашиглан байгууллагаас мөнгө завших
- Албан тушаалаа ашиглан хуурамч бичиг баримт үйлдэх

Орон нутагт авлигын гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр

- Хахууль авч ажилд оруулах
- Ажилтан сонгон шалгаруулахдаа албан тушаалын эрх мэдлээ ашиглах
- Тендерийг будилуулах
- Тендер хууль бусаар зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх
- Танил тал, найз нөхөд, өөрийн хүнийг тендерт ялуулах
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулах
- Дутуу гүйцэтгэлтэй тендерийн явцад санхүүжилтийг гэрээг зөрчин олгох
- Хувийн компаний дансанд байгууллагын мөнгийг шилжүүлж ашиглах
- Хийгээгүй ажлыг хахууль авч хүлээж авах
- Хууль бусаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хахууль авах
- Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг хувьдаа завших
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах

- Албан тушаалын байдлаа ашиглан хуурамч бичиг баримт үйлдэж хөрөнгө, мөнгө завших
- Танил талдаа илт давуу байдал олгох, хувийн сонирголоор хандах
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчих зэргээр илэрч байна.

3.3. Авлигын илрэн гарч буй хэлбэрийн талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн судалгааны дүн

Авлигын талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн 2011 оны судалгаанд 21 аймаг, нийслэлийн 351 шинжээч, 6009 иргэн, бизнес эрхлэгч, төрийн албан хаагчид хамрагдлаа.

Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа болон хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, хүнд суртал гаргах, ажилдаа хариуцлагагүй хандах, иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах зэрэг нөхцөл байдал нь авлигын илрэн гарч буй хэлбэрүүд бөгөөд судалгаанд оролцогчдоос тухайн аймаг, нийслэлийн түвшинд төрийн албаны үйл ажиллагаанд эдгээр нөхцөл байдал оршин байдаг гэдэгтэй санал нийлж буй эсэхийг нь судалгаагаар асууж тодруулсан юм.

Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэдэгтэй авлигын талаарх иргэдийн төсөөллийн судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.3 хувиар буурч, зарим талаараа санал нийлж байна гэж 33.9 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.4 хувиар нэмэгдсэн байна. 17 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 5.4 хувиар өссөн байна.

Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 50.2 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 4.3 хувиар буурсан бол 28.9 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.1 хувиар нэмэгдсэн байна. 13.4 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 5.4 хувиар нэмэгдсэн байна.

Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 45.4 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.3 хувиар, 30.1 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 4.1 хувиар тус тус буурсан байна. 14.5 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 5.8 хувиар нэмэгдсэн байна.

Төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргадаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 49.0 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 3.5 хувиар, 30.1 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.0 хувиар тус тус буурсан байна. 13.6 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 6.9 хувиар өссөн байна.

Төрийн албан хаагчид ажилдаа хариуцлагагүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 37.4 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулбал 0.5 хувиар, 40.1 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэсэн нь 2.0 хувиар тус тус буурсан байна. 14.0 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 6.7 хувиар өссөн байна.

Төрийн албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчтэй харилцааны соёлгүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 38.4 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 3.2 хувиар, 40.0 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.2 хувиар тус тус буурсан байна. 13.7 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 2009 оныхтой

харьцуулахад 5.9 хувиар нэмэгдсэн байна.

Авлигатай тэмцэх газарт шалгагдсан хэргүүдийн баримтын судалгаагаар төрийн байгууллагын төрөөс баталж өгсөн төсвийн хэмжээ, төсвийн зарцуулалттай холбоотой авлигын илрэн гарч буй хэлбэрүүдийг дээр дурдсан. Төрийн байгууллагын төсвийн хэмжээ, түүний зарцуулалттай холбоотой мэдээ, мэдээлэл иргэд, олон нийтэд ил тод байх нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд маш чухал. Нөгөө талаас төрийн байгууллагын жилийн төсвийн төлөвлөлт, төрөөс баталж өгсөн төсвийн хэмжээ, төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл ажилтан, албан хаагчдад нээлттэй байх нь дотоод хяналтыг хэрэгжүүлэх ач холбогдолтой юм. Тухайн байгууллагын жилийн төсвийн төлөвлөлт, төрөөс баталж өгсөн төсвийн хэмжээ, төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл судалгаанд оролцсон төрийн албан хаагчдад нээлттэй байдаг эсэхийг асууж тодруулахад судалгаанд оролцогчдын 25.2 хувь нь нээлттэй байдаггүй гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.4 хувиар буурсан, 19.9 хувь нь ихэнх тохиолдолд нээлттэй байдаг гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.5 хувиар өссөн байна. 22.8 хувь нь байнга нээлттэй байдаг гэж хариулсан нь өмнөх удаагийн судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.2 хувиар өссөн байна.

Төрийн байгууллагын жилийн төсвийн төлөвлөлт, төрөөс баталж өгсөн төсвийн хэмжээ, төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй байдлыг төрийн байгууллагын төрлөөр авч үзэхэд агентлагийн албан хаагчдын 27.3 хувь нь, төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 25.5 хувь нь, яамны албан хаагчдын 20.6 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын 20.5 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 2.2 хувь нь тухайн байгууллагын жилийн төсвийн төлөвлөлт, батлагдсан төсвийн хэмжээ, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан нь 2009 онтой харьцуулахад 0.8-5.1 хувиар буурсан байна.

Харин төрийн төв захиргааны байгууллага буюу яамны албан хаагчдын 20.6 хувь нь яамныхаа жилийн төсвийн төлөвлөлт, батлагдсан төсвийн хэмжээ, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 5.2 хувиар өссөн байгаа нь төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчим яамдад буурч байгаа нь ноцтой юм.

Харин Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын байгууллагын албан хаагчдын 31.5 хувь нь, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагын албан хаагчдын 31.0 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын албан хаагчдын 30.5 хувь нь байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. 2009 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын, Хууль зүй, дотоод хэргийн сайдын, Батлан хамгаалах сайдын, Эрүүл мэндийн сайдын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагын болон Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан албан хаагчдын хувь хэмжээ 1.2-24.1 хувиар буурсан байна. Харин Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын, Сангийн сайдын, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагын албан хаагчдын тухайн байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан хувь хэмжээ 2009 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.1-20.8 хувиар өссөн байна.

Дархан-Уул, Баян-Өлгий, Сүхбаатар, Орхон аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 30.0-36.8 хувь нь

төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан хь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Тухайн байгууллагын боловсон хүчний томилгоо, шагнал, урамшуулал, шийтгэл, аж ахуй, гадаад дотоодын сургалт гэх мэт удирдлагын шийдвэр албан хаагчдад нээлттэй байдаг эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 14.0 хувь нээлттэй байдаггүй гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 3.7 хувиар буурсан, 29.9 хувь нь зарим талаараа нээлттэй байдаг,

26.3 хувь нь ихэнх тохиолдолд нээлттэй байдаг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.2 пунктээр өссөн, 29.7 хувь нь байнга нээлттэй байдаг гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.4 пунктээр өссөн байна.

Тухайн байгууллагын удирдлагын шийдвэрийн нээлттэй байдлыг төрийн байгууллагын төрлөөр авч үзвэл агентлагийн албан хаагчдын 15.1 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын 14.4 хувь нь, төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 14.1 хувь нь, яамны албан хаагчдын 9.1 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 7.7 хувь нь тухайн байгууллагын удирдлагын шийдвэрийн талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 3.4-12.8 пунктээр буурсан байна.

Харин уг үзүүлэлтийг салбараар нь авч үзвэл Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 18.0 хувь нь, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын

17.5 хувь нь, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 16.9 хувь нь, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын

16.2 хувь нь, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 14.3 хувь нь байгууллагын удирдлагын шийдвэрийн талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллага, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллага, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын удирдлагын шийдвэрийн талаарх мэдээлэл тухайн байгууллагын албан хаагчдад 2.5-11.7 пунктээр нээлттэй болсон гэж судалгаанд оролцсон төрийн албан хаагчид үзсэн бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллага, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын удирдлагын шийдвэрийн талаарх мэдээлэл тухайн байгууллагын төрийн албан хаагчдад 8.7-11.7 пунктээр хаалттай байна гэж хариулсан байна.

Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 25.8-38.5 хувь нь удирдлагын шийдвэрийн талаарх мэдээллийг авдаггүй гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Удирдлагын шийдвэрийн талаарх мэдээлэл тухайн байгууллагын төрийн албан хаагчдад нээлттэй байх нь авлигын эрсдэлийг буруулахад ач холбогдолтой юм. Гэтэл дээр дурдсан гурван аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлагын шийдвэрийн талаарх мэдээлэл тухайн байгууллагын төрийн албан хаагчдад 10.0-28.0 пунктээр хаалттай болсон гэж судалгаанд оролцсон төрийн албан хаагчид үзсэн байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал хэрхэн нөлөөлдөг вэ гэсэн асуултад яамны албан хаагчдын 28.7 хувь нь, агентлагийн албан хаагчдын 23.6 хувь нь, төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 20.8 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 20.5 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 20.4

хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал байнга нөлөөлдөг гэж хариулжээ.

Төрийн яамд болон төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал байнга нөлөөлдөг гэж үзсэн төрийн албан хаагчдын хувийг 2009 оныхтой харьцуулахад 0.1-0.8 пунктээр өссөн бол агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал байнга нөлөөлдөг гэж үзсэн төрийн албан хаагчдын хувь хэмжээ 1.0-9.1 пунктээр буурсан байна.

Харин уг үзүүлэлтийг салбараар нь авч үзвэл Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын

37.5 хувь нь, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 33.8 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 27.1 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 26.4 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал байнга нөлөөлдөг гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Эдгээр нь 2009 оныхтой харьцуулахад 2.2-18.8 пунктээр өссөн байна.

Сүхбаатар, Дархан-Уул, Өмнөговь, Хэнтийн аймгуудын нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 29.3-42.0 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нөхцөл байдал байнга нөлөөлдөг гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт боловч өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 1.6-10.7 пунктээр буурсан байна. Харин Хэнтийн аймгийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 29.3 хувь нь улс төрийн нөхцөл байдал төрийн байгууллагын үйл ажиллагаанд байнга нөлөөлдөг гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.6 пунктээр өссөн байна.

Тухайн байгууллагын удирдлагаас өгсөн шагнал, урамшууллын хэдэн хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэсэн байдаг вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 5.7 хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд огт үндэслэдэггүй гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.9 пунктээр өссөн байна. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 17.5 хувь нь маш бага хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэдэг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 5.2 пунктээр буурсан байна. Тухайн байгууллагын удирдлагаас өгсөн шагнал, урамшууллын тал болон бараг ихэнх хувь нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэдэг гэж судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 26.2-36.2 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.9-3.6 пунктээр өссөн байна. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 14.2 хувь нь тухайн байгууллагын удирдлагаас өгсөн шагнал, урамшуулал бүгд ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэдэг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.2 пунктээр буурсан байна.

Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 13.6 хувь нь удирдлагаас өгсөн шагнал, урамшуулал нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэдэггүй гэж хариулсан нь анхаарал татахуйц үзүүлэлт болж байна. Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 33.0 хувь нь, Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 26.2 хувь нь, Дундговь аймгийн төрийн албан хаагчдын 16.0 хувь нь, Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчдын 13.5 хувь нь удирдлагаас өгсөн шагнал, урамшууллын нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд огт үндэслэдэггүй гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Эдгээрийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 4.0-33.0 пунктээр нэмэгдсэн байна. Баян-Өлгий аймгийн нутгийн болон өөрөө удирдах байгууллагын удирдлагын өгсөн шагнал, урамшуулал нь ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үндэслэдэггүй гэсэн үзүүлэлт өнгөрсөн судалгааны үр дүнгээр ч

аймаг, нийслэлийн хувь хамгийн өндөр байсан нь анхаарал татаж байна.

Нийт төрийн байгууллагуудад улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдал байнга байдаг гэж судалгаанд оролцогчдын 27.1 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.2 пунктээр буурсан бол 50.0 хувь нь хааяа гэж хариулсан нь 2.0 пунктээр өссөн, 23.0 хувь нь огт байдаггүй гэж хариулсан нь 1.0 пунктээр өссөн байна. Хүнд суртал гаргах байдал байнга байдаг гэж 33.1 хувь нь хариулсан өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.8 пунктээр буурсан, 51.5 хувь нь хааяа хүнд суртал гаргадаг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнгээс 3.2 пунктээр өссөн, 15.4 хувь нь огт байдаггүй гэж хариулсан нь өмнөх 2009 оныхтой харьцуулахад 0.4 пунктээр буурсан байна. Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх явдал байнга байдаг гэж судалгаанд оролцогчдын 20.5 хувь нь хариулсан нь өмнөх судалгааны үр дүнгээс 4.0 пунктээр буурсан бол судалгаанд оролцогчдын 55.3 хувь нь хааяа хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 4.3 пунктээр өссөн байна. 24.1 хувь нь хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх байдал огт байдаггүй гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.3 пунктээр буурсан байна.

Ажилдаа хариуцлагагүй хандах байдал байнга байдаг гэж 16.4 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.6 пунктээр буурсан, хааяа байдаг гэж 67.2 хувь нь хариулсан нь 1.3 пунктээр өссөн, огт байдаггүй гэж 16.4 хувь нь хариулсан нь 0.8 пунктээр буурсан байна. Иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал байнга гаргадаг гэж 18.0 хувь нь хариулсан нь 0.7 пунктээр, хааяа байдаг гэж 64.2 хувь нь хариулсан нь 0.7 пунктээр буурсан бол огт байхгүй гэж 17.8 хувь нь үзсэн нь 1.3 пунктээр өссөн байна. Ах, дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх явдал байнга байдаг гэж судалгаанд оролцогчдын 32.9 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.3 пунктээр өссөн, хааяа байдаг гэж 50.6 хувь нь, огт байдаггүй гэж 16.5 хувь нь хариулсан нь 0.4 пунктээр буурсан байна. Албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх байдал байнга байдаг гэж 14.7 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.8 пунктээр, хааяа байдаг гэж 68.2 хувь нь хариулсан нь 0.2 пунктээр буурч харин огт байдаггүй гэж 17.1 хувь нь хариулсан нь 1.0 пунктээр өссөн байна.

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 4.9 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдал байнга байдаг гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 1.0 пунктээр буурсан байна. 37.3 хувь нь хааяа уг байдал илэрдэг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнгээс 2.2 пунктээр өссөн байна. Харин 57.8 хувь нь огт байдаггүй гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгээс 1.2 пунктээр буурсан байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 20.5 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдал байнга гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад

13.2 пунктээр өссөн байна. Харин нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 7.6 хувь нь, агентлагийн албан хаагчдын 7.2 хувь нь, яамны албан хаагчдын 5.8 хувь нь, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 4.6 хувь нь тухайн байгууллагад улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдаг байнга байдаг гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.7-11.2 пунктээр буурсан байна. Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах байдал байнга тохиолддог гэж Зам тээвэр, барилга хот байгуулалтын болон Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 11.6-12.7 хувь нь үзсэн нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.

Судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 5.7 хувь нь тухайн байгууллагын

үйл ажиллагаанд хүнд суртал гаргах байдал байнга байдаг гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.9 пунктээр буурсан байна. 46.6 хувь нь уг байдал хааяа байдаг гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнгээс 4.2 пунктээр өссөн байна. 47.7 хувь нь уг байдаг огт байдаггүй гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 3.3 пунктээр буурсан байна. Төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 6.0 хувь нь, агентлагийн болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 3.1 хувь нь, яамны албан хаагчдын 2.5 хувь нь тухайн байгууллагад хүнд суртал гаргах байдал байнга тохиолддог гэж хариулсан байна. Энэ нь 0.9-6.9 пунктээр өмнөх судалгааны үр дүнгээс буурсан байна. Хүнд суртал гаргах байдал байнга тохиолддог гэж Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 10.7 хувь нь, Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 10.5 хувь нь, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 8.7 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 7.4 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 2.4-4.5 пунктээр нэмэгдсэн байна.

Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 3.8 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд хээл хахуулиар асуудалд хандах байдал байнга байдаг гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.2 пунктээр буурсан байна. 29.5 хувь нь хааяа энэ асуудал илэрдэг гэсэн нь 0.9 пунктээр өссөн, 66.7 хувь нь огт байдаггүй гэж үзсэн нь 0.7 пунктээр буурсан байна. Төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 4.0 хувь нь, яамны албан хаагчдын 1.9 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 1.7 хувь нь, агентлагийн албан хаагчдын 1.0 хувь нь тухайн байгууллагад хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх байдаг байнга тохиолддог гэж хариулсан нь 0.9-6.6 пунктээр буурсан байна. Харин төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын хувьд 0.1 пунктээр өссөн байна. Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх байдал байнга тохиолддог гэж Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 9.7 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 6.5 хувь нь, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 6.2 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 0.5-8.4 пунктээр өссөн байна.

Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 4.5 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд ажилдаа хариуцлагагүй хандах байдал байнга байдаг гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.9 пунктээр өссөн бол 54.9 хувь нь хааяа уг байдал илэрдэг гэсэн нь 2.0 пунктээр буурсан, 40.6 хувь нь огт байдаггүй гэж үзсэн байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 1.1 пунктээр өссөн байна. Төрийн захиргааны төв байгууллага буюу яамны албан хаагчдын 8.5 хувь нь, агентлагийн албан хаагчдын 7.9 хувь нь, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 4.4 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 4.0 хувь нь тухайн байгууллагад ажилдаа хариуцлагагүй хандах байдал байнга тохиолддог гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.4-3.4 пунктээр өссөн байна. Ажилдаа хариуцлагагүй хандах байдал байнга тохиолддог гэж Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 13.7 хувь нь, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 12.5 хувь нь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн албан хаагчдын 10.1 хувь нь хариулсан

нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 6.1-9.6 пунктээр өссөн байна.

Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 4.2 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал байнга тохиолддог гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.5 пунктээр өссөн бол 47.9 хувь нь хааяа уг байдал илэрдэг гэж хариулсан нь 2.3 пунктээр буурсан байна. Харин 47.9 хувь нь огт байдаггүй гэж үзсэн нь 1.8 пунктээр өссөн байна. Төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 4.3 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 3.3 хувь нь, агентлагийн албан хаагчдын 3.2 хувь нь, яамны албан хаагчдын 2.7 хувь нь тухайн байгууллагад иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал байнга тохиолддог гэж хариулсан нь 0.4-2.3 пунктээр өссөн бол нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 2.1 хувь нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал байнга тохиолддог гэж үзсэн нь 1.7 пунктээр буурсан байна. Иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал байнга тохиолддог гэж Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 20.1 хувь нь, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 10.9 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 8.4 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 7.9 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдын 9.3 хувь нь тухайн байгууллагад ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх байдал байнга тохиолддог гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.9 пунктээр, хааяа уг байдал илэрдэг гэж 43.8 хувь нь хариулсан нь 1.4 пунктээр өссөн байна. Харин 46.9 хувь нь огт байдаггүй гэж үзсэн нь 2.3 пунктээр буурсан байна. Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 6.4 хувь нь, агентлагын албан хаагчдын 6.2 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 5.4 хувь нь, яамны албан хаагчдын 4.7 хувь нь тухайн байгууллагад ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх байдал байнга тохиолддог гэж үзсэн нь 1.5-5.3 пунктээр буурсан байна.

Төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 9.6 хувь нь уг байдал байнга илэрдэг гэж хариулсан нь 0.9 пунктээр өссөн байна. Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх байдал байнга тохиолддог гэж Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 15.1 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 12.8 хувь нь, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 12.1 хувь нь, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 11.2 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 3.5-4.2 пунктээр өссөн байна. Харин Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 11.2 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт боловч өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 23.1 пунктээр буурсан боловч Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын болон Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын хувьд ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх байдлын үзүүлэлтээр бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт давтагдаж байгаа нь анхаарал татаж байна.

Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаанд оролцсон

төрийн албан хаагчдын 4.5 хувь нь тухайн байгууллагын албан хаагчид мэдлэг чадвар дутмаг байх байдал байнга тохиолддог гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.6 пунктээр, 55.7 хувь нь хааяа уг байдал илэрдэг гэж үзсэн нь 3.4 пунктээр буурсан бол 39.9 хувь нь огт байдаггүй гэж хариулсан нь 3.9 пунктээр өссөн байна. Төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 4.4 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 4.2 хувь нь, яамны албан хаагчдын 3.2 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 2.2 хувь нь тухайн байгууллагын албан хаагчид мэдлэг чадвар дутмаг байх байдал байнга тохиолддог гэж хариулсан нь 0.2-5.5 пунктээр буурсан байна. Харин Төрийн захиргааны байгууллага буюу агентлагийн албан хаагчдын 8.2 хувь нь уг байдлыг байнга илэрдэг гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 3.0 пунктээр өссөн байна. Тухайн байгууллагын албан хаагчид мэдлэг чадвар дутмаг байх байдал байнга тохиолддог гэж Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 9.2 хувь нь, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 8.8 хувь нь, Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 7.5 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад тухайн байгууллагын албан хаагчид мэдлэг чадвар дутмаг байх байдал байнга тохиолддог гэсэн үзүүлэлт Шадар сайдын эрхлэх асуудлын болон Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын хувьд өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад улс төрийн нөлөөнд автаж асуудалд хандах байдал байнга тохиолддог гэж Увс аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 25.3 хувь нь, Баян-Өлгий аймгийн албан хаагчдын 19.1 хувь нь, Завхан аймгийн албан хаагчдын 16.4 хувь нь үзжээ. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 4.7-15.3 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хүнд суртал гаргах байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад байнга тохиолддог гэж Увс аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 9.3 хувь нь, Говь-Алтай аймгийн албан хаагчдын 8.3 хувь нь, Дундговь аймгийн албан хаагчдын 7.9 хувь нь үзсэн нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 4.0-4.6 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад байнга тохиолддог гэж Өвөрхангай аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 9.8 хувь нь, Дорноговь аймгийн төрийн албан хаагчдын 5.1 хувь нь, Дундговь аймгийн албан хаагчдын 4.1 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.1-5.6 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ажилдаа хариуцлагагүй хандах байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад байнга тохиолддог гэж Баян-Өлгий аймгийн албан хаагчдын 14.7 хувь нь, Увс аймгийн албан хаагчдын 9.3 хувь нь, Дорноговь аймгийн албан хаагчдын 9.1 хувь нь, Сэлэнгэ аймгийн албан хаагчдын 8.2 хувь нь хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 4.0-6.0 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэд үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад Баян-Өлгий аймгийн албан хаагчдын 9.2 хувь нь, Өвөрхангай аймгийн албан хаагчдын 6.9 хувь нь, Увс аймгийн албан хаагчдын 6.0 хувь нь байнга тохиолддог

гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.5-4.4 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэх байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад Баян-Өлгий аймгийн албан хаагчдын 28.4 хувь нь, Дорноговь аймгийн албан хаагчдын 19.2 хувь нь, Ховд аймгийн албан хаагчдын 14.9 хувь нь, Увс аймгийн албан хаагчдын 12.7 хувь нь байнга тохиолддог гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 4.6-6.5 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад албан хаагчид нь мэдлэг чадвар дутмаг байх байдал хэр олон тохиолддог вэ гэсэн асуултад Булган аймгийн төрийн албан хаагчдын 16.8 хувь нь, Баян-Өлгий аймгийн албан хаагчдын 9.2 хувь нь, Дорноговь аймгийн албан хаагчдын 8.8 хувь нь, Увс аймгийн албан хаагчдын 8.3 хувь нь байнга тохиолддог гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 3.8-16.8 пунктээр өссөн байна. Харин Баян-Өлгий аймгийн хувьд 5.2 пунктээр буурсан байна.

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 22.5 хувийг нь ажил үүргээ гүйцэтгэж байхад нь иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс хууль бус санал тавих тохиолдол гарч байсан бол 17.5 хувьд нь найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс, 16.4 хувьд нь дээд албан тушаалтны зүгээс, 13.9 хувьд нь бизнес эрхлэгчдийн зүгээс, 11.9 хувьд нь улс төрийн намын бүлгийн гишүүдийн зүгээс, 10.3 хувьд нь хамт ажиллагчдын зүгээс, 8.2 хувьд нь харилцагч байгууллагынхны зүгээс, 7.1 хувьд нь ах дүү, хамаатан садангийнх нь зүгээс хууль бус санал тавих нөхцөл тохиолдож байсан гэж хариулжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулбал төрийн албан хаагчдад ажил үүргээ гүйцэтгэж байхад нь иргэд, үйлчлүүлэгчид болон найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс хууль бус санал тавих тохиолдол 0.4-1.2 пунктээр нэмэгдсэн байна. Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын 28.0 хувьд нь, агентлаг болон тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 23.2-22.3 хувьд нь, яамны албан хаагчдын 17.3 хувьд нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын 13.5 хувьд нь иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс хууль бус санал тавих тохиолдолтой гарч байжээ.

Дээрх үзүүлэлтийг салбараар авч үзэхэд Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын хувьд голчлон иргэд, үйлчлүүлэгчид (43.1 хувь), дээд албан тушаалтан (25.9 хувь), найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс (25.7 хувь), харилцагч байгууллагынхны зүгээс (18.0 хувь), улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс (22.3 хувь) хууль бус санал тавьдаг байна. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын хувьд голчлон дээд албан тушаалтны зүгээс (32.7 хувь), иргэд, үйлчлүүлэгчид (26.6 хувь), найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс (10.6 хувь) хууль бус санал тавьдаг байна. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдад голчлон иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс (34.6 хувь), найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс (33.6 хувь), дээд албан тушаалтны зүгээс (22.5 хувь), хамт ажиллагчдын зүгээс (22.5 хувь), ах дүү, хамаатан садны зүгээс (21.1 хувь) хууль бус санал тавьдаг байна. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдад голчлон иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс (27.8 хувь), харилцагч байгууллагынхны зүгээс (19.0 хувь), дээд албан тушаалтын зүгээс (16.9 хувь) хууль бус санал тавьдаг байна.

Төрийн албан хаагчийг өөрийн хариуцсан ажил, үүргээ гүйцэтгэх явцад дарамт шахалт үзүүлэх явдал тохиолдож байсан эсэх асуултад төрийн захиргааны төв байгууллага буюу яамны албан хаагчдын 15.8 хувь нь, агентлагийн албан хаагчдын 15.1 хувь нь, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан

хаагчдын 22.2 хувь нь, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 20.4 хувь нь, нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 19.1 хувь нь дээд албан тушаалтны зүгээс дарамт шахалт үзүүлж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад яам, агентлагийн албан хаагчдын хувьд 1.6-1.8 пунктээр буурч, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчид болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын хувьд 0.3-1.4 пунктээр өссөн байна. Харин нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын албан хаагчдын хувьд 15.8-13.7 хувь нь улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс, нутгийн захиргааны байгууллагын болон төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн албан хаагчдын 17.4-16.6 хувь нь иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс дарамт шахалт үзүүлж байсан гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчид дээд албан тушаалтан, иргэд үйлчлүүлэгчид, улс төрийн нам, бүлгийн гишүүд, хамт ажиллагчдын зүгээс (11.2-15.6 хувь нь) дарамт шахалт үзүүлдэг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнгээс 1.82-4.9 пунктээр буурсан байна. Харин хамт ажиллагчдын зүгээс дарамт шахалт үзүүлэх байдал 5.0 пунктээр өссөн байна. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчид дээд албан тушаалтны зүгээс голчлон (16.1 хувь) дарамт шахалт үзүүлдэг гэж хариулсан нь өмнөх судалгааны үр дүнгээс 6.4 пунктээр буурсан байна. Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 29.8 хувь нь дээд албан тушаалтны зүгээс, 24.9 хувь нь иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс, 12.5 хувь нь хамт ажиллагчдын зүгээс голлон дарамт үзүүлэх явдал тохиолдож байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.4-3.2 пунктээр өссөн байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын төрийн албан хаагчдад дээд албан тушаалтны зүгээс (11.8 хувь нь) дарамт шахалт ирэх байдал тохиолддог гэсэн нь өмнөх судалгааны үр дүнгээс 4.6 пунктээр өссөн байна. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн албан хаагчдын 34.0 хувь нь дээд албан тушаалтны зүгээс, 12.3 хувь нь иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс, 10.9 хувь нь найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс дарамт шахалт тохиолддог гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.3-24.9 пунктээр өссөн байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдад дээд албан тушаалтны зүгээс (19.6 хувь нь), иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс (12.6 хувь нь) дарамт шахалт тохиолддог гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 0.2-0.3 пунктээр буурсан байна.

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 31.6 хувь нь иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс, 27.1 хувь нь дээд албан тушаалтны зүгээс, 22.3 хувь нь улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс, 17.7 хувь найз нөхөд, танил хүмүүсээс голчлон дарамт шахалт үзүүлэх байдал тохиолддог гэсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 7.1-15.8 пунктээр өссөн байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдад голчлон иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс (9.7 хувь) дарамт шахалт үзүүлж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.4 пунктээр өссөн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын төрийн албан хаагчдын 26.8 хувь нь дээд албан тушаалтны зүгээс, 12.4 хувь нь хамт ажиллагчдын зүгээс, 12.3 хувь нь улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс дарамт шахалт үзүүлж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 7.2-13.4 пунктээр өссөн байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын

албан хаагчдад дээд албан тушаалтны зүгээс (30.2 хувь нь) дарамт шахалт үзүүлж байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.6 пунктээр буурч, харилцагч байгууллагынхны зүгээс (16.9 хувь нь) үзүүлэх дарамт шахалт 10.1 пунктээр өссөн байна. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагын албан хаагчдын 25.0 хувь нь иргэд, үйлчлүүлэгчдийн зүгээс, 24.2 хувь нь дээд шатны албан тушаалтны зүгээс, 11.1 хувь нь улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс дарамт шахалт үзүүлэх байдал тохиолдож байсан гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.1-4.0 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын төрийн албан хаагчдад иргэд үйлчлүүлэгчдийн зүгээс өөрийн хариуцсан ажил, үүргээ гүйцэтгэх явцад хууль бус санал тавьдаг гэж үзсэн төрийн албан хаагчдын эзлэх хувийг аймаг, нийслэлээр авч үзэхэд 15.4-43.1 хувьтай байна. Энэхүү хувь хэмжээ Орхон (43.1 хувь), Архангай (35.3 хувь), Дархан-Уул (33.5 хувь), Сэлэнгэ (33.3 хувь) аймгуудад харьцангуй өндөр байгааг 2009 оныхтой харьцуулахад Орхон, Сэлэнгэ аймгуудын хувьд 7.5-12.0 пунктээр өссөн, Архангай аймгийн хувьд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 16.3 пунктээр буурсан хэдий ч аймаг, нийслэлтэй харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт хэвээр байна. Төв (19.7 хувь), Ховд (17.3 хувь нь), Хөвсгөл (17.1 хувь нь), Сүхбаатар (15.4 хувь нь) аймгуудад харьцангуй доогуур үзүүлэлт байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 2.7-25.7 пунктээр буурсан байна.

Баян-Өлгий, Увс, Орхон аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 26.9-43.1 хувь нь дээд албан тушаалтнуудын зүгээс хууль бус санал тавьдаг гэж хариулсан нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 9.5-14.0 пунктээр өссөн байна.

Баянхонгор, Увс, Дархан-Уул, Орхон, Говь-Алтай аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 30.3-34.8 хувь нь найз нөхөд, танил хүмүүсийн зүгээс хууль бус санал тавьдаг гэж хариулсан нь бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Баянхонгор, Увс аймгуудын хувьд 2.0-7.6 пунктээр буурч харин Дархан-Уул, Орхон аймгуудын хувьд 13.5- 15.0 пунктээр өссөн байна.

Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын төрийн албан хаагчдад улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс хууль бус санал тавих байдлыг аймаг, нийслэлээр авч үзэхэд Баян-Өлгий, Увс аймгуудад уг байдал нэлээд түгээмэл буюу нийт судалгаанд оролцогчдын 34.7-38.2 хувь нь тэдний зүгээс хууль бус санал тавьж байсан гэж хариулжээ. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.3-5.3 пунктээр буурсан байна. Түүнчлэн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд улс төрийн нам, бүлгийн гишүүдийн зүгээс дарамт шахалт үзүүлдэг эсэх талаар тодруулахад Баян-Өлгий, Увс, Архангай, Дорнод аймгуудын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчдын 22.1-28.4 хувь нь тийм гэж хариулжээ. Үүнийг 2009 оныхтой харьцуулахад Увс, Дорнод аймгуудын хувьд 8.0-11.2 пунктээр өссөн, Баян-Өлгий аймгийн хувьд 10.0 пунктээр буурсан, Архангай аймгийн хувьд ямар ч өөрчлөлтгүй байна.

Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдээс улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд хандах, ах дүү, танил талаараа болон хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэх, хүнд суртал гаргах, ажилдаа хариуцлагагүй болон иргэд, үйлчлүүлэгчидтэй харилцааны соёлгүй хандах зэрэг авлигын хэлбэрийн талаар судалгаанд оролцогчдоос тухайн аймаг, нийслэлийн түвшинд төрийн албаны үйл ажиллагаанд дараах нөхцөл байдал оршин байдаг гэдэгтэй санал нийлж буй

эсэхийг нь судалгаагаар асууж тодруулсан юм.

Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 36.0 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 3.5 пунктээр буурсан бол 31.8 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж үзсэн нь 0.3 пунктээр, 17.4 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 9.1 пунктээр тус тус өссөн байна. Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Сүхбаатар (63.6 хувь), Завхан (56.3 хувь), Өвөрхангай (53.3 хувь) аймгуудад харьцангуй өндөр байгаа бол Архангай (23.1 хувь) аймагт харьцангуй доогуур байна. Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Сүхбаатар, Завхан, Өвөрхангай аймгуудад өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 13.6-20.5 пунктээр өссөн байна. Харин Архангай аймагт 19.8 пунктээр буурсан байна.

Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 47.3 хувь нь санал нийлж байна гэж хариулсан бол 32.5 хувь нь зарим талаараа санал нийлж байна, 13.0 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулбал ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлэхгүй байх байдал 1.59 пунктээр буурч, зарим талаараа санал нийлэх, эсвэл санал нийлэхгүй байх байдал 0.07-6.4 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Ах дүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Дундговь (72.7 хувь), Ховд (68.2 хувь), Увс (62.5 хувь), Баянхонгор (61.5 хувь) аймгуудад харьцангуй өндөр байгаа нь 2009 оныхтой харьцуулахад 19.6-39.4 пунктээр нэмэгдсэн байна. Баянхонгор аймгийн хувьд ах дүү танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн хувь хэмжээ 7.7 пунктээр буурсан байна. Харин Архангай (7.7 хувь) аймагт байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт болж байна. 2009 оныхтой харьцуулахад 42.3 пунктээр буурсан байна.

Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 38.0 хувь нь санал нийлж байна гэсэн нь 2009 оныхтой харьцуулахад 1.8 пунктээр өссөн байна. Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй зарим талаараа санал нийлнэ гэж судалгаанд оролцогчдын 35.1 хувь нь үзсэн нь өмнөх судалгааны үр дүнгээс 3.1 пунктээр буурсан байна. Харин санал нийлэхгүй гэж судалгаанд оролцогчдын 16.0 хувь нь хариулсан нь 7.9 пунктээр өссөн байна. Хээл хахуулиар асуудлын шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Баян-Өлгий (47.1 хувь), Өмнөговь (46.7 хувь), Дундговь, Сүхбаатар, Ховд (45.5 хувь тус бүр) байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт болж байна.

Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн хувь хэмжээг 2009 оныхтой харьцуулахад Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын хувьд 4.5-4.9 пунктээр буурсан бол Өмнөговь, Дундговь, Сүхбаатар аймгуудын хувьд 22.6-37.1 пунктээр өссөн байна. Харин Дорноговь, Архангай (7.7 хувь) аймгуудад харьцангуй доогуур үзүүлэлт болж байна. Хээл хахуулиар асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн хувь хэмжээг 2009 оныхтой харьцуулахад 23.1-42.3 пунктээр буурсан байна.

Төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргадаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 51.6 хувь нь санал нийлж байна гэж хариулсан бол энэ нь 2009 оныхтой харьцуулахад 4.7 пунктээр буурсан байна. Төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргадаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 30.5 хувь нь зарим талаараа нийлж байна гэж үзсэн нь 1.3 пунктээр мөн буурсан байна. Харин Төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргадаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 12.1 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 8.3 пунктээр өссөн байна. Тухайн аймаг,

нийслэлийн төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргах байдал байдаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Увс (81.3 хувь), Баянхонгор (76.9 хувь), Дундговь (72.7 хувь), Сүхбаатар (63.6 хувь) аймгуудад харьцангуй өндөр байна. Тухайн аймаг, нийслэлийн төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргах байдал байдаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувийг 2009 оныхтой харьцуулан үзвэл Сүхбаатар аймгаас бусад аймгуудад 7.7-23.8 пунктээр өссөн бол Сүхбаатар аймагт 3.0 пунктээр буурсан байна. Тухайн аймаг, нийслэлийн төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргах байдал байдаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Баян-Өлгий аймагт (11.8 хувь) байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт болж байна. Тус үзүүлэлт өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 48.2 пунктээр буурсан байна.

Төрийн албан хаагчид ажилдаа хариуцлагагүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 44.6 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.9 пунктээр өссөн байна. Төрийн албан хаагчид ажилдаа хариуцлагагүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 35.2 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 6.5 пунктээр буурсан байна харин санал нийлэхгүй байна гэж 12.2 хувь нь хариулсан нь 6.8 пунктээр мөн өссөн байна. Тухайн аймаг, нийслэлийн төрийн албан хаагчид ажилдаа хариуцлагагүй ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Увс (68.8 хувь), Сүхбаатар (63.6 хувь), Дундговь (54.5 хувь), Баянхонгор (53.8 хувь) аймгуудад харьцангуй өндөр байна. Эдгээр аймгийн төрийн албан хаагчид ажилдаа хариуцлагагүй ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувийг 2009 оныхтой харьцуулахад 12.5-21.2 пунктээр өссөн байна. Харин Завхан (17.6 хувь) аймагт харьцангуй доогуур байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 3.8 пунктээр буурсан байна.

Төрийн албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчидтэй харьцааны соёлгүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 41.0 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.7 пунктээр буурсан байна. Төрийн албан хаагчид харьцааны соёлгүй ханддаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 40.3 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.3 пунктээр буурсан байна харин санал нийлэхгүй байна гэж 12.4 хувь нь хариулсан нь 5.9 пунктээр мөн өссөн байна. Тухайн аймаг, нийслэлийн төрийн албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчидтэй харьцааны соёлгүй ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувь Баянхонгор (61.5 хувь), Дундговь (54.5 хувь), Өмнөговь (53.3 хувь) аймгуудад харьцангуй өндөр байна. Эдгээр аймгийн төрийн албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчидтэй харьцааны соёлгүй ханддаг гэдэгтэй санал нийлж буй хүмүүсийн эзлэх хувийг 2009 оныхтой харьцуулахад 12.9-20.0 пунктээр өссөн байна. Харин Архангай (15.4 хувь) аймагт харьцангуй доогуур байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 13.2 пунктээр буурсан байна.

Төрийн албан дахь авлигын илрэн гарч буй хэлбэрийн талаар шинжээчдийн судалгаанд оролцсон шинжээчдээс үнэлж буй салбарт удирдах албан тушаалтны томилгоо хийгээд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал хамгийн гол шалгуур болдоггүй гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 6.3 хувь болдог гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнгээс 2.4 пунктээр буурсан байна. Мөн 51.9 хувь нь зарим тохиолдолд шалгуур болох нь бий гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 15.0 пунктээр өссөн байна. Харин 41.9 хувь нь огтхон ч шалгуур болдоггүй гэсэн нь 2009 оныхтой харьцуулахад 10.0 пунктээр буурсан байна. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын удирдах албан

тушаалтны томилгоонд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал огт шалгуур болдоггүй гэж үзсэн шинжээчдийн хувь 50.0-57.1 байгаа нь анхаарал татаж байна.

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын болон Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагууд дахь удирдах албан тушаалтны томилгоо хийгээд мэргэшсэн, шударга зарчимч байдал хамгийн гол шалгуур болдоггүй гэж үзсэн тухайн салбарын шинжээчдийн хувь 3.3-7.1 пунктээр өссөн байна. Харин төрийн удирдах албан тушаалтны томилгоо хийгээд мэргэшсэн, шударга зарчимч байдал хамгийн гол шалгуур болдоггүй гэж үзсэн шинжээчдийн хувь хэмжээ дараах салбараар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын, Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудын хувьд 46.4-20.5 пунктээр буурсан байна.

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын удирдах албан тушаалтны томилгоо хийгээд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал шалгуур үзүүлэлт болж чаддаг эсэхийг аймгуудаар авч үзэхэд Хөвсгөл (100.0 хувь), Баян-Өлгий (87.5 хувь), Ховд (87.5 хувь), Дархан-Уул (75.0), Өмнөговь (75.0), Баянхонгор (75.0) аймагт уг байдал огтхон ч шалгуур болдоггүй гэж үнэлсэн байна. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 3.6-30.4 пунктээр өссөн байна. Харин Орхон, Архангай, Булган, Увс, Сүхбаатар аймагт уг байдал огтхон ч шалгуур болдоггүй гэж үзэж буй шинжээчдийн хувь 50.0-62.5 пунктээр буурсан байна.

Салбарын удирдах албан тушаалтны томилгоо хийхэд мэргэшсэн байдал, шударга зарчимч байдал гол шалгуур үзүүлэлт болдоггүй бөгөөд улс төрийн намын харьяаллыг гол болгож үздэг гэдэгтэй нийт шинжээчдийн 61.5 хувь нь санал нийлж байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 23.5 пунктээр буурсан байна. Уг үзүүлэлтийн салбаруудаар авч үзвэл Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын (100.0 хувь), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын (85.7 хувь), Сангийн сайдын эрхлэх асуудлын (75.0), Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (66.7 хувь), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын (66.7 хувь), Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (66.7 хувь), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын (62.5 хувь), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага (61.4 хувь), Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь) төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн үзэж буйгаар улс төрийн намын харьяаллаар удирдах албан тушаалтны томилгоог хийгдэг гэж үзжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад 14.3-75.0 пунктээр буурсан байна.

Танил тал, садан төрлийн холбооны хувьд нийт шинжээчдийн 23 хувь нь удирдах албан тушаалтны томилгоог хийхэд дээрх шалгуурыг голчлон үздэг гэдэгтэй санал нийлж байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 52.1 пунктээр буурсан байна. Үүнийг салбараар авч үзвэл Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын (75.0 хувь), Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын (50.0 хувь) төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн хувь харьцангуй өндөр байна. Харин Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын (14.3 хувь), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагыг үнэлж буй шинжээчдийн 18.2 хувь нь уг байдал байдаг гэдэгтэй санал нийлж байна гэжээ.

Авлига, хээл хахууль удирдах албан тушаалтны томилгоонд гол шалгуур болдог гэж нийт шинжээчдийн 14.2 хувь үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 28.7 пунктээр буурсан байна. Уг үзүүлэлтийг салбараар авч үзэхэд тухайн салбарыг

үнэлж буй шинжээчдийн 11.1-25.0 хувь нь тухайн салбарын удирдах албан тушаалтны томилгоо хийхэд авлига, хээл хахууль гол шалгуур болдог гэж үзжээ. Сангийн сайдын эрхлэх асуудлын, Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчид авлига, хээл хахууль удирдах албан тушаалтны томилгоонд огт нөлөөлдөггүй гэж үзсэн бол Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (33.3 хувь), Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын (25.0 хувь), Шадар сайдын эрхлэх асуудлын (20.0 хувь), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага (19.3 хувь), Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудыг үнэлж буй шинжээчдийн 11.1 хувь нь авлига, хээл хахууль удирдах албан тушаалтны томилгоонд авлига, хээл хахууль голлон нөлөөлдөг гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 13.3-51.4 пунктээр буурсан байна.

Харин нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын хувьд Архангай, Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон аймгуудад улс төрийн намын харьяаллаар удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэдэгтэй шинжээчид бүгд санал нийлж байна гэжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад Булган, Говь-Алтай аймгуудад улс төрийн намын харьяаллаар удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэдэгтэй санал нийлж буй санал нийлж буй шинжээчдийн хувь 15.0-25.0 пунктээр нэмэгдэж харин бусад аймгуудад 14.3-87.5 пунктээр буурсан байна.

Баян-Өлгий, Баянхонгор, Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Говьсүмбэр, Улаанбаатар, Ховд аймгуудад танил тал, садан төрлийн холбоогоор удирдах албан тушаалтны томилгоог хийдэг гэдэгтэй шинжээчдийн 16.7-50.0 хувь нь санал нийлж байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 14.2-66.7 пунктээр буурсан байна. Хэнтий (66.7 хувь), Ховд (57.1 хувь), Увс (50.0 хувь), Хөвсгөл (50.0 хувь), Дархан-Уул (33.3 хувь), Говьсүмбэр (33.3 хувь), Говь-Алтай (25.0 хувь), Төв (25.0 хувь), Улаанбаатар хотыг үнэлж буй шинжээчдийн 11.1 хувь нь албан тушаалтны томилгоог авлига, хээл хахуулиар шийддэг гэж үзжээ. Энэ нь 2009 оныхтой харьцуулахад Говь-Алтай, Төв, Ховд, Хэнтий, Дархан-Уул, Улаанбаатар, Говьсүмбэр аймгуудад албан тушаалтны томилгоог авлига, хээл хахуулиар шийддэг гэж үзсэн шинжээчдийн хувь хэмжээ 6.7-75.0 пунктээр буурсан байна. Харин Увс, Хөвсгөл аймгуудад албан тушаалтны томилгоог авлига, хээл хахуулиар шийддэг гэж үзсэн шийнжээчдийн хувь хэмжээ 16.7-33.3 пунктээр өссөн байна.

Нийт шинжээчдийн дунджаар 40.7 хувь нь үнэлж буй салбарын удирдах албан тушаалтнуудын дотор ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 7.3 пунктээр өссөн байна. Харин шинжээчдийн 45.6 хувь нь дунд зэрэг тархсан, 12.3 хувь нь тун бага тархсан, 1.4 хувь нь огт тархаагүй гэж үзсэн нь 2009 оныхтой харьцуулахад 1.0-5.1 пунктээр буурсан байна. Шинжээчдийн үзэж байгаагаар удирдах албан тушаалтнуудын дунд ашиг сонирхлын зөрчил маш их тархсан салбар бол Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын (72.7 хувь), Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (47.1 хувь), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын (44.4 хувь), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын (44.4 хувь), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага (44.1 хувь), Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (43.8 хувь) төрийн байгууллагууд юм.

Ашиг сонирхлын зөрчил маш их тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 5, дунд зэрэг тархсан гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 3, тун бага тархсан гэж үзсэн шинжээчдийн хувийг 2, огт тархаагүй гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийг 1 гэсэн үнэлгээгээр үнэлэн тухайн салбар дахь ашиг сонирхлын зөрчлийн тархцын дундаж хувийг тооцож үзвэл нийт салбаруудын дунджаар 3.66 болж байгаа нь өмнөх судалгааны үр дүнгээс 0.18 пунктээр өссөн байна. Ашиг сонирхлын зөрчил ихээхэн тархсан салбараар Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын (4.27), Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (3.88), Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (3.88), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын (3.78), Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага (3.78), Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын (3.73) төрийн байгууллагууд орж байна. Уг үзүүлэлт Сангийн сайдын эрхлэх асуудлын, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын, Шадар сайдын эрхлэх асуудлын төрийн байгууллагуудад 2009 оныхтой харьцуулахад 0.09-1.27 пунктээр буурсан байна.

Нутгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад ашиг сонирхлын зөрчил тун их тархсан гэж судалгаанд оролцсон Дундговь, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймгуудын төрийн байгууллагуудын шинжээчдийн 75.0-87.5 хувь нь үзсэн байна. Ашиг сонирхлын зөрчлийн тархцын дундаж хувийг тооцож үзвэл нийт нутгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын дунджаар 3.78 байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 0.20 пунктээр өссөн байна. Дундговь, Ховд, Хөвсгөл, Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр аймгуудын төрийн байгууллагуудад ашиг сонирхлын зөрчил тун их тархсан гэж шинжээчид үзжээ. Сүхбаатар, Төв, Сэлэнгэ аймгуудын төрийн байгууллагуудад ашиг сонирхлын зөрчил харьцангуй бага тархсан гэж үнэлэгджээ.

БҮЛЭГ IV. АВЛИГЫН ҮҮСГЭЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ

4.1. Баримтын судалгааны дүн шинжилгээ

Мөрдөн шалгах хэлтэст шалгагдсан эрүүгийн хэрэг, мөрдөн байцаагчийн бичсэн мэдэгдэлд дурдсанаар гэмт хэргийн шалтгаан дараах байдлаар илэрч байна.

Хувь хүнээс үүдэлтэй шалтгаан:

- Төрийн алба, ажлыг хийж гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлыг эхэнд тавих
- Төрийн албанд хувийн ашиг сонирхолд ашиглах гэсэн хүмүүс ажилладаг
- Намын эрх ашгийг өндөрт тавих
- Улс төрийн нөлөөнд байдаг
- Танил талаар асуудал шийдвэрлэх
- Дээд шатны албан тушаалтны хууль бус шийдвэрийг биелүүлдэг
- Хууль журам биелүүлдэггүй
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа баримталдаггүй
- Хууль эрх зүйн мэдлэг сул
- Мэргэшлийн мэдлэг, ур чадвар сул
- Нөхцөл байдал тохируулан дүгнэлт гаргах чадвар сул
- Ажлаа хайнга, хайхрамжгүй хийдэг
- Ёс зүй алдагдсан,
- Бие биендээ шан харамж ихээр өгдөг
- Төрийн албыг мөнгө олох хэрэгсэл гэж үздэг байдал

Хууль, эрх зүйн орчноос үүдэлтэй шалтгаан:

- Аливаа үйл ажиллагааг /процессыг/ зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй
- Хууль, эрх зүйн зохицуулалт хангалттай бус
- Зарим үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам байхгүй
- Хяналт сул, хариуцлага тооцох тогтолцоо тодорхой бус
- Хууль, дүрэм журам зөрчдөг явдал газар авсан

Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой шалтгаан:

- Төрийн үйл ажиллагааг зохих түвшинд хийдэггүй
- Удирдлагаас хууль бус үүрэг даалгавар өгөх явдал
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулдаг
- Байгууллагын дотоодын болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, захиалгат ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул
- Үйл ажиллагаа ил тод бус
- Мэдээлэл хаалттай
- Төрийн ажлыг хуулийн дагуу бус итгэлцэл дээр тулгуурлан явуулдаг
- Удирдах ажилтны мэдлэг, ур чадвар хангалтгүй
- Боловсон хүчний ажлын ачаалал жигд бус
- Ажилчин албан хаагчдын хэвийн ажиллах нөхцөлийг хангаж өгдөггүй
- Боловсон хүчний бодлого, сонгон шалгаруулалт хангалтгүй
- Сонгон шалгаруулалтын талаар олон нийтэд нээлттэй мэдээлдэггүй
- Албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх ажил хангалтгүй, нэр төдий хийдэг
- Албан хаагчдын ёс зүйн дүрмийг сахиулах ажиллагаа доголдолтой
- Олон шат дамжлага
- Хэт олон журам заавар
- Зарим ажлыг хариуцах эзэн тодорхойгүй
- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул
- Албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоогүй, харилцан мэдээлэл муутай байдал
- Иргэд, ажилтан албан хаагчдын гаргасан өргөдөл гомдолд хуулийн хугацаанд нь хариу өгдөггүй байдал
- Санхүү бүртгэлийн ажиллагаа хайнга хийгддэг.
- Хариуцлага тооцдоггүй
- Зөрчлийг арилгуулах арга хэмжээ авдаггүй, дотооддоо дараад өнгөрдөг
- УМХГ, Аудитын газар зэрэг хууль хяналтын байгууллагаас илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай авдаггүй.
- Удирдлагаас албан хаагчиддаа тавих дотоодын хяналт, шалгалт хийхгүй байх, тогтоосон журмын дагуу ажилаа явуулахгүй байх

4.2. Авлигын нөхцөл, шалтгааны талаар шинжээч, олон нийтийн төсөөллийн судалгааны дүн**Шадар сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:**

- Төрийн үйлчилгээ хангалтгүй байдал;
- Хүнд суртал, шат дамжлага их байдал;

- Төрийн албан хаагчдын хангамж, ажиллах нөхцөл муу байдал;
- Төрийн албан хаагчид ёс суртахуунгүй, мэдлэг, чадваргүй байдал;
- Тус салбар мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин томилдоггүй байдал;
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их байдал;
- Мэдээллийн болон үйл ажиллагааны ил тод байдал дутмаг, муу байдал;

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх хүрээ явцуу, судалгаагүй, оновчтой биш байдал;
- Төлөвлөгөө ил тод байдаггүй;
- Сургалт, сурталчилгаа хангалтгүй байдал;

Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дахь авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Төрийн албан хувийн ашиг сонирхлын зөрчил их байдал;
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлаг их байдал;
- Хууль эрх зүйн орчин муу, хангалтгүй байдал;
- Мэдээллийн болон шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдал дутмаг байдал;
- Тендер шалгаруулалт хуулийн дагуу явагддаггүй байдал;
- Дотоодын болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул байдал;
- Газар олголт хууль зөрчиж явагддаг байдал;
- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай;
- Төрийн албан хаагчийг улс төрийн зорилгоор томилдог, намчирхдаг байдал;
- Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдал;
- Төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон байдал.

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний хэрэгжүүлэх хүрээ явцуу, бодит судалгаагүй, оновчтой биш хийгддэг;
- Ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалж;
- Үр дүнг тооцдоггүй, хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт муу тавьдаг;
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй, эзэнгүй буюу арга зам нь тодорхойгүй;
- Улс төр, намын нөлөө их байдал;
- Төлөвлөгөө ил тод байдаггүй;

Сангийн сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлаг ихтэй
- Төрийн албаны дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул байдал
- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муу байдал
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их байдал
- Төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон байдал
- Албан хаагчдын мэдлэг, ур чадвар муу, мэргэжлийн бус байдал
- Төрийн албан хаагчийн ёс суртахуунгүй байдал,

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Үр дүнг тооцдоггүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь тавих хяналт муу байдал
- Удирдлагаас авлигатай тэмцэх манлайлал бага байдал
- Төсөв, мөнгө төлөвлөдөггүй байдал
- Төлөвлөгөө нь биелэх боломж хомс, боломжгүй байдал

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муу байдал
- Танил талаараа мэдлэг, чадваргүй боловсон хүчин авдаг
- Улс төрийн зорилготой томилдог, намчирхах байдал их
- Албан хаагчдын ажил үүргийн хуваарь тодорхой бус байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөө оновчтой биш зөвхөн үзүүлэлт болгодог байдал
- Үр дүнг нь тооцдоггүй байдал
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй,
- Төсөв, мөнгө хомс
- Төлөвлөгөө ил тод байдаггүй
- Байгууллагын үндсэн чиг үүрэг биш учир орхигддог

Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай байдал
- Албан хаагчид нь ёс суртахуунгүй байдал, хүнд суртал ихтэй байдал
- Хууль бус үйлдлийг далдлах, хууль бус шийдвэр гаргуулах боломж их байдаг
- Албан тушаал ахих, цол нэмэх сонирхол их байдал
- Хувийн ашиг сонирхлын зөрчил ихтэй байдал
- Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төсөв, мөнгө төлөвлөгдөөгүй байдал
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй байдал
- Үр дүнг тооцдоггүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт муу байдал

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Тусгай зөвшөөрөл олголт хууль журмаар явагддаггүй байдал
- Тендер худалдан авалт хуулийн дагуу явагддаггүй байдал
- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай байдал
- Хувийн ашиг сонирхлын зөрчил ихтэй байдал
- Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх ажиллагаа хангалтгүй байдал

- Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул байдал
- Боловсон хүчний бодлого буруу

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй, хариуцах эзэнгүй болон хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй
- Төлөвлөгөө нь албан хаагчдад ил тод байдаггүй
- Хэрэгжүүлэх хүрээ нь явцуу, бодит судалгаагүй буюу оновчтой биш, ёс төдий
- Ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалдаг

Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Улс төрийн томилгоо, намчирхах байдал их
 - Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
 - Авлигыг илрүүлэх, тэмцэх хүсэлгүй
- Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжилт үр дүнг тооцдоггүй, үйл ажиллагааны хяналт муу
- Хамаарах хүрээ явцуу, бодит судалгаагүй буюу оновчтой биш
- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, хангалтгүй, удаан
- Тунхгийн шинжтэй

Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
 - Их дээд, дунд сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муугаас
 - Хувийн ашиг сонирхлын зөрчил их
 - Мэдээллийн болон шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдал дутмаг, муу
- Бүх салбарт авлигатай тэмцэх хүсэл сул

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний хэрэгжилт болон үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй

Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Хэт олон бүртгэл, тусгай зөвшөөрөл, хураамж байдгаас
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Улс төрийн томилгоо, намчирхах байдал их
- Тендер худалдан авалт хуулийн дагуу явагддаггүй
- Хүнд суртал, шат дамжлага их
- Албан хаагчдын мэдлэг, ур чадвар муу

- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
- Албан хаагчдын ёс зүйн төлөвшөл муу, шударга бус байдал
- Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Үр дүнг тооцдоггүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт муу
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй буюу сул
- Төсөв, мөнгө төлөвлөгдөөгүй болон хязгаарлагдмал
- Хэрэгжүүлэх хүрээ явцуу, бодит судалгаагүй буюу оновчтой биш

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Тендер, худалдан авалт болон төслүүд хуулийн дагуу явагддаггүй
- Төрийн албан хаагчдын амьдралын түвшин бага, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
- Хууль эрх зүйн орчин муугаас
- Хүнд суртал, шат дамжлага их Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Тухайн салбарын бүтэц, төлөвлөлт нь оновчгүй

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төсөв, мөнгө төлөвлөгдөөгүй
- Хэрэгжүүлэх хүрээ явцуу, бодит судалгаагүй буюу оновчтой биш
- Нийгмийн хамгааллын үйл ажиллагаа нь өөрөө тааруу учир хэрэгждэггүй
- Албан хаагчдын ёс зүйгээс шалтгаалдаг

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Тендер шалгаруулалт, төсөл хуваарилалтыг хууль журмын дагуу явагддаггүй байдал
- Төслийн зээл, тоног төхөөрөмж хангалттай бус байдал
- Албан тушаалтнуудад хуулиар олгосон эрх мэдэл их, ашиг сонирхол их байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх эзэнгүй болон арга зам нь тодорхойгүй

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа буюу лиценз, тусгай зөвшөөрөл хууль бусаар олгодог, цуцалдаг, шилжүүлдэг;
- Тус салбарын албан хаагчдын амьдралын түвшин бага, нийгмийн хангамж муугаас;
- Ёс суртахуунгүйгээс хүнд суртал, шат дамжлаг ихтэй;

- Хууль эрх зүйн орчин хангалтгүй, хоорондоо зөрчилтэй

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцдоггүй, дотоод болон хөндлөнгийн хяналт муу;
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүйгээс;
- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, хангалтгүй, удаан.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

- Эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ хүртээмж муутай
 - Хүнд суртал, шат дамжлага маш их
 - Төрийн албан хаагчдын амьдралын түвшин, хангамж муу
 - Тендер, төсөл хуулийн дагуу явагддаггүй
 - Албан хаагчид ёс суртахуунгүй
 - Боловсон хүчний томилгоо, шалгуур үзүүлэлт хангалтгүй
 - Улс төрийн нөлөө, намчирхах байдал их
- Төсөв нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж хуваарилалтад лобби их

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөө нь бодит судалгаагүй тул оновчтой биш байдаг
- Төлөвлөгөө албан хаагчдадаа ил тод байдаггүй
- Авлигатай тэмцэх механизм муугаас, хэрэгжүүлэх болон хариуцах эзэнгүй байдаг
- Ач холбогдлыг нь ойлгодоггүй
- Сургалт, сурталчилгаа хангалтгүй биш тиймээс авлигын талаарх ойлголтууд зэргийг дурдсан.

Архангай аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Тусгай зөвшөөрөл олголт хууль, журмын дагуу хийгддэггүй байдал
- Тендер, худалдан авах үйл ажиллагаа хууль бусаар явагддаг байдал
- Төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл, шат дамжлага их байдал
- Албан тушаалын томилгоо хууль бус хийгддэг байдал
- Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын зөрчил их байдал
- Төрийн албан хаагчийн ёс зүйн ухамсар муу байдал

2. Иргэд

- Авлига нь ажлыг бүтээж, амжуулах хөшүүрэг гэж үздэг байдал
- Хүнд суртал, шат дамжлага их байдал
- Албан хаагчдын цалин, нийгмийн хангамж бага, ажиллах орчин хангалтгүй байдал
- Ажлын байрны хомстол болон ажилгүйдэл

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөө нь цаасан дээр бичихээс цаашгүй, ёс төдий зүйл болсон
- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу байдал

Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид
 - Тендер бараа ажил үйлчилгээ худалдан авалт хууль бусаар явагддаг байдал
 - Хяналт шалгалт сул байдал
 - Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж муу байдал
 - Ажилд авах, томилох нь хууль журмын дагуу бус байдал
 - Төрийн албан хаагчийн ёс зүйн ухамсар муу байдал
 - Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын зөрчил их
 - Иргэдийн хуулийн мэдлэг дутмаг
2. Иргэд
 - Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
 - Ашиг сонирхлын зөрчил их байдал
 - Ядуурал
 - Нам, улс төрийн хараат байдал, нөлөөлөл
 - Төрийн албан хаагчид ёс суртахуунгүй
 - Тендер, төсөл хууль ёсоор явагддаггүй байдал
 - Хяналтын тогтолцоо муу байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй, хариуцах эзэнгүйгээс
- Төсөв мөнгө төлөвлөгдөөгүйгээс
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл бага, хэрэгжүүлэх сонирхолгүй

Баянхонгор аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид
 - Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
 - Ёс зүйн ухамсар муу, доройтол, ядуурал
 - Төрийн албан хаагчдын амьдралын түвшин, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
 - Хэвлэл мэдээлэл хараат байдал
 - Иргэдийн хуулийн мэдлэг дутмаг
2. Иргэд
 - Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
 - Төрийн албанд хүнд суртал, шат дамжлага их
 - Төрийн албанд ашиг сонирхлын зөрчил их
 - Ядуурал
 - Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдал

- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж муу, ажиллах орчин хангалтгүй
- Хуулийг хэрэгжүүлдэггүйгээс
- Төрийн албан хаагчдын мэдлэг, чадваргүй байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх ажлын хүрээ явцуу
- Хэрэгжүүлэх сонирхолгүй

Булган аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
 - Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
 - Хяналт шалгалт сул
 - Иргэдийн хуулийн мэдлэг дутмаг
 - Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албан хаагчдын мэдлэг, боловсрол муутай

2. Иргэд

- Ашиг сонирхлын зөрчил их
- Хүнд суртал, шат дамжлага их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчид ёс суртахуунгүйгээс
- Мэдээлэл муу, ил тод бус
- Нам, улс төрийн хараат байдал, нөлөөлөл их

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Авлигатай тэмцэх механизм хөгжөөгүй
- Хариуцлага тооцдоггүй
- Авлига буурах итгэл үнэмшил байхгүй Төлөвлөгөөний хэрэгжилт нь тааруу явагддагаас
- Цаасан дээр бичихээс цаашгүй, ёс төдий хийгддэг
- Сургалт сурталчилгаа төдийгөөр л ажлаа явуулдаг

Говь-Алтай аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Намчирхах, намын харьяалал их байдаг
- Тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа хуулийн дагуу бус
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муутай
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Боловсон хүчний бодлого алдагдсан

2. Иргэд

- Төрийн байгууллагын хүнд суртал, шат дамжлага их
- Ядуурал
- Ашиг сонирхлын зөрчил их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй, шударга бус байдал
- Хяналтын тогтолцоо муу

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх субъект нь өөрсдөө авлигач
- Цаасан дээр бичихээс цаашгүй, ёс төдий байдаг
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй
- Ажилтнууд арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй

Дорноговь аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Хууль, эрх зүйн орчин муу
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их

2. Иргэд

- Ашиг сонирхлын зөрчил их, танил хүнд үйлчилдэг
- Төрийн байгууллагын хүнд суртал, шат дамжлага их
- Гаалийн хяналт шалгалт муу
- Иргэдийн хуулийн мэдлэг муу
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Нам, улс төрийн нөлөөлөл их

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөө нь албан хаагч, иргэдэд ил тод байдаггүй
- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Хэрэгжүүлэх ажлын хүрээ нь бага, явцуу Сурталчилгаа хангалтгүй
- Улс төрийн нөлөөлөл ихээс
- Ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалж

Дорнод аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн албан хаагчдын ёс зүйн ухамсар муу
- Лиценз олголт хууль бус явуулдгаас
- Төрийн албан хаагчдын мэдлэг, чадвар, боловсрол муутай
- Төрийн албан хаагчдын цалин, хангамж муу, ажиллах нөхцөл муутай

2. Иргэд

- Ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албаны хүнд суртал
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Авлига нь ажлыг бүтээх хөшүүрэг болдог гэсэн ойлголт
- Эрх мэдэл, албан тушаалыг буруугаар ашиглах
- Нам, улс төрийн хараат байдал, нөлөөлөл их

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Төсөв мөнгө төлөвлөгдөөгүй
- Хэрэгжүүлэх ажлын хүрээ бага
- Улс төрийн нөлөө их
- Ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалж

Дундговь аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах нөхцөл муутай
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн дээд албан тушаалтнуудын үлгэр муу
- Хуулийг хэрэгжүүлдэггүй

2. Иргэд

Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их

- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Ашиг сонирхлын зөрчил их
- Газар олголт хууль ёсны бус
- Хууль хэрэгждэггүй, хэрэгжүүлдэггүй
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Төсөв мөнгө төлөвлөгдөөгүй
- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, хангалтгүй байдгаас
- Иргэдэд чиглэгдсэн үйл ажиллагаа байхгүй
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй Улс төрийн нөлөө их

Завхан аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах нөхцөл муу
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их

- Ажлын байрны хомстол

2. Иргэд

- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах орчин муу
- Ашиг сонирхлын зөрчил их
- Нам, улс төрийн нөлөөлөл их байдгаас
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Авлигыг ажлыг бүтээж амжуулах хөшүүрэг гэж үздэгт

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх субъект нь өөрсдөө авлигач
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Иргэдийн ухамсар муу
- Цаасан дээр бичихээс цаашгүй, ёс төдий хийгддэг
- Хууль хэрэгждэггүй, хэрэгжүүлдэггүйгээс
- Иргэдийн оролцоо тааруу
- Төлөвлөгөө ил тод байдаггүй

Өвөрхангай аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албан хаагчдын шударга, ёс зүйгүй байдал
- Тендер хууль бусаар явагддаг, явуулдаг
- Төрийн үйлчилгээ хангалтгүй
- Хуулийг хэрэгжүүлдэггүй

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ашиг сонирхлын зөрчил их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Нам, улс төрөөс хараат байдал, нөлөөлөл
- Ядуурал
- Хариуцлага тооцдоггүй
- Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах орчин муу
- Хяналтын тогтолцоо муу
- Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Төлөвлөгөөг ёс төдий л хийдэг
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй
- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу

Өмнөговь аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн албаны хүнд суртал
- Газар авах хэрэгцээ их, үнэд орсноос, газар олголт хяналтгүй
- Төрийн албан хаагчийн шударга бус, ёс зүйгүй байдал
- Хуулийг хэрэгжүүлдэггүй
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ёс суртахууны доройтол
- Ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Тендер хууль ёсоор явуулдаггүй
- Ядуурал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Цаасан дээр бичихээс цаашгүй, ёс төдий хийгддэг
- Биелэх боломжгүй

Сүхбаатар аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муугаас
- Хөрөнгө төсвийн хомстол
- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл их
- Ашиг сонирхлын зөрчил их
- Ёс суртахуунгүй байдал
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муугаас
- Ядуурал
- Төрийн албан хаагчдын мэдлэг, чадваргүй байдал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу байдгаас
- Санаачилга муутай
- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Хэрэгжүүлэх ажлын хүрээ явцуу
- Сурталчилгаа хангалтгүй, байхгүй

Сэлэнгэ аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид
 - Төрийн албан хаагчдын амьдралын цалин, хангамж, ажиллах нөхцөл муу
 - Лиценз олголт хууль бус явагддаг
 - Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
 - Эрх мэдлийн хэт төвлөрлөөс
 - Хяналтын механизм муугаас
2. Иргэд
 - Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
 - Ашиг сонирхлын зөрчил их
 - Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах орчин хангалтгүй
 - Эрх мэдлийн дарамт, эрх мэдлийн хэт төвлөрөл
 - Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
 - Хэт олон зөвшөөрөл шаардлагатай байдаг
 - Хяналтын тогтолцоо муу
 - Ядуурал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Төлөвлөгөө нь цаасан дээр бичихээс цаашгүй

Төв аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид
 - Хариуцлагын механизм хангалтгүй
 - Хувийн эрх ашгаа дээгүүр тавьдаг, төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон
 - Төрийн албан хаагчдын цалин, хангамж, ажиллах нөхцөл муутай
2. Иргэд
 - Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
 - Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
 - Ашиг сонирхлын зөрчил их
 - Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
 - Эрх мэдлийн хэт төвлөрөл

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэлэлцүүлэлгүй хэсэг хүн л боловсруулж, баталдаг
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй
- Судалгаагүй, цаасан дээр л хийгддэг
- Хариуцлагын тогтолцоо байхгүй
- Удирдлагын санаачилга муугаас
- Үр дүнг тооцдоггүй

Увс аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага
- Мэдээллийн болон үйл ажиллагааны ил тод байдал дутмаг
- Намчирхах, намын харьяалал их
- Хууль бус шийдвэр гаргуулахын тулд
- Эрх мэдлийн төлөөх хүсэл, тэмцэл их

2. Иргэд

- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Ядуурал
- Ашиг сонирхлын зөрчил их
- Хууль хэрэгждэггүй, хэрэгжүүлдэггүй

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөг цаасан дээр бичихээс цаашгүй, шалгуулах гэж л хийдэг
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй, санаачилга муутай

Ховд аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Намчирхах үзэл, намын харьяалал ихтэй
- Ажлын байр хомстол, ажилгүйдэл
- Тендер хуулийн дагуу явагддаггүйгээс

2. Иргэд

Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их

- Ашиг сонирхлын зөрчил их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Хяналтын тогтолцоо муу, хариуцлага тооцдоггүй
- Ядуурал
- Төрийн албан хаагчдын ёс суртахууны доройтол
- Тендер, төсөл хууль ёсоор явагддаггүй, явуулдаггүй

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгааны талаар судалгаанд оролцогчид ямар нэгэн санал, дүгнэлт хийгээгүй байв.

Хөвсгөл аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
- Намчирхах, намын харьяаллаар албан тушаалын томилгоо хийдэг

- Тендер хуулийн дагуу явагддаггүй
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муу

2. Иргэд

- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ашиг сонирхлын зөрчил их
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муу
- Эрх мэдлийн төлөөх тэмцэл, хүсэл

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй байдгаас
- Биелэх боломж хомс, боломжгүй төлөвлөгөө хийгддэгээс зэргийг дурдсан байна.

Хэнтий аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул
- Үйл ажиллагааны болон бусад мэдээлэл ил тод бус, дутмаг
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж, ажиллах нөхцөл муу
- Албан тушаалтнууд хувийн эрх ашгаа дээгүүр тавьдаг, төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон
- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
- Ёс суртахуунгүй байдал, хүнд суртал, шат дамжлаг ихтэй

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Төрийн албан хаагчдын цалин бага, нийгмийн хангамж, ажиллах орчин хангалтгүй
- Ашиг сонирхлын зөрчил их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Эрх зүйн орчин хангалтгүй, хоорондоо зөрчилтэй, олон журам, дүрэм
- Ядуурал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй, санаачилга муутай
- Хууль эрх зүйн орчин, зохицуулалт хангалтгүй
- Төсөв мөнгө төлөвлөгдөөгүй
- Үр дүнг тооцдоггүй, мониторинг байхгүй
- Авлигын талаарх мэдээллийн нууцлалыг хангаж чаддаггүйгээ

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Хувийн эрх ашгаа дээгүүр тавьдаг, төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон
- Тендерийг хуулийн дагуу явуулдаггүй, явагддаггүй
- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
- Дотоод болон хөндлөнгийн хяналт, шалгалт сул
- Хууль эрх зүйн орчин муу
- Төрийн албан хаагчдын мэдлэг чадваргүй байдал

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин хангалтгүй
- Ашиг сонирхлын зөрчил их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Тендер, төсөл хууль ёсоор явагддаггүй
- Төрийн албан хаагчдын мэдлэг, боловсрол, чадваргүй, ёс суртахуунгүй
- Газар олголт хууль ёсны бус явагддаг
- Ядуурал
- Иргэд, хувийн хэвшлийнхэн өөрсдөө авилга өгдөг
- Эрх зүйн орчин хангалтгүй, хоорондоо зөрчилтэй, олон журам, дүрэм
- Нам, улс төрийн хараат, нөлөөлөл ихээс
- Хяналтын тогтолцоо муу

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний үр дүнг тооцдоггүй, мониторинг байхгүй
- Биелэх боломж хомс, боломжгүй
- Ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалж
- Цаасан дээр бичихээс цаашгүй, шалгуулах гэж л төлөвлөгөө хийгддэг,

Улаанбаатарын нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Албан хаагчдын амьдралын түвшин, хангамж муу, ажиллах нөхцөл муутай
- Ёс суртахуунгүй байдал, хүнд суртал, шат дамжлаг ихтэй
- Төрийн үйлчилгээ хангалтгүй, танил талдаа үйлчилдэг
- Улс төрийн нөлөөлөл, томилдог, намчирхах байдал их
- Хяналт, шалгалт сул
- Тендер худалдан авах үйл ажиллагаа хуулийн дагуу явагддаггүй
- Мэдээллийн болон үйл ажиллагааны ил тод байдал дутмаг, муу
- Тусгай зөвшөөрөл олголт хяналтгүй, зохицуулалтгүй
- Хууль эрх зүйн орчин муу, зөрчилдсөн заалт ихтэй, хэт олон журам, дүрэм
- Төрийн албан хаагчид хувийн эрх ашгаа дээгүүр тавьдаг
- Төрийн албыг мөнгө олох хэрэгслээ болгосон
- Хариуцлагын механизм хангалтгүй

- Төрийн албаны боловсон хүчний бодлого алдагдсан
 - Албан хаагчдын мэдлэг чадваргүй байдал
 - Хөрөнгө хуваарилахдаа хууль журмын дагуу дагуу бус
 - Авлигыг илрүүлэх хүсэлгүй
 - Нийгмийн ядуурал, ажилгүйдэл
2. Иргэдийн төсөөллийн судалгаагаар
- Хувийн ашиг сонирхлын зөрчил их
 - Хүнд суртал, шат дамжлага ихээс ажлаа бүтээх зорилгоор
 - Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж бага
 - Ядуурал
 - Албан хаагчдын мэдлэг, боловсрол, чадваргүй байдал Хяналтын тогтолцоо муу
 - Төрийн үйлчилгээ хүртээмжтэй бус
 - Мэдээллийн ил тод бус байдал
 - Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
 - Тендер, төсөл хууль ёсоор явагддаггүй
 - Олон төрлийн зөвшөөрлийг төр өгдгөөс
 - Хариуцлага тооцдоггүйгээс
 - Ажлыг бүтээж амжуулах хөшүүрэг
 - Нам, улс төрийн хараат байдал, нөлөөлөл их
 - Эмнэлэг, эмч, орны хүртээмж, сургууль цэцэрлэг бага
 - Газар олголт хууль ёсны бус, үнэд орсноос
 - Төр засгийн буруу бодлого
 - Эрх зүйн орчин хангалтгүй, хоорондоо зөрчилтэй, олон журам, дүрэм
 - Албан хаагчдын ёс суртахуунгүй байдал
 - Хууль хэрэгждэггүй, хэрэгжүүлдэггүйгээс
 - Дээд шатны албан тушаалтны дарамт шахалт их байдаг
 - Инфляц их, үнийн хөөрөгдөл
 - Иргэдийн хуулийн мэдлэг муу

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Үр дүнг тооцдоггүй, хяналт муу
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй, сул
- Төсөв, мөнгө төлөвлөдөггүй
- Судалгаагүй, оновчтой биш
- Төлөвлөгөө нь нээлттэй ил тод байдаггүй
- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, хангалтгүй, удаан
- Ёс төдий хийгддэг
- Авлигатай тэмцэх механизм, бүтэц хөгжөөгүй

Орхон аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид
 - Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдал, хүнд суртал
 - Хяналт шалгалт сул
 - Авлигын эсрэг тэмцэл сул, тууштай биш

- Тендерийг мөнгө олох хэрэгсэл болгодог
- Намын харьяалал ихтэй

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Ядуурал
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Ашиг сонирхлын зөрчил их
- Иргэдийн хуулийн мэдлэг муу, дутмаг
- Төрийн албан хаагчдын ёс суртахуунгүй байдал, доройтол
- Эрх зүйн орчин хангалтгүй, хоорондоо зөрчилтэй
- Иргэд, хувийн хэвшлийнхэн өөрсдөө авилга өгдөг

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төрийн албанд улс төрийн нөлөө их байдаг
- Хэрэгжилт нь тааруу
- Цаасан дээр бичихээс цаашгүй
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй
- Үр дүнг тооцдоггүй, мониторинг байхгүй
- Биелэх боломжгүй, хэрэгжүүлэх чадамжгүй

Говьсүмбэр аймгийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад авлига буурахгүй байгаа болон авлига үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл:

1. Шинжээчид

- Албан тушаалтнууд хувийн эрх ашгаа дээгүүр тавьдаг, төрийн ажлыг мөнгө олох хэрэгслээ болгосон
- Төрийн албан хаагчдын цалин, амьдралын түвшин, хангамж муу
- Төрийн албан хаагчдын ёс зүйн ухамсар муу

2. Иргэд

- Төрийн албаны хүнд суртал, шат дамжлага их
- Ажлын байрны хомстол, ажилгүйдэл
- Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамж, ажиллах орчин муу
- Гэмт хэргээс мултрах санаа
- Ядуурал

Авлигатай тэмцэх стратеги төлөвлөгөө үр өгөөжтэй байж чаддаггүй шалтгаан:

- Төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, цаасан дээр бичихээс цаашгүй
- Авлигатай тэмцэх механизм хөгжөөгүй
- Иргэдийн ухамсар муу
- Төсөв мөнгө төлөвлөгдөөгүй
- Хариуцлагын тогтолцоо байхгүй
- Иргэдэд чиглэгдсэн үйл ажиллагаа байхгүй, иргэдийн ойлголт дутуу
- Төлөвлөгөө нь ил тод байдаггүй
- Удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл байхгүй
- Үр дүнг тооцдоггүй

БҮЛЭГ V. АВЛИГЫН ИНДЕКС ТООЦОХ АРГАЗҮЙ, ОЛОН НИЙТИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТАЙЛБАР, СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1. Авлигын индекс тооцох арга зүй

Монгол Улсын Авлигын индекс тооцох аргачлалыг Авлигатай тэмцэх газрын болон Үндэсний Статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76/(06/69) хамтарсан тушаалаар баталсан юм. Авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр буюу аймаг, нийслэл, тэдгээрийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн нэгж, орон нутаг дахь салбар дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц юм. Тиймээс авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр буюу аймаг, нийслэл, тэдгээрийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн нэгж, орон нутаг дахь салбарын авлигын цар хүрээг тодорхойлох тоон үзүүлэлт юм.

Авлигын индексийн тоон үзүүлэлт нь авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн арифметикийн дундаж байна. Авлигын индекс нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үзнэ. Тухайлбал, авлигын хэлбэрийн үзүүлэлтийн утга нэмэгдэж байвал авлигын хүнд хэлбэрүүд үгүй болж байна гэж үзнэ.

Авлигын цар хүрээний үзүүлэлтүүдэд дараах үзүүлэлтийг авч үзсэн.

Үүнд:

1. Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт буюу авлига түгээмэл гэж үзсэн олон нийт, шинжээчдийн эзлэх хувийн жин;
2. Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт буюу авлигын бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлд эзлэх хувь;
3. Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ буюу тодорхой төрлийн хэлцлийн үнийн дүн дэх авлига, хээл хахуулийн эзлэх хувь;
4. Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад төлсөн хээл хахуулийн өрхийн орлогод эзлэх хувь.

Авлигын цар хүрээний үзүүлэлт нь авлигын тархцын талаарх шинжээчид, олон нийтийн төсөөлөл, авлигын гэмт хэргийн мэдрэгдсэн эдийн засгийн үр дагавар, улсаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, худалдан авах үйл ажиллагаан дахь авлигын хувь хэмжээ, хээл хахуулийн өрхийн төсөвт үзүүлж буй үр дагавар зэрэг үзүүлэлтийн нийлбэр цогц юм.

Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт нь 1 гэсэн утгад ойрхон байх тусам авлигагүй байгааг 0-д ойрхон байх тусам авлига их байгааг илтгэн харуулах учир авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлтийг авлигын цар хүрээний үзүүлэлтүүдийн арифметикийн дунджийг нэгээс хасч тооцсон. Өөрөөр хэлбэл, хасагдаж байгаа утгын хэмжээгээр авлига байна гэж үзэж болно.

Авлигын хэлбэрийн үзүүлэлтүүдэд дараах үзүүлэлтүүдийг авч үзсэн. Үүнд:

1. Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь
2. Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь
3. Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь
4. Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт

5. Шунахайн сэдэлттэй авлигын гэмт хэргийн эзлэх хувь

Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлтийг дээр дурдсан үзүүлэлтүүдийн арифметик дунджийг нэгээс хасч тооцох бөгөөд уг үзүүлэлт авлига хэмээх гэмт үзэгдэл нь илрэн гарахдаа хэр ноцтой байдлаар илрэн гарч байгааг харуулах тоон үзүүлэлт байна. Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт 1-д ойрхон байх тусам авлигын хүнд хэлбэрүүд алга болж байгааг илэрхийлэх бол нөгөө талаас 0-д ойрхон байх тусам авлига хэмээх гэмт үзэгдэл нь ихээхэн хүнд ноцтой байдлаар илрэн гарч байгааг харуулна.

Дээрх бүх үзүүлэлтүүд нь авлигын индексийг үндэсний түвшинд тооцон гаргах үзүүлэлтүүд болно. Авлигын индексийг салбараар буюу төрийн захиргааны төв байгууллага буюу яам, түүний эрхлэх асуудлын байгууллагуудаар болон аймаг, нийслэлээр буюу нутгийн захиргааны болон нутгийн удирдах байгууллагаар тооцоход төсөөллийн үзүүлэлтүүдэд илүү тулгуурлан тооцсон.

Авлигын индексийг салбараар тооцохдоо дараах ангиллыг ашигласан.

Үүнд:

1. Сангийн сайдын эрхлэх асуудлын;
2. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын;
3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын;
4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын;
5. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын;
6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын;
7. Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын;
8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын;
9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын;
- 10 . Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын;
- 11 . Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын;
- 12 . Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага;
- 13 . Шадар сайдын эрхлэх асуудлын.

Тухайн салбарын сайдын эрхлэх асуудлын гэдэг хүрээнд төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн харьяа байгууллагууд, тэдгээрийн орон нутаг дахь салбар нэгжүүдийг хамруулан авч үзсэн. Авлигын индексийг аймаг, нийслэлээр тооцохдоо аймаг, нийслэлийн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын түвшинд авч үзсэн. Дээрх ангиллыг авлигын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийг цуглуулах судалгааны түүвэрлэлт, мэдээлэл боловсруулалтад ашигласан.

5.2. Олон нийтийн төсөөллийн судалгааны мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл боловсруулалт

Авлигын индексийг тооцоход дараах үндсэн мэдээллийн эх үүсвэрийг ашигласан. Үүнд Олон нийтийн төсөөллийн судалгааны дүн, Шинжээчдийн төсөөллийн судалгааны дүн, Баримтын судалгааны дүн гэх мэт. Олон нийт (иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгч)-ийн төсөөллийн судалгаагаар авлигын талаарх төсөөлөл, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан, авлигын тохиолдлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг бусад мэдээллийг цуглуулах явдал юм.

Шинжээчдийн төсөөллийн судалгааны зорилго нь тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, авлигын хэлбэр, шалтгаан, эдийн засгийн хор уршиг зэргийг тодорхой шалгуураар сонгосон шинжээчдээр үнэлүүлэхэд оршино.

Баримтын судалгаагаар тухайн жилд бүртгэсэн авлигын эрх зүйн зөрчлийн тоон

үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, авлигын индексийн бүрдэл хэсгүүд болох авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг тодорхойлно.

Олон нийтийн судалгаанд хамрагдах иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид нь олон нийтийн төсөөллийн судалгааны үндсэн нэгж байсан.

Иргэд: Иргэдийн төсөөллийн судалгааны үндсэн нэгж нь Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа 18 болон түүнээс дээш насны иргэд байсан. Судалгааны түүвэрлэлтийг өрхөөр хийсэн бөгөөд тухайн өрхийн тэргүүлэгч нь өрхөө төлөөлөн иргэдийн төсөөллийн судалгаанд хамрагдсан. Албан ёсны статистик мэдээллээр 2008 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад нийт 677.8 мянган өрхөд 2683.5 мянган хүн амьдарч байна.

Төрийн албан хаагчид: Төрийн албан хаагчдын төсөөллийн судалгааны үндсэн нэгж нь Монгол Улсын Төрийн албаны хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа...”, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан ангилалд багтах төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчид байсан. Судалгааны зорилгод нийцүүлэн нийт төрийн албан хаагчдаас төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлаг, тэдгээрийн салбар нэгж; шүүх, прокурорын байгууллага; нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын төрийн албан хаагчдыг энэ удаагийн судалгаанд хамруулсан. Төрийн албаны зөвлөлийн 2007 онд хийсэн төрийн албан хаагчдын тооллогын дүнгээр энэ төрөлд багтах 2051 байгууллагын нийт 96.0 мянган төрийн албан хаагчид хамрагдаж байна.

Бизнес эрхлэгчид: Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2-д заасан “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг ... ашиг олох зорилготой ашгийн төлөө... зохион байгуулалтын нэгдлийн...” буюу хуулийн этгээд нь бизнес эрхлэгчдийн төсөөллийн судалгааны үндсэн нэгж болсон. 2009 оны эхний хагас жилийн байдлаар ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа 36.4 мянган аж ахуйн нэгж байна.

Газар зүйн байршлын хувьд Монгол Улсын бүх аймаг, нийслэлийг уг судалгаанд хамруулсан бөгөөд хүн амын нягтшил, улс төр, эдийн засгийн төвлөрөл зэргийг харгалзан үзэж аймаг бүрээс 1-3 сумыг судалгаанд хамруулсан.

Судалгааны ажлыг Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас удирдан зохион байгуулж явуулсан бөгөөд судалгааны мэдээлэл цуглуулах, ярилцлага авагчаар өмнө нь судалгаанд оролцож ажиллаж ирсэн туршлагатай хүмүүсийг сонгон, сургаж бэлтгэн тэднээр дамжуулан ярилцлагаар мэдээллийг цуглуулсан.

Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дараахь дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн.

- Авлигатай тэмцэх газрын УССГХ-ийн Судалгаа шинжилгээний албаны зүгээс судалгааны түүвэрлэлт, хуваарийг гаргасан.
- Судалгааны тоологч нарыг сонгож авч, тэдэнд зориулсан сургалтыг зохион байгуулсан.
- Ярилцлага авагч нарт судалгааны асуулга, заавар, судалгаанд хамрагдах нэгжийн жагсаалтыг хүлээлгэн өгсөн.
- Ярилцлага авагч нар нь сонгогдсон нэгж дээр очиж, судалгааны нэгжтэй ярилцах байдлаар судалгааны асуулгыг бөглүүлж авсан.

- Судалгааны ажлын ажлын явцыг 21 аймаг, нийслэлд хянаж, холбогдох заавар, зөвлөмжийг өгч ажилласан.
- США-наас цуглуулсан мэдээллийг асуулга тус бүрээр асуулт бүрийг бүрэн бөглөсөн эсэх, код, дугаарыг зөв тавьсан эсэхэд хяналт тавьж, холбогдох засвар өөрчлөлтийг хийлгэсэн.
- Холбогдох засвар, өөрчлөлтийг хийсний дараа асуулгуудыг компьютерт шивж оруулахаар хүлээлгэн өгсөн.

Судалгааны мэдээлэл цуглуулах ярилцлага авагч нарт зориулсан зааврыг боловсруулан тэдэнд зориулсан сургалтыг зохион байгуулж тэндэнд тайлбарлан танилцуулж мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд ашигласан. Энэхүү зааварт судалгааны зорилго, ач холбогдол, судалгааны ажлын зохион байгуулалт, ярилцлага хийх, асуулгыг бөглөх зөвлөмж, судалгааны мэдээллийг цуглуулахад анхаарах асуудал, судалгааны асуулт тус бүрийг хэрхэн ойлгох тайлбар зэргийг оруулж өгсөн.

Судалгааны мэдээлэл цуглуулах үе шатанд дараахь зарчмыг баримталсан. Үүнд:

а) Судалгааны асуулгад судалгааны нэгжийн нэр, хаягийг тусгахгүйгээр мэдээллийг цуглуулсан.

б) Ярилцлага өгөгчийг бусдын нөлөөнд автахгүй тайван хариулт өгөх боломжийг бүрдүүлж зөвхөн ярилцлага өгөгч, ярилцлага авагч хоёр хоорондоо харилцах боломжийг бүрдүүлсний дараа ярилцлагыг хийсэн.

в) Сум, баг, хорооны ажилтан, албан тушаалтныг тухайн асуулга авах айлд дагуулан очихоос аль болох зайлсхийсэн.

г) Ярилцлага өгөгчид асуулгын мөн чанарыг сайтар тайлбарлаж ойлгуулсны дараа ярилцлагаа эхлүүлсэн.

Тухайн аймаг дахь судалгаанд хамрагдах нэгжийн тооноос шалтгаалан аймаг бүрт 2-4, нийслэл Улаанбаатар хотод 33, нийт 85 хүн судалгааны ярилцлага авагчаар ажиллалаа.

Олон нийтийн төсөөллийн судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг орон даяар 2011 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 17-ны өдрийн хооронд, шинжээчдийн төсөөллийн судалгааны мэдээллийг 2011 оны 9 дүгээр сарын 09- нөөс 11 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэсэн.

Судалгааны ажлын төсөв, нийт судлагдах ерөнхий олонлогийн хэмжээ зэрэгт үндэслэн олон нийтийн судалгаанд 6000 нэгж хамрагдахаар тооцсоны 3001 нь иргэд, 2000 нь төрийн албан хаагчид байна гэж тооцсон.

Авлигын индекс тооцох аргачлалд заасны дагуу¹ олон нийтийн төсөөллийн судалгааны түүвэрлэлтийн эхний шатанд судалгаанд хамруулах сум, дүүргийг сонгохдоо ҮСХ-ноос авсан баг, хороогоорх өрх, хүн амын албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн хүн амын тоо, нягтрал зэргийг харгалзан үзэж 21 аймгийн 59 сум, нийслэлийн 8 дүүргийг сонгосон (Хүснэгт 39).

Хүснэгт 38. Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдах сум, дүүргийн нэрс

Аймаг, нийслэл	Сонгогдсон сум, дүүргийн нэр
Архангай	Тариат, Өндөр-Улаан, Эрдэнэбулган
Баян-Өлгий	Ногооннуур, Улаанхус, Өлгий
Баянхонгор	Эрдэнэцогт, Баянлиг, Баянхонгор
Булган	Сайхан, Хангал, Булган
Говь-Алтай	Дэлгэр, Эрдэнэ, Есөнбулаг

¹ Авлигын индекс тооцох аргачлал, 6-р тал

Дорноговь	Айраг, Сайншанд, Замын-Үүд
Дорнод	Баяндун, Дашбалбар, Хэрлэн
Дундговь	Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Сайнцагаан
Завхан	Отгон, Тосонцэнгэл, Улиастай
Өвөрхангай	Хужирт, Хархорин, Арвайхээр
Өмнөговь	Ханбогд, Цогтцэций, Даланзадгад
Сүхбаатар	Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Баруун-Урт
Сэлэнгэ	Ерөө, Мандал, Сүхбаатар
Төв	Батсүмбэр, Борнуур, Зуунмод
Увс	Өмнөговь, Тэс, Улаангом
Ховд	Булган, Үенч, Жаргалант
Хөвсгөл	Жаргалант, Их-Уул, Мөрөн
Хэнтий	Өмнөдэлгэр, Батноров, Хэрлэн
Дархан-Уул	Дархан, Хонгор
Орхон	Баян-Өндөр
Говьсүмбэр	Сүмбэр, Шивээговь
Улаанбаатар	Хан-Уул, Багануур, Баянзүрх, Налайх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан

Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгаанд сонгогдсон сум, дүүргийн өрх, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн талаархи мэдээллийг түүврийн хүрээ болгон ашиглан пропорциональ магадлалт, санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэлтийг хийж судалгаанд оролцох судалгааны нэгжийг гаргасан.

Хүснэгт 39. Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдах нэгжийн тоо, аймаг, нийслэлээр

Д/д	Аймаг/нийслэл	Өрхийн тоо	Төрийн албан хаагчдын тоо	Бизнес эрхлэгчдийн тоо	Бүгд
1	Архангай	48	49	13	110
2	Баян-Өлгий	65	55	17	137
3	Баянхонгор	53	59	13	125
4	Булган	32	47	11	90
5	Говь-Алтай	37	41	12	90
6	Дорноговь	58	40	13	111
7	Дорнод	73	57	18	148
8	Дундговь	35	36	11	82
9	Завхан	39	64	17	120
10	Өвөрхангай	72	72	15	159
11	Өмнөговь	39	48	15	102
12	Сүхбаатар	43	46	11	100
13	Сэлэнгэ	82	79	39	200
14	Төв	40	50	20	110
15	Увс	53	58	16	127
16	Ховд	63	53	22	138
17	Хөвсгөл	69	50	15	134

18	Хэнтий	44	46	16	106
19	Дархан-Уул	128	80	29	237
20	Улаанбаатар	1772	884	640	3296
21	Орхон	131	63	33	227
22	Говьсүмбэр	21	26	4	51
	Дүн	2997	2003	1000	6000

Судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CPro 4.0 (Census and Survey Program) програм дээр боловсруулсан.

Мэдээллийг оруулсаны дараа CPro 4.0 програмын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) програм руу хөрвүүлсэн. Мэдээллийн баазыг бэлтгэсний дараа мэдээллийн баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж мэдээллийг дахин шалгаж холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн.

SPSS 16.0 програмыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайланг бэлтгэхэд ашигласан.

Авлигын талаарх иргэдийн төсөөллийн судалгаа (ОНТС-1)-ны мэдээлэл нь 43 хувьсагчтай байсан бол Авлигын талаарх төрийн албан хаагчдын төсөөллийн судалгаа (ОНТС-2) мэдээлэл нь 89 хувьсагчтай, Авлигын талаарх бизнес эрхлэгчдийн төсөөллийн судалгаа (ОНТС-3)-ны мэдээлэл 67 хувьсагчтай байсан.

ДҮГНЭЛТ

Авлигын цар хүрээний үзүүлэлтийн олон нийт, шинжээчдийн 79.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл байна гэж үзсэн нь 2009 оныхоос 4.0 пунктээр нэмэгджээ.

Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 0.02 гарч байгаа нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.1 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас учирсан байна.

Шинжээчдийн төсөөллөөр авлигын хувь хэмжээ 0.11 гарсан нь 2009 оныхоос 0.01 пунктээр нэмэгдсэн нь төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалт буюу тендерт оролцох зэрэг хэлцлүүдийн үнийн дүнгийн дунджаар 11.1 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө авлига, хээл хахууль байдлаар зарцуулагддаг.

Авлигын хэлбэрийн үзүүлэлт буурч, авлигын хэргийн давталт, зохион байгуулалттай байдлын үзүүлэлт нэмэгдсэн байна. Хоёр болон түүнээс дээш давтан үйлдэлтэй авлигын гэмт хэрэг сүүлийн хоёр жилд 21.0 пунктээр нэмэгдэж, авлигын гэмт хэргийн давталт буюу үйлдлийн тоо бууралт буурахгүй байгаа нь төрийн байгууллагын дүрэм, журмын гажуудал, үйл ажиллагааны ил тод бус байдал нь эдгээр хэргийг дахин давтан үйлдэгдэхэд хүргэж байгаатай холбоотой байна. Мөн зохион байгуулалттай гэмт хэргийн эзлэх хувь өмнөх судалгааныхаас 16.0 пунктээр нэмэгдсэн нь авлигын гэмт хэргийг илүү зохион байгуулалттайгаар үйлдэх болсныг харуулж байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний (0.57), Эрүүл мэндийн (0.59) болон Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын (0.59) төрийн байгууллагууд авлигад өртөх илүү эрсдэлтэй гэж тодорхойлогдсон байна. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын салбарын авлигын индекс 2009 оныхоос 0.09 пунктээр сайжирсан хэдий ч бусад салбартай харьцуулахад хамгийн доогуур үзүүлэлттэй хэвээр байна.

Аймаг, нийслэлийн авлигын индекс 2009 оныхтой харьцуулахад 9 аймагт өссөн, 3 аймагт өөрчлөгдөөгүй, 10 аймаг, нийслэлд буурсан байна. Баян-Өлгий (0.46), Ховд

(0.49), Дархан-Уул (0.52), Өмнөговь (0.53), Хөвсгөл (0.53) аймгуудын авлигын индекс доогуур буюу харьцангуй авлигад өртөх эрсдэл өндөртэй аймгууд болж байна.

Авлигатай тэмцэх газар 2011 онд ирсэн нийт гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 443 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Нийт 443 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 54 гомдол, мэдээлэл буюу 12.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 214 гомдол, мэдээлэл буюу 48.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, 164 гомдол, мэдээлэл буюу 37.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 3 гомдол, мэдээлэл буюу 1.0 хувийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж шийдвэрлэсэн бөгөөд ажиллагаанд 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 98.2 хувьтай байна.

Улс төрийн намын нөлөөнд автаж асуудалд ханддаг гэдэгтэй авлигын талаарх иргэдийн төсөөллийн судалгаанд оролцогчдын 35.8 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 2.3 хувиар буурч, зарим талаараа санал нийлж байна гэж 33.9 хувь нь хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 0.4 хувиар нэмэгдсэн байна. 17 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 5.4 хувиар өссөн байна.

Ахдүү, танил талаараа асуудлыг шийдвэрлэдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 50.2 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 4.3 хувиар буурсан бол 28.9 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.1 хувиар нэмэгдсэн байна. 13.4 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 5.4 хувиар нэмэгдсэн байна.

Төрийн албаны үйл ажиллагаанд хүнд суртал гаргадаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 49.0 хувь нь санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 3.5 хувиар, 30.1 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан нь 2009 оныхтой харьцуулахад 1.0 хувиар тус тус буурсан байна.

13.6 хувь нь санал нийлэхгүй байна гэж хариулсан нь 6.9 хувиар өссөн байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

